

*Дэчин галав буюу Дүйнхор дацан
байгуулагдсаны 230 жилийн ойд
зориулав.*

НОГООН ДЭВТЭР

Есдүгээр цуврал

Түвд судраас орчуулан эмхэтгэсэн
Монголын Бурханы Шашинтаны Төв Гандан хийдийн гавж
Доктор, Ph/D нэрийг зүүгч Ц.Отгонбаяр

Улаанбаатар, 2016 он

Хянасан: Ц.Бямбаа
Д.Саруул
П.Яньдий
П.Цэвэгмид
Г.Жалсрайжамц

Эх бэлтгэсэн: О.Ширавжамц
О.Ширавсингэ
Ж.Дагийжанчив
Ч.Мандалсүрэн

Printed for free distribution by

The Corporate Body of the Buddha Educational Foundation

11F, No. 55, Sec. 1, Hang Chow South Road, Taipei, Taiwan, R.O.C.

Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415

Email: overseas@budaedu.org

Website: <http://www.budaedu.org>

Mobile Web: m.budaedu.org

This book is strictly for free distribution, it is not to be sold.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО

ГАРЧИГ

ДЭД БҮЛЭГ.

Гандан хийдийн түүхэн бүтцийн товчоо	5
Үндэсний Төв Архивын баримтыг эшлэвэл	7
Тагнуулын Ерөнхий Газрын архивын эшлэл	13
Нэрт Эрдэмтэн Заваа Дамдин Гавжийн эшлэл	18
Багш нарынхаа намтрыг дурьдваас	22

Ц.ОТГОНБАЯРЫН ДОКТОРЫН ДИССЕРТАЦААС

Ерөнхий агуулга	31
------------------------------	----

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

Цагийн хүрдний номлолын үүсэл	45
Шамбалд дэлгэрсэн нь	55
Энэтхэгт дэлгэрсэн нь	65
Түвдэд дэлгэрсэн нь	67
Монголд дэлгэрсэн нь	71

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

Цагийн хүрдний номлолын бүтэц агуулга

Гадаад Цагийн хүрд	92
Дотоод Цагийн хүрд	102
Дүйнхорын Ван	124
Арван үсгэн тэмдэгт Намжүбандан	130

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

Лагшингийн хот мандал	138
Зарлигийн хот мандал	144
Тааллын хот мандал	146
Их амгалангийн хот мандал	147
Билиг билгүүний хот мандал	148
Цагийн хүрдний номлол ба Авидармагийн ялгаа	151

Ерөнхий дүгнэлт	157
Ном зүй	162
Цагийн хүрдний номлолын ерөөл	182
Дүйнхор дацангийн жаяг	187
Архангай дахь бурханы шашины улбаа	213
13-р Далай Лам Заяын хүрээнд морилсон нь.....	226

Дөрвөн уулын тахилга

Чингэлтэй хайрханд тахил өргөхүй	283
Баянзүрх хайрханд тахил өргөхүй	297
Богдхан ууланд тахил өргөхүй	303
Сонгино хайрханд тахил өргөхүй	307

ДЭД БҮЛЭГ.
МОНГОЛЫН ИХ ХҮРЭЭ ГАНДАН ХИЙДИЙН
ТҮҮХЭН БҮТЦИЙН ТОВЧООН
(1651-1938 он)

Их хүрээний үндсэн суурь болсон аймгуудаас гадна, нийт Хүрээний хурал ном, хувраг лам нарын хэргийг захиран зохицуулах гол газар болох Цогчин, философи, боловсролын болон анагаах ухаан, шүтлэг мөргөлийн үйлчилгээ явуулдаг дацангууд, бас тусгай бэсрэг сүмүүд цувран байгуулагдсаар байсан агаад тухайлбал, анхны долоон аймаг байгуулагдсаны дараахан 1654 онд Өндөр гэгээн "Цогчин" хэмээх төв удирдлагын газрыг байгуулж, хожим II Живзундамба хутагт Лувсандамбидонмой 1756 онд Дашчоймбол дацанг байгуулжээ.

Түүнээс хойш: 1760 онд эмч нарын дацан
1778 онд Жүд дацан
1789 онд Зурхайн дацан
1806 онд Бамба-ёго дацан
1806 онд Дэчин галав дацан
1809 онд Гунгаа-Чойлин дацан
1834 онд Майдарын дацан
1837 онд Дашсамданлин дацан
1838 онд Гандантэгчилэн
1844 онд Ламрим дацан
1910 онд Идгачойнзонлин дацан
1913 онд Мигжид жанрайсэг дацан тус тус

байгуулагджээ.

Эдгээрээс Жүд, Дашчоймбол, Гунгаа-Чойлин, Идгачойнзонлин, Эмч нарын, Ламрим, Зурхайн дацангууд жинхэнэ

мэргэжлийн сургуулийн, бусад нь жасаа хуралтай мөргөл шүтээний дацангууд юм.

Харин Гандантэгчилэн нь дацангууд төвлөрсөн Гандан хийдийн хурал номын ажиллагааг удирдан зохицуулдаг бага Цогчин бөгөөд их хүрээний гол Цогчины салбарын үүргийг гүйцэтгэдэг төв газар байжээ.

Үүнээс гадна:

1830 онд Гунгаадэжидлин (Богдын цагаан ордны сүмүүд),

1840 онд Пандилин сүм (Нар хажидын сүм),

1898 онд Шаравпэлжээлин сүм (Богдын ногоон ордны сүм),

1906 онд Зэпэлин (Чойжин ламын) сүмүүд байгуулагдаж бас Богдын шар ордны жижиг сүмүүд болон ноён шүтээний зэрэг байнгын хуралтай бэсрэг сүмүүд бий болж тэдгээрийн зардал хэрэглэлийг их сан ба цогчингоос хангаж байжээ.

XII зуунаас эхтэй олон нүүдэл буудлын урт замыг туулсан Их хүрээн зохион байгуулалтын хувьд ийнхүү өргөжин тэлж, буддын шашны онол философийг судлан дэлгэрүүлэх, шүтэн бишрэхийн ёс суртахууныг жинхэнэ ёсоор хэрэгжүүлэгч том төв болон хөгжсөн түүхтэй ч XX зууны гучаад оноос коммунист харгис явууллагад дайрагдаж, хувраг лам нар нь гүтгэлгээр хэлмэгдэн, бурхан ном, сүм дуган нь баргаараа устгагдсан бараан түүх бас бий билээ.

Монгол Улсын Үндэсний Төв архивын баримтыг үндэслэвэл

Тус дацанг Монголын XIII жарны гал барс жил IV Живзундамба хутагт Лувсантүвдэнваанчогжигмиджамц үүсгэн байгуулжээ. Энэ нь Манжийн Сайшаалт ерөөлтийн 11 дүгээр (1806) он болно. Дацангийн хурал номын ажил 1938 онд бүрмөсөн зогсчээ.

Гол ядам нь: ДҮЙНХОР

Гол сахиус нь: ДОРЖШҮГ, ЖАМСРАН

Дацангийн бүх хэрэглэл зүйлийг Живзундамба хутагтын их сангаас гаргадаг байсан боловч 1926 оны үеэс бие даасан Дүйнхорын жас, Загдсамбарын жас зэрэг жасуудтай болжээ.

Тодруулбал:

1. Дэчингалав хэмээх нэр нь "Их амгалант цаг" гэсэн утгатай. Тахисан Ядам бурханы нэрээр Дүйнхор дацан гэж ч нэрлэдэг байжээ.
2. Тус дацанд хурдаг лам нар нь орчлонт ертөнцийн жам ёс, амьд байгаалийн хууль, бурханы хутгийг олох зам мөрийн номуудыг үзэж судалдаг боловч, шашны эрдмийн ямар нэгэн мяндагийг олгодоггүй байжээ.
3. Дэчингалав дацангийн анхны дуган сүм нь бүх бурхан ном, эд зүйлийн хамт цагаагчин туулай (1891) жилийн өвлийн сүүл сарын 28-нд шатсан учир их сан ба их шавийн сүсэгтэн олноос хуримталсан 50000 лан мөнгөөр 1893 онд сэргээн босгожээ.

Гэвч хөх барс жил (1914 он)-ийн өвөл дахин бүрмөсөн шатаж асар их хохирол учирчээ. Энэ удаа Халхын 4 аймаг хутагты их шавиас татвар ба хандиваар 34500 лан мөнгө цуглуулж, хөхөгчин туулай жил (1915 он) Богдын шар ордны хашаан дотор алталсан дээвэртэй бэсрэг модон дуган барьж дахин

босгожээ.1937он хүртэл номоо явуулж байгаад цагийн ороо бусгаа байдлаас болж хоёрхон жилийн дотор нийт хүн ам 512хон мянга байхад Дүйнхорын Цогтзандан цорж,миний багшийн багш богдын долоон цоржийн нэг Цойнзон цорж тэргүүтэй гуч гаруй мянган эрдэмтэн хувраг нарыг зориуд буудан хороож дэлхийд байхгүй генацид цуст яраглалыг үйлдчихээд өөрсдийгөө долоон бурхан одоор зүйрлэдэг нөхдүүдийн балгаар амьд бүгдийг тамлан алж амгүй орон хийд шүтээн номыг нь галдан шатааж хүчээр хаасан байдаг. Хаагдаж байгаад 1943 онд Дэлхийн 2-р дайны гол дүрэлзэж эрлэгийн элч Сталин бүхнийг фронтод ялалтын төлөө гэх уриан дор амьд үлдсэн бүхэнд нь албан татвар ноогдуулаж хувьсгалт монгол танкийн бригад, нисэх онгоцны эскадрэл зэргийн бэлгийг хүлээлгэн өгөх комиссын дарга нөхөр Бумцэнд оросын талын Калининд хүлээлгэн өгч байхад оросууд урьд өдөр нь буриад лам нарын шар тостой боов марчин, зэрэг нүнжигтэй хүнсийг хүлээн авч өлсгөлөнгийн улсуудад өгч байснаа санаад лам нарын бэлэг хаа байна гэхэд Бумцэнд бид лам нарыг устгасан гэхэд Калинин ихэд цочин дуу алдаж,монголд хэдэн хүн үлдсэн бэ гэж асуусан гэдэг. үг Сахал ихт Сталин, Сагсуу Чойбалсан нарт хүрч нэгийг бодож эхэлжээ. Чойбалсан наашаа вагонд явахдаа комисар нартаа үүрэг өгч НАХЯ ны дэслэгч хуучин лам байсан Эрдэнэпилийг дуудуулж хурал зохион байгуулахыг үүрэгдсэн ба тэр үеээр нь Америкийн дэд ерөнхийлөгч Ульямс монголд иржээ. Түүнийг Бурханы шашинтан гэхээр нь гэр барьж хойморт нь Бурхан багш залсанд их баярлаж танай сүм хийдээр орно гэсэнд агтны байр хийж байсан гандан хийдийг цэвэрлэж Эрдэнэпилээр хамба болгож долоон ламыг хуралд хуруулж дэд ерөнхийлөгчийг дагуулан ирж үзүүлсэнээр гандан хийд үүдээ нээж, эхлээд 1962оны хаврын адаг сарын 15д Өглөгийн эзэн Өсөхбаяр гуайн Дүйнхор Бурханыг ганданд залж дүйнхорын хурал эхэлж байгаад 1990онд Д.Данзан Сэрээтэр нарын ахмад лам нар санаачилан Дэчингалав дацанг сэргээн барьж Сагар Чогар Сачог дүлцэнтэй хурал хурж эхлэв.

Үүнд Дээрхийн гэгээнтэн Далай ламын шууд туслалцаагаар намжараа дацанд Ц.Отгонбаяр тэргүүтэй лам нарыг сургаж, Тэндээс Агваанжамцо тэргүүтэй дөрвөн түвд лам нарыг авчирч багшлуулан байж хуучин Дэчингалавын хуралыг үргэлжлүүлэн хурж эхэлсэн ба 1995 онд Дээрхийн гэгээнтэн монголд морилон Дүйнхорын ван айлдаж төгс ван авшигтай болсон билээ.

Иймээс төв архивын материалыг гол болгон үзвэл 2016 он дэчингалав дацан үүсгэн байгуулагдсаны 210 жилийн ой тохиож буй билээ. Ой тэмдэглэж чаддаггүй ч гэсэн хорь гаруй жил дацанд байсны хувьд энэхүү номоо ойн номын хуриманд зориулан шамбалын ерөөл тавьж байна.

Бид нар Шамбалаа гэж ахиалдаг ламрим дацангийн ловон Балдангомбуу ламын дурсамжаас:

Равжин, Дамба, Вантан /анхдугаар/ "энхтайван жаран" тогтсон Х зууны эхэн үед Замбуулинд гурван сайхан билэгдэлтэй үйл нэгэн зэрэг тохиосон нь:

- а. Шамба "XII хаан Ригдэннямаа" алтан ширээнд суусан
- б. Борондамбий гэгээн мэндэлсэн
- в. Жагарын оронд Дүйнхор /Цагийн хүрд/-ын номлол дэлгэрсэн

Дүйнхор "Цагийн хүрд" шашин ном дэлгэрч улмаар Түвд, Монгол болон олон улсад түгэн дэлгэрсэн дээдсийн түүх ном, номлол байдаг болой.

Ганжуурын Дүйнхор, Жуд /Цагийн хүрдний тантрисын хаан Дандар судрыг Түвд, Монгол оронд дэлгэрсэн "Шамбалын орны тухай номлол"-ын гол эх сурвалж болой.

Одоогоос 295 жилийн өмнө XVIII зууны эхэн үед Монголд Дүйнхор "Цагийн хүрд"-ний шажин номлол сургаалыг дэлгэрүүлэх бүх зан үйлийг байгуулахад Монголын IV Богд Жавзүндамба Лувсантүндэвванчүгжигмэджамц бээр зүтгэл

гарган Бурханы шашин мандан бадрах ялангуяа ирээдүйд Дүйнхор "Цагийн хүрд"-ний номлолыг нийт Монголчуудад дэлгэрүүлэх зорилгоор Цаст Түвдийн орныг зорьж Лхасад Далай лам, Банчин Богд нарт айлтгаж соёрхлыг олсон байна.

IV Богд 1804 онд Лхасад байхдаа Далай ламын засгийн газраар дамжуулан Богд өөрийн сангаас зардал хэрэгсэл зүйлийг гаргаж Өмнөд Түвдийн Лхоха гэдэг газраас алдарт эрдэмтэн "Жалсрай" гэгээн Галсантаүндэвванчүгжигмэд Дамбийжанцанг Лхасад урин залж ирүүлэн Дүйнхорын ван авшгийг бүрэн дүүрэн хүртэж авсан байна.

IV Богд Түвдийн Дашлхүмбэ хийдэд байхдаа Банчин Богд, Далай лам нарт айлтгал айлдсан ба Монголд Дүйнхор дацан байгуулахаар шийдэж Монголын 10 гаруй лам нарт Дүйнхорын уншлагы бүрэн цээжлүүлсэн байна.

Мөн Монголын 2 гэлэнд Дүйнхорын уншлага бүрэн цээжлүүлж Банчин Богд, Далай лам нарт жүг өргүүлж байжээ.

Банчин Богдын дэргдэх Дүйнхор дацангийн шавь нараас Дүйнхорын зан үйлийг Монголд дэлгэрүүлэхийн чухлыг айлтган Банчин Богдын зарлигаар Гачэн Ишчоймбол хэмээх ламыг Монголд томилсон байна. IV Богд хүрээнд буцаж ирээд 1805 онд их хүрээнд Дүйнхорын уншлага, Сагар, Чогарыг дэглэн байгуулжээ. 1806 онд 3 давхар Дүйнхор дацангийн дуганыг шинээр байгуулан Дүйнхор дацанд "Галаараабаа поврон" хэмээх нэр хайрласан билээ.

Мөн энэ онд Дүйнхорын лам хувраг, шавь нараар Сагар, Чогар эхлэн байгуулж Дүйнхорын бүрэн ном уншлагыг 30 гаруй лам нараар цээжлүүлэн бүтээлгэн Түвдийн Гачэн, Лувсаншэйрэв, Ишдондүв хоёрыг Цагийн хүрдний номлолын цогламд босгож байжээ. Дүйнхорын дүлцон жинхорыг бүрэн гүйцэд бүтээгээд дүлцонгоо адислан Туул голын Хар усан тохой гэдэг газар залахаар тогтоосон болой.

Дүйнхор дацангийн дуганыг барих ажлыг Эрдэнэшанзав, Дамчойравжан биечлэн удирдан бариулах газар Дашсонжин, Ганжуур ном хуруулж байсан байна. Сайн ноён хан Пунцагдаш тэргүүтэн бусад ноёд Дүйнхор дацанг байгуулах ажилд өглөгийн эзэд болж байв.

Дүйнхор дацан шизээр барьсан баяр ёслолд IV Богд, Ёнзон хамба Лувсангэндэн, Хан номун хан Жанчивдорж, Ялгуусан номун хан Ренчиндорж, Эрдэнэ шанзав Дамчойравжан, Да лам Лувсанжамба, Да лам Цэцэн тойн Гомбожав, Цогчин 4 гэсгүй зэрэг эрхэм тушаалтан, лам нарын зэрэг 100 гаруй лам нар оролцож Богдын сангаас хэрэгсэл зүйлсийг гарган зарим урчуудыг шагнасан байна. Цэцэн тойн Да Лам Гомбожав, Дүйнхорын гэсгүй, Чандмань тойвон Ядамжавыг Дүйнхорын унзад болгожээ.

IV Богд 1806 оны цагаан сарын шинийн 1-ний ёслолыг Дэчингалбын дуганд ёслон өнгөрүүлжээ. Үүнээс хойш Их хүрээний Дүйнхор дацан нь Богдын ордонд хамрагдах болсон. IV Богдоос хойш V Богд улам өргөжүүлэн дараачийн Богдуудад энэ дацанд морилон саатдаг байжээ. VIII Богд Живзундамба Дүйнхор дацанд удаа дараалан морилон дацангийн дэг журам, лам нарын ном эрдмийг дээш татаж хөгжүүлсэн байдаг.

Их хүрээнд Дүйнхор дацан байгуулагдсанаас уламжлан Монголын хөдөө орон нутгийн сүм хийдүүдэд Дүйнхорын дацангууд буй болсон юм. Ингэж Дүйнхорын номлол өргөжин дэлгэрэхийн сацуу тухайн чиглэлийн эрдэм ухааныг төгс эзэмшсэн эрдэмтэй лам нар олноор бий болж Дүйнхорын ван авшигийг түмэн олонд тавьдаг уламжлалтай болсон билээ.

Дүйнхорын шажин номлол Халх Монголын олон хүрээн хийдүүдэд дэлгэрсэнийг дурьдахад:

1. Одоогоос 270 орчим жилийн өмнө Хүрээний цорж лам Агваанхайдав "Шамбал ба замбуулингийн 5 ариун оронд

энэ ба хойд насандаа төрөх ёс зам мөр" ном туурвин номлож дэлгэрүүлсэн.

2. XIII зууны сүүлчээр одоогийн Булган аймгийн нутагт Дайчин Ван Ханддорж ноён "Өргөө" хэмээх 2 дахь Дүйнхорын дацан байгуулсан ба тухайн нутагт их гэм Лувсандамба аграмба их лам "Шамбалын оронд очих зам мөр" ламиг номлолыг зохиожээ.
3. XX зууны эхэнд Бизъяагийн их ламтан Дамдинсүрэн "Шамбалын орны 32 их хаадын тахилга, чагчид номлол"-ыг айлтгаж Их хүрээнээ хурдаг уламжлал тогтоожээ.
4. Тойслон аймгийн Заваа Дамдин гавьж, Говь түшээ гүний лам Лувсанжамц аграмба, Боржигоны зүүн Чойрын дэмч лам Хайзэншонуу зэрэг эрдэмт лам нар Дүйнхор дацан байгуулж Дүйнхорын дамжааг шинээр дэглэн "Шамбалын орны хаадуудын тахилга ном"-ыг номлож дэлгэрүүлсэн.
5. Эрдэнэзуугийн ширээт их лам Балгангадавдорж "Лаврэн" хэмээх 2 давхар сүм барьж дээд давхарт нь "Ламрим", доод давхарт нь "Дүйнхор" дацан байгуулсан нь Монголын 3 дахь Дүйнхор дацан болой. Дүйнхорын ван авшигийг сүсэгтэн олонд айлдаж байсан энэ дацанд одоо музей байрлаж байгаа билээ.
6. "Рэгүүгэжээ Гандан шадивлан"Баруун хүрээний Ноён ламын анхны дүр 4 дэх Дүйнхор дацанг байгуулсан. /Одоогийн Өвөрхангай аймаг, Шанх сумын нутаг/
7. XX зууны эхэн үед Эрдэнэзуугийн ширээт ламын 3-р дүр миний ачит багш Лувсангончигжанцан хэмээх алдарт лам

бээр өөрийн сууж байсан сүмдээ Дүйнхор дацан, шүтээн байгуулан Ван авшиг 17 удаа айлдсан гэдэг.

8. Говийн хутагт Данзанравжаа нутаг орныхоо уул толгодын дунд байгалийн төрөл бүрийн өнгөт чулуугаар Шамбалын орныг 8 хэсэг салаа газарт дүрслэн бүтээж гол дундах хүйсэнд нь ёслол хийж байсан гэдэг ба одооч энэ газар шамбал толгой гэдэг жижиг уул байгаа. Үүнийг 1936 оны үед Оросын цэргүүд эвдэн сүйтгэснийг нутгийн зон олон сэлбэн суварга босгосон нь бэлэгдэлтэй сайн үйл байв.
9. VIII Богд XX зууны эхэн үед Их хүрээ 30 аймгийг 32 болгож өргөтгөснийг нэг нь Дар ноёны аймаг, нөгөө нь Дүйнхорын аймаг болой. Зөвхөн дөрвөн уулын дундах Дэчингалба, Дамбадаржаа хийд, Дүйнхор аймгийн дацангуудад Дүйнхор "Цагийн хүрд"-ний ном хурал дэлгэрч байжээ.. Дүйнхорын нандин шүтээн алтан шармал "Дүйнхорын хот мандал" эдүгээ Дүрслэх урлагийн музейд байдаг.

ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АРХИВААС ЗАРИМ НЭГЭН АЙМАГТ ДҮЙНХОР ДАЦАН БАЙГУУЛАГДСАН ТУХАЙ ЭШЛЭВЭЭСҮҮ

Дорноговь аймаг

Хэбэй жанжин мэргэн ван Лхасүрэнбазар, дүү тойн хамба хутагт лам Гэндэн, Цогт-Дарь, агь эет мэргэн хунтайж, эх хатан Номундарь голдож, 14 дүгээр жарны 46 дугаар хар хулгана жил, Түгээмэл Элбэгтийн 3 дугаар он, европын 1853 онд Дүйнхор байгуулахаар хэлэлцэн, Дэчинчойнхорлин дацанг анх үүсгэн бурхан шүтээн ба дуган жас сүрэг тэргүүтнийг бэлтгэн, хориод хуврагар жилийн дөрвөн цаг тус бүр бүгд нийлж, хорин найман хоног Дүйнхор хурахын зардал үүсгэн эхэлжээ.

15 дугаар жарны 23 дугаар шороон үхэр жил, Бадаргуулт төрийн 16 дугаар он, европын 1890 онд жанжин ван Амарбазар, агь, хатад, хүүхэд бүгдээр энэхүү Дүйнхор дацанг дэглэх баг ба дэглүүлэх ламыг Их Хүрээнээс залваас болох эсэхийг Богд Жибзундамбад мандал өргөн, соёрхлыг айлтгасанд: "Эндхийн Дашчойнхор дацангаас дэлгэрүүлбээс сайн. Цорж Ванчинг зал" хэмээн лүндэн соёрхсоныг дагаж, цорж Банчин нааш гарахын цагт Богд гэгээнтэнд бараалхаж: "Богдын зарлигийг дагаж, мэргэн вантны хошуунд Чойр дацан байгуулахаар явах болов. Өчүүхэн шавь өндөр зарлиг дагах болов." хэмээн айлтагсанд "Чойр дацан байгуулахын түрүүнд гурван хоногийн урьд Жүд дацан байгуулваас нэн сайн" хэмээн зарлиг болжээ.

Дараа усан үхэр жилийн зуны тэргүүн сарын шинийн сайн өдөр Баруун Зуугийн аграмба Дамбадаржаа, гэвхүй тойн Ренчин, унзад гэлэн Эрэнчин тэргүүтнийг томилж, хорь шахам хуврагар жил, сар, хоног лугаа барилдуулсан их, бага оточ хийгээд бас жил бүрийн Гүнрэг ба Хангал тэрүүтний унших номыг тогтоож байгуулжээ. Түүний хойно Богд гэгээнтнээс нэр айлтгасанд Пандидэгчилэн хэмээх нэрийг соёрхов. Түүний хойно жүн ван Амарбазараас Бадаргуулт Төрийн 15 дугаар он, 15 дугаар жарны 33 дугаар шороон үхэр жил, европын 1889 онд 8 дугаар Богд гэгээнтэнд соёрхол айлтгасанд "Их Хүрээний эмч нарын дацан Пандиёнгайлангаас дэглэ" хэмээн айлтгаснаас гадна мөн Эмч нарын дацангийн унзад Эрэнчиндоржийг багшид даалгасан зарлигийг нэгэн хамтад соёрхов.

1936 оны байдлаар Амгалант хийдийн аймаг, дацангуудын анх байгуулагдсан цаг үеэс хойш Хүрээний аймаг 271 жил, Минжүүр аймаг 169 жил, Цогчин 100, Жүдвэ дацан 98, Дүйнхор дацан 85, Унзад дацан 29, Чойр дацан 98, Хойд аймаг 21, Мэнва дацан 85 жил болжээ.

Дундговь аймаг

Бүрэнт Засагчийн 3 дугаар он, европын 1877 онд модон хулгана жилд гэлэн Ишбалдан хэмээх "Дүйнхор дацанг байгуулъя" хэмээн өөрийн засаг бээл ноён Цэрэнсандавт айлтгаж, түүнээс уламжлан 7 дугаар Богдын гэгээнтнээс болох эсэхийг айлтгасаж, зөвшөөрлийг авч, Ундараг зандан ширээт хэмээх газар гэлэн Ишбалдангийн гэрийг барьж, түүнд равжамба Лувсансампил зэрэг арван нэгэн лам тарнийн ёсыг дагаж эхэлж хуралд хуржээ.

Зүүн Чойр хийдийн Дүйнхор дацангаас лам Түдэв, Ойдов нарыг урин ирүүлж, Дүйнхорын хурлуудыг заалгуулж гүйцэтгэсэн байна. Мөн цаг цагт Хангал, Дүйнхор, Дордов зэргийг хурж иржээ. Дараа мөнхүү өлөгийн эзэн Ишбалдан, Цэрэнсандүв, жонон Балган нар санаа сэдэж, зөвлөлдөн "Дуган баръя" хэмээн мод зэргийг бэлдэн, Бүрэнт Засагчийн гал туулай жилээс эхлэн шороон могой жил хүртэл маарамба Дамчаа, хар Дархан хэмээх хоёр хүрээр даалгаж, арав гаруй монгол дархчуудаар дуганыг гурван зуун тавин лан мөнгөөр бариулжээ. Мөн дуганд Ганжир, Жанцан хоёр өгчээ. Энэхүү дуган хуучран муудсан учир сэлбэхээр Монгол улсын 22 дугаар оны усан бичин жилд сумын захиргаанаас зөвшөөрлийг олж, жас ба дацан шавь нар олноор өөр өөрийн саналаар эвсэж, дуган жасыг сэлбэж гүйцэтгэжээ. Дуганы шалны хэмжээ арван гурван метр хагас, зүүн тал нь хойш урагш долоон метр, зүүн баруун нь дөрвөн метр болно. Чойрын шавь нараас анх арван нэгэн лам анх хурсан. Түүнээс хойш зуу хүрсэн байна. Эдгээр бүгд мөн Чойрын шавь нар болно.

Дацангийн жасыг Бүрэнт Засагчийн 7 дугаар оны гал туулай жил, европын 1868 онд гэлэн Ишбалдан, жонон Булган нар эвсэж, жастай болгожээ. Жас анх үүсэхдээ мал сүрэг нь дөчин дөрвөн бодын хөрөнгөтэй байжээ.

Монгол улсын 12 дугаар оны усан гахай жилээс урагш Хөх эрэг, Шанд зэрэг газруудад арав гаруй тэмээгээр жин тээж, арьс шир ноос зэргийг худалдан өгч, хурал номын зүйл хэрэглэлийг бэлтгэж байжээ. Өглөгийн эзэн Дандар хүрээ барын Ганжуур тавьжээ. Дуу үл тасалдах хурал бас үл тасрах Нүгнэй хийгээд эдгээр зүйлүүд үл байна.

Баруун Чойр хийдийн Дүйнхор дацангийн Лойлин жасыг Бадаргуулт Төрийн 13 дугаар оны шороон үхэр жил, 1887 онд маарамба Гэндэнчоймбол Лойлин жинхор бүтээлгэж, Дүйнхорын дуганд тавьжээ. Нэг өдрийн Дүйнхор байгуулагджээ. Тэр цагт тавин хоёр бодын мал сүрэгтэй байв.

Төв аймаг

Бүрэнт Засагчийн 3 дугаар оны модон хулгана жил, европын 1864 онд санаа сэдэж, гэлэн Ишбалдан эх болсон зургаан зүйлийн хамаг амьтны тусын тулд "Дүйнхор дацанг байгуулъя" хэмээж ноён Цэрэнсандүвт айлтгасанд "болно" хэмээсэнд долдугаар Богд гэгээнд айлтгаж, зарлигийг гуйн зөвшөөрлийг олжээ. Мөн Богдоос "ногоон бүчтэй овоодой, хүрэн жанч, дөрвөлжин бэрээ, тугдантай бай" хэмээн зарлигласан болно. Тэр цагт Зандан ширээт хэмээх газар гэлэн Ишбалдангийн гэрт лам равжамба мэргэн Лувсансампил тэргүүтэн арван нэгэн лам модон үхэр жилд намрын дунд сарын хорин хоёрны өдөр хурал эхлэн хуржээ. Өглөгийн эзэд Ишбалдан, Цэрэнсандүв Балган тэргүүтэн шар хар нийтээр санаа сэдэж, "дуган баръя" хэмээн хэлэлцээд гал туулай ажилд эхэлж, шороон могой жилд аграмба Дамчой, хар Дархан нараас дааж хурлыг эхлүүлжээ. Мөн арав гаруй монгол дархчууд дуган гонхыг хийжээ. Төмөр морин жилийн намар равнай хийж, дуганы алт будгийг зурхайч Жүрмэдцэрэн будуулжээ.

1932 оны усан бичин жил Дүйнхор дуганыг сэлбэхээр сумын захиргаанд мэдэгдэн, жас ба дацан түүний шавь нар нийтээр өөр өөрийн дур саналаар сэлбэж үйлджээ. Монгол дархан Сүх, Мөнх нарын долоон хүнээр сэлбүүлжээ. Сэлбэг хөлс нийтээр 1400 төгрөг өгсөн байна.

Бадаргуулт Төрийн 15 дугаар оны шороон үхэр жил, европын 1889 онд маарамба Гэндэнцэмпил өглөгийн эзэн болж, Лойлин жинхор, гол шүтээн Дүйнхор бурхан энэ хоёрыг хоёр зуун тавин лангаар Утайд бүтээлгэж тавьжээ.

Мөн хааны 29 дүгээр оны төмөр хулгана жил, европын 1903 онд Дандар хэмээгч бээр хятад барын Юмжайбириндүйсүм тавив. Түүнээс хойш хар шар олноор элбэж, хүрээн барын Ганжуур залж тавьжээ.

Бүрэнт Засагчийн 10 дугаар оны төмөр хонин жил, европын 1871 онд ноёны зарлигаар Зүүн Чойр Дэчилин хэмээгч дацангийн Ойдов, Түдэв хэмээх багшийг залж ирж, их Дүйнхор, Сацог, Дүлцэн эдгээрийг гүйцэдээр заалгав.

Олноо Өргөгдсөний 10 дугаар оны төмөр бичин жил, европын 1920 онд Дүйнхор дацанг Богдод аврал айлтгасанд: "Доржшүг бүтээлгэ. Доржшүгийн дордов гаргаж бай" хэмээн айлджээ. Хаврын тэргүүн сарын хорин долооноос эхлэн гурав хоног хурж эхэлжээ. Битүүнд Дүйнхор хурдаг буй. Хаврын сүүл сарын шинийн нэгнээс эхэлж, арван гуравныг хүртэл арван есөн ламаар Сацог хурдаг байжээ. Мөн арван гуравнаас эхлэн хорин нэгнийг хүртэл олноор Дүвчид, мөн энэ сард арван гурван лам Гомбын Дордов хурдаг байжээ. Зуны дунд сарын хорин есөнд Хангал, битүүнд Дүйнхор, намрын дунд сарын арван Хангал, арван нэгэнд Дүйнхор, өвлийн дунд сарын хорин есөнд Хангал, битүүнд Дүйнхор хурдаг байжээ. Үүний дотор бага хурал нь арван тав байжээ. Их хурал нь арван найм болно. Энэ их, бага хурлын хамт хорин долоон хурлыг жас хуруулдаг байжээ.

Анх байгуулах цагт жандаг нар нь Ишбалдан, Балган, Жалсрай, лам Шарав байсан бөгөөд эдүгээ буй /1937/ жандаг нь Борын Дорж, Лувсанбалдан, Жадамба, Даваа эдгээр болно.

Монгол улсын нэрт эрдэмтэн Заваа хэмээх Лувсан Дамдин гавжийн өөрийн зохиосон 17 боть, Сүмбум зохиолын битүү Га ботьд орсон Дүйнхор дацан Эбам Сүнжиглэн буюу арга билэг хосолсон Цагийн хүрдний номлолын гарчиг сэтгэлийн үзэсгэлэнт чимэг хэмээх Дүйнхор дацан байгуулагдсан түүхээс орчуулан бичвэл:

Хойд зүгийн шашны ёсныг дэлгэрүүлэн үйлдэгч очир авралт Живзүндамба хутагтын урд дүр Лувсандамбийжанцанбалсамбуу гэгээнтний лагшингийн наран шингэхийн цагт магтаалын гэрэл эрдмийн цогийг эрхшээгч засаг Цэмбэлдорж хэмээн алдаршсан шавь нарынх нь нэг Эрдэнэ дайчин хошууны хүрээ Пунцагдэчиндаржаалин хэмээхүй дор Цогт хоёр үгүй. Цагийн хүрдний хот мандлыг бүтээхүйн тахилыг сэргээн дэлгэхийн гол дэглээч анхны дацан энэ мэт үйлдсэний зэрэг ануу. Энэ зүг дор буюу Монголд Бурханы шашныг баригч авралын таалалтай ерөөл сайтар бүтээгч дээд төрөлхтөн Цогчин Унзад лам, Дорж Ловон Агваанцэрэн хэмээх алдартнаас Дүйнхор дацанг бүтээж өгөөч хэмээн үлэмжийн сэтгэл гарган он удаан жил гуйсны эцэс дор өөрийн хошууны гүн ноён Найдансүрэн бээр зөвшөөрөн үйлдэж түүн дор чү баясал ихээр төрөн таалалдаан багтаажээ. Дээрхийн гэгээн Жибзүндамба хутагтын сонорт ч дуулгажээ. Тэр мэт ерөөлчлөн бүтэхийн зарлиг дэлгэрэн дэлгэрсээр XV жарны галзуу төгөлдөр хэмээх эм туулай жилийн Монголын есөн сарын хорин хоёрны өдөр буюу 1806 оны 9-р сарын 22-ны өдөр Бурхан багш Гучин гурван тэнгэрийн орноос бууж номын хурыг буулгуулсан тэмдэглэлт баярын өдөр би ямагт бээр өөрийн гэрийн дотор зохилдохуйн шалтгаан бүхий бүтээхийн урд залбиран суусан нэгэн билээ. Тэгээд ч дээрхийн гэгээн

Жибзундамба хутагт тэргүүтэй дээдэс хамтран шийдэж Банчин Богдын зохисон Чог судрыг шүтэж Цагийн хүрдний номлолын бүтээлийн тахилыг эхнээс нь шинээр тавин байгуулсан болой. Үүнээс аваад жил бүр бүтээлийн тахилыг алхаслалгүй хурж Ловонренбүчигээс хаана байсан ч сэтгэлээ түүний тухай зориулсаар. Наран хэмээх усан эм хонин жил буюу 1883 онд дуган бүтээж аравнай үйлдэн баясгалангийн нээлтийн хуримыг төгс төгөлдөр болговой. Энэ жил мэргэд хийгээд бүтээлийн эрх баялаг болсон Жамгонренбүчи буюу Далай ламтнаас яруу алдрыг нь соёрхон сонсож их баясал төрүүлсэн дор Эбамсүнжиглэн хэмээх нэр хайрлаж шүтэн барилдлагын үүдийг нээн таалсан буй. Энэ үед Цогчин жасын хөрөнгөөс Цагийн хүрдний номлол буюу Дүйнхорын том зурмал Бурхан бүтээлгэн барьсан бөгөөд Ловонренбүчигийн дацангийн лам нарт өглөгийн эзэн болж лагшин зарлиг тааллын шүтээн буюу Гүсэнтүг, Бурхан багш гуулин, Богд лам хоёр шавьтайгаа хамт, өндөр гэгээний дүрд, гурван цагийн Бурхан буюу Дүйсүмсанжэй, Дүйнхорын Бурханы хөрөг таван тохой, Очирвааний хөрөг тохой хагас, Дамдинсандав Бурханы хөрөг нэг тохой, Гонгор болон Дамдинчойжил тэргүүтний хөрөг Бурхан, Бурхан багш, Майдар, Ногоон дарь эх, Цагаан дарь эхийн зурмал хөрөг Бурхан, Шагж төв Мандал, Жанрайсаг, Намсрай тэргүүтний алтан дүрт шармал бурхад, Сайн цагийн мянган Бурхан, Ламанчодовын чогшин буюу багш нарын дамжлага сэлтийн Танг Бурхан, Найданжүдэг Бурхан, Сандүй, Дэмчиг, Жигжид, Одвогмэд, Цэнд-Аюуш, Жүгдэрнамжил, Цагаан дарь эх, Рэгсүнгомбо Бурхан, мөн Жи ламын дүрүүд, өндөр Богдын дүрүүд, Шамбалын хорин таван хаад, бардам Барайбүн суварга, Дүйнхор, Доржшүг, Дамдинсандүв, Гончойлхасүм, Намсрай, Жамсрай тэргүүтний Бурхад өмнө зүгт байдаг Рэгзан уулын зураг, Шамбалын зураг тэргүүтний модон дээр сийлэн хийсэн ба Жадонба, Доржзодов, Алтан, Таравчинбу, Цанбум, Сундуй, Гүна, Ламрим, Лондол ламын сүмбум ёнзого, Дэлчиндэмид од болон түүний дэлбэ,

Дүйжиднямбуу, Дүйдэн Дүйнхорын чог ёнзого, Дүйнхорын жидром, зогримын судар ёнзого, бодь суварга хийгээд алтадсан суврагууд, авралт Богд дээдсээс эрхэм тоён дор өргөсөн Намжил суварга, алтан тэргүүтэн олон ховор нандин шүтээнүүдтэй байхаас гадна Очир хонх тэргүүтэй Ёжид, Шүхэр Лавир тэргүүтэй чимэг, тахил цөгц тэргүүтэй тахилын хэрэглэл, хэнгэрэг сэлэм, дун тэргүүтэй хөгжим, хөгжмийн зэмсэг, Жавдан сэнтий тэргүүтэй лам нарын суудал, цөм бүрэн бүтээсэн болой.

Тэр үеэс эхлэн Их хүрээнээс Жамгүнренбүчигийн лагшин өлмийд Дүйнхор дацан, Дэчин галавын лам унзад Агваангомбо хэмээх бээр дахин дахин заларч Чогийг лам нарт мэргэшүүлэн Дүйнхорын бүтээлийн арга дэлгэрсээр Хайдавжийн гэгээнийг Жалчиг ном бээр даган мэргэшиж, лам нарт цээжлүүлэн Чог, Чаглин заан сургаж бүжиг болон тэгийн онол, хөгжим үлээх тэргүүтнийг заав, Жасрайдоржчан, Жамгүнренбүчи дөрөвдүгээр бээр шавь нарын хамт Чог, Чаглингийн ёсыг дамжуулан заан зохиосноор үл дийлдэх хэмээх гал эр нохой жил Дүлцэнгийн Жанхар буюу элсэн хот мандал дор шүтэн бүтээж жинсрэг буюу гал мандал өргөн лүйчов буюу лусад дүлцэн өргөвөй. Тэгээд Доржловон, Агваанцүлтэн хэмээх алдартнаас дуган тэр жилдээ үүсгэн Дүйнхорын шавь нарт өргөвөй.

Ингээд гучиад жилийн дотор Дүйнхорын номлол оргилдоо хүртэл дэлгэрсэн. Ялангуяа мич хэмээх гал эм үхэр жилийн наг сарын шинээр Дүлцэнгийн Жанхар буюу есөн хот мандалд шүтэж, ялж төгс нөхцөгсөн Цогт Цагийн хүрдний ван авшигийг авах урьдчилсан Ломоожинзон, Ломоодаган тэргүүтнийг сайтар хүртсэний эцэст ойш буюу нялхасын долоон ван тэргүүтэй, дээдийн дээдийн дөрөв тэргүүтэй, Доржловон, Дагвачинбу ван зэргийг эрэмбэ дарааллан төгс төгөлдөр хайрлажээ. Тэгээд лам хуврагнууд нунанд сууж зүг зүгийн шавь нартаа уг нь боловсрох хөрөнгийг нь сайтар бүрдүүлэн зохионо. Тэр үед өглөгийн эзэд бээр авшигийн Чогнуудыг ёсчлон бүтээхийн тухайд Их хүрээнд

очиж дээрхийн гэгээн Жавжийренбүчи бээр Лавран морилж олон түмэнд элдэв зай, балин, жанлав, адис түгээвэй. Түүний нэгэн ажай бээр Цагийн хүрдний номлолын увидас нэгэн бээр тусаж сонин гайхамшигт билэг дэмбэрэл дээр нийцсэн маш баясгалантай нэгэн үйл явдалтай соёрхсон. Түмэн хэмээх төмөр эр нохой жилийн тагар сарын Гавж Лувсан бээр айлтгаж судрын уламжлал, увидасын далайг эрхшээгч аграмба лам Доржчан, Минжүүрдорж гэгээний нигуураас Цогт Цагийн Хүрдний номлолын хураангуй үндэс Дэлчиндэмид од буюу хэргүй хэргийн их тайлбар хэмээх Будан гэгээний айлтсан номын тайлбар сэлт зэрэг төгс төгөлдөр Лүн ван авшиг тэргүүтнийг хоцроолгүй хайрлавай.

Хувь төгөлдөр шавь нар нь гүн нууц дээдийн номын аршааныг уун цэнгэж зарлигийн ач төгөлдөр дэлгэрэн хөгжвэй. Дацанд хурдаг номын зэрэг ануу жил бүхэн дарааллан алхсалгүй хаврын адаг сар буюу наг сарын шинэ дээр шинийн хоёрноос эхлэн Сагар Чогор, Сачиг Дүлцэнтэй, ёнзого Дүйнхор хурж жинсрэгэ зотгон лусаан тахидаг. Монголын аравдугаар сарын шинийн гуравнаас Сандүйн Чог, Дүлцэн Жанхартай ёнзого хурдаг байв. Шинийн арвандөрвөнд Ловонренбүчи Дүйчод хурдаг ба Ванчин Дүйнхорын Чог уншдаг байв гэх мэт нарийн түүх үүхийн холбогдолтой зүйлийг Заваа лам маань айлтгаснаас гадна Дүйнхор дацангийн дэглэм ямар байсны талаар дэлгэрэнгүй бичиж өвлүүлэн үлдээсэн байдаг. Нэг жишээ хэлэхэд: Дүйнхорын номоор Дамжаа барьж Дүйрэм цол олгодог байсан талаар дэлгэрэнгүй бичиж өөрийнхөө Сүнбүмгийн тавдугаар ботьд Дамжааны талаарх ёсыг дэлгэрэнгүй бичсэнээс гадна Дамжаа барих ном таажидыг нэгд нэгэнгүйгээр бичсэн байдаг.

АЧИТ БАГШ НАРЫНХАА НАМТАРЫГ ДУРЬДВААС

УРАН ЛАМ Д.ДАНЗАН БАГШ (1916-2005)

Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошуу, одоогийн Булган аймгийн Орхон сумын нутагт Хайлаастын гол хэмээх газар 1916 онд мэндэлжээ. Дугаржавын Данзан нь 1921 онд Вангийн Өргөө гэж алдаршсан Булганы хүрээнд лам хувраг болж ах лам Балданцэрэн гавжаар ном заалгажээ. 9 настайдаа Чойрын дацанд сууж гүн ухааны ном заалгахын зэрэгцээ вангийн хүрээний гавж Дашжамцаар цам бүжгийн онолыг заалгасан байна. Мөн вангийн хүрээний бурханч лам Нямд шавь орж Ядам бурхадын амирлангуй, хилэнт дүрийг бүтээж тиг болон баримал, шуумал зэрэг төрлүүдийг заалгаж суралцжээ.



Анх вангийн өргөөнд сууж байх үедээ Гачой лам гэж алдаршсан Дамба аграмбаас гэцэл сахил хүртжээ. 1934 онд Домын дамжаа барьж 1933 онд Их хүрээнд Дүйнхорын аймагт аймаглан Гүн ухааны ном үзэхийн зэрэгцээ цамд гарах, дүлцэн жинхор, балин дором хийдэг байв. 1939 онд цэргийн албыг 5 жил хаажээ. 1944 онд Улаанбаатар хотод зураг урлалын газар ажилд орж Сүхбаатар, Чойбалсан нарын хөшөөг бүтээлцжээ. 1948 онд Гандантэгчэнлин хийдэд орж тахилч, бичээч, гэсгүй, даамал, захиргааны орлогч дарга, Шашны дээд сургууийн багшаар ажиллаж байв. Гандантэгчэнлин хийдийн хоёр цагаан суварга, Гандан хийдийн хоёр давхар байшингийн доторх хээ хуар, зүмбэр чимэглэлийг хийжээ.

1976 онд Буриадын Иволгийн дацанд 6 метр өндөр Найданжүдүгийг цаасан шуумлаар бүтээжээ. Шашны их сургуулийн барилгын зураг төсөл, Дүйнхор дацангийн зураг төслүүдийг хийсэн байна. Шашны их сургуулийн талбайд байх 12 жил, дөрвөн хүчтэнг бүтээсэн. Хүрээ цамыг шинэ цагт дахин сэргээж Дүйнхор Бурханы хот мандалыг бүтээх ажлыг удирдан хийлгэжээ. 1990-д оны эхээр Монгол улсын урлагийн гавъяат зүтгэлтэн цолоор шагнагджээ. 2005 онд таалал төгсчээ.

Багш маань бидэнд Дүйнхорын номын эхлэлийг нь зааж сургасан ачит буянтан бөгөөд манай Дүйнхор дацанг байгуулах үйлсэд чухал хүчин зүтгэсэн түүчээний хүмүүсийн нэг байсан.


ЦОГТ ЗАНДАН ЦОРЖ **(Хамгийн сүүлийн дүйнхорын очир ловон)**

1937 оны Ёнзон хамбын хавтаст хэрэгт байгаа байцаалтаас үзэхэд "Цогт Зандан нь Улаанбаатар хотын харъяат нас 64" гэж мэдүүлсэн байдаг. Үүнээс үзэхэд Цогт Зандан нь бага наснаасаа Их хүрээнд шавилан сууж байжээ. Их хүрээний Дандарлингийн аймагт сууж байгаад VIII Богдын үед Дэчингалавын тэргүүн лам болж байснаа 1930-аад оны үед Хүрээний долоон Цоржийн нэгээр томилогдож байжээ. 1930-аад оны дундуур Их хүрээнд олон лам хувраг шавь нартаа гурван сарын турш Ганжуурын лүнг хайрлаж байсныг түүний шавь Гандан хийдийн лам нарын дунд Өндөр багш гэж алдаршсан хамба лам Дамдинсүрэн айлдаж байсан. 1937 онд Ёнзон хамбын хэрэг гэгчид хэлмэгдэн хороогджээ.



МИНИЙ АЧИТ БАГШ АГВААНЖАМЦ (Хорин жил хамт амьдарсан Түвд багш маань)

Багш маань 1931 оны 5-р сарын 15, одоогийн БНХАУ-ын Түвдийн өөртөө засах орон нийслэл Хас хотын ойролцоо Дашпунцагийн ууган хөвүүн болон нарт хорвоод мэндэлсэн байдаг. улмаар гурван настайдаа дээрхийн гэгээнтэн Далай ламын Намжираа дацанд элсэн орж бүхий л насаараа бурхан шашны үйлийг чин үнэнчээр үүрэглэн авч, дэлэнгийн сахил санаваарыг



өчүүхэн ч доройтуулалгүй чин ариунаар сахин хамгаалж чадсан нэгэн билээ. Бага наснаасаа өнчрөл хагацлыг үзэж, хэдэн дүү нараа асарч хүмүүжүүлэн хүний зэрэгт хүргэсэн байдаг.

1959 онд дээрхийн гэгээнтэн Далай лам Данзанжамц цагийн байдлаас шалтгаалан Энэтхэг улсад түрвэн гарахад хамт даган явсан 25 хүний нэг байсан гэдэг. Дацангийн бүхий л ажлыг хийхийн хажуугаар Энэтхэгт газар шорооны ажил, мал тэжээх, тариа тарих зэрэг дацангийн аль хэцүү ажилд идэвхитэй оролцож дацангийн хайр хишгийг хүртэж, дацан гэсгүй, тахилч, дуганч, унзад, ловон, гарван зэрэг ажлыг хийсээр иржээ. 1990 онд дээрхийн гэгээнтэн Далай багш Монгол морилон саатах үед Монголын Бурханы шашинтны төлөөллөөс Дүйнхорын дацанг байгуулах саналыг дэвшүүлэхэд уриалгахнаар хүлээн авч өөрийн дацандаа Монгол лам нарыг сурган заахаас гадна, нааш нь Монгол руу дөрвөн Түвд лам явуулсны нэг нь багш маань билээ. Монголд Дүйнхор дацан байгуулахад бүхий л чадлаараа чармайн ажиллаж Дүйнхор дацаныг хөл дээр нь бүрэн гүйцэд

зогсооход чухал байр суурь эзлэх гавъяатай хүн гэж би боддог. Миний багш бөгөөд хамгийн дотны зөвлөх минь байсаар ирсэн билээ. Би Монгол улсын иргэн болгож хажууд байлгасаар 19 жилийн нүүрийг үзэж ааваас минь өөрцгүй түшиг тулгуураасаа энэ жил хагацсан билээ. Багшийн маань гавъяаг олон хүмүүс үнэлж байдаг билээ.

Ум сайн амгалан болтугай.

ЧОЙНЗИН ЦОРЖ

(Миний багш (Донжиладүцанамид) Агваанлодой гэж номт эрдэмтэн хүн байсан түүний багш Богдын долоон цоржийн нэг Чойнзин цорж)

Сэцэн хан аймгийн нутагт байсан Их шавийн отог болох Хэрээ хөхөлийн отгийн нутагт мэндэлжээ. Энэ нь одоогийн Хэнтийн аймгийн Баянмөнх сумын нутаг юм. Бага наснаасаа Их хүрээнд ирж Эрдэнэ хувилгааны аймагт аймгалдаг байв. Их хүрээний Дашчойнпэл дацан, Жүд дацанд гавж, аграмба цолыг удаа дараалан хамгаалжээ. Их хүрээнд байхдаа төвд хлээр гурван боть зохиол бичжээ.



1908 онд VIII Богд Гунгаачойлин дацанд гавжийн дамжаа барихад Чойнзин цорж нь VIII Богдын долоон цоржийн нэг байв. Түүний гол номын багш нь Луу гүний хошууны Чойжил гавж юм. Дайчин бэйсийн хошууны Тэгшийн хийдэд залагдаж, Дүйнхорын ван айлдсан гэдэг. 1937 онд Ёнзон хамбын хилс хэрэгт холбогдон хороогджээ.

МИНИЙ БАГШ ЦЭВЭГМИД УНЗАД

Ачит багш Дарийн Цэвэгмидийн зухас дурдах нь зүйтэй болов уу: Одоогийн Төв аймгийн бүрэн сумын бэрх гэдэг газар Дарийн бага хөвүүн болон 1909 онд мэндэлжээ. Улмаар бага насаа ээж аавын гар дээр өнгөрөөж, таван насандаа төхөмийн хийдэд ах лам Даваа гэлэнгийн хамтаар шавилан сууж харанга магтаал сахиус уншлага заалгаж эхлэв. Дунд худагийн багшаар ян дан заалгаж их янч болох гараагаа эхлэжээ. Түүний дараагаар хүрээнд суралцахаар суурьшив.



Хүрээ 30 аймгийн цэцэн тойны аймагт харъяалагдан чойрийн номонд зуугийн багшаараа заалган суралцав. Улмаар Раднаа шунлайв багштайгаа хамт нэг гарт олон жил амьдарч байжээ. Нэгэн удаа багш нь мэргэ төлөгний ном бариад үзэж байхыг нь хараад чамд энэ ном зохимжгүй чи уншлагаа л оролдож суу гэж захисан гэдэг Тэгээд Хөвсгөлийн багшаараа нэр заалгаж байгаад 1967 онд Ганданд орж зам хийж байв. Диваасамбуу цоржийн хэлснээр: Манай Гандангийн гол зууханд байдаг нэг шар өвгөн гэнэт нэг өдөр лам хувцастай болсныг хараад шоолонгүй харж суутал гэнэт гэсгүй бэрээ тогшон Цэвэгмид госоогоороо суу хэмээн цогломдоход унзадын доор суусанд арын хаалганы Раднаа шунхлайвийн шавь гэж байлаа. Гэтэл их манал цээжээр уншиж хангалын ян данд сайн болохыг нь мэдээд уучлал гуйж билээ. Ц.Отгонбаяр миний бие 1983 онд лам болж анх Цэвэгмид унзад жигдэн гиргантайгаа танилцсан билээ. Би оюутан байхдаа голд сууж, сургууль төгсөөд шууд голч болж дараа нь 1970 оноос

хойш сургууль төгссөн залуу лам нараас анх удаа унзад болж байса нь Цэвэгмид унзадын гавъяа гэж боддог. Унзад гуай маань даруу зангийн туйл эрдэмийн далай зууны манлай унзад байжээ. Энд тэндээс хуран цугласан олон лам нарыг нэг ая дантай болгоаж чадсан гавъяатай. Одоо Ганданд уншигдаж буй бүх чого номын гором ян дангууд Цэвэгмид унзадын дэгээр цэгцэрч эмхлэгдэж байгааг хэлэхэд бахтай байна. Би 100 насных нь ойд зориулж Цэгмээгийн хэрэглэж байсан 43 хуудас гар бичмэл арван хангалын ая дангийн дэвтэр горим хэмээх судрыг 2005 онд хэвлүүлэн нийтийн хүртээл болгон хуралд зэдэлсэн билээ. Хойшид дурсгалыг хүндэтгэн ном гаргаж, нутагт нь суварга босгохоор зэхэж байна. За үүгээр багш лам нартаа тахил өргөх үгээ түр өндөрлөө.

УНЗАД ЦЭВЭГМИД БАГШИЙН МААНЬ БАГШ РАДНААШУНЛАЙВ

Раднаа Шунлайв нь Түшээт хан аймгийн Далай гүний хошуу, одоогийн Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын нутагт мэндэлжээ. Бага наснаасаа Их хүрээний Амдо нарын аймагт сууж, Дашчойнпэл дацанд буддын гүн ухаан судлан гавж,



аграмба цолыг дараалан хамгаалжээ. 1910 онд байгуулагдсан Идгаачойнзингийн дацангийн Шунлайв ламаар томилогдон очжээ. Номч мэргэн гавж Гомбожав Их хүрээнд Буддын гүн ухаанд суралцаж байхдаа Раднаа шунхлайвыг шүтэж байв.

Раднаашунлайв нь 1961 онд таалал төгсчээ. Раднаа шунлайвын шавь нараас хамгийн алдартай нь Гандан хийдийн хамба лам агсан номч мэргэн гавж С.Гомбожав байв.

НАМЖИРАА ДАЦАНГИЙН КАНСУР ЖАДО РЕНБҮЧИ ТЭРГҮҮНИЙ МИНИЙ НОМЫН МЯЛААЛГА ЕРӨӨЛИЙН ҮГ

Анхны бурхан галзагда

Ялж төгс нөгчигсэн цогт
Галзагда Бурханы
дамжлага нь шагжаа
язгуурт Бурхан багш бээр
тас цогцолсон ууланд
билиг бармидийн зарлигаа
хайрлаж байх тэр цагт
нэгэн зэрэг ирт
хувилгааны хүчээр өмнөд
Энэтхэгийн Балдан
брэйвун хэмээх их
суварганы дэргэд судар
гарнийн дамжлага бүгдийн



туйлын үзүүрт хүрээд ч зогсохгүй, хутагт мунзуширийн алдрыг өгүүлэх утга бүгдийг эцэслэн оршоогоод гадаад, дотоод бусад гуравын үүднээс дамжлагын утга бүгдийг эцэс дор нотлон буулгасан нь энэ үеийн зурхайн ухаан хийгээд илт орчилонгийн (шинжлэх ухаан) ухааны ишлэл лугаа таараад ч үл барам, сэтгэлийн орчилонгийн (дотоод ухаан) ухааны энэ үе хийгээд эцэс хойд суурь, зам, үр дүн гурвыг агуу их бээр үйлдэж, дамжлагын утгын ёс заншлыг анхааран авч үйлдсэний хүчээр, ертөнцийн буурал бүгдийг арилгах ач туст давалгаан магад гарах энэ ямагтыг Монгол хувраг Отгонбаяр маань олон жил урт хугацаанд цагийн хүрдний номлолын ёс заншилыг Монголын Бурхан шашинтны төв Гандан хийд, түүний Дүйнхор дацан, хутагтын орон Энэтхэг буй Дээрхийн гэгээнтэн Далай ламын Намжираа дацанд үнэн сэтгээлээсээ дээрх номлолын чого чаглинд суралцаж эрдмийг олсон нэгэн билээ. Түүнийгээ цааш

нь задалж өнөөг хүртэл суралцаж өөртөө байгаа эрдмийг өргөн түмэндээ бүтээл болгон барьж буй энэхүү буянд өөрийн сэтгэлээр даган баясахын ялдамд тус эрдэнэ дэлгэрч үйлс бүтэхийн ерөөлийг дамжуулья.

Намжираа дацангийн кансур Жадо Ренбүчи
2009.03.27



ནམ་རྒྱལ་མཁན་ཟུར་བྱ་དོན་གྱི་སྐུ་ལྔ་

Jhado Tulku Rinpoche

(Abbot Emeritus of Namgyal Tantric College)

Date:

མཚོག་གི་དང་ལོ་ལོ་ལོ་ལོ་ལོ་

། འཛོམས་ལྡན་འདས་དཔལ་དུས་ཀྱི་འཁོར་ལོའི་རྒྱུད་འདི་ནི་ཐུབ་པ་མངས་རྒྱས་བཅོམ་ལྡན་འདས་ཀྱིས་གནས་བྱོན་དུང་པོའི་རིར་ཡུམ་ཤེས་རབ་ཀྱི་ཡོན་ཏན་གྱི་ལྷན་པ་གསུངས་པ་དང་དུས་མཉམ་དུ། རྒྱ་གར་རྩོམ་སྤྲོད་པ་དཔལ་ལྡན་འབྲས་སྤུངས་ཀྱི་མཚོད་རྟེན་ཆེན་པོར་གསུངས་པའི་མདོ་རྒྱུད་ཀྱི་རབ་དང་ལུལ་དང་ཅེ་མོར་གྱུར་པ་མ་ཟད། ལྷ་འབྲུལ་དུ་བའི་རྒྱུད་འཕགས་པ་འཇམ་དཔལ་མཚན་བཞི་དཀྱི་བཞི་དོན་མཐར་ཐུག་ཏུ་གནས་ཤིང་། རྩེ་ནང་གཞན་གསུམ་གྱི་སློབ་ཆ་རྒྱུད་དོན་མཐའ་དག་གཏན་ལ་འབེབས་ཤིང་། དེར་དུས་ཀྱི་སྐར་ཅིས་རིག་པ་དང་། དངོས་ཁམས་རིག་པའི་གཞུང་དང་མཉམ་བཤོད་ཐུབ་པ་མ་ཟད། སེམས་ཁམས་རིག་པའི་གནས་སྐབས་མཐར་ཐུག་གི་གཞི་ལམ་འབྲས་གསུམ་རྒྱ་ཆེར་བཞེད་བྱ་བྱེད་ཅིང་། རྒྱུད་དོན་གྱི་ཚོག་དང་ཉམས་ལེན་བྱས་པའི་མཐུ་ལས། འཛིག་རྟེན་གྱི་རྒྱུད་པ་སེལ་བ་ལའང་ཕན་རྒྱུས་ངེས་ཅན་ཡོད་པ་འདི་ཉིད་སོག་པོ་ཨོཾ་ཧྲི་ལྷོ་ཨིར་ལགས་ནས། ལོ་མང་རིང་དུས་འཁོར་གྱི་ཚོག་ལུག་ལེན་དང་། གར་ཐིག་གཞུང་དོན་བཅས་ལ་ཐུགས་སྐྱེད་ཆེན་པོའི་ཐོག་ནས་སོག་ཡུལ་དགའ་ལྡན་ཐིག་ཆེན་གྱི་དུས་འཁོར་གྱི་ཚོད་དང་། རྒྱ་གར་འཕགས་ཡུལ་དུ་སྤྱི་བཅར་ནས་རྒྱལ་གྱི་ཚོད་བཅས་ལ་སློབ་སྦྱོང་ལེགས་པར་གནང་། རང་གིས་མཐུན་རྐྱེན་གྱི་ཡོན་ཏན་རྣམས་འབྲུང་འགྱུར་མི་རབས་གསར་པར་ལེགས་སྐྱེས་སུ་ཡིག་འཛོག་དཔེ་དེ་བགས་རྒྱན་གནང་བ་འདི་ལ་ཇེས་སུ་ཡི་རང་དང་། ཕན་ཐོགས་ཆེན་པོ་ཡོད་པའི་རེ་སློན་བཅས། རྣམ་གྱི་མཁན་ཟུར་བྱ་དོན་གྱི་ལ་མིང་ནས་ལྷོ་ཆེས་



2009. 3. 27

Ц.ОТГОНБАЯРЫН ДОКТОРЫН ДИСЕРТАЦИЙН АЖЛААС ОРУУЛБАЛ:

ЕРӨНХИЙ АГУУЛГА

Судлах болсон учир холбогдол: XIV Далай лам Данзанжамц бээр Монголын ард түмэнд хандаж хэлсэн айлдвартаа Эзэн Чингис богд эр морь, эрэмгий зориг, эрдэм ухаанаар жигүүрлэн дэлхийн талыг эзлэж монгол орныг дэлхийн дэвшил хөгжлийн төв болгосныг хүмүүн төрөлхтөн мэддэг билээ. Тэгүүн лугаа адил Оюун ухаанаараа жигүүрлэн уламжлалт шашин соёлоо сүслэн дээдэлж, хөгжүүлснээр орчлон ертөнцийн холбоо тогтцыг олох их нээлт хийх хувь тавилангийн, үр хөрөнгө та бүхэнд бий хэмээн цохон айлдсан. Энэхүү сургаалийг Намжараа дацангийн кансүр Жадо Ренбучи тайлбарлахдаа: Танай өвөг дээдэс болох монголчууд [хоржийн юл] Мэө III зууны Жужан, Кидан, Хүннү гүрний үеээс бурханы шашныг уламжлан дээдэлж ирсэн номт гурван орны нэг бөгөөд өнөөг хүртэл Бурханы шашнаас татгалзаагүй буянт орон учир Дээдийн номын хураар шимлэгдсэн үржилт хөрстэй тул эзэн нь хичээвэл заяа нь биелэх түмэн юм. Энэтхэгийн Бихар мужийнхан бурханы шашнаас ихэнх нь татгалзсаны үйлийн үрээр Энэтхэг орны 25 сая орон гэргүй гуйлагчингийн олонхи нь энэ мужид амьдардаг ч байж магадгүй гээд улаан хувьсгалын үед монголчууд хэлмэгдсэн ч гэсэн язгуурын үндэс угсаа болох шашнаасаа татгалзалгүй, сэтгэлдээ тээсээр ирсэн нь Монголд Далай багшийг удаа дараа морилох үеээр сүсэгтэн олны цугларалтаар тод илэрдэг хэмээн бахархаж тайлбарладаг. Иймээс дээрхи хоёр их багш нарын айлдвар монгол түмнийг бурханы шашин дэлгэрэх багчаг авъяас ойрхон буйг хэлж байна. Дээрхийн гэгээнтэн Далай багш 1954-оноос одоог хүртэл 30н удаагийн цагийн хүрдний авшгаар олон сая

хүмүүст дүйнхорын ван хүртээж, Калачакрагийн онолыг өрнөдийн хөгжингүй орнуудад өргөн цар хүрээгээр түгээж, Дэлхийн Их найман орны олонхи төрийн тэргүүнүүдтэй албан бусаар бараалхаж уулздаг, АНУ-ын конгресийн алтан одонт, Нобелийн шагналт Дээрхийн гэгээнтэн 14-р Далай лам Данзанжамц багштаных алдарын оргилд хүргэсэн хүчин зүйлийн нэг бол Цагийн хүрдний номлол юм. Тэгэхлээр Далай ламын айлдаж буй Цагийн хүрдний номлолыг судалж үржил шимт монгол түмний оюуны хөрсөнд¹, уг номлолын охь үрийг тарьж, ургуулсан цэцгийн анхилам үнэрт ухаан бодлоо ариусгахыг бэлгэдэн, горилогч энэхүү сэдвийг нийтийн хүртээл болгохын тухайд судлах болсон ба 1983 оноос эхлэн уламжлалт сургалтын дагуу дүйнхор дагжид (цагийн хүрдний тэнгэрүүдийг өөрийн биед байрлуулах бясалгал) цээжлэн эхэлж улмаар Энэтхэг улсын Химачал мужийн (Прадеш) Дарамсала дахь Намжараа дацанд 1991-1995 онуудад мэргэжил дээшлүүлэн суралцан зохих түвшингийн өчүүхэн төдий мэдлэг хуримтлуулснаа ачит багш нарын алтан сургаалийг анхааран авсны тус эрдмээр боловсруулсан нь уг судалгаа хийхэд дөхөмтэй болсон гэж ойлгодог. Энэ сэдэв нь монголчуудад шинэ зүйл огт биш. Үе үеийн эрдэмтэн багш /Дүйнхорва/ нар судлан баяжуулсаар иржээ. (Уг диссертацийн судлагдсан байдал хэмээх хэсгээс монгол лам нарын зохиол бүтээлийн тоймыг 1937 оноос өмнөх бүтээлийг дэлгэрэнгүй үзэж болгооно уу). Уламжлалт монголын цагийн хүрдний номлолын гол төлөөлөгч болох Зава лам Лувсан даяан 1937 онд таалал төгсөж, Угалзын лам Лувсанжамц 1934 онд дүйнхорын ван айлдсан хэмээн улс төрийн хэргээр баривчлагдсан ороо бусгаа цагийн байдлаас шалтгаалан 1990 он хүртэл дорвитой бүтээлүүд гараагүй боловч ард түмэн сэтгэлдээ тээсээр, орчлон ертөнцийн жам ёсыг судлан, одон

Их хүрээний Дүйрамбын дамжааны ёс жаягын талаар Зава ламын "га" боть дотор гавжийн дамжаа, маарамвын дамжаа, зээрэмбийн дамжаа, дүйрэмбийн дамжаа зэргийг ангилан тодорхой үзүүлсэн байдаг. "га боть 599 --610хуудас"

зурхайгаа гаргаж ажил үйлсээ тохируулсаар, нууцаар Дүйнхор бурханаа шүтсээр ирсэн билээ.

Үүний нэг жишээ нь их зохиолч Д.Нацагдорж: "Од" хэмээх шүлэгтээ

Холхи газраас гялалзан харагдах өнгөт Од оо
Хязгааргүй огторгуй дунд зугаалах олон улаан Оч оо
Нарт ертөнцийг толидон суугаа марс Од оо
Манай хүн төрөлхтөн чамтай танилцахыг хэдийнээс хүсэв

хэмээн Гадаад цагийн хүрдний номлолын утгыг харуулснаас гадна, Гадаад орчлонтойгоо сэтгэлийн хүчээр холбогдож болох дотоод энергийн боломжийг Дотоод цагийн хүрдний агуулга лугаа дүйхээр илэрхийлж ард олны хүсэл эрмэлзлэлийг яруу дүрслэлээр гаргажээ. Ерөөсөө монголчууд одод гарагийн тохиол учралыг танин мэдэж үр удамдаа үлдээж, өвлүүлэж ирсэн баялаг оюуны өвтэй улс орон юм. Жишээ нь Бямба гарагт орсон хур дараагийн бямба гараг хүртэл үргэлжилдэг нь бараг батлагддаг учир манайхан бямба гарагт эд гаргах, нүүдэл хийх, ажил эхлэх зэрэг үйлийг тэвчдэг учир нь тухайн үйл сунжирдаг гэж үздэг. Энэ мэт нүүдэлчин монголчуудын уламжлалт заншил, зан үйлийг Бурхан багшийн цагийн хүрдний онолоор хослон тайлбарлахын эхний шат суурь тавихын тухайд энэхүү сэдвийг судлах болсон билээ.

Судлагдсан байдал: Бурхан багшаас уламжлалтай цагийн хүрдний номлолоор Энэтхэг, Төвд, Монголын үе үеийн эрдэмтэн лам нар зохиол бүтээлээ туурвиж ирсэн ба тэдний зохиол бүтээл энэхүү судалгааны гол эш үндэс болсон. Барууны ертөнцийн хувьд Н.К.Рерих, А.Берзин тэргүүтэй эрдэмтэд цагийн хүрдний номлолоор судалгаа, зохиол бүтээл хийж, дэлхийн олон нийтэд танилцуулах ажлыг эхлүүлсэн. ОХУ-ын судлаач Н.К.Рерих 1874 онд Петербургт төрсөн, түүний хүү Юрий Николаевич Рерих

1900-1960 он Шамбалыг олох гэж олон удаагийн экспедиц зохион байгуулж тодорхой үр дүнд хүрсэн ба Төвд–Орос хамгийн анхны толь бичиг гаргасан.

Хорьдугаар зууны дунд үеээс Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам Намжираа дацангийн Кансүр Жадо Ренбүчи зэрэг эрдэм номтой лам нар цагийн хүрдний авшиг хүртээж, сургааль явуулах зэргээр энэ номлолыг дэлхий нийтэд сурталчилж байна. Мөн Төвдийн ба барууны эрдэмтэдийн нэлээд тооны зохиол бүтээл гараад байгаа.

АНУ-ын судлаач Александр Берзин Дарамсалаад 29 жил амьдарсан. Далай багшийн хүсэлтээр Төвд гэвш нартай хамтран Дүйнхор судалж Англи хэл дээр олон ном зохиосны дотор “Дүйнхорын Ван хүртээх” гэсэн ном гаргасан. Тэр ном монгол хэл дээр хэвлэгдэж олны хүртээл болсон байдаг.

Монгол дахь шинэ үеийн (1937-2009) судалгааны хувьд сүүлийн жилүүдэд Б.Батсанаагийн цуврал “Шамбалд зорчсон нууц тэмдэглэл” орчуулгын номууд хэвлэгдэн гараад байгаа. Мөн 1990 оноос нэрт эрдэмтэн доктор Л.Тэрбиш цагийн хүрдний номлолын одон зурлагаар, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалснаас гадна жил бүр цагийн хүрдний номлолын дагуу Монгол зурхайн аргаар “Цаглабар” зохион нийтийн хүртээл болгож, хэд хэдэн томоохон бүтээл гарсан. Уг номлолоор томоохон судалгаа хийгдээгүй болно.

Судалгааны зорилго, зорилт: Цагийн хүрдний номлолын дахь Монголын судлаачдын өвөрмөц онцлогийг нээн, шинжлэх ухааны эргэлтэнд оруулж нийтийн хүртээл болгоход энэхүү судалгааны зорилго оршино.

Монгол өвөг дээдсээс уламжлагдан ирсэн цагийн хүрдний номлолыг Энэтхэг, Төвд гадаадын эрдэмтдээс өвөрмөц ялгаатай судлаачид байсныг тогтоохын зэрэгцээ монголчуудад

уламжлагдан ирсэн ахуй зан үйлээ зохицуулах, ёс журам болсон зурхай ухаан нь цаанаа цагийн хүрдний номлолоос улбаатай бөгөөд тус номлолын бэлгэдэл арван үсэгт тэмдэг нь Дүйнхор Бурхан болон түүний хот мандлыг хэрхэн төлөөлдөг тухай, Хот мандал нь дүйнхор Бурханы лагшин, зарлиг тааллын эрдмийг илэрхийлдэг учир холбогдол, цаашилбал орчлон ертөнцийн тогтцыг Дүйнхорын номлолоор тайлбарлах, уг номлолд орох эрх, ван авшиг, тус эрдмийн талаар ерөнхий ойлголтыг энгийн жишээгээр, зурган хэлбэрээр энгийн хүмүүст ойлгогдохоор тайлбарлахыг зорилтоо болгосон юм.

Судалгааны арга зүй: Орчин үеийн шашин судлалд шашны зан үйл бэлгэдлийг бүхэл бүтэн систем гэж үзэх хандлага давамгайлах болсон. АНУ-ын эрдэмтэн Т.Парсон "Нийгмийн нийтлэг онол асуудлууд" хэмээх номондоо хүмүүсийн үйл ажиллагаа бэлгэдлийн шинжтэй төсөөллүүдийн тусламжтайгаар зохион байгуулагддаг ба хүний үйл ажиллагааны систем нь шашин ёс суртахууны ойлголт, ухагдахууны талуудыг өөртөө багтаасан тусгай зарчмаар явагддаг хэмээжээ. Мөн эрдэмтэн, Э.Дюркгейм "Шашны амьдралын элементар хэлбэрүүд" хэмээх номондоо Шашны зан үйл мөргөл шүтээн нь зарим тохиолдолд хачирхалтай мэт санагдах боловч түүнийг бэлгэдэл гэж үзээд, түүний цаана мөн чанар нь оршино гэсэн бол, эрдэмтэн Л.Фейербах бээр хүний танин мэдэхүйн тэмүүлэл нь орчлон ертөнцөд болж буй бодит байдлын бүхий л харилцаа хүнд төвлөрч, хүнээр дамжин ухамсарлагдаж байдаг тул байгалийн мөн чанарыг таних түлхүүр нь хүн гэсэн дээрхи санаануудыг дэмжин судалгааныхаа арга зүйг болгосон. Мөн Төвд, Англи, Орос хэл дээрхи ном судруудыг сурвалж судлалын аргаар судалсны зэрэгцээ Өмнөд Энэтхэгийн Амрапади хэмээх газар буй орон нутгийн судлах музейн үзмэр, эд өлгийн бусад зүйлийг газар дээр нь судалж бурхан багш бээр цагийн хүрдний номлолыг дээрхи газарт номлосон гэдгийг нотлохыг оролдсон

болно. (Дээрхи материалыг 1-р бүлгээс эд өлгийн дурсгалт зүйл болох зургийн хамт үзнэ үү) Мөн буддын судлалаар гадаад, дотоодод гаргасан зохиол бүтээлүүд энэ судалгаанд арга зүйн ач холбогдолтой.

Судалгааны гол эх сурвалж нь:

1. Төвд хэлээр бичсэн судар болон Англи, Орос хэлээр бичсэн, Энэтхэг, Төвд, Монгол, өрнөдийн эрдэмтдийн ном зохиолын эх сурвалж:

Төвдийн Будонренчиндүв, Богд лам Зонхава, Хайдавжи, Жалцавжи, Ванчин лам, Далай лам (V), Хайдавнорсонжамц болон Монголын эрдэмтэн Зая Лувсанпэрэнлэй, Дамба-Аграмба, Бэзьяагийн ламтан Агваандамдинсүрэн, Угалзын лам Лувсанжамц, Халх Барагрэй Дамцагдорж, Зава лам Лувсандаяан нарын зохиол бүтээл болно. Өрнөдийн судлаач А.Берзин, Н.К.Рерих тэргүүтэй эрдэмтэд, лам нарын зохиол бүтээл болон 1983 оноос одоог хүртэл цагийн хүрдний номлолыг энэтхэг, монгол багш нараараа заалгасан аман уламжлал нь тулгуур үндэс болсон.

2. Эд, өлгийн эх сурвалж: Судалгааны ажлыг баримтжуулахын тухайд өөрийн биеээр Энэтхэгийн Дели хотод буй Үндэсний музей, Өмнөд Энэтхэгийн Амрапади дахь орон нутаг судлах музей, Непал улс, Шриланка улс, Төвдийн лхас зэрэг газрууд дахь мэдээ баримттай танилцсан нь судалгааны бас нэг эх сурвалж болсон.

Судалгааны ажлын таамаглал: Орчин үеийн шинжлэх ухааны давшингуй хөгжлийг би хувь хүний хувьд хүлээн зөвшөөрдөг. Гэвч энэ нь төгс төгөлдөр зүйл огтхон ч биш. Яагаад гэвэл байгаль экологи болон хүний бие махбодь талдаа эерэг, сөрөг нөлөөтэй гэдгийг нөгөө л шинжлэх ухаан маань нотолсон байдаг. "Богд ламын Бодь мөрийн зэрэг" хэмээх номын Гурван төрөлхтөний аймгийн 9 учир шалтгааны бүлэгт цэвүүн цагт

амьтны амьдрахын шалтгаан хорогдож, үхлийн шалтгаан нэмэгдэнэ гэсэнчлэн онгоц машин гэх оньсон техникийн дэвшил буй болсон ч осол эндэгдэл нэмэгдсээр л байна. Осолд ордоггүй юмаа гэхэд оюун санаа нь мунхардаг. Нэгэн жишээ хэлбэл: Хараар амьдарч буй миний хамаатан Г.Дорж өндөр настан Людвик Франсуа хэмээх 98 настай хөгшнийг асардаг байна. (Франц улсын нийслэл Парис хотод)

Өндөр настан бээр 5 цул эрхтэн болон 5 сав махбодь өвдөх өвчингүй маш эрүүл, чийрэг нэгэн юм. Гэвч хоол идэхдээ нэг асрагчтай, бие засахдаа бас нэг асрагчтай, гадагшаа гарахдаа бие хамгаалагчтай, үзүүлдэг тусгай эмч сувилагч нартай, санхүү зохицуулдаг менежертэй, харахад нэгэн том вант улс шиг том бизнесмэн мэт боловч түүний сэтгэхүй 1-3 насны хүүхэдтэй адил адгууслаг тал нь ухамсар талаасаа давамгайлсан манайхаар бол зөнөг залгана гээч болсон нэгэн. Одоо болтол Парис хотноо амьдарсаар байдаг ба асрагч Доржийн хэлж буйгаар эмч нар болон эрдэмтэд түүнийг өндөр насны доройтол бус үсрэнгүй хөгжлийн өвчин гэж тодорхойлсон гэдэг. Иймээс материаллаг талын хөгжил дээд шатандаа хүрсэн ч гэлээ дээрхи өндөр настанд туслах эм бэлдмэл одоогоор гараагүй, гарах ч үгүй тул түүнд туслах төгс төгөлдөр арга байхгүй, иймээс өвдөх өвчингүй мөртлөө хэвийн бус амьдарсаар байна. Ухаанаа хөгжүүлэхгүй хэвшсэн тогтмол үйл хийсээр байгаад хашаатай хониныхоос ялгаагүй болзолт рефлексстэй болж ухамсраа алдаж чухамдаа хүн дүрстэй адгуус болжээ. Зүйрлэвэл хүн унтахдаа 5 цогцос хураагдаж зөвхөн дүйжид пунбу буюу хуран мэдэхүй цогцос гололдог учир бусад цогцос амардаг. Тэгэхлээр дээрх настаны 5н цогцос сааталд орсны шинж гэж үзэхээр байна. Бурханы шашинтны үзэл онолоор тэр тусмаа цагийн хүрдний номлолоор оюун ухаанлаг хэлбэрээр дамжин 5 цогцос (дүрст цогцос, мэдрэхүй цогцос, хуран мэдэхүй цогцос, хуран үйлдэхүй цогцос, тийн мэдэхүй цогцос) болох өөрийн биеэ нарийн мэдэрч бясалгаж удирдаж чадвал төгс төгөлдөр хөгжил хэмээн

номлосон байдаг. Үүнийг мэдэхийн тухайд 5 цогцсыг буй болгодог зарчим, эхийн хэвлийд гаднаас орох хийн байдалт цагийн хүрдний номлолын хэллэгээр "нума жү "хэмээх дүрсгүй сүлдлэг амьд организмыг судлах нь эрүүл ахуйд тустай гэсэн таамаглал дэвшүүлэн тавьж байна.

Судалгааны сорилго: Горилогч 1991-1995 онд Энэтхэг улсын Дарамсала дахь Дээрхийн Гэгээнтэн XIV Далай лам Данзанжамцын Дандарын номлолыг дэлгэрүүлэх Намжира Дацан, түүний "Тантрик коллеж"-д суралцан, Хайдавжи Гэгээний айлдсан цагийн хүрдний номлолын "Чого"-ын Дагжид Дүнжид Ван тэргүүтэй бүтээлийг нийт 1020 орчим цаас 16-тын барын судрыг цээжлэн тус коллежийн "Калачакра мастер" хэмээх зэрэг хүртсэн болно. Хангай дээд сургуульд "Монгол дахь Буддизм" гэдэг сэдвийн дагуу хичээл заахдаа цагийн хүрдний номлолыг анхан шатны түвшинд заан сургасан. Мөн Монголын бурхан шашинтны төв Гандан хийдийн Дүйнхор Дацангийн хуврагуудад зан үйлийн талаар багшилдаг. ОХУ-ын Буриадын Б.Ш Төв сургууль, Дашчойнхорлон институтын сар болгон гаргадаг "Лэгшад" хэмээх шинжлэх ухаан танин мэдэхүйн сэтгүүлд 3 хуудас цагийн хүрдний номлолын талаар өгүүлэл бичсэн болно. МУИС-ийн нийгмийн шинжлэх ухааны салбар Философи Шашин судлалын тэнхмийн хамтран гаргадаг сэтгүүлд 3.2 хэвлэлийн хуудас цагийн хүрдний номлолын талаар өгүүлэл нийтлүүлэхээр шилжүүлсэн. МУИС, Нийгмийн шинжлэх ухааны сургууль, Шашин судлалын тэнхмийн эрдэмтэн докторуудын тэнхмийн хэлэлцүүлгээр 2 удаа, тэнхмийн өргөтгөсөн хэлэлцүүлэг буюу урьдчилсан хамгаалалтаар уг сэдвээр хэлэлцүүлэгт орон дэмжигдсэн болно.

Судалгааны ажлын шинэлэг тал

- Монголдоо цагийн хүрдний номлолын судалгааны талаар 1937 оноос хойш анхан шатны асуудлуудыг дэвшүүлэн тавьж буй анхдагч хүмүүсийн тоонд хамрагдаж байна.

- Гадаадын эрдэмтдийн Төвд, Англи, Орос хэл дээрхи материал эд өлгийн дурсгалт зүйлийг хослуулан судалж дүгнэлт гаргаж байгаа нь миний судалгааны өвөрмөц онцлог.
- Орчин үеийн компьютер технологийг ашиглан дэлхийн үүсэл цагийн хүрдний номлолоор ертөнцийн тогтоцыг VCD хэлбэрээр дүрсжүүлж хүмүүст ойлгоход дөхөм болгон 15 орчим минутын дүрсжүүлсэн кино хийсэн.
- Авидарма (Илт өгүүлэгчийн номлол) болон цагийн хүрдний номлолын зарим үзэл, онолын зөрүүтэй талыг харьцуулан бичсэн болой.
- Мөн гадаад цагийн хүрдний номлолтой дүйцүүлэн" Катарина салхи, "Цунами" усан галав, Газар хөдлөлт, Галын аюул хэмээх 4-н махбодиор хямрах ертөнц дэлхийн авир раншинг, Дотоод цагийн хүрдний номлолтой дүйцүүлэн хүний биеийн чакраны системийг харьцуулсахыг оролцсоныг судалгааны шинэлэг тал гэж үзэж байна. (дээрхи Цагийн хүрдний дотоод,гадаад номлолтой харьцуулсан харьцуулалт нь орчин үеийн шинжлэх ухаан хүлээн зөвшөөрсөн зүйл болно.)

Судалгааны ач холбогдол: Бурханы шашинд орчлонгийн бүтцийг хүсэлт 6 н орчлон болох муу заяаны 3(там, бэрд, адгуус), сайн заяаны 3(тэнгэр, асар тэнгэр, хүмүүн), дүрст орчлонгийн 17 орон, дүрсгүй орчлонгийн 4 орон, хэмээн бичигдсэн дараалалаар босоо байрлуулж, түүний голд сүүн далай, сүмбэр уул, эргэн тойрон 7 далай, 7 тив, 7 уулаар хүрээлэгдэн буй эрхэс гарагийн цогц систем гэж үздэг. (Лондол ламын Дүйнхорын түүх хэмээх төвд ном дагуу горилогч зурган хэлбэрт оруулан схемлэв. 1-р зургаас үзнэ үү) Эцэс төгсгөл нь үл мэдэгдэх эргэлдэн буй хүрдэн орчлонг мэдэхийн тухайд тодорхой нэгэн цагт зогсонго байдлаар сэтгэн судлахыг цагийн хүрд хэмээмой. Эдгээр тогтцыг нээх түлхүүр бол цагийн хүрдний номлол, түүний товч утга, суурь

бэлгэдэл нь Намжүвандан буюу арван үсэгт тэмдэг бөгөөд ойлгох арга зам нь гадаад, дотоод агуулга, үндсэн үр дүн нь бусад хэмээх утгад харгалзах үйлдэхийн болон төгсөхийн зэрэг хийгээд авшигууд болой.

Дээрхи номлолыг Энэтхэг болон төвдийн "Цагийн хүрдний номлол" гэдгээс өвөрмөц хэв маягтай уламжлалт Монгол сэтгэгчдийн онцлогт тулгуурлан судалгаа хийж, таамаглал дэвшүүлж байсан бурханлаг дээдсийнхээ зохиол бүтээлийн далайд өчүүхэн төдий харьцуулалт хийн, шинжлэх ухааны эргэлтэнд оруулан, оюунлаг Монгол түмнийхээ эрдэнийн далайд өчүүхэн төдий ч гэсэн өөрийнхөө номын өглөгийг өргөж буй нь сэдвийн ач холбогдол гэж үзэж байна.

Марксизмын үед ертөнцийг материаллаг талаас нь харж нүдэндээ харагдах зүйлийг байна, харагдахгүй зүйлийг байхгүй гэдэг онолыг олон жил мөрдлөг болгож хүрээлэн буй уул ус, лус савдгийг амьгүй эзэн биегүй, ертөнцийн эзэд нь зөвхөн бид хэмээн номлож байгаль орчин руугаа хайр найргүй хандаж экологийн тэнцвэртэй байдлыг алдагдуулахад хүрээд байгаа билээ.

Харин одоогийн шинжлэх ухаанд шашны уламжлалт зан үйл үзлүүдийг үгүйсгэлгүйгээр үл барам үндэсний зан заншил хэв маягийг сэргээхэд ихээхэн хүч хөдөлмөр зарцуулж байгаа нь оройтсон ч гэсэн эерэг хандлага бий болох найдвар төрүүлж байна.

Бурхан багшийн аг тарнийн ёсны дээд дамжлага болох цагийн хүрдний номлол нь эх дэлхийдээ эерэг хандах гол аргын дээд хэмээн Дээрхийн гэгээнтэн XIV Далай ламтан Данзанжамц бээр ТИС-н оюутнуудад хандан айлдсан билээ.

Иймээс Бурхан шашин дахь цагийн хүрдний номлолыг судалж, энэхүү номлолын утгыг тайлбарлах нь бурханы шашны

ертөнцийн тухай сургаалыг ойлгох, эх дэлхийгээ хайрлах үзлийг төлөвшүүлэх чухал ач холбогдолтой.

Судалгааны ажлын бүтэц: Удиртгал, нэгдүгээр бүлэг, хоёрдугаар бүлэг, гуравдугаар бүлэг, хавсралт, дүгнэлт, ном зүйгээс бүрдэж байна.

Удиртгал хэсэгт: Судлах болсон учир холбогдол, сэдвийн судлагдсан байдал, сэдвийг судлах зорилго зорилтууд, судалгааны арга зүй, судалгааны эх сурвалж, шинэлэг тал, сорилт, таамаглал, ач холбогдол, судалгааны ажлын бүтэц.

Нэгдүгээр бүлэгт: Цагийн хүрдний номлолын дэлгэрэлт, ном зохиол номлолын үүсэл дэлгэрэлт, эдийн дурсгалт зүйл, өлгийн дурсгалт зүйл, Шамбалд дэлгэрсэн түүх, Шамбалын орны байгуулалт, Цагийн хүрдний номлол Энэтхэгт дэлгэрсэн нь, Цагийн хүрдний номлол Түвдэд дэлгэрсэн нь, Цагийн хүрдний номлол Монголд дэлгэрсэн нь

Хоёрдугаар бүлэгт: Цагийн хүрдний номлолын бүтэц агуулга, Цагийн хүрдний номлолын товч гурван утга, 1. гадаад цагийн хүрд хэмээх дэлгэрэнгүй агуулга, 2. дотоод цагийн хүрд хэмээх дэлгэрэнгүй агуулга, 3. Бусад хэмээх агуулга, **Арван үсэгт тэмдэгт буюу Намжүбандан цагийн хүрдний номлолын бэлгэдэл болох нь**

1. **Гадаад** утгаар нь сав ертөнц, шимийн амьтны дотроос сав ертөнцийн гарал үүсэл тогтоцыг физикийн үзэгдэл болон химийн урвалын процессоор тайлбарлахаас биш яагаад Цунами усан галав, Катарина хар салхи болоод байгааг хариулж чадахгүй байгаа нь бүхэнд илхэн. Үүний хариултыг Бурхан Буддагийн номлосон Дандарын ёсны охь болсон цагийн хүрдний номлолоос мэдэж болно хэмээн энэ сэдвийг орчин үеийн шинжлэх ухааны тайлбартай харьцуулахыг хичээсэн болно.

2. **Дотоод** утгаар хүний бие махбодь нь өдөрт 21600 удаа, 2 цагийн зайтай, 2 хамраараа ээлжлэн хүчилтөрөгчөөр амьсгалж, нүүрсхүчлийн хий болгон гаргадаг бяцхан үйлдвэр бөгөөд энэхүү бичил организм нь орчлонгийн бүтэцтэй адилхан түүний багасгасан хэлбэр гэдгийг тайлбарлахыг оролдсон. Орчин үеийн шинжлэх ухаан ч гэсэн чакра, сүнс, гэрлэн бүрхэвч гэдгийг хүлээн зөвшөөрдөг болсныг нотлох баримт материалыг харьцуулан үзүүлсэн болно.
3. **Бусад** гэдэг агуулгаар **а) Үйлдэхийн** зэргээр хүний биеийг 5 цогцсоор төлөөлүүлэн 84000 орчим номын цогцосоор дамжин хүний биед оршиох тэнгэр бурханы заллагын үйлийг илэрхийлсэн бол. **б) Төгсөхийн** зэргээр хүний биед орших төв судсаар дамжин дээш доош гүйх хийн урсгалын орой, хоолой, хүйс, нууцын орны баясал төрөх, ялгамжаатай баясал төрөх, дээд баясал төрөх, бясалгалын дээдийг үзүүлсэн бол. **в) Ван** буюу авшгаар дээрхи 2-т хүрэх үйлдэх зөвшөөрлийг албан ёсоор Доржловон багшаас залах ёслол болох ба нялхсын 7-н авшиг, дээдийн 4, дээдийн дээд 4, Дорж ловонгийн гэх 16н авшгийг эхийн гэдсэн дэхь хүүхдийн бойжилтоор харьцуулан үзүүлсэн болой.

Намжү бандан буюу 10-н үсэгт тэмдэг хэмээх ялгуусны дувааз нь цагийн хүрдний номлолын хураангуй бэлгэ тэмдэг болохыг нотлох нь

- 10-н үсгэн хэлбэрээр Ум - аа - хум - хам - ча - ма - ла - ба - ра - ям хэмээх цагийн хүрдний хөрөнгө болох зүрхэн тарни бээр илэрхийлэгдэнэ.
- Огторгуй, хий, гал, ус, шороо, сав шим болох 6-н махбодь тус бүрийг хөх, цагаан, улаан, шар, ногоон, хар зэрэг 6-н өнгөөр хураан үзүүлдэг.
- Түүнийг сахиуслан зүүсэн бурханчлан шүтсэнийг тус эрдмийг үзүүлсэн ба аль нэг улсын ерөнхийлөгч тэр улсын хүн ам нутаг дэвсгэрийг төлөөлдөг шиг хүсэлт 6, дүрст 16, дүрсгүй 4н орчлонг хураангуйлан төлөөлдөг төрийн далбаа мэт яруу алдрын дувааз юм. Энэхүү Намжү банданг шүтвээс ирээдүйд цагийн хүрдний номлол дэлгэрэхэд эхний хувь төгөлдөр шавь нарын нэг болох монгол туургатны бөгсний хөх толбо шиг буяны тамга хэмээн номложээ. /"Хиргүй гэрэл" номноос тахилын хэсэг/

Гуравдугаар бүлэгт: Цагийн хүрдний номлол дахь хот мандалын тухай ойлголт.

Хот мандалыг зурмал ба өнгөт элсэн хот мандал гэж хуваадаг. Өнгөт элсэн хот мандалыг тайлбарлавал гадна талаас хүрээний хот мандал дугуй хэлбэртэй, 108 тэнгэрийн байрлалыг заах ба 10-н хоролын хоорондох 11-н хос үсгээр 88000 тэнгэрийг илэрхийлдэг нь дотоод цагийн хүрдний ёсоор хүний үсийг бэлгэдэг энэ нь шинжлэх ухаан насанд хүрсэн хүний үсийг 88000 ширхэг гэж нотолсонтой дүйж байна. Мөн бурханы шашинд эрдэмтэн хүмүүнд 88000 номын цогцос буй нь дээрх утгатай адил дүйж буй хэрэг билээ.

1. **Лагшингийн хот мандал** Цагийн хүрдний Калачакра Бурханы ордны анхны давхар буюу хүнээр бол биеийн хот мандал нь нийт 416 тэнгэрээр, 12 сарыг бэлгэдэж, 12 амьтныг үзүүлдэг ба амьтан тус бүрд 30 тэнгэр байрлаж, сарын 30 хоногийг ээлжлэн нэг нэг өдрөөр хариуцдаг бурхадыг үзүүлдэг. (84-р хуудас зураг52-64)
2. **Зарлигийн хот мандал** Нийт 116 тэнгэртэй, Бурханыг энгийн хүнээс илүү болох лагшин найраг 116 шинжийг үзүүлсэн байдаг. Ордны 2-р давхар(90-р хуудас зураг 66-74)
3. **Тааллын хот мандал** Ордны 3-р давхар буюу бурханы язгуурын 92 бурхадыг үзүүлсэн их амгалан хийгээд билиг билгүүний хот мандлыг багтаасан байдаг. (91-р хуудас зураг 75,76)
4. **Цагийн хүрдний номлол ба Авидармагийн номлол дахь ертөнцийн тогтцын болон цаг хугацааны ялгаа**

Дүгнэлт


Ном зүй

Хавсралт

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЦАГИЙН ХҮРДНИЙ НОМЛОЛЫН ҮҮСЭЛ, ДЭЛГЭРЭЛТ, НОМ ЗОХИОЛ

ЦАГИЙН ХҮРДНИЙ НОМЛОЛЫН ҮҮСЭЛ

2540 жилийн тэртээ Сайзанжалбуу хааны хүү Шагжа язгуурын Шонүдондов буюу Сиддхарта Энэтхэгтийн хойд хэсэг одоогийн Бихар мужын Лумбини цэцэрлэгт мэндлээд бурхан болох ёсыг үзүүлж, 12 зохионгуйг ном ёсчлон бүтээсэн. Судрын буюу нийтийн ёсонд Бурхан багш 12 зохионгуйг эрхшээснээр ялж төгс нөгчсөн бурхан болсон хэмээдэг. Жишээлбэл: Майдар бурханыг энэ мэт судрын ёсонд 12 зохионгуйг эрхшээгээгүй тул ирээдүйн бурханд тооцдог. Бурхан багш “Бод гаяа” Дорждангийн бодь модны дэргэд 6н жил бясалгал хийж, Илт чуулсан бурхан болж “Хутагтын дөрвөн үнэн” хэмээх зарлигаа 35 сүүдэртэй байхдаа айлдаад хойд жил нь



Энэтхэгийн Дели хотын үндэсний музейд байгаа Бурхан багшийн чандар, үүгээр Бурхан багш бодит хүн болохыг нотолж байгаа эдийн дурсгалт зүйл

“Ширчиндо” (билиг барамид)-г номлох тэр агшинд (нэгэн зэрэг хоёр газар болох өмнөд Энэтхэгийн Балдан брэйбун болон Энэтхэгийн Бихар муж Жаргадпумбуунрэ буюу “Тас цогцолсон уул” хэмээх газар хувилгаан дүрээрээ хоёр хувилж, “Билиг барамидын номлол” буюу “Ширчиндоо”-г номлох тэр агшинд өмнөд Энэтхэгийн Амрапади хэмээх газрын Балдан брайбун суврагын дэргэд калачакра буюу цагийн хүрдний номлолыг нэгэн зэрэг номлосон гэж бурханы шашинтнууд үздэг ба ганжуурын жүдийн ботьд ч энэ тухай дэлгэрэнгүй гардаг. Тэр үзлийн дагуу номын хаан Жалбуу Даваасамбуу бээр Шамбалын орноос Замбуулинд ирж Бурханы гэгээнээс номын авшиг хайрлахыг хүссэний хариуд өмнөд Энэтхэгийн Балдан брэйбунд цагийн хүрдний нууц тарнийн үндэс болох 5 бүлэг, 1200 шүлэг номыг хайрласан ба Шамбалын хаан Жалба Даваасамбуу бээр Шамбалдаа буцаж залраад цагийн хүрдний номлолыг дэлгэрүүлсэн гэдэг.

Хойд Энэтхэгт “Билиг барамидыг”-ыг айлдах тэр агшиндаа Өмнөд Энэтхэгийн Амрападид цагийн хүрдний номлолыг номлосон гэх логикийн хувьд зөрчилтэй гэмээр доорхи санаанаас улбаалан хэд хэдэн асуудал урган гарч байна.

1. Өмнөд Энэтхэгт очиж байгаагүй гэх түүхэн баримтын үндсэн дээр яригддаг Бурхан багш цагийн хүрдний номлолыг номлосон эсэх
2. Өмнөд Энэтхэгт очиж байгаагүй Бурхан багш Амрапади хэмээх газар цагийн хүрдний номлолоо номлосон гэж үздэг нь юутай холбоотой үзэл баримтлал болох
3. Бурханы гэгээнээс цагийн хүрдний авшиг хүртсэн номын хаан Жалбуу Даваасамбуу, түүний залгамжлагчид хэн болох, ерөөс Шамбалын орон гэж юу болох

Дээрх асуудлуудын тухайд олон талын судалгаа хэрэгтэй байгаа нь ойлгомжтой. Миний хувьд энэ талаар санаа оноогоо

илэрхийлэхийн дашрамд Шамбалын орны тухай ном судраар уламжлагдсан зарим мэдээ баримтыг толилуулахыг зорилоо.

1. Бурхан багш цагийн хүрдний номлолыг номлосон эсэх тухайд Бурхан багш номлосон гэдэгт эргэлзэхгүй байгаа.


Бурхан багш түүхэн бодит хүн байсан нь шинжлэх ухааны олон баримтаар нотлогдсон байдаг. Үүнд:

Эдийн дурсгалт зүйл: Шриланк улсад буй бурхан багшийн ренсүрэл чандар, үүгээр бурхан багшийн бие махбодиос үлдсэн "шүд"-ийг археологийн шинжлэх ухаанаар бурхан багшийнх мөн хэмээн нотолсон.

Энэтхэг улсын Нью Дели дахь үндэсний музейд ("National museum New Delhi") байгаа бурхан багшийн ренсүрэл хавирганы ясыг орчин үеийн палеонтологичид бурхан багшийнх бас мөн хэмээн тогтоосон байдаг.

Кушинагар, Лүмбини Бодгаяа дахь суврага Бурхан багшийн бурхан болсон, мэндэлсэн, нирваан дүр үзүүлснийг бэлгэдэг ба эдгээр үйл явдлыг тэр үед бүтээсэн эдийн дурсгалт зүйлээр бас нотолж болно.

Өлгийн дурсгалт зүйл: Бурхан багшийн Дорждан, Варанаси, Янбаажин тэргүүтэй газар айлдсан сургаалийн цомог болох "Ганжуур"-ын 108 боть тэр үеийн "пали" самгард хэл дээр бичигдсэнийг Бурхан багшийн зарлиг хэмээн эрдэмтэд хүлээн зөвшөөрдөг. Калачакра цагийн хүрдний номлолыг номлосон эзэн нь бурхан багш болох бөгөөд бурхан багшийн аман гэгээнээр айлдсан гэх "Ганжуур"-т цагийн хүрдний номлол олон гардаг нь үүний нэг гол нотолгоо болж байгаа юм.



Аръяабалын
хувилгаан XIV далай
лам Данзанжамц

2. Цагийн хүрдний номлолын номлосон газрын талаар Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам Данзанжамц бээр өмнөд Энэтхэг (Andra pradesh) Андра Прадэш мужийн “Амрапади” хэмээх газрыг Балдан брайбун хэмээн айлдаад тэнд 2006 онд цагийн хүрдний авшиг хүртээсэн. Энэ талаар Норбуулингаа хэмээх Далай багшийн байгуулсан соёл гар урлагийг хөгжүүлэх нийгэмлэгээс гаргасан..ས་ལོའ་གི་ངོ་སྤོང

цагийн хүрдний номлолын танилцуулга номонд тодорхой нотлон тайлбарласан байдаг. Гэвч Лондол-лам Агваанлувсангийн анхны бурхан Цогт Галазагдын түүх хэмээх Бээжин барын сударт.ང་པོ་སངས་རྒྱས་དཔལ་དས་གི་

ལོའ་ལོའི་ལོ་རྒྱུས་བཞུགས་སོ། མཇད་བ་པོ་གྲོང་རྫོལ་སྤྱ་མ་ངག་དབང་

སྤོ་བཟང་མ ། Энэтхэг Бутан хоёр улсын хил дээр Балдан

брайбун байдаг гэж бичсэн нь дээрх үзлээс ялгаатай байна.

Миний хувьд: Амрапади дах Балдан брайбун суврага нь Бурхан багш цагийн хүрдний номлол номлосон газар мөн. Тэнд орон нутаг судлах музей байдаг, тэндээс англи хэл дээр гаргасан музейн тайлбараас авч үзвэл, тэнд хадгалагдаж байгаа гурван үзмэр өөрийн эрхгүй цагийн хүрдний номлол номлогдсон газар болохыг нотлох эд өлгийн дурсгал юм. Тус музейд байгаа хүрд очир хоёр, чулуун дээр сийлсэн Шалабанзага хэмээх үүд сахигч тэнгэрийн дүр, мөн чулуун дээр сийлсэн цагийн хүрдний суврага тэргүүтэн 3 төрлийн үзмэр нотлогдохуун эд өлгийн дурсгал хэмээн үзэж болмоор санагдана.

Нэгдүгээрт. нотлох эд өлгийн зүйл - Чулуун дээр товойлгож сийлэн гаргасан байгаа Дүйнхорын суврага нь Өндөр гэгээний мөнгөөр бүтээсэн Дүйнхорын суврагатай төстэй, бэлгэдэл нь адилхан. (Дүйнхорын номлолд Сүмбэр уулыг бөөрөнхий хэлбэртэй гэж үздэг учраас хэлбэр нь хоорондоо төсөөтэй ба шүхрийн бэлгэдэл нь адилхан)

Зураг 4



Өмнөд Энэтхэгийн Амрапади дахь музейн олдвор суврага

Зураг 5



Сүмбэ хамба Ишбалжирын тэгийн онолоор Өндөр гэгээн Занабазарын бүтээсэн суврага

Суврагын цэцгүүд нь Сүмбэ хамба Ишбалжирын суврагийн тэгийн номлолын дагуу (цадмидши, 4 махранзийн орон, арслант сэнтий, чойнхор жүсүм, цэцгэн эрхи нь адилхан) хийгдсэн.

Хоёрдугаарт нотлох эд өлгийн зүйл - Музейн үзмэр болох чулуун дээр товойлгон сийлсэн Хүрд, Очир хоёр байгаа юм.



Өмнөд Энэтхэгийн Амрапади дахь музейн олдвор хонх очир

Зураг 6

Очир бол нууц тарнийн ёсны гол бэлгэдэл бөгөөд арга билиг хоёрын аргыг нь голчлон төлөөлдөг ба Аг тарнийн ёсыг бэлгэддэг. Хонх нь арга билиг хоёрын билгийг бэлгэддэг ба

судрын ёсыг ихэвчлэн илэрхийлдэг.

Хиндү шашинд ерөөсөө Очир байдаггүй. Энэ нь цагийн хүрдний номлол энд дэлгэрсний гэрчлэх чухал эдийн дурсгал болно.

Гуравдугаарт нотлох эд өлгийн зүйл - Бас тэнд Дүйнхорийн хот мандлын лагшин, зарлиг, тааллын хаалган дээр Шалабанзага хэмээх хүн дүрстэй “Лха” буюу тэнгэр байдаг. Музейн ойролцоо оршдог хүмүүс хоорондоо царай муутай

Зураг 7



Цагийн хүрдний хот мандалын хаалган дээрхи

Зураг 8



Амрападийн музейд буй чулуун дээр сийлсэн

нэгийгээ Шалабанзага хэмээн хоч өгч яриандаа хэрэглэж байгаа нь бас нэг нотолгоо болно. Шалабанзага гэдэг үг нь одоо болтол уламжлан дамжуулж энэ үгийг хэрэглэж байгаа нь үг соёлд үлдсэн дурсгал юм.

Хот мандлын Шалабанзага хэмээх хүн дүрст амьтан (Зураг 8) орон нутгийн музейд байгаа Шалабанзага хэмээх хүн дүрст амьтан хоорондоо адилхан байгаа нь цагийн хүрдний номлол тэр тусмаа хот мандлын талаар олдсон цорын ганц олдворын нэг юм. Иймээс цагийн хүрдний номлол Амрапади хэмээх газар номлогдсоны гурав дахь гэрч болж байна.

Лондол ламын “Дүйнхорын түүх” хэмээх номонд: Урьд Сэртүв бурханыг заларч байх тэр үед их өлсгөлөн, зуд болжээ. Тэгтэл нэгэн гэлэн гарч ирээд 12 хоног тасралтгүй бороо оруулж ган тайлсны эцэст арвайгаар хур оруулсан бөгөөд тэр арвайг цуглуулж бөөрөнхийлөн овоолсноор алдарт Балдан брайбун суврага үүсэлтэй гэдэг. Одоо ч хүмүүс “Маха-чү-яата” буюу Балдан брайбун суврага, Шалабанзага гэх мэт үгсийг марталгүй одоо болтол хэрэглэсээр ярьсаар байгаа билээ. /тэндэхийн хүмүүс/ Балдан брайбун гэдэг бол Шри данагардига буюу Shire Dhana-qardega гэж дуудагддаг.


Горилогч миний бие Энэтхэгийн өмнөд хэсэгт байрлах энэхүү музейд очиж тайлбарлагчийн хамт тус музейг 5 орчим цаг үзэж үзмэрийг тайлбарлуулан сонирхсон бөгөөд Шалабанзага хэмээх үүдэн тэнгэрийг тэрбээр эмэгтэй хүн гэж байсан. Цагийн хүрдний номлолд бол эрэгтэй хүн байдаг гэж үздэг учраас бид 2 удаан маргалдаж байсан билээ. Музейн тайлбарлагч эрэгтэй, эмэгтэй аль алин болох тодорхой ялгааг сайн мэдэхгүй байсан. Палеонтологийн шинжлэх ухаанаар тэр үеийн зүйл хэмээн баталсан сертификат бичгүүдийг надад үзүүлж байсан нь шинжлэх ухаанчаар нотлох бичиг баримтын нотолгоогоор бурхан багш цагийн хүрдний номлолоо тэр газар айлдсан болох бас нэг баталгаа болно.

Зураг 9



Энэтхэгт цагийн хүрдний номлолыг Шамбалын орноос 1027 онд залсан. Роша мужийн Ражгийр хэмээх хийдийн бандида Зэлүба

Зураг 10



དཔལ་ལྷན་འབྲས་ལྷོ་ས་མཚོ་དཀྱིའི

Одоогийн байдал Амрапади дахь Балдан Брайбун суврага

Нэр томъёоны утга нь олон янз байдаг доор бичсэнчлэн

1. Цагийн хүрдний номлол - орчин үеийн монгол орчуулга
2. Дүйнхорын номлол - Төвд хэлнээс шууд хэрэглэгдэн монголжсон үг
3. Калачакрагийн номлол - Дива, Нагари буюу тэнгэрийн хэл гэх самгард үг
4. Анхны бурхан Галазагд - "Мэргэд гарахын орон" толь бичгийн уламжлалт орчуулга

Эдгээрийн алин бээр бичигдсэн ч гэсэн утга нь адилхан болой.

Бурхан багш 2550 жилийн өмнө өмнөд Энэтхэгт “Дүйнхорийн жажүд” хэмээх нууц тарнийн сургаалиа номлохоос өмнө бурханы шашны судар ёсны урсгалын хийд орон болон лам нар байсан нь Амрапади болон “алура” “аланго” гэх мэт агуйнаас олдсон Бурхан багшийн чулуун дүр болон эд өлгийн зүйлээс харагддаг.

(Үүнийг дэлгэрүүлж үзье гэвэл Амрападийн музейн тайлбараас үзнэ үү)

Шамбалын хаан Рэгдэн Жамбал Дагва түүний хүү Рэгдэн БадмаГарав хоёр хэзээ ч Замбуу Тив, Жагар, Төвдэд морилсон гэх ном судар байдаггүй боловч Рэгдэн Жамбалдагвын зохиосон **འགྲུབ་ལྡན་འཇམ་དབལ་གྲགས་པའི་བསྐྱེས་རྒྱུད།** "Рэгдэн жамбал дагвын дүйжид" хэмээх ном нь "Ганжуур"ын жүдийн "ГА" боть дотор,, **འགྲུབ་ལྡན་པ་རྣམས་དཀར་པོའི་འགྲེལ་ཆེན་གྱི་མེད་འོད།** Рэгдэн Бадмагаравын "Дэлчин дэмид од" хэмээх ном нь "Данжуур"-т байгаа нь Шамбал Замбуулин хоёрын хооронд ямар нэгэн бодитой холбоо байгааг эд өлгийн зүйлээр нотлож байна гэж үзэж болно.

Цагийн хүрдний номлол нь мөө 625 орчим онд Өмнөд Энэтхэгийн Балдан брайбун хэмээх газар дэлгэрсэн нь эдийн дурсгалт зүйл болох очир, хүрд, шалабанзага буюу үүд сахигч тэнгэр гурваар нотлогдож байна.

Бурхан багш бодит хүмүүн байсныг Шриланк дахь бурхан багшийн "шүд", Энэтхэгийн Дели хотын Үндэсний музейн бурхан багшийн "хавирганы яс" зэргээр палеонтологийн шинжлэх ухаан нотолсны зэрэгцээ цагийн хүрдний номлолын дамжлага буюу Дүйнхорын жүдийг Замбуулинд анх номлооч нь Бурхан багш гэдэг нь нэлээд тодорхой нотлогдож байна.

Эндээс дараах дүгнэлт урган гарч байна. Өмнөд Энэтхэгийн Амрапади нь цагийн хүрдний номлол Замбуулин тивд дэлгэрсэн анхдагч газар бөгөөд номлооч нь Бурхан багш Шагжамуни болж таарч байна.

Дээр дурдсан англи хэл дээр бичигдсэн орон нутгийн музейн тайлбар болон "Шакта" хэмээх энэтхэгийн шинжлэх ухаан танин мэдэхүйн сэтгүүл дээр гарсан "Амрападийн нууц" хэмээх

өгүүллүүдийг монгол хэл дээр орчуулан түүнчлэн Лондол ламын “Дүйнхорын түүх”, Норбуулингагаас нийтлүүлсэн Дүйнхорын вангийн танилцуулга зэргийг төвд хэлнээс монгол руу орчуулан энэхүү хэсэгт ашигласан бөгөөд мөн Жадо ренбүчи, Лочин ренбүчи нарын аман гэгээнээр айлдсан айлдвар, өөрийн бодол эргэцүүлэлд тулгуурлан дүгнэж үзсэн болно. Дээрхи дүгнэлтийг дэлгэрүүлж үзэхийг хүсвэл номын орчуулгуудыг эх хувь болон монгол орчуулгаар нь үзэж танилцаж болох юм. Мөн Дүйнхор дацангаас Энэтхэгийн Дарамсалаа дахь Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам өөрийн дацан болох Намжираа дацангаас эрхлэн гаргасан "Whole times" хэмээх англи хэл дээр гаргасан номын дотор гарсан зургуудыг нотолгоонд-ашигласан.

Бурхан багшийн цагийн хүрдний номлол дэлгэрсний үндсэн дээр Амрападийд энэ сургааль нэлээд газар авсныг харуулж буй нь илт байна. Дараа дараагийн судлаач нар энэ талаар анхаарч үзэх нь зүйтэй санагдана.

Гэвч цагийн хүрдний номлол Бурхан багшаас өмнөх үеэс улбаатай байх магадлалтай.

ЦАГИЙН ХҮРДНИЙ НОМЛОЛЫН ДЭЛГЭРЭЛТ, НОМ ЗОХИОЛ

ЦАГИЙН ХҮРДНИЙ НОМЛОЛ ШАМБАЛД ДЭЛГЭРСЭН НЬ

Цагийн хүрдний номлол дэлгэрсэн нь Шамбалын орны тухай олон янзын баримтлал байдгийг энд үл өгүүлэн цагийн хүрдний номлолыг Шамбалд дэлгэрүүлсэн 7 номын хаан, Шамбалын орны байгуулалт ба Шамбалын 25 хааны тухай “ Лондол лам Агваанлуvsангийн Дүйнхорын түүх номын Шамбалын тухай 3-р бүлэгт” өгүүлснээр авч үзье.

Шамбалд дэлгэрсэн эшлэл: МЭӨ 625 орчим оны үед бурхан багш Өмнөд Энэтхэгийн Амрапади хэмээх газар цагийн хүрдний номлолыг анх түрүүн айлдаж түүнийг Шамбалын номын хаан Даваасамбуу бээр Шамбалд залж цагийн хүрдний номлолыг Шамбалд дэлгэрүүлсэн гэдэг. (Энэ тухай Бурхан багшийн айлдсан зарлигийн хураангуй Ганжуурын жүдийн "Га" ХА" боть дотор бүхэлдээ гаргасан буй.) Шамбал хэмээх орны тухай цухас дурдваас: 1.Шамбалын долоон номын хаад, 2. Шамбалын орны байгуулалт 3. Шамбалын 25 хаад

Номын 7 хаан болох Даваасамбуу, Лхаеэ Ванчүг, Сэжид Таяа, Даваашин, Ванчиг Чинму, Нацаг сүг, Лхаеэвалдан нар үе улируулан цагийн хүрдний номлолыг залгамжлуулсан ба өөрийн буй орныг Шамбал хэмээн нэрийдсэн гэдэг боловч Лондол лам бээр Шамба хаанаар толгойлуулсан Шагжа язгуурын хүмүүс нутгаасаа хөөгдөн Шамбалд очиж тэр орныг хааныхаа алдраар нэрийдсэн хэмээдэг хоёр янзын тайлбар байдаг (Лондол ламын “Дүйнхорын түүх” номонд).

Бурхан багш нирваан дүрийг үзүүлснээс 800н жилийн дараа Шамбалын 25н хааны анхдугаар Рэгдэн Жамбалдагва бээр хаан ширээнд сууж, цагийн хүрдний номлолыг Шамбалд дахин

дэлгэрүүлэн “дүйжад нямбу”-г айлджээ. Энэ нь “Ганжуурын” Жүдийн “ГА” боть дотор байдаг билээ. /хураан үйлдэхийн зүрхэн хэмээх номлол/

Түүний дараа Жамбалдагвын хүү Рэгдэн Бадмагарав буюу Шамбалын 2-р хаан ширээндээ заларч цагийн хүрдний номлолыг уламжлан авч "Бадмалабарва" хэмээх алдарт зохиолоо бүтээж авшгийг увдисан дор ургуулснаас гадна “Дүйнхор дэлчин дэмид од” буюу цагийн хүрдний тайлбар хиргүй гэрэл хэмээх гол номлолоо Шамбалд айлдсан тухай Данжуурын жүд дотор байдаг. Энэ мэт дээр дурдсан хаадууд үе улиран заларч байжээ.




1. Номын хаан Жалба
Даваасамбуу
замбуулингаас
Дүйнхорын цагийн
хүрдний номлолын
авшигийг Шамбалд
дэлгэрүүлсэн.



2. Номын хаан Лхаеэ
ванчүг Жалба
Даваасамбуугийн
хөвүүн бөгөөд
эцгийнхээ номлолыг
үргэлжлүүлсэн.



3. Номын хаан Сэжид
Таяа цагийн хүрдний
номлолыг Шамбалын
оронд дамжуулан
залгуулсан.



4. Номын хаан
Даваашин бээр
дээдсийн уламжлалыг
дагасан.



5. Номын хаан
Ванчиг Чинму
уламжлалаа
хадгалсан.



6. Номын хаан
Нацаг сүг бээр
цагийн хүрдний
номлолыг
уламжлан дагасан.




7. Номын хаан
Лхаеэвалдан дээдэх
эцэг хаадуудынхаа
уламжлалыг ном
ёсчилон бүтээсэн.
Удам дамжсан номын
7 хаадын отгон хаан.

ШАМБАЛЫН ОРНЫ БАЙГУУЛАЛТ

Мөн Шамбалын орны байгуулалтын талаар дээрх сударт өгүүлсэн нь:

Гандангийн төвөөс хагас багцад Шамбал маш бөөрөнхий цоморлиг найман дэлбээтэй, түүнийг гурав хуваасны нэг цоморлигийн хэмжээ мянган багцад, дэлбээ тус бүр мянган багцад хэмжээтэй ба уул бүрийн үзүүр бүгд Цаст уул хийгээд завсраар нь нар зөв эргэсэн уул, үндэст уул, зүлэгт уул, цэцэрлэгт уул, шилэн уулс нь цэцэг жимс үрээр чимсэн бусдаас ялгамжаатай, уужим, есөн хүсэл бүрдэж, сэтгэлд зохистой дэлбээнээсээ ялимгүй өндөр цоморлиг тал дээр хааны ордон “галава” таван эрдэнийн мөн чанартай 12 багцад ба ордны голд Шамбалын хаан заларч харшийн чимэг маргад, болор, дорж паламын гэрлээр арван тавны сарны гэрлийг сүрээр дарахуйц шилэн үүд нь өдөр шөнийг ялгахад хэцүү гэмээр, алтан сэнтийтэй, энд тэнд зүүсэн болор хорол чимгүүд нар сар од мэт, горооны зам 12 орд мэт, арслант сэнтий дээр зандан тавиур нь үнэртэж байгаа үгээр дүрслэх аргагүй, түүн дээр залрах хаан боловсорсон цэцэг адил титэм буюу зүгдортой, өлмийн бугуйвчнаас гэрэл цацарсан цагаан нигуураас улаа бутарсан нь орчноо гэрэл дулаанаар гийгүүлж, эргэн тойронд байх түшмэл хатад баатар заан морин унаатай тоолшгүй олон өөр болон бусад ажил хийдэг язгуурын тарнийн хүчээр ус оруулдаг, лус, тэнгэр хүмүүн бээр өргөсөн төгс эдлэлт тэнгэрийн баатруудыг тоолж баршгүй. Хааны олон хатадаас мэндлэх ханхүү бүрийн гишгэсэн газраас цагаан цэцэг ургаж, бороо орж, эхний долоо хоног эрдэнээр дүүрдэг гэж "Донёд загжү" хэмээх сударт айлдсанчлэн өвдөх хөгшрөхийн зовлон үгүй үүрд жаргаланг эдлэнэ гэжээ. Ордны хойд талд ажилчид, боолууд, зарц нарын дүртэй тэнгэр Жанрайсаг Хала, Хала тэргүүтэй бодьсадва олон саяараа, урд талд ма-ла гэдэг цэцэрлэгийг 12 багцадын хэмжээсээр голд нь калачакра хот мандлын таван эрднээс

бүтсэн “лолин” буюу модель загварыг зүг зүгтээ 412 тохой хэмжээтэй цэцэрлэгтэйгээр Даваасамбуу хаан бээр бүтээжээ.



Сүүлд нь өөр хааны бүтээсэн лолин (Шамбалын орны загвар) олон. Цэцэрлэгийн өмнө талд 12 багцад шинийн 8-ны сар адил сэтгэлийн далай, хойд талд цагаан лянхуа далай хагас саран мэт 12 багцад, өнгийн цэцгээр бүрхсэн эрдэнийн онгоцонд хүмүүн тэнгэр лус баясгалантай хөвдөг. Төв галава хотыг тойроод цаст уулаас гадагш цаст уул хүртэл 500 багцад найман дэлбээтэй цэцэг мэт хэлбэртэй. Дэлбээ бүрийн завсар улс, дэлбээ бүрт 12, 12 хот байх ба нийлбэл 96 жива хот болно. Хот тус бүр хаантай номын хаан 96 байдаг./дээрхи зураг лугаа адил/

Бурхан багшийн шашин 50000 жилийн түүхтэй гэдэг. Цаг үргэлжид номоо айлддаг тарнийн язгуур бүтээсний хүчээр 96 хаан бүр юугва буюу төмөр саваатай (дээрээ Очиртой бөөрөнхий), түүнийгээ гартаа барихын цагт, хаа санасан газраа эгшин төдийд очдог, хотын байшин бүгд 2 давхар ба энэтхэг байшингийн хэлбэртэй байдаг ба эндхийн хүмүүс гоо үзэсгэлэнтэй, өмсөж эдлэх, хоол унд нь өөрөө бүтдэг. Зөөлөн салхи далай мэт өргөжсөн, хорих цагдах, зуд ган байдаггүй. Араншин сайтай ухаан хурц, буянаар аяндаа жигүүрлэдэг. Ихэнх нь дөрвөн жүд ханьцашгүй ёгузорын үүднээс бурхан болох нь олонхи Билиг барамидын номлолын бясалгал олсон, энгийн дүртэй боловч насан эцэстээ арилсан орноос бусдад төрдөггүй, муу заяанд унахгүй, тэдгээрийн төрх энгийн боловч хаан байдалтай. Номын дуу сонсох төдийд л сайн хувьтны замыг олох шидтэй. Эрэгтэйчүүд нь улаан цагаан номын хувцастай, эмэгтэй нь цагаан хөх, эрдэнийн зурагтай хувцас өмсдөг, чухаг дээд гурвыг хаа байгаа газар нь тахиж хүндэлдэг, хуврага болж буй нь номын ёсоор, дээдийн ном, зарлиг Замбуулинд байгаатай адил, зарим нэг нь богд Зонхавын судар номыг шүтдэг. (Лондол ламын Шамбалын орны байгуулалт хэмээх судраас)


Шамбалын 25 хаад МЭӨ 625 онд Бурхан багш мэндэлсэн гэж үзээд Дунгарлуvsанпэрэнлэйн он тооллыг дагавал “Чойжилдүн” буюу Долоон номын хаад (Жалбаа ДавааСамбуу хаан бээр бурхан багшаас Дүйнхорын номлолын үндсийг Балдан Брайбун Амрападигаас залж Замбуулингаас Шамбалын оронд анхлан Дүйнхорын номыг дэлгэрүүлсэн) Мээ 592 он - 277 он = 315 жил, удам дамжсан номын 7 хаад Шамбалын хаанд ээлжлэн залраад, түүний дараагаар 277 оноос эхлэн Шамбалын орны 25 хаад² ээлж дараалан хаан ширээнд суусан болон суухыг үзүүлбэл:

Үүнд:

Шамбал хэмээх орны номын 7 хаад нь эцэг хаадууд хан хөвгүүддээ уламжлан хаан ширээгээ залгамжилдаг ёстой."Зөвхөн өөрийн нуган хөвгүүддээл "




1-р хаан 277 онд
Рэгдан Жамбалдавга
бээр дүйнхорын
номлолыг шамбалд
дэлгэрүүлсэн.



2-р хаан 177 онд Рэгдан
Бадмагарбу - бээр Дэлчин
Дэмид Од буюу их тайлбарын
хиргүй гэрэл хэмээх номыг
зохиов.



3-р хаан 77 онд Рэгдан
Самбуу бээр хаан
ширээнд суув.



4-р хаан МЭ, 24 онд
Рэгдан Намжил хаан
суув.



5-р хаан МЭ 124 онд Рэгдан
Шинэнсамбуу хаан суув.



6-р хаан 224 онд
Рэгдан Чагмар хаан
суув.




7-р хаан 324 онд
Рэгдан Чамжүг байва
хаан болов.



8-р хаан 424 онд Рэгдан
Няндаг хаан болов



9-р хаан 524 онд
Рэгдан Шиндүсан
хаан болов.



10-р хаан 624 он +
182 жил= 806 он
Жацо Намжил 282
жил хаан байв.



11-р хаан 806 он + 221
жил=1026 он Жалга хаан
суув. Энэ үед энэтхэгийн
бандида Зэлүба бээр
дүйнхорын номлолыг анх
түрүү энэтхэгт залан
дэлгэрүүлэв.



12-р хаан 1126 он
Рэгдан Нямаа хаан
болов.



13-р хаан 1226 он
Рэгдан Нацагсүг суув.




14 -р хаан 1326 он
Дави од хаан суув.




15-р хаан 1426 он
Рэгдан Таеэ хаан суув.



16-р хаан 1526
Санжун хаан суув.



17-р хаан 1626 он Рэгдан
Бэжун хаан суув.



18-р хаан 1726 он
Рэгдан Синги хаан
суув.



19-р хаан 1826 он
Рэгдан намнан
хаан суув.



20-р хаан 1926 он
Рэгдан Давучи хаан
суув.



21-р хаан 2026 он
Рэгдан Мангагва
хаан сууна.



22-р хаан 2126 он
Рэгдан Мэээ синги
хаан сууна.



23-р хаан 2226 он Рэгдан
ванчиг чимбу хаан сууна.



24-р хаан 2326 он Рэгдан
таезнамжил хаан сууна.



25-р хаан 2426 он
Рэгдан Дагву хаан
сууна Энэ хааны үед
хаан бээр өөрийн
биеэр замбууланд
заларч тэрсүүд буруу
номтныг дарж
дүйнхорын шашныг
өнөд удаан
мандуулна хэмээн
номлосон байдаг.

:

Тайлбар: Удам залгасан 7 номын хаад болон үе дамжсан 25 хаад, Шамбалын орны байгуулалтын зургийг XIV Далай лам Данзанжамцын Намжираа дацангаас эрхлэн гаргадаг сэтгүүл дээрээс түүвэрлэн авсан ба Намжираа Кэнсүр Жадо Ренбүчи болон Дарма лочин лхаарамба нарын аман гэгээнээр айлдсан сургааль Будон Ренбүчи, Богд Зонхава, түүний 2 шавь, Хайдавнорсонжамц, Зава ламтан, Угалзын лам, Бизьяагийн лам, Дандар аграмба, Дунгарлуvsсанпэрэнлэй тэргүүтэй дээдсийн бүтээсэн ном зохиолын дагуу энэхүү ончлолыг бичсэн болой.

- I. Мэе 277 онд Рэгдан Жамбалдавга бээр Дүйнхорын номлолыг Шамбалд дэлгэрүүлсэн.
- II. Мэе 177 онд Рэгдан Бадмагарбу бээр Дэлчин Дэmid Од буюу их тайлбарын хиргүй гэрэл хэмээх номыг зохиов.
- III. Мэе 77 онд Рэгдан Самбуу
- IV. 24 онд Рэгдан Намжил 53 жил хаан байв.
- V. Мэе 124 онд Рэгдан Шинэнсамбуу хаан байв.
- VI. 224 онд Рэгдан Чагмар хаан байв.
- VII. 324 онд Рэгдан Чамжүг байва хаан болов.
- VIII. 424 онд Рэдан Няндаг
- IX. 524 онд Рэгдан Шиндүсан
- X. 624 он + 182 жил= 806 он Жацо Намжил 282 жил хаан байв.
- XI. 806 он + 221 жил=1026 он Жалга хаан суув. Энэ үед Энэтхэгийн бандида Зэлүба бээр Дүйнхорын номлолыг анх түрүү Энэтхэгт залан дэлгэрүүлэв.
- XII. 1126 он Рэгдан Нямаа хаан
- XIII. 1226 он Рэгдан Нацагсүг
- XIV. 1326 он Дави од хаан
- XV. 1426 он Рэгдан Таеэ хаан
- XVI. 1526 Санжүн хаан
- XVII. 1626 он Рэгдан Бэжүн хаан
- XVIII. 1726 он Рэгдан Синги хаан
- XIX. 1826 он Рэгдан намнан хаан

- XX. 1926 он Рэгдан Давучи хаан
- XXI. 2026 он Рэгдан Мангагва хаан
- XXII. 2126 он Рэгдан Мэээсинги
- XXIII. 2226 он Рэгдан ванчиг чимбу
- XXIV. 2326 он Рэгдан таээнамжил хаан
- XXV. 2426 он Рэгдан Дагву хаан сууна

Шамбалын дээрх 25 хааны сүүлчийнх болох Рэгдан дагву хааны үед хаан бээр өөрийн биеээр Замбуулинд заларч тэрсүүд буруу номтныг дарж Дүйнхорын шашныг өнөд удаан мандуулна хэмээн бошиглосон байдаг ба түүнийг бусад хааддаасаа онцын ялгаатай Хорол жүрвийн жалба буюу загарвардын хаан хэмээн нэрийддэг. Тэр хааны Замбуулинд өөрийн хүчээр залрах чадалтай, эрх сүр нь 3 орчлон болох хүсэлт 6-н, дүрст 17, дүрсгүй 4-н орныг сүрээр дарах сэвжидтэй, ном номлох эрх мэдэлтэй онцгой нэгэн хаан гэж үздэг.

ЦАГИЙН ХҮРДНИЙ НОМЛОЛ ЭНЭТХЭГТ ДЭЛГЭРСЭН НЬ

Мэ-ний (1027 онд) Шамбалын XI хаан Жалгаа хаан ширээнд заларч байх тэр үед Энэтхэгийн зүүн талын одоогынхоор Ороши мужийн “Раднагири” хийдийн эрдэмтэн хувраг “Зэлүбандида” хэмээх

- I. Хоосон чанар, чойеэн ишээ
- II. Билиг билгүүний толь, мялон ишээ
- III. Тус тусад нь болгоох билиг билгүүнд одох шүлэг болох

རྣམ་ ཅིག་ བཅིག་ གི་ རྗེ་གས་ སངས་ ལྷན། "гаджиг, жигийс жогсанжэ"

гэдэг үгийг Жамбалцанзодын тайлбараас хартал. ང་ རོ་ སངས་ ལྷན་

དམ་གྱི་འཁོར་ལོ། "данбу санжай дүйжий хорлоо" хэмээх үг гарсан

бөгөөд үүнийг цааш нь бодоод асууж сурагласан боловч Замбуу тивд мэдэх хүн байсангүй тул “Ногоон дарь эх” бясалгаад “Зүнбэрэлжийн ганба” түргэн явдаг ид шидийг эрхшээгээд Шамбалд очиж цагийн хүрдний номлолыг Жалгаа хаанаас залж манай эриний (Анхдугаар жарны равжүн хэмээх гал туулай жил) 1027 онд цагийн хүрдний авшиг Энэтхэг оронд дэлгэрүүлсэн гэж Төвдийн номт хаан Тэсрэдсанжайжамцын "Бидэргарва" хэмээх зурхайн гол судрын данзэ буюу он тоолол дотор байдаг бол Будон Ренчингийн “Дүйнхор чойнжүн” буюу “Дүйнхорын түүх” номын дагуу Шамбалын XI хаан Жалгааг Замбуулинд залж авчраад цагийн хүрдний номлолыг бүрэн төгс уламжилж авсан гэдэг хоёр янзын түүх байдаг. (Тэсрэдсанжай жамц нь Бидэр онбу анагаах ухаан, Бидэр сирбу түүхийн талаар зохиол бичсэн эрдэмтэн хаан билээ.)

Ийнхүү цогт цагийн хүрдний номлолыг Зэлү бандида бээр Энэтхэгт эхлэн дэлгэрүүлсэн боловч зарим нэгэн хүмүүс хүлээн зөвшөөрөхгүй байсан тул тэр үеийн буддын шашны төв болох Налиндара хийдийн үүдэн дээр нь “Намжү-Бандан” буюу Дүйнхор бурханы ялгуулсны дуваазыг (10н үсэгт тэмдэг) залсанд тэд ихээр гайхаж, Үнэн номлол юм бол үүдэнд залах хэрэггүй хэмээж учир шалтгааныг нь олохын тухайд Зэлү бандидааг дамжаанд суулгаж ном хаялцсаны эцэст Налиндарын 500 бандида нар хүлээн зөвшөөрч Энэтхэгт цагийн хүрдний номлол бүрэн төгс 1027 онд дэлгэрсэн түүхтэй.

ЦАГИЙН ХҮРДНИЙ НОМЛОЛ ТҮВДЭД ДЭЛГЭРСЭН НЬ

Эртний Төвдийн Нятадзамбуу хаанаас (Ширээн шилт хэмээх хочтой) XXVI хаан болох Соронзонгомбо хаан хүртэл "Ванганчагжаа" хэмээх Арьяабал бурханы бүтээл голчлон дэлгэрсэн ба "Маани Ганбум" хэмээх Арьяабалын тайлбарыг зохиож, бүх зүйлийг Арьяабал бурханаас үүдэлтэй хэмээн, хааныгаа ч хүртэл Арьяабалын хувилгаан мөн гэсэн /МэVII зуун хүртэл/ үзэл бүхий бурханы шашин дэлгэрч байжээ. Түвдийн цаст уулын Тонмисамбуу, Арлозава, Ренчинсамбуу тэргүүтэй 7 их мэргэд Энэтхэгт очиж бурханы шашны номлолд суралцан цагийн хүрдний номлолыг 1028 онд анх түвд хэлэнд орчуулан Төвдэд дэлгэрүүлсэн гэдэг боловч 200-аад жил эрчимтэй хөгжиж чадаагүй ээ. Учир нь бурханы шашинтай тэрсэлдсэн Ланадрама хааны үе байжээ. XI зууны сүүл үеэс Нямава буюу улаан малгайтны шашин дэлгэрч дараа нь Сажава, Нароба, Гаажүдба нар бурханы шашныг залгамжлан дэлгэрүүлсэн. Түүний дараа XIII зууны эхэн үед Жононба нар гарч ирж өөрийн ёсонд цагийн хүрдний номлолыг өвөрмөц онцлогтой хөгжүүлсэн байдаг.

XIII зууны дунд үеэс Богд лам гелүгва ёсыг (шарын шашин) дэлгэрүүлж Төвдийн шашны олон урсгалыг нэгтгэж шинэчлэл хийсэн. Судрын ёсыг нэгтгэн Ламрим ченбо буюу "Бодь мөрийн зэргээ" номлож, Аг тарнийн ёсыг нэгтгэн "Агримчинбо" хэмээх алдарт зохиолоо туурвисан. Калачакра, Хэрүка, Ямантага, Гүеэсамажо зэрэг 4 жүдийг тус тусад нь дэлгэрүүлэхийн хамт цагийн хүрдний номлолыг оройд нь хүртэл хөгжүүлсэн ба түүний шавь Хайдавжи, Жалцавжи хоёр болон 8-н цоржоороо дамжин хөгжүүлсэн байдаг гэж оросын эрдэмтэн Щербатской, японы эрдэмтэн Сүзүки нар цохон тэмдэглэсэн байна (Т.Булган багшийн лекц)

Төвд лам нарын зохиол бүтээл: Арлозава 1028 онд цагийн хүрдний номлолыг төвд хэлэнд орчуулан Төвдэд дэлгэрүүлжээ.

Цастны орон болох Түвдэд олон янзын газар онол хоорондоо зөрүүтэй байсныг 1290 онд Занд төрсөн Будонренчиндүв бээр 26 боть номынхоо 12 ботьдоо зөвхөн цагийн хүрдний номлолыг айлдаж зөрүүтэй талуудыг нэгтгэн цогц болгосон билээ. Хамгийн алдартай 3 зохиолын нэрийг дор дурьдвал:

"Дүйнхор чойнжүн". ཏུས་ལའོར་ཚོས་འབྱུང་། буюу "Дүйнхорын түүх гарал"

"Дэлчин чандэл" འགྲིལ་ཚེན་མཚན་འགྲེལ། хэмээх "Дэлчин дэмид - од" -ын зүүлт тайлбар хийсэн "Галбон":གལ་སྐྱོངས། бүтээлдээ тус тусдаа өөр өөр ёсыг нэгтгэж сагар, чогар, сачиг, дүлцэн бүхий чогийг дэглэсэн ба Дүйнхорын аравнай хүртэл зохиосон.

Богд лам Зонхава Лувсандагва бээр 1357 онд Төвдийн Амдү хэмээх газар "Сонгины ам" гэдэг нутаг одоогийн Хятадын Гүмбум Жамбаалин хийдийн ойролцоо мэндэлжээ. Бурхан багшийн эрхэм шавь монголжийбүү бээр ирд хувилгаанаар эш үзүүлж, төрсөн газрын хойд талд номын цагаан лавай нуусан бөгөөд эндээс монгол хүний үр сад шашны эзэн шар малгайтны тэргүүн төрнө хэмээсэн бошиг лүндэнгээр богд лам дээд монгол хүний хөвгүүн болон мэндэлсэн гэдэг. (Богдын намтар 65х) Нийт 18 боть сүмбүмтэй түүний "ДА" боть нь тэр чигээрээ цагийн хүрдний шим болсон төгсөхийн зэрэг "Зогрэмийн жорвоо янлаг дүг" хэмээх бүтээл билээ. Үүнийг товч тайлбарлавал:

རྗེ་རིན་པོ་ཆེའི་སྐུར་བ་ཡན་ལག་བྱུག། Бэлтгэл зургаан гишүүн

- | | | | |
|--------------|----------|---|--------|
| 1. སོར་སྐྱད། | Сордүд | - | Орой |
| 2. བསམ་གཏན། | Самдан | - | Магнай |
| 3. སྲོག་ཚུལ། | Сорогзол | - | Хүзүү |
| 4. འཛིན་པ། | Зэнба | - | Зүрх |
| 5. རྗེས་བྲལ། | Зэдэн | - | Хүйс |
| 6. ཉིང་འཛིན། | Дэнзэн | - | Нууц |

Сордүд, самдан, сорогзол, зэнба, зэдэн, дэнзэн хэмээхийн судасны 6 орон бээр дамжуулагдах увдис эрдмийн талаар Замбуулинд анх удаа маш дэлгэрэнгүйгээр энгийн хүмүүнд ойлгогдохоор (орой магнай, хүзүү, зүрх, хүйс нууцын хүрдний талаар) дэлгэрэнгүй тайлбарласан байдаг. (да боть дотор нь буй).

Түүний эрхэм шавь Жалцавжий бээр 1364 онд төвдийн лхасын ойролцоо мэндэлсэн нийт 8 боть сүмбүмтэй анхны “ГА” боть дотор нь ལྷུལ་ཚབ་རྗེའི་དུས་ལའོར་རིམ་གཉིས་ཀྱི་རྣམ་བཤག

"Дүйнхор ремни намшаг" хэмээх номондоо үйлдэхийн зэрэг болон төгсөхийн зэргийн талаар нийт 58 хуудас бүтээл байдаг. Үүндээ үйлдэхийн зэрэг болон төгсөхийн зэргийн талаар хамгийн ойлгомжтой оновчтой тайлбарласан. Жишээлбэл Дүйнхорын хот мандалд 722 лха тэнгэрийг байрлуулан (цомбо годлон) лайжалчог буюу бэлтгэл үйлийн дарааллыг

жилхоржалчог буюу хот мандлын бясалгалаас ялгаж өгсөн онцлогтой бүтээл юм..

Мөн эрхэм шавийн нэг болох མཁའ་ལྷན་གྱི་རྗེ། Хайдавжий бээр:

1385 онд Төвдэд мэндэлжээ. Нийт 12 боть зохиолтой, түүний 5-н ботинд нь цагийн хүрдний номлол байдаг ба хот мандалын үйлдэл буюу жинхор жилчог болон хот мандлын ажил буюу лайжилчогийн талаар дэлгэрэнгүй бичсэн.

Ванчин богдын анхдугаар дүр བན་ཚེན་སློབ་བཟང་ཚོས་ཀྱི་རྒྱལ་མཚན།

Ванчин лувсан чойжий жалцан бээр 1567 онд Төвдэд мэндэлсэн ба нийт 5 боть номтой боловч сүмбүмд ордоггүй сүрэв судар ихтэй цагийн хүрдний номлолыг “ГА” боть “Дэцэн а” буюу 5-н бүлэгт хуваасан төгсөхийн зэргийг номлосон. ཏུས་འཁོར་

འགྲེལ་ཚེན་གྱི་ཡང་སྟོན་། Дүйнхорын тайлбарын зүрхэн хэмээх

хураангуй 184 хуудас бүхий дүйнхорын номлол байдаг.

Титэ жамъяан түвдэн нямаа སྡེ་བྲི་འཇམ་དབྱེངས་ཐབ་བསྟན་ཉི་མ།

1779 онд Төвдийн Амду нутагт төрсөн. Нийт 5-н боть сүмбүмтэй ба түүний “ГА” боть цагийн хүрдний номлол нянба хийх ёс вангийн талаар нялхасын 7, дээд 4, дээдийн дээд 4, доржловонгийн 1, нийт 16 вангийн талаар ялгаж дэглэж бичсэн байдаг. Мөн жинсрэг өргөх ёс лагшны болон шижа вандагийн жинсрэгийн ялгааны талаар бичсэн.

Нийт 17 боть сүмбүмтэй, “ХА” боть дотор “Салам” тэргүүтэй бүтээлүүддээ, орчлонгийн тогтоцыг эхийн хэвлий дотор буй болох хүүхэдтэй зүйрлэн цагийн хүрдний номлолоор гүн утга агуулгатай урьд өмнө байгаагүй тайлбарыг 12 шүтээн барилдлагатай хослон тайлбарласан байдаг.

Зая Лувсанпэрэнлэй гэгээнтэн ཇོ་ཡ་དགེ་རྒྱལ་སྤོ་བཟངས་ཤིན་ལས།

Заяын санеэг хэмээх 4-н боть сүмбүмгийн бяцхан “А” ботид Дүйнхорын нянба дүвцэлийн талаар дэлгэрэнгүй бичсэн байдаг.

Булган аймаг Дайчин вангийн хүрээний гача лам Дамба

аграмбын бичсэн: གྲུབ་པའི་གནས་མཚོན་དཔལ་ལྷན་འགྲུ་ལར་གྲོད་པའི་

ལམ་གསལ་བར་བྱེད་པའི་རིན་ཆེན་ཤེལ་གྱི་ཐེམ་སྐས།

"Шамбалд зорчих замыг гийгүүлэгч эрдэнийн болор шат" хэмээх бүтээлдээ Шамбалын орны талаар, түүний байрлах газар орон нутгийн онцлог, тэнд амьдарч буй хүмүүсийн сүсэг бишрэлийн талаар бичсэн байдаг.

Их хүрээний гавж Бизъяагийн их лам Агваан

Дамдинсүрэнгийн: འགྲུ་ལའི་ཞིང་གི་བཀོད་པའི་འདོན་སྒྲིགས་ཚོས་རྒྱལ་

རིག་ལྷན་ལ་མཚོན་པའི་ཚོ་ག་ཀ་ལ་བར་བཀོད་སྐུར་ལམ།

"Шамбалын орныг байгуулах утга номын хаадад тахил өргөх дөт зам" хэмээх зохиол буй. Үүнд Шамбалын орны түүх болон номын 7 хаад, удам залган сонгогдох Шамбалын 25 хаадын онцлол зэргийг тодорхой бичсэн байдаг.

Угалзын лам хэмээн алдаршсан Лувсанжамц ламтан бээр цагийн хүрдний номлолын оройд гарч, түүгээр авшиг өгөх зиндаанд хүрсэн ба 1935 онд Дүйнхорийн ван айлдаж байх тэр үед нэгэн хөвгүүн бээр дарагдаж нас нөгцсөнд ламтанг хүний амь хөнөөсөн хэмээн яллаж байжээ. Угалзын ламтан одоогийн Булган аймгийн нутагт мэндэлсэн бөгөөд цагийн хүрдний номлолоор 3 боть бүтээлтэй дэлхийд гайхагдах монгол эрдэмтэн билээ.

Жалханз хутагтын ёнзон Минжүүр Дэчин Ширав ламтаны: "Оюуны орны дээд Шамбалд төрж Рэгдиндагвын шашин лугаа учрахын ерөөл, сайн хувьт шавийн эрдэнийн гишгүүр" хэмээх бүтээлдээ Ерөөл тавихын тайлбар сэлт хийгээд төрөл хоорондын бардо буюу завсрын төрөл, түүний шинж чанарыг харуулсан бүтээл байдаг.

Мөн Богдын Шамбалын ерөөл зэрэг ба миний мэдэхгүй монгол лам нарын зохиосон олон зохиол буй гэдэгт би эргэлзэхгүй байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЦАГИЙН ХҮРДНИЙ НОМЛОЛЫН БҮТЭЦ АГУУЛГА

"Цагийн хүрд хэмээх" ойлголт нь орчлон ертөнцийн үүсэл, бүтэц тогтоцыг түүний орших цаг хугацаатай уялдуулан авч үзсэн ойлголт. Тиймээс цагийн хүрдний номлолд бурхан шашны ертөнцийн бүтэц тогтоц төдийгүй түүний өөрчлөлт хувирлыг од гарагийн хөдөлгөөн, амьд амьтаны амьдарлын хэмнэлээр "гадаад", "дотоод", "бусад" хэмээх гурван утгаар илэрхийлсэн байдаг.

Гадна дүйнхор болон гадна цагийн хүрдийг маш хураангуйгаар тайлбарлавал "цаг" буюу **дүй** гэдэг нь **12 сар, 365 хоног, 7 гараг, 28 од, 12 орд** зэргийг нэрлэж болох бөгөөд **хор буюу хүрд** гэдэгт нь **жилийг** дүйцүүлж болно. Яагаад гэвэл нэг жилд 365 хоног ээлжлэн эргэдэг, хулгана, үхэр тэргүүтэй 12 сар дараалан эргэдэг, миндүг нарма, тэргүүтэй 28 од, ням, даваа тэргүүтэй 7-н гараг ээлж дараалан эргэдэг зэрэг нь гадна цагийн хүрдэнд хамаарагдана.

Цагийн хүрдний номлолын цаг гэдэг үг хамаг амьтны нийтийн үйлийн хүч боловсрох цаг гэдгээс эхлэн орчлон галав юулж үгүй болсныг нь өнгөрсөн цаг, ертөнц тогтохын цагийг одоо цаг гэх мэтээр тайлбарлаж болно. Яагаад гэвэл ертөнцийг **ᠰᠡᠮᠡᠮᠡᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ**

эхлэл төгсгөлгүй гэх боловч тодорхой нэг хэсгийг цаг хугацаагаар авч үзэж болдог. Тиймээс **цаг** гэдэг бол орчлонг тайлахын **түлхүүр** юм. Үүнтэй уялдуулан хүрд гэдэг ямарваа нэгэн зүйл хөдөлж буйг хэлдэг бөгөөд үл хөдлөх зүйл нь амьгүй болж таардаг учир цаг, хүрд хоёр бол арга билиг болж байна.

ЦАГИЙН ХҮРДНИЙ НОМЛОЛЫН ТОВЧ ГУРВАН УТГА

Хайдавнорсонжамцын “Их тайлбарын хэргүй гэрлийн чимэг” хэмээх сударт цагийн хүрдний номлолыг “гадаад”, “дотоод”, “бусад” хэмээх гурван утгаар бүхэлд нь илэрхийлэн гаргасан байдаг ба тэр дагуу цагийн хүрдний номлолын бүтэц агуулгыг авч үзье.

1. **Гадаад** гэдэг агуулгаар очир тамаас эхлээд хүсэлт зургаан орчлон сүн далай, сүмбэр уул, дүрст орчлон, дүрсгүй орчлон түүний зохицон эргэлдэх ёсыг харуулдаг ба ялгуулсны дувааз Намжү бандангийн 6 өнгөөр гадаад агуулгыг төлөөлүүлнэ. (Зураг 12-ыг үзнэ үү)
2. **Дотоод** гэдэг агуулгаар хүний бие махбодь гадаад орчлонгийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд гадаад орчлонд буй бүх зүйл хураангуйлагдан агуулга хэлбэрээ алдалгүй зохицон орчих ёсыг гаргадаг ба ялгуулсны дувааз Намжү бандангийн үсгийн хэлбэрүүдээр дотоод агуулгыг илэрхийлдэг. "Ерөөлийн хаан" хэмээх сударт хумхийн тоос бүрийн дээр бурхан болон түүний орон нөхөр сэлт буй, тоос болгоны төдийд орчлон оршино гэдэг. Эрдэмтэн Фейербах: байгалийн мөн чанарыг танин мэдэх түлхүүр хүн гэсэнчилэн, дотоод цагийн хүрд, болох хүний бие махбодио мэдэх нь ертөнцийг ойлгох түлхүүр болно.
3. **Бусад** гэдэг утгаар:
Үйлдэхийн зэрэг - үүгээр Дагжид буюу Лха тэнгэрийг өөрийн биеэн дээр байрлуулан Жинхаржалцог буюу хот мандалын төвийг байгуулдаг ёс билээ.
Төгсөхийн зэрэг - үүгээр өмнийн огторгуйд бурхадыг залж залсан бурхад дээр өөрийн биед байгуулсан бурханы хот мандалаа нийлүүлэн бясалгаж төв судас болон рома, жама судсаар дамжуулан оройн, хоолойн, зүрхний хүйсний,

нууцын орнуудад баясал, ялгамжаатай баясал, дээдийн баясалыг төрүүлдэг төгс бясалгалыг хэлнэ.

Цагийн хүрдний авшиг нь нялхсын 7-н авшиг, Дээд 4-н авшиг, Дээдийн дээд 4-н авшиг, Дорж ловонгийн авшиг нийт 16 авшгийг хүртээдэг. Үүнийг хүртсэнээр Рэгдэндагва хаан энэ Замбуулинд залрахад эхний шавь болох Хувь төгөлдөр болж энэ насандаа барцад саадгүй болно хэмээжээ.(Хайдавжи гэгээний "Цагийн хүрдний номлолоос")

ГАДААД ЦАГИЙН ХҮРД ХЭМЭЭХ ДЭЛГЭРЭНГҮЙ АГУУЛГА

“Гадаад цагийн хүрд” хэмээх ойлголтоор сав ертөнц доторх шимийн амьтны шүтэн барилдлагааг бэлгэддэг ба **ус, гал, хий, шороо, уулс, ургамал** нь бие биенээ шүтэн зохилдож дээрх арван үсэгт тэмдэгтийн “яа” үсэг хийн махбодь, “га” үсэг гал махбодь, “ба” үсэг усан махбодь, “ла” үсэг шороон махбодийг төлөөлдөн гадаад ертөнцийг бэлгэдэнэ. “Хам”, “ча”, “ма” гэх мэт гурван үсэг дүрст, хүсэлт, дүрсгүй орчлонд орших шимийн амьтдыг бэлгэдэхээс гадна нар, сар, дөл гурав нь “амь”, “илч”, “огторгуйг” төлөөлнө.

Гадаад бэлгэдлийн хүрээнд орчлонгийн тогтоц болон бүтэц цагийн хүрдний номлолын ёсоор тайлбарлавал (Төвдийн эрдэмтэн хуврага Хайдав норсонжамцын онолоор)

ОРЧЛОНГИЙН ТОГТОЦ ҮҮСЭЛ

“Гадаад цагийн хүрд” хэмээх ойлголтонд багтах сав ертөнц орчлонгийн тогтоцыг Төвдийн эрдэмтэн Хайдавнорсонжамц, Жалцавжи Гэгээн, Богд лам Зонхава нарын номлолын дагуу горилогч Ц.Отгонбаяр миний бие доорхи зургыг санаачлан бүтээж үсгэн хэлбэрээс дүрст хэлбэрт (зураг 1) анх буулгахыг оролдсон болой.

Уг зургийг (зураг 1) дороос нь тайлбарлавал хамгийн доод талд хүсэлт 6н орчлон байх ба тэр 6-гын ёроолд халуун 8н там, хүйтэн 8н там ойр орших 1 там, ойр тохиолдох 1 там зэрэг 18 тамын байдлыг дүрслэн, сүмбэр уулын урд байрлах Лхо Замбуулингээс 20 бээрийн дор буй хэмээн зурагласан. Түүний дээр бэрд хэмээх маш нарийн хоолойт мөнхийн харамч амьтныг дүрслэн, түүний дээр адгуусан төрөлтнийг давхарлан зурж, сүмбэр уултай зэрэгцэн очих сүн далайн голд Тагмин рэ хаан, Гүлтэн хаан, Дайжин хаан, Ножин Лхана Шүндог, Ножин Лхана Тивдог, Ножин даной, Жалчиншииг давхарласны дээр сүмбэр уул 80000 багцадын өндөртэй, бөөрөнхий хэлбэртэй, хөх улаан шар цагаан 4 талтай.

76-р хуудасны зургийн тайлбар

Орой дээр нь Шамбалын орон 96 хаад байрлаж буйгаар дүрсэлсэн. Сүмбэр уулыг тойроод 8 гишүүн төгөлдөр далай, сүүн далай, зөгийн балан далай, архин далай, тосон далай, усан далай, давстай далай, гадаад далай гэх мэт далайнууд, алтан уул, анжис хэлбэрт уул, суман модон уул, үзэсгэлэнт уул, морины чих хэлбэрт уул, хүрээний гадна уул, очирт хүрээ гэх 7 уул, 7 тивээр салаавчлан тойрч, 4 том тив, 8 бага тив, гадаад далайн чигтэй сүмбэр уулын 4 талд байрлах ба түүнээс дээш хүмүүн төрөлхтөн тэнгэр, асар тэнгэр, дүрстэй 16 орон, дүрсгүй 4 орон оршдог хэмээн дүрсжүүлэн буулгасан болно.

Дүрст 16 орон

- | | |
|---------------------|---------------------------------------|
| 1. Анхны самади | Цанрэ, Цамбадүн, Цаначин |
| 2. Хоёрдохь самади | Оочүн, Цамайнод, Одсал |
| 3. Гуравдахь самади | Гичүн, Цамаги, Гижэ |
| 4. Энгийн хүн | Брэמיד, Содномжива, Брайвжива, Мичива |
| 5. Хутагтын 4 орон | Мидүнба, Жиндүба, Огмин |


Дүрсгүй 4-н орон:

1. Намхайтаяа
2. Намшитаяа
3. Жияамэд
4. Сэрза

Хүсэлт 6-н орон:


- | | |
|-----------|----------------|
| 1. Там | 2. Бэрд |
| 3. Адгуус | 4. Асар тэнгэр |
| 5. Хүмүүн | 6. Тэнгэр |

Доорхи зурагт (зураг 13,14) түшиглэн Төвдийн эрдэмтэн хувраг Хайдүвнорсонжамцын онолоор тайлбарлая:




Хайдувнорсонжамц "Дэлчин дэмид одын жан" буюу Их тайлбарын хиргүй гэрлийн чимэг хэмээх номын дүйнхорын бүлэгтээ орчлонгийн тогтоцын талаар: "Нэг орчлон галав юүлж үгүй болоод хоосрох тэр цагт (юу ч үгүй болох), (огт – торох – юм - үгүй буюу огторгуй мэт болох) **шорооны** үл үзэгдэх жижиг биетүүд үнэр, дүрс, амт, мэдрэхүй, дуу тэргүүтэй 5-н эрдмийн мөн чанартай, **усны** жижиг биетүүд дээрхийн адил үнэрээс бусад 4-н эрдэм төгөлдөр, **гал махбодь** мөн дээрхийн адил дүрс, үнэрээс бусад 3-н эрдэм төгөлдөр, **хийн махбодь** үнэр дүрс амтнаас бусад 2 эрдэм төгөлдөр, **огторгуй** нь ганц дуу эрдэмтэй, энэ мэт 5-н махбодь хоосон орон зайд холилдон маш нарийн тоосонцор бий болж **амьтны нийтийн үйлийн хүч боловсрох цагийн эрхээр** эхлэн хийн тоосонцор хоорондоо барьцалдаж хөнгөн бөгөөд хөдөлдөг хийн мөн чанартай болоод гал махбодтой нийлж цахилгаан цахих мэт гэрлийн хурдтай болон усан махбодтой холилдон бороо мэт мөн чанартай болмогц шороон махбодтой холилдон нум мэт хөвчирсэн хатуу байдалтай болоход огторгуй махбодь бусад 4-н махбодь доо тэгш тархаж мөнхийн огторгуй бус мөнх бусын нэгэн болдог.

Зураг 14

*VIII Гармапа Мэжид Доржийн бүтээл*


Улмаар арвижин доороосоо хийн хот мандал, гал хот мандал, усан хот мандал, шороон хот мандал болон зузаарч 55000 багцад хэмжээтэй давхарлан орших бөгөөд нэг нь нэг дотроо багтахар дээшээ харсан конус хэлбэртэй тогтож сүмбэр уулын бүтцийг бүрдүүлдэг. Дороосоо 4 дэх шороон хот мандал 18 тэгш хэсэгт хуваасны хэсэг тус бүрт 6-н тив, 6-н уул, 6-н далай нь салаавчилан орших Дава, Одгар, равчогчүша, мэ-ам-жи тантүн, дагву гэх 6-н тив түүний гадуур зөгийн бал, тос, тараг, сүү, ус, архин далай, түүнийг хүрээлэн Одон, Мандара, Нихадан, Норовод, Донадан, Силрэ хэмээх 6-н уул нь өндөр нам адил байх ба Силрэ гаднаас усан хот мандалын дотор хязгааргүй хүртэл 25000 багцад байхын шороон хот мандал нэг хувьд байхын 7-н тивийн 7-р нь их Замбуулингийн газар гэдэг. (зураг 14,15)

Зураг 15




Энэхүү зураг нь Энэтхэг дэх эм зурхайн сургуулийн музейд хадгалагдаж буй цагийн хүрдний номлолын орчлонгийн тогтоц, бүүдүүвч зураг болой.

Зураг 16




Энэхүү зураг нь Түвдийн нийслэл Лхас дахь Потала хэмээх ордонд буй зураг V далай ламын үед бүтээгдсэн Авирдармын ёсны орчлонгийн тогтоцыг харуулсан бүтээл

Зураг 17



Энэхүү зураг нь Энэтхэгийн эм зурхайн салбараас гаргадаг Литин нүүр хуудсан дээрээс авсан гадаад цагийн хүрдний зураг, схем

Зураг 18



Энэхүү зураг нь Отгонбаярт хадгалагдаж буй гадаад цагийн хүрд, 12 жилээр тойрон эргэх, 5 махбодиор тойрон эргэхийг үзүүлсэн.


Тэгээд Сүмбэр уулын эргэн тойронд 12 хуваагаад 12 тив, 12 хэсэг газар болжээ. Хийн хот мандалаас дээш 5000 багцад 33-н тэнгэрийн орноос доош 50000 багцад тамын орон гэжээ. Усан хот мандалын харалдаа дор хүйтэн там, гал мандалын харалдаа дор халуун там оршино хэмээжээ.

Үүнд: Зүүн пагвалин бөөрөнхий, Урд Замбуулин гурвалжин, Хойд даминин саран дугуй, Баруун баланжид дөрвөлжин хэлбэртэй байх ба 4-н том тив, дагуул жижиг 8-н тивтэй нийлээд Замлин жүни буюу 12 тив тогтжээ.

13, 14, 15, 17, 18 зургууд нь цагийн хүрдний номлолын онолын дагуу ертөнцийн тогтоцыг олон талаас нь илэрхийлсэн олон мэргэдийн үзэл санаа бясалгал бүтээлийн үр дүн юм. Үүнээс 16-р зураг нь Авидармагийн номлол буюу Васубандугийн үзлээр ертөнцийн тогтоцыг харуулна. Авидармагийн номлол дахь ертөнцийн тогтоц нь дүйнхорын номлолынхоос зөрөөтэй байгааг зурган дээрээс бэлхэн харж болно. Авидармагийн номлолоор Сүмбэр уул дөрвөлжин хэлбэртэй бөгөөд дүрст орчлон нь арван долоо байдаг бол Цагийн хүрдний номлолд Сүмбэр уул нь конус (15-зураг шиг) хэлбэртэй, дүрст орчлон 16 байдгаараа ялгаатай. Цагийн хүрдний номлолд Сүмбэр уулын орой дээр нь Шамбалын орон байдаг бол Авидармын онолоор Сүмбэр уулын орой дээр 33 тэнгэрийн орон байна хэмээжээ. Бүтцийн хувьд өөр олон онцлог ялгаа байгааг зурган дээрээс харж болно. Цагийн хүрдний номлолын эдгээр зургуудад тусгасан орчлон ертөнцийн тогтоцын тухай ойлголт орчин үеийн шинжлэх ухааны тайлбаруудтай ижил төсөөтэй зүйл олон бий.

Цагийн хүрдний номлол дахь орчлон ертөнцийн тогтоцыг зургаар илэрхийлж ирсэн арвин уламжлалтай билээ. Эдгээр зургууд нь орчлон ертөнцийн тогтоцыг олон өнцгөөс харах бололцоо олгодог. Сүмбэр уул, 12 тив бүхий орчлон ертөнцийн тогтолцоог дээрээс нь харуулсан дор үзүүлсэн зураг ийм бүтээлийн нэг юм. (Зураг 19)

Орчлон ертөнцийг дээрээс нь харсан план зураг болой




Энэхүү зураг нь дээрхийн гэгээнтэн XIV далай лам Данзанжамцын Намжира дацангийн лам нар эмхэтгэсэн "Whole times" хэмээх номонд байх ба энэ зургийг VIII Гармапа Мэжид дорж бүтээсэн байж магадгүй хэмээн зургийн тайлбарт бичигдсэн байдаг.

Орчлон ертөнцийг 12 орд тойрон эргэх ба эдгээр ордыг мөн зургаар илэрхийлэн харуулсан, тэрийг дор толилуулья. (Зураг 20)

Зураг 20

Орчлон түүнийг тойрон эргэх 12 ордын хамтаар дүрсэлсэн зураг



Ертөнцийг 12 орд тойрон эргэх нь хүмүүн болон амьтдад хамааралтай харилцан шүтэлцээтэйг харуулсан схем. Энэхүү зургийг "Цагийн хүрдний номлол" хэмээх англи сэтгүүл дээрээс буулгав.

Орчлонг тойрох ордын байрлалыг зурхайн ухаанд тооцдог уламжлалтай ба дараах 12 орд юм:

1. **Хумхын орд** Барсын үс дэлгэрч, дуу нь гарч, гүйдэл нь эхэлдэг тул энэ сарыг Барс сар, хумханд хөлдсөн ус уярах

- тул энэ сард наран байрлаж буй оддын ордыг Хумхын орд хэмээжээ. Наран Хумхын ордонд байрлах үед яв, юм суугаа золгоно.
2. **Загасны орд** Туулай хэвтрээсээ гарч хэвтдэг үе учир энэ сарыг туулай гэх бөгөөд, загасны орд эвдрэх тул энэ үед наран байрлаж буй оддын ордыг Загасны орд хэмээнэ. Наран Загасны ордонд байрлах үед яв, юм босоогоор золгоно.
 3. **Хонины орд** Луун дуун анх гарах тул энэ сарыг луу сар, хонь хургалах үе тул энэ үед наран байрлаж буй оддын ордыг хонины орд хэмээжээ. Наран Хонины ордонд байрлах үед яв, юм суугаа золгоно.
 4. **Үхрийн орд** Могойн хальс гууждаг тул Могой сар, үхрээр анжис чирж тариа тарих цаг тул энэ үед наран байрлаж буй оддын ордыг үхэрийн орд хэмээн нэрлэжээ. Наран Үхэрийн ордонд байрлах үед яв, юм босоо золгоно.
 5. **Хамтатгахын орд** Адуу нийлэлтийн үе тул энэ сарыг Морин, ихэнх амьтны үржих үе тул энэ үед наран байрлаж буй оддын ордыг Хамтатгахын орд хэмээжээ. Наран Хамтатгахын ордонд байрлах үед яв, юм суугаа золгоно.
 6. **Мэлхийн орд** Хонь хяргах үе учир энэ сарыг Хонин сар гэсэн ба морин мэлхийн дуу гарах үе учир наран байрлаж буй оддын ордыг Мэлхийн ордон хэмээн нэрлэжээ. Наран Мэлхийн ордонд байрлах үед яв, юм суугаа золгоно.
 7. **Арслангийн орд** Бич болон арслангийн ороо ордог үе тул энэ сарыг бичин сар гэсэн ба наран байрлаж буй оддын ордыг Арслан хэмээн нэрлэжээ. Наран Арслангийн ордонд байрлах үед яв, юм суугаа золгоно.
 8. **Охины орд** Тахиа хүчир болсон тул сарыг Тахиа сар, өчүүхэн охидын царай гуа үзэсгэлэн төгөлдөр болдог тул наран байрлаж буй оддын ордыг Охины ордон хэмээжээ. Наран Охины ордонд байрлах үед яв, юм суугаа золгоно.

9. **Жинлүүрийн орд** Нохойн гүйдлийн цаг тул энэ сарыг Нохой сар гэсэн ба тариа ургацаа хураан авч жинлэх үе тул энэ үед наран байрлаж буй оддын ордыг Жинлүүрийн ордон хэмээнэ. Наран Жинлүүрийн ордонд байрлах үед яв, юм суугаа золгоно.
10. **Хилэнцийн орд** Гахай хүчир болох тул энэ сарыг Гахай хэмээх бөгөөд амьтад нүхэнд орж ичиж дуусдаг тул наран байрлаж буй оддын ордыг Хилэнцийн ордон хэмээн нэрлэнэ. Наран Хилэнцийн ордонд байрлах үед яв, юм босоогоор золгоно.
11. **Нумын орд** Хулгана үүрээ засч, хөөөгөө хураах үе тул энэ сарыг Хулгана, хүйтэнд нум царцан хөлдөх үе тул наран байрлаж буй ордыг Нумын орд хэмээн нэрийдмүй. Наран Нумын ордонд байрлаж байх үед яв, юм суугаа золгоно.
12. **Матрын орд** Ихэд хүйтэрч үхрийн хэвтэш хөлдөх тул энэ сарыг үхэр гэсэн ба матар даарч усанд шургах тул энэ үед наран байрлаж буй оддын ордыг Матрын ордон хэмээн нэрийдмүй. Наран Матарын ордонд байрлах үед яв, юм хэвтээ золгоно.

Энэхүү 12 орд нь Төвд болон Энэтхэг цаашилбал Дорнын зурхайгаас өвөрмөц ялгаатай ба Монгол орны цагийн хуваарьт тохируулан үйлдсэн. Дээрхи 12 орд ертөнцийг тойрон эргэх шүтэлцээг Хайдавжи гэгээний Галбун хэмээх сүмбүмгийн битүү "гаа" ботиос сэдэвлэн зурсан бөгөөд 12 ордны тайлбарыг Монголын үндэсний шинжлэх ухааны академич, шинжлэх ухааны доктор, профессор, зурхайч Л.Тэрбишийн XVII жарны харшлалт хэмээх шороон үхэр жилийн монгол зурхайн цаг тооны бичгээс буулган авсан болмой.

Энэ цагалбар нь

Огторгуйд орчигч одон гараг

Орчлонгийн амьтанд сайн муугаар нөлөөлмүй


Огоорч авахыг мэдүүлэхийн тулд

Оддын зурхайг бичвэй би хэмээн айлдсан Монголын анхны хүрээ хамба ламын гэгээний анхдугаар дүр, Лувсанданзанжанцаны монгол үндэстэнд зориулан зохиосон оддын зурлагаас улбаатай билээ.Энэ нь цаанаа оддын зурхай гадаад цагийн хүрдний номлолоос үүдэн гарсан ба эртний монголчууд ахуй амьдралаа гараг эрхэстэй /17н жаран буюу мянга гаруй жилийн тэртээгээс /тохируулсаар ирсэн нь гадаад цагийн хүрдний номлолыг аль эрт ойлгосны баталгаа юм.

Монгол эрдэмтэд цагийн хүрдний номлолыг судалж, ахуй амьдралдаа ашиглаж хэрэглэж ирсний нэг жишээ бол орчлон ертөнцийн тогтцыг түүнийг тойрон эргэлдэх од гарагийн хэмнэлтэй уялдуулан илэрхийлсэн зургууд юм. Бүтээсэн хүний нэр төдийлөн тодорхойгүй боловч цагийн хүрдний номлолыг “гадаад” хэмээх утгаар нь илэрхийлсэн дорхи зураг үүний баталгаа болно.


Доорхи гадна цагийн хүрдний тайлбар хүснэгт зургаас харахад огторгуйн хязгааргүй уудамд "ям" үсгээс гарсан хийн хот мандал бөөрөнхий хэлбэртэй хөх өнгөтэй бөгөөд түүний дотор хүрээнд 28 од тойрч эргэдгийг харуулж байрлуулсан бол, түүний дараа цантэг, сүртэг татаж 12 хэсэг хуваасан нь 12 ордыг төлөөлүүлж үзүүлсэн ба түүн дотор 12 тивийг багтаасан 12 бөөрөнхий тэгээр 12 сарыг харуулаад дотор хүрээнд сүмбэр уулыг тойрон эргэлдэх 7-н тив, 7-н далай, 7-н уулыг үзүүлсэн бол зуйван тойргоор нарны замыг харуулсан байна.

Монгол эрдэмтдийн зохиосон гадаад цагийн хүрдний систем




Зураг 21


Хумх загас тэргүүтэй 12 орд ээлжлэн буйг энэхүү трапец маягийн дүрсээр харуулсан.



12 бөөрөнхий дугуйгаар тойрсон 12 сарыг үзүүлсэн.



12 сарыг үзүүлсэн 12 дугуй дотор давхар дугуй байх ба тэр нь 8 хуваагдсан байгаа нь 8 гарагийг илэрхийлнэ. Дүйнхорын ёсонд даажин, дүмэ хэмээх гарагийг нэмээд 8 гэж тоолдог.




Сүмбэр уулын дээрээс харахад бөөрөнхий хэлбэртэй байдаг.

Сүмбэр уулыг тойрон сүүн далай тэргүүтэй 7 далай, 7 тив, 7 уул оршиж буйг илэрхийлсэн.

Үүгээр гадаад төмөр хүрээг харуулсан.

Энэхүү хүрээгээр Тагар Брани тэргүүтэй 28 одыг түвд үсгээр бичиж илэрхийлсэн.

Хамгийн гадна талд буй гал хүрээгээр огторгуйн хүрээ хийн махбодийг зурж тайлбарласан.




Энэхүү зураг нь монгол хүний ур дүйгээр бүтсэн бөгөөд модон бартай давуун дээр барлан түгээдэг байжээ. Чухам хэдэн онд хэн гэдэг хүн бүтээсэн нь тодорхойгүй боловч монгол хүн цагийн хүрдний номлолоо урд өмнө хэзээ ч гаргаж байгаагүй хүснэгтийг модон баран дээр сийлсэн нь цагийн хүрдний номлол монголд оройдоо хүртэл хөгжсөнийг нотлох нэгэн баримт бөлгөө.

ДҮЙНХОР БУЮУ ЦАГИЙН ХҮРДНИЙ БУРХАН

Бурхны шашны салбар бүрийг аль нэг бурхнаар төлөөлүүлэн өнгө төрх, мутрын хөдөлгөөн зэргээр утга санааг нь илэрхийлсэн байдаг. Дүйнхор буюу цагийн хүрдний бурхан нь Цогт Галазагд юм. (Зураг 22)

Дүйнхор буюу Калачакра бурханы гадна талын бэлгэдэл сар болон нарны эрдэм



Цогт Галазагд буюу цагийн хүрдний Дүйнхор бурханы хар цагаан дүрийг "Whole times" хэмээх номоос буулган авсан ба Дүйнхор бурханы 24 мутарт барьсан зүйлийг англи хэл дээр орчуулан харуулсан бурханы дүр болой.

Зураг 22

Дүйнхор буюу цагийн хүрдний бурханы талаар дээрх Зураг 22-н тайлбар

Дүйнхор буюу калачакра бурхан нь жажүд, жоджүд, налжир, ламид гэх дөрвөн жүд язгуур байдгаас ханьцашгүй ёгузор болох ламид ёсонд багтдаг. Гадна талын ажил (сахил сахих, мацаг барих, болон биеийн хүчний ажлууд) дотор талын бясалгал хоёроос гадна талын ажлыг голлож хийдэг бол жаджүд буюу

ажлын дамжлага. Үүнд Цагаан шүхэрт, Ногоон дархи, Манал, Чагдар, Жанрайсаг зэрэг бурхад багтдаг.

Гадна дотно ажлыг зэрэг хийдэг бол жоджүд буюу явдлын дамжлагад хамрагдах ба Намнан, Онжин зэрэг бурхад багтдаг.

Гадна дотно ажил хоёроос доторхи талыг голлож байвал налжоржүд буюу ёгузорын дамжлага үүнд Гүнрэг, Дамдин дорлиг гэх мэт бурхад байдаг.

Зөвхөн дотоод бясалгалыг эрхэмлэдэг бол ламиджүд буюу ёгузорын ханьцашгүй дамжлага хэмээдэг. Үүнд Сандэжигсүм дүйнхор тэргүүтэй ядам бурхад хамрагдана.

Гадна талаас нь харвал калачакра дөрвөн нигууртай ба үүгээр монголчууд дөрвөн улирлыг бэлгэднэ гэдэг. Дөрвөн өөр хөх, улаан, шар, цагаан өнгийн нигуураар үүгээр Сүмбэр уулын дөрвөн тал, хот мандалын дөрвөн хаалганы өнгө, нар, сар, дажин дүмэ гарагийг төлөөлөн хэлдэг.

Дажин гэж сар хиртэхэд рахула залгилаа, нар хиртэхэд мөн түүнчлэн эртний хүмүүс ярьдаг байжээ. Энэ нь дэлхийн сүүдэр сар, наран дээр тусахыг хэлдэг ба сар хиртэхэд дэлхий “Рахула”, нар хиртэхэд дэлхий “дүмэ” болдог учир хойд хоёр нигуурууд нь дажин, дүмээг төлөөлдөг гэж бас үздэг. Зургаан мөрнөөс салбарласан 24 мутар нь 12 сарын, сар бүрийн эхний 15 хоног, сүүлийн 15 хоногийг бэлгэдэж төлөөлөн үзүүлдэг. Мутар болгон барьж буй зүйлээрээ 24 цагийг үзүүлж байдаг. Гар болгон гурван үетэй ба түүгээр дамжсан таван хуруу тус бүр 15 үетэй байдаг нь 24 гарыг 15-үеэр үржүүлбэл 360 хоног илэрхийлдэг. Бас хүн болгонд 360 үе бүхий яс байдаг нь үүнтэй таарч байна.

Эрхий хуруунаас чигчий хуруу хүртэл таван хуруу тус бүр шар, цагаан, улаан, хар, ногоон өнгөтэй энэ нь цаанаа шороо ус, гал хий, огторгуй үзүүлж буй **Нарны эрдэм** болой. Түүнчлэн 24 мутарт мөр, тохой, буглаг гэх гурван үе байх 24 мутарыг 3

үеэр үржүүлбэл 72 цэг болно. Түүнийг арван үсгээр буюу 10 хийгээр эргүүлвэл 720 тэнгэр буй болж калачакрагийн хот мандалыг үүсгэдэг учиртай.

Калачакра бурхан нь баруун хөлөө жийж зүүнээ ялимгүй өвдгөөр нугалсан байдлыг тайлбарлавал: Ер нь хүн үхэхдээ цагаан дусал дээрээсээ доош, улаан дусал доороос дээш өгсдөг бол Дүйнхор бясалгасан хүн түүний эсрэг учраас Дүйнхор бурхны хөлний байрлал үүнийг илэрхийлдэг. Энэ нь **Сарны эрдэм** болой.

ГАДААД ЦАГИЙН ХҮРД БА БУРХНЫ ХОТ МАНДАЛ

Гадаад цагийн хүрдний номлол дахь сансар орчлонгийн бүтцийг бурхны хот мандал хэмээх ойлголтоор илэрхийлдэг бөгөөд мандал өргөх ёслол нь Дүйнхор буюу цагийн хүрдний зан үйлийн чухал хэсэг юм. Цагийн хүрдний ёслолд хэрэглэдэг мандалын жишээг дээрээс нь болон хажуугаас нь харуулсан (Зураг 23, 24) дорхи зургаас харж болно.

Цагийн хүрдний номлол дахь сансар орчлонгийн бүтэц Авидармын ёсныхоос ялгаатай байдаг ба дараа дараагийн судлаачид энэ талаар нарийвчлан судлууштай юм. Зарим ялгааг дорхи зургаар (Зураг 25, 26) харуулбал Авидармын ёсны сансар орчлонгийн тогтоцыг дөрвөлжин хэмээн үздэг нь цагийн хүрдний номлолынхоос ялгаатай болох нь тодорхой байна.

Цагийн хүрдний мандал өргөх ёслолд хэрэглэдэг мандал



Зураг 23



Зураг 24

Цагийн хүрдний номлол дахь сансар орчлонгийн бүтцийг дээрээс нь болон хажуугаас нь бодит материал болох бэлгэдсэн алтан шармал зэсээр хийсэн 9 цомбо бүхий мандалыг дээрээс нь болон хажуугаас нь үзүүлсэн зураг. Энэхүү зургийг Түвдийн Лхаса хотын Потала хэмээх Далай багшийн ордоноос Отгонбаяр бээр өөрийн биеэр очиж авсан болно.

Гадаад цагийн хүрдний номлол болон Авидармын номлолд хэрэглэдэг мандалыг харьцуулсан зураг



Зураг 25




Зураг 26


Авидармын ёсонд сансар орчлонгийн тогтоцыг дөрвөлжин хэмээн үздэг ба мандал өргөхдөө 37 цомботойгоор дэлхий ертөнцийг бэлгэдэж өргөдөг. Энэхүү зургийг бурханы "Тэг" хэмээх Энэтхэгийн Дарамсалаагаас хэвлүүлсэн өнгөт номноос бүүлган авсан болой.

ГАДААД ЦАГИЙН ХҮРД БА ХҮНИЙ БИЕ

Цагийн хүрдний номлолд орчлон ертөнцийг бурхнаар төлөөлүүлэх төдийгүй хүний биеийг орчлон ертөнцийн салшгүй бүрэлдэхүүн хэсгийн хувьд уялдуулан авч үздэг. Орчлон ертөнц хий, гал, ус, шороо зэрэг махбодоос бүрддэг шиг хүний махбод мөн эдгээрээс бүрддэг нь зурхайн ухааны нэгэн тулгуур үндэс болдог юм. Зурхайн ухаан цагийн хүрдний номлолтой холбоотой байдаг нь үүнтэй холбоотой юм. Гадаад цагийн хүрдийг хүний бие дээр хэрхэн төлөөлүүлэн авч үздэгийг дорхи зургаар толилуулан харуулъя. (Зураг 27-30)




Зураг 27




Зураг 28

Дэлхийн бүтэц маш нарийн хий, гал, ус, шороо, ургамал амьтан зэргээс бүрддэг бол хүний бүтцийг адил болохыг нотлон харьцуулсан зураг. Доод талын хар өнгөөр хийн дэвсгэр тавхайнаас өвдөг хүртэл, өвдөгнөөс дээш улаан өнгөөр гал махбодь, түүний дээр цагаан өнгөөр усан махбодь, тэгээд шар өнгөөр шороон махбодийг харуулсан нь урдах зурагтай бэлгэдэлийн хувьд адил төсөөтэй байгаа нь илт харагдаж байна. Энэхүү зургийг жононгийн ёсны тайлбар хэмээх номноос авсан болой.

Зураг 29



Зураг 30



Гадаад цагийн хүрдний номлолыг хүний бие дээр жишин үзүүлбэл Лүн, Мэ, Чү, Са буюу хийн дэвсгэр, гал дэвсгэр, усан дэвсгэр, шороон дэвсгэр дээр лагшин зарлиг Тагаалалын хот мандалыг босгож үзүүлбээс босоо хүний хэлбэртэй байгааг дээрхи 2 зургаар харуулсан ба 4 жагрэ буюу хүрээг босгож Жанцангаар хүний дээд хэсэг болох толгойг бэлгэдэн байгуулсан.


Орчлон ертөнцийн хүрдний систем ба орчин үеийн шинжлэх ухаан

Цагийн хүрдний номлолын цаг гэдэг үг хамаг амьтны нийтийн үйлийн хүч боловсрох цаг гэдгээс эхлэн орчлон галав юүлж үгүй болсныг нь өнгөрсөн цаг, ертөнц тогтохын цагийг одоо цаг гэх мэтээр тайлбарлаж болно. Ертөнцийг, ག་མཐའ་མེད། эхлэл

төгсгөлгүй гэх боловч тодорхой нэг хэсгийг цаг хугацаагаар авч үзэж болдог. Тиймээс цаг гэдэг бол орчлонг тайлахын түлхүүр юм. Үүнтэй уялдуулан хүрд гэдэг ямарваа нэгэн зүйл хөдөлж буйг хэлдэг бөгөөд үл хөдлөх зүйл нь амьгүй болж таардаг учир цаг, хүрд хоёр бол арга билиг болж байна.

Эхлэл төгсгөлгүй гэх боловч тодорхой нэг хэсгийг нь цаг хугацаагаар хэмжиж болдогийг тойрон эргэлдэх хүрдний тухай ойлголт тод томруун илэрхийлдэг. Энэ ойлголтоор орчлон галав үүлэх үзэгдийг илэрхийлж болмоор байгаа юм. Тухайлбал Нар

ба түүнийг тойрон эргэлдэх гарагуудыг бурхны шашинд яригддаг “хүрд”- ний систем маягаар төсөөлж болно. (Зураг 31)



Шинжлэх ухааны нарийн багаж технологиор тогтоогдсон од гаригийн тогтолцоо хүрдний систем

Орчин үеийн шинжлэх ухаанд орчлон ертөнцийг багаж төхөөрөмжөөр судлан физик, химийн шинж чанараар нь тайлбарладаг.

Харин бурхны шашинд, үүнийг дотор цагийн хүрдний номлолд орчлон ертөнцийг бурхнаар төлөөлүүлэн илэрхийлж, амьд маягаар төсөөлөх төдийгүй хүний биеийн хэмнэл, түүний үйлийн үртэй уялдаатайгаар авч үздэг. Тиймээс сургааль нь хүний үйл ажиллагааг амьд хэмээн үздэг ертөнцийн жам ёстой уялдуулан авч үздэг бурхны шашны сургаалийг судлах нь орчин үеийн шинжлэх ухааны хөгжлөөс үүдэн гарч буй дутагдлыг нөхөхөд тус дөхөм болох олон талын ач холбогдолтой юм.


Бурханы шашинд ертөнцийн бүтцийг хүсэлт 6н орчлон болох муу заяаны 3, (там, бэрд адгуус), сайн заяаны 3, (тэнгэр, асар тэнгэр, эрдэмтэн хүмүүн) дүрст орчлонгийн 17 орон, дүрсгүй орчлонгийн 4 орон дороосоо дээш байрлаж түүний голд Сүүн

далай нь Сүмбэр уулаа тойрон 7н далай, 7н тив, 7н уулаар хүрээлэгдэн буй галактик систем гэж үздэг. Үүнийг марксизмын үед коммунистууд материаллаг талаас нь харж нүдэндээ харагдах зүйлийг байна, харагдахгүй зүйлсийг байхгүй гэдэг онолоор олон зуун жил мөрдлөг болгож хүрээлэн буй уул ус лус савдагийг маань эзэн биегүй ертөнцийн эзэд нь зөвхөн бид хэмээн номлож байгаль орчинруугаа хайр найргүй хандаж экологийн тэнцвэртэй байдлыг алдагдуулан дээрхи од гаригийн системд өөрчлөлт оруулахад хүргээд байгаа билээ.

Харин одоогийн шинжлэх ухаанд дээрхи шашны уламжлалт үзлүүдийг үгүйсгэхгүйгээр үл барам үндэсний зан заншил хэв маягийг сэргээхэд ихээхэн хүч хөдөлмөр зарцуулаж байгаа нь оройтсон ч гэсэн эерэг талуудыг гаргаж байна.


Байгалын зарим үзэгдэл, тухайлбал, сүүлийн жилүүдэд газар дэлхий дээр тохиолдсон зарим аймшигдт үзэгдлийг орчин үеийн шинжлэх ухааны үүднээс судалсан бүтээлүүдтэй танилцахад, эдгээр үзэгдлийг “хүрд” хэмээх ойлголттой дүйцүүлж болохоор байгаа нь харагддаг. Үүний зэрэгцээ, дээрх олон үзэгдлүүд нь хүний үйл ажиллагаатай холбоотой болохыг өнөөгийн шинжлэх ухааны үүднээс нотолсон байдаг. Эдгээр үзэгдлийг цагийн хүрдний номлол дахь ус, салхи, шороо, гал зэрэг махбодийн хүрдний системээр илэрхийлж, доорхи зургаар харуулахын хамт, хүний үйл ажиллагаа, үйлийн үр дагаварыг чухалчилдаг бурхны шашны үзэл санаа ямар ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэхийг хүсч байна.

Цунами хэмээх аймшигт усан хүрдний систем



Зураг 32

Энэхүү аймшигт усан галавыг эхлэх цаг, байршил, хамрах




Зураг 33

хүрээ, маршрутыг орчин үеийн шинжлэх ухаан дэвшилтэт тоног төхөөрөмжөөр урьдчилан мэдэж байгаа боловч зогсоох ямарч боломжгүй хүчин мөхөсдөж байна. Тэгээд яагаад аюул болов гэдэг асуултанд цаг уурын болон физик, химиин урвал үзэгдэлээр

тайлбарлах нь төгс бус үүнд зөвхөн цагийн хүрдний номлолыг судалж бясалгаж дадуулсанаар хариулт өгөх боломжтой.

Катарина хэмээх аймшигт хар салхины хүрдний систем

Зураг 34



Газар хөдлөлтийн гамшиг буюу шороон хүрдний систем

Зураг 35



Дэлхийн цөм болох халуун магми хэмээхийн таталт түрэлтийн хүрднээс хамааран газар хөдөлдөг болохыг эрдэмтэд судлан тогтоосон хийн болон галан хvллийн систем

Дээрхи аюулт үзэгдлийн дотроос хий махбодын хүрдийг төлөөлөх “циклон” хэмээх үзэгдлийг орчин үеийн шинжлэх ухаанд хэрхэн тайлбарласаныг авч үзье.

Агаарын урсгал муруйж, тэр ч байтугай эргэж хургаж байдаг бөгөөд нар буруу чигтэй хургаа салхины төвд агаарын даралт бага, нар зөв чигтэйн төвд даралт их байдгаас эдгээрийг их, бага даралтын төв гэж нэрлэдэг. Урсгалын чиг нь нар буюу бага даралтын орныг хургаа буюу дэлхийн ихэнх улс орон “Циклон”, нар зөв чиглэл бүхий урсгалтай, их даралтын орныг эсрэг хургаа буюу эсрэг циклон хэмээн нэрлэж заншжээ. Циклонд агаарын өгсөх хөдөлгөөн ихээхэн үүсэх учир үүл үүсэж хур орох, эсрэг циклонд уруудах хөдөлгөөн их учир үүл замхарч, тэнгэр цэлмэх тул цаг агаарын горимд их нөлөө үзүүлэх ажээ.

Агаар мандалын фронт гэдэг нь 2 өөр төрлийн агаарын массын хоорондох заагийг хэлнэ. Газрын гадарга орчмын агаарын массуудын хоорондох шилжилтийн бүсийг фронтын шугам гэх ба түүний өргөн хэдэн арван км-т хүрдэг байна.

Манай цаг уурын шинжлэх ухаанд хур тунадас орох процессыг физик болон химийн шинж чанараар нь ийнхүү тайлбарлах ажээ. Яагаад вэ гэдэг асуултанд бид хариулж мэдэхгүй байгаа. Дэлхий дээр шинжлэх ухаан технологи хөгжсөн АНУ тэргүүтэй NASA гийн байгууллагууд хүртэл Цунами хэмээх усны аюул, Катарина хэмээх далайн хар салхийг үүсэх процессыг өдрийг нь хүртэл зөв тогтоон одоо тэнд явж байна, тэдэн км/с-ын хурдтай гэх мэт тодорхойлж чаддаг боловч үүний эсрэг арга хэмжээ авч чадахгүй хүчин мөхөсдөж байгаа нь дэлхий ертөнцийн жинхэнэ эзэд нь бид биш гэдгийг харуулж байна. Иймээс гадаад орчноо өөртэйгөө бус гадаад орчинтойгоо өөрсдөө зохицон амьдрах үйлийн үрээр бүтээгдсэн гэж Авидармын ёсонд **лай ла жигдэн нацаг** гэж тодорхойлсон байдагчилан бид өөрсдийн нийтийн буяны үйлийг арвижуулан дэлгэрүүлж байж гэмээнэ ирэх аюулыг сөрж чадах болно хэмээн үзэж байна.

Мөн бурханыг мэдэхгүй бол бугыг эхлээд тань гэдэг шиг дэлхий ертөнцийн тогтолцоог мэдэхгүй бол өөрийнхөө биеийг судлах нь хамгийн чухал гарц болно хэмээн **Рангийн лүла бэлинла шанла нодво ма жид жиг** өөрийн биеэр жишиж бусдыг бүү хорло гэдэг зарлигчилан 10 цагаан буяны үйлийг дэлгэрүүлж гэмээнэ дэлхий ертөнцийн сүйрлийн аюулыг 1 өдрөөр ч гэсэн цаашлуулж чадна гэж бодох хэрэгтэй санагдана. Ийм ч учраас барууны соёлтой орнууд бурханы шашны уламжлалыг дагаж тэргүүн технологийг нь ашиглаж байгаагийн нэг жишээ нь Төвдийн дээрхийн гэгээнтэн XIV Далай лам Данзанжамцыг дэлхий дээр дээгүүрт тооцогдох нобелийн шагналаар шагнаж, АНУ-ын конгрессийн алтан одонгоор энгэрээ мялаалгаж, дэлхийн 8 том гэгдэх улс орны ерөнхийлөгч, ерөнхий сайдын түвшинд

хүлээн авч уулзаж байгаа нь бурханы шашны худал үгүй номлолын үр шим хэмээн үзэж байна.

Гал, ус, хий, газар хэмээх 4 махбодийн аюул эх дэлхийд маань байнгын сүйрэл дагуулж байгааг бид олон зуун жилийнхээ турш тэмдэглэн үлдээж ирсэн боловч түүний эсрэг бодитой зүйлийг хийж чадаагүй байгаа билээ. Тэгэхээр материаллаг эд зүйлээр эсэргүүцээд, бороо оруулах гэж тэнгэр лүүгээ буудах, шинэ орон зайг нээх гэж сансарт пуужин хэмээх төхөөрөмжийг илгээн азоныхоо давхаргыг цоолж амьсгалах агаараасаа салах үндэслэлийг хийж байгаа нь техникийн дэвшил гэх боловч сүйрлийн эхлэл гэдгийг ойлгох нь зүйтэй. Манай бурханы шашинд материаллаг зүйлээр биш сэтгэлийн бясалгалаар гадаад орчныхоо өмөг түшгийг авч чадна гэж номлосон байдаг.

Гадаад цагийн хүрд гэдэг ухагдахуунаар орчлон ертөнцийн эргэх, орших ёсыг харуулж буй бөгөөд үүний хөдөлгөөн бүр нь 12 шүтэн барилдлагааны дагуу явагддаг бөгөөд ийм учраас цунами, катрина гэх мэт аюул гамшгийг гэтлэн давахын тулд физик болон химийн шинжлэх ухааны үүднээс нь тайлбарлахаас гадна хүний үйл ажиллагаатай нягт холбоотойгоор авч үзэх нь зүйтэй юм. Хүний бие махбодын гадаад орчинтойгоо харьцах харилцааг энэхүү цагийн хүрдний номлолын үүднээс судлах нь бидний зорилт болж байгаа учраас дээрх зурагт үзүүлсэн аюул гамшгуудыг гадаад гэдэг ухагдахуунд харъяалагдана хэмээн бодож оруулсан юм.

ДОТООД ЦАГИЙН ХҮРД ХЭМЭЭХИЙ ДЭЛГЭРҮҮЛЭХ АГУУЛГА

Цагийн хүрдний номлол дахь "Дотоод цагийн хүрд" буюу རྩོམ་གྱི་དཔྱད་པ། хэмээх ойлголтоор хүний бие махбодийн бүтэц,

оршин тогтнох ёсыг илэрхийлдэг. Дотоод цагийн хүрдийг хамгийн товчоор юу вэ? гэвэл почин жүни буюу хүн хоногт хамрынхаа 2 нүхээр ээлжлэн 2 цагийн зайтай хүчилтөрөгч хэмээх агаараар 21600 удаа амьсгаа авч гаргадаг.

Хүн бол хоол идэж хүчээ сэлбэж өөртөө хэрэгтэй шим тэжээлийг аваад үлдсэнийг заавал бүдүүн шулуун гэдсээр дамжуулан гаргадаг нэг ёсны бяцхан үйлдвэр билээ.


Хоногт хамрынхаа хоёр нүхээр ээлжлэн 2 цагийн зайтай хүчилтөрөгч хэмээх агаараар 21600 удаа амьсгалаад илүүдэл болсон нүүрс хүчлийн хийг гаргадаг. Нэг хамрынхаа нүхээр хэзээч зэрэг амьсгаа авдаггүй. Цагийн хүрдний онолоор бол гаднаас биед нэвтрэх 21600 амьсгааг 2 цагийн давтамжтай ээлжлэн орж гаргадгийг цаг гэвэл гаднаас ирсэн агаарыг 5-н цул эрхтэн, ума, рома, жама судсаар дамжуулан авч бүхий л эд эсэд түгээж буцаан гаргадаг хүний бие нь нэг ёсны хүрд юм. Тиймээс **дотоод цагийн хүрд** хэмээх ойлглолт нь хүний биеийн системийг илэрхийлсэн ойлголт юм.

Орчин үеийн анагаах ухаанд хүний биеийн цусны эргэлтийн систем, дотоод шүүрлийн булчирхайн систем гэсэн олон дэд бүтцээр авч үздэг билээ.

Тэгвэл цагийн хүрдний номлолд хүний биеийн бүтэц, үйл ажиллагааг түүний дотор орших чакра буюу хүрдний системээр


илэрхийлсэн байдаг. Хүний биед үндсэн таван хүрд ба арванхоёр туслах хүрд байдаг гэж үздэг. (зураг 36)

Нөгөө талаар гадаад цагийн хүрдний талаарх хэсэгт өгүүлсэнчлэн хүний биеийг бурханаар төлөөлүүлэн орчлон ертөнцийн хэмнэлтэй уялдуулан авч үздэг. Зүрхэн тушаа байрлах гол хүрд буюу үндсэн чакраг доорх зураг дээр (зураг 37) од гарагийн 12 ордыг тодруулан дүрсэлсэн нь хүний бие ба гадаад ертөнцийн холбоо уялдааг тусгасан санаа юм.




Зураг 36

Биеийн дотор орших чакра буюу хүрдний байрлалыг харуулав. Оройн цэг, хоолойн цэг, зүрхний цэг, хүйсний цэг, нууцын цэг гэх мэт үндсэн 5 хүрд байх ба үе болгон дээр 12 туслах хүрд байдаг



Зураг 37

Зүрхэн тушаа хонь, хумх, загас тэргүүтэй 12 ордыг тойруулан байрлуулсан гол хүрд буюу үндсэн чакра




Зураг 38

Ром, жама хэмээх судасны огтлолцол дээр цагаан улаан дусал нэгдэж эс буй болж буйг процессыг харуулсан хүрд буюу чакра

Хүйсэн дэхь бүрэлдэн бий болох хүрдний үйл явц (зураг 38) бие махбодын эд эсийн бусад үйл ажиллагааг (зураг 40) мөн л хүрдээр илэрхийлдэг.

Зураг 39




Гол судас буюу за ума артерийн судас болох рома, венийн судас жама нарын огтолцох байдлыг харуулсан схем

Зураг 40



Эр хүний нууцын оронд цагаан дусал хуримлагдан буй болдог хүрд буюу чакра

Мөр, буглаг, тохойд орших 2 гарын 6-н хүрд, ташаа, өвдөг, шагайнд орших 2 хөлийн 6 хүрд нийт 12 ордыг төлөөлөн 12 хүрд судсаар эргэлдэж өдөрт 21600 амьсгалыг хоёр цагийн зайтай хамраар хүчилтөрөгчийг авч махбодь чакра буюу хүрдний системээр дамжуулан гаднаас орж ирэх хоол тэжээл болон амьсгалах агаар 6-н мэдэрхүйгээр дамжуулан гадаад орчинтой харьцдаг бичил схем болно. Хүний бие нь 2 гарын 6 үе хөлийн 6-н үе орой, магнай, хоолой, зүрхэн тушаа, хүйс нууцын газар тус тус чакра буюу хүрднүүдээр дамжуулан төв мэдрэлийн системээс ирсэн үүргийн дагуу ажилладаг механизм юм.




Энэхүү зургийг Ц.Отгонбаяр бээр компьютер графикийн аргаар дотоод цагийн хүрдний номлолын сэдвийн дагуу зохиомжлон зурсан болой. Үе бүгдэд байрлах 12 хүрдээр 12 сарыг бэлгэдэж байгаа ба оройноос эхлээд нууцын орон хүртэл үндсэн 5 хүрд байрладаг. Мөн өлмийнөөс ташаан толгой хүртэл лагшингийн хот мандал, ташаан толгойноос мөр хүртэл зарлигийн хот мандал, мөрнөөс цомбон хүртэл тагаалалын хот мандал, цомбонгоос зодбон хүртэл их амгалангийн хот мандалыг Лондол ламын "Дүйнхорын түүх" номын дагуу зурсан болой.

Мөн хүний биеийг бурхан тэнгэрийн тухай ойлголттой уялдуулан авч үздэг.

Заваа лам Лувсандаяан Монголын түүх "Хор Чойнжин" /Зава ламын 17 боть сүмбүмгийн 2-р дэвтэр ХА боть дотор Хойд зүгийн их монгол оронд дээдийн ном дэлгэрсний ёс өлзийт лавайн эгшиг / хэмээх судрын 3-р хуудас дээрээс 5-р мөрөнд энэ дэлхий дээр 722 төрлийн хэлтэн байна гэсэн нь цагийн хүрдний номлолд 722 тэнгэрийг бэлгэднэ гэж үздэгтэй дүйж болох юм. Энэ нь хүн бий болоход ямар нэгэн хөрөнгө, бурхан тэнгэрийн аль нэгэн язгуурыг даган гарна гэсэн Бүдөн Ренчиндүв гэгээнтний таалалтай таарч байна.

"Бүдөн Ренчиндүв гэгээний бүтээлийн бяцхан "а" боть дотор Галбон хэмээх гарчигт /2-р хуудасны дээрээс 2 дахь мөрөөс/ Арванбайдал төгөлдөр амин хий хөрөнгө гаднаас, хүний биед орж дүрслэг хэлбэрт шилжихэд ааваас олох цагаан дуслас чөмөг, яс, 5н цул эрхтэн бүрдэж, ээжээс олох улаан дуслас, цус мах, тунгалаг 6н сав эрхтэн буй болж улмаар холилдон таван рашааны мөн чанараар шимлэгдэн эхийн гэдсэн дотор байгаа хүүхдийн 1-7 сар хүртэлх хугацаанд амь буй болох процесс явагдаж 8-р сараас эхлэн 5 илт мэдэл, 5 цогцос буй болно" гэжээ.

Хүний биеийн хүрдний систем ба орчин үеийн анагаах ухаан



АНУ-н NASA-н сар бүр
гаргадаг танин
мэдэхүйн мэдээллээс

Зураг 42

Орчин үеийн шинжлэх ухаанд хүний бие организмыг дүрслэг, сүнслэг, гэрлэн бүрхэвч болон сүлдтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа учир энэхүү хүний биеийн чакра буюу хүрдний системүүдийг тайлбарлах ёсыг дотоод цагийн хүрдэнд хамруулан үзүүллээ.

Хэрэв та өөрийнхөө мэдрэмжийг хөгжөөвөл таны өмнө гайхамшигт ертөнц нээгдэн хүлээн авах чадвар тань өндөрсөж, бодол, санаа чинь аливаа зүйлийг өнгө, хэлбэрээр нь нүдээрээ үзэхээс өмнө илэрхий мэдэж нуугдмал ертөнц гэнэт өөрөө илэрч ирнэ.

Хүний биед харагдах бодит байдлаас гадна олон нөлөөт хүчин зүйл байдаг. Харамсалтай нь олонхи хүн нүдэнд харагдах бие мах бодь, материаллаг ертөнц л бодит байгаа зүйлс гэж боддог. Учир нь олонхи зөвхөн нүдэндээ харагдах бодит зүйлсээр л орчноо мэдэрч ажигладаг. Гэтэл хүний биеийн дотор болон эргэн тойронд олон тооны энергийн биет байдаг.

Үүнд:


1. Эфирийн бие
2. Сэтгэл хөдлөлийн бие
3. Оюун санааны бие
4. Сүнсэн бие

Энергийн бие бүхэн хамгийн нам болон хамгийн өндөр доргио, чичиргээ, долгионыг хүлээн авах өвөрмөц онцлогтой байдаг. Түүнчлэн иж бүрэн энергийн систем ажилладаг.

Үүнд:

1. Хүрд буюу энергийн төв
2. Надис буюу энергийн сувгууд болно

Шөнийн цагаар бүдэг гэрэлтэй үед гараа урагш сунган хараагаа төвлөрүүлэхгүй байснаар таны нүдний торлог



Зураг 43

бүрхэвчний гадна хэсэгт тодорхой бус бүдэг бадаг зүйл таны гарыг эргэн тойрон байгааг ажиглах болно. Энэ бол эфирийн бие юм. Эфирийн биеийг харах боломж байдаг. Хүний бодол санаатай холбоотой оюун санааны бие гэрлэн бүрхүүлтэй байдаг мөн хүний сэтгэл хөдлөлийн бие ч гэрлэн бүрхүүлтэй байдаг байна.

Дээрх зураг (зураг 43) хүний биеийн хүрдний системийг илэрхийлсэн бөгөөд олон тооны хоёрдох хүрд болон надисын иж бүрэн цогцлыг харуулж байна. Надисууд гол болон хоёрдугаар хүрднүүдтэй зохицох 14 үндсэн сувгийг нэгтгэсэн байна.

Хамгийн гол надисууд нь 1 сушумна 2. айда 3. пигала зэрэг юм.

Дээр өгүүлснээс үзэхэд Хүний биеийн хүрднүүд гэдэг нь энергийн төвүүд юм. Хүрднүүд судсаар дамжуулж хүчтэй энергийг долгион болгон хүний бодит биеийн хэрэгцээт газар болгонд тогтмол хүргэснээр хөгжүүлж байдаг. Хүрд тус бүр ус, шороо, агаар, тэнгэр зэрэг газрын аль нэг элементтэй холбоотой байдаг бөгөөд оюун санаа гэдэг бол ухамсар юм.

Ухамсрын хэмжээ аливаа зүйлийг хүлээн авах, хадгалж санах чадвар нь пранагийн долгионоор хэмжигдэнэ. Прана нь агаарт оршиж зөв амьсгалснаар сэргэж, өөрийгөө сэлбэж явдаг.


Чакра гэдэг нь санскрит үг бөгөөд “Хүрд” гэсэн үг. Хүний биеийн хүрд дугуй шиг эргэлдэж хүний эфирийн биеийн өнгөн хэсэгт оршдог байна. Уламжлалт бичигт хүний биед 88,000 хүрд байдаг хэмээн тэмдэглэсэн байдаг. Ихэнх нь маш жижигхэн бөгөөд энергийн системд туслах үүрэг гүйцэтгэж байдаг байна. Ойролцоогоор 40н чухал туслах хүрд хүний биед байдаг бөгөөд хүний биеийн дэлүү, хүзүүний ар хэсэг, гарын алга, хөлийн өсгий зэрэгт байрладаг аж.



Зураг 44

Хэрэв бид мушгиа үрчлээт цэцгийн хонхыг сайтар харвал (Зураг 44) хүний биеийн хүрдний харагдах байдлыг үндсэндээ ойлгох боломжтой юм.

Зураг 45




Хүний бие Лянхуа цэцэг шиг сээр нуруунаас үүсч гаран ижил хэлбэрээр салбарласан байдаг ба бидний нуруу үндсэн төв нь болдог. (Суугаа хүнийг дүрсэлсэн зураг 45)

Ихэнх хүмүүсийн Хүрд нь үүсч гарсан төв цэгээсээ тал бүр тийш 4 инч урт гарсан байдаг. Ургаж хөгжөөгүй байхдаа 2 инч хэртэй жижиг дугуй хэлбэртэй байдаг. Хэрэв түүнийг сэргээвэл гялалзсан, төөнөсөн, усны

эргүүлэг шиг, нартай тун төстэй хэд хэдэн инч диаметртэй болдог. Хүрд ургаж хөгжихдөө биенээс урган гарч түүний долгион, чичиргээ нэмэгдэж, өнгө гэрэл нь тунгалаг өнгөлөг болдог.

Хувь хүний хүйснээс хамаарч Хүрд нь цагийн зүүний дагуу буюу цагийн зүүний эсрэг тийш эргэдэг. Тухайлбал: Эрэгтэй хүний нэг Хүрд цагийн зүүний дагуу эргэж байвал эмэгтэй хүнийх ижил бус Хүрд цагийн зүүний эсрэг эргэдэг. Энэ нь эрэгтэй эмэгтэй хүний харилцан энерги авахад хэрэгтэй байдаг. Цагийн зүүний дагуу Хүрд эргэх нь хятадын сургаалиар бол эр буюу Ян, харин цагийн зүүний эсрэг Хүрд эргэх нь эм буюу Инь болно.




Чакра буюу Хүрд тус бүр өөр өөр чигт эргэдэг болохыг эр, эм хүний дүрсэлсэн зурагнаас харж болно. (зураг 46, 47)

ХҮНИЙ БИЕЙН ҮНДСЭН ДОЛООН ХҮРД

Хүний бие нь үндсэн долоон хүрдтэй (Нэг хүн суугаа дүрсийг харуулсан зураг 45) ба эдгээр нь дараах болно:

1. Титэм \гуравдахь нүд
2. Гуравдахь нүд
3. Хоолойн Хүрд
4. Зүрхний Хүрд
5. Нарны судаснууд
6. Ёс заншлын болон дэлүүний Хүрд
7. Үндэс шалтгааны Хүрд

Зураг 48



Нэгдүгээрт: **Үндсэн шалтгааны Хүрд** нь хошног бэлгийн эрхтний хооронд орших бөгөөд сээр нуруутай холбогдон доош онгойсон байдаг. **Хүнийг идэвхитэй байх үед гал шиг улаан шаргал өнгөтэй байдаг.**

Хоёрдугаарт: **Ёс заншлын болон дэлүүний Хүрд** нь дэлүүний дээгүүр байрлаж нар шиг харагдан урагш тэмүүлэн онгойдог. Санскрит номонд хоёрдугаар хүрдийг дэлүүний дээгүүр биш хүйсний доогуур байрладаг гэж тогтмол бичдэг.

Гуравдугаарт: **Нарны Хүрд** хүний хүйснээс хоёр хуруу амьсгалын дээгүүр байрлаж сэтгэл хөдлөлийн биетэй шууд холбоотой байдаг. Нарны судаснууд Хүрдний тусламжаар нарны энерги авч эфирэн бие, бодит биеэ энергээр тэтгэдэг. Үүгээр бидний сэтгэл хөдлөл илэрдэг. **Энэ хүрд нь голдуу ногоон өнгөтэй байдаг.**

Дөрөвдүгээрт: **Зүрхний Хүрд** нь бидний Хүрдэн системийн үндсэн төв хэсэг. Энэхүү Хүрд нь цээжний төв хэсэгт зүрхний хөндийтэй зэрэгцэн байрлаж хүний биеийн 3 доод хэсэг сэтгэл хөдлөлийн төвүүдийг оюун санааны болон сүнсний 3 дээд хэсэгтэй холбож байдаг. **Энэ Хүрд нь алтан өнгөөр гялалзаж байдаг.**

Тавдугаарт: Хоолойн Хүрд нь савны үе хэсэг Адамын алимны ардаас эхлэн хоолойн хонхорхой болон төвөнхний дунд байрладаг. Энэхүү Хүрд нь савны үенээс урагш тэмүүлэн онгойсон байдаг. Мөн хүзүүнд байж ар нуруунд нээгддэг түүнчлэн хоёрдугаар хүрднүүдтэй нэгддэг. Энэ хоёр Хүрд маш ойрхон байдаг тул нэгддэг аж. Хэдийгээр түүнд цэнхэр өнгө давамгайлдаг боловч усанд туссан мөнгөн сар шиг байдаг байна. **Энэ Хүрдэнд цэнхэр ногоон өнгө давамгайлдаг байна.**

Зуравдугаарт: Гуравдахь нүд Хүрд нь ямар нэг хэлбэр дүрсгүй 1\8 инч хэмжээний диаметр бүхий тархины үндсэн булчирхайтай нэгдэж хөмсөг нүдний гүүр нэг хуруу амьсгааны дээр духны хэсэгт байрладаг байна. Энд хүлээн авах мэдрэмж байх бөгөөд бидний оюун санааны хүчтэй хэсэг байдаг байна. Физик биеийн хувьд нервний системийн төвийн хамгийн дээд захирах хэсэг байдаг. **Энэ хүрдний нэг хэсэг нь голдуу шаргал ягаан нөгөө хэсэг нь цэнхэр голдуу чернилэн өнгөтэй байдаг аж.**

Долдугаарт: Титэм /Гуравдахь нүд/ Хүрд тархинд орших булчирхайнаас ч бага махан хэсэг тархины төв хэсэгт чихний чиглэлээр байрладаг. титэм Хүрд нь толгойны дээд хэсэгт дээш онгойдог. Сонирхолтой нь анагаахын шинжлэх ухаанд энэ хүрдийг хүний биед физик нөлөө өгч байгааг тодорхойлох болсон. **Энэ хүрдэнд хөх ягаан өнгө давамгайлдаг.**

Орчин үеийн анагаах ухаанд дээрх долоон хүрдний дотороос үндсэн шалтгааны хэмээх нэгдүгээр хүрд тэнцвэртэй байхыг эрүүл ахуйд чухал ач холбогдолтой гэж үзэх ажээ.

Үндсэндээ Хүрд тэнцвэргүй байх үндсэн хоёр шалтгааныг дараах байдлаар авч үзэж байна:

1. Хурдан эргэх, илүүдэл болох, ачаалал ихтэй, таарамж зохимжгүй

Хүнд, нойрмог, мохоо, ноомой, гөлрөнгө, мэдрэмжгүй, залхуу, зүгээр суух, ичих, зэрэгцэх, унжгар болох, уйтгарлах, гашуудах, ядрах, сулрах, аливаад ялгаагүй болох, амьдралд идэвхгүй болох, хаалт хашаа болох, хүндрэлгүй болох, материаллаг болох, өөдрөг бус, биеэ тоох, амбицлах, амьтан шиг, шунахай, сувьдаг, ховдог, аймхай, хулчгар, эрүүл чийрэг, амарч чадахгүй, санаа сэтгэл тогтворгүй байх

2. Удаан эргэх, дутагдал, хомсдол, дуусгах, барах, таарамж, зохимжгүй

Хөл хүйтэн болох, хулчийх, амиа бодох, зовлон, туйлдах, цочролд орох, сэжигтэй, санаа зовох, үймүүлэх, хоёрдох бодол, шийдвэргүй байх, хэтрүүлж авирлах, найдваргүй болох, хамгаалалтгүй байх, сахилга батгүй, амралтгүй, хэт хөнгөн, бодолгүй, мөрөөдөгч, төөрөх, бодолгүй, ажигч бус, аливаад сонирхолгүй, зай барих, амалсандаа хүрэхгүй, сониуч бус, холбогдохгүй, хаях, гарах, зорилгогүй, андуурах, зохион байгуулалтгүй, хэнэггүй, халамжгүй, алхаж гишгэхэд хүнд болох

Үндсэн хүрд тэнцвэртэй бол:

Чадварлаг амьдрах, төвлөрөх, газардах, ачаа үүрэх чадвартай байх, хүчтэй байх, эрүүл байх, халуун дулаан, хүндтэй, сүр жавхлантай амьдрах, эрүүл саруул байх ажээ.

Мөн орчин үеийн шинжлэх ухаанд Хүний биеийн тодорхой хэсгийг Хүрд тус бүр захирдаг гэсэн үзэл байх ба тэр үзлийн дагуу эдгээрийн үйл ажиллагаа гадаад ертөнц, бусад хүнтэй харьцах харьцааг зохицуулдаг байна. Үүнийг харуулсан зарим материалыг толилуулбал:

"Хэрэв хэн нэг хүн ямар нэг зүйл хэлэхэд эсвэл хэлээгүй байхад....Та нөлөөнд орох, хэн нэг хүн ямар нэг зүйл хийхэд

эсвэл хийгээгүй бол.... Та нөлөөнд орсон бол “Тэр” таны товчийг даржээ.

Хэрэв таны тайван байдал, таарамж өөр хүнээс хамаарч байвал, хэрэв таны товч олон дахин дарагдвал таны амьдралын хяналт өөр хүний гарт байна.

Чадалтай байна гэдэг энгийнээр хэлэхэд өөрийнхөө амьдралын хяналтын товчийг өөрийнхөө гарт авах

Энерги яаж төвлөрдгийг яаж ойлгох вэ? – Хүрднүүд – ажиллах

Бид бие, оюун санаа, сэтгэл, дотоод сэтгэлийн таарамжийг бүтээдэг....

Хүрдээ эмчилснээр бид өөрсдийн зам мөрөөр өөрсдийгөө идэвхжүүлдэг

Бид та бүхнийг замбраагүйдлээс сансар хүртэлхи дотоод ертөнцийн гайхалтай тавиланд уръя.

Гэрлэн бүрхүүлээ цэвэрлэх мөн Хүрдэн эмчилгээгээр цэвэрлэх.

Сонголтот эмчилгээ таныг гялалзсан эрүүл болгоно.

Хүрд унших – Албан тушаалын зам – Харилцааны ирээдүй зэрэг олон зүйлсийн олон оньсогыг дэлгэж өгнө" гэх зэргээр өгүүлсэн байна.

Ийнхүү хүрдний системийг хүний биеийн чухал хэрэглэгдэхүүн болоод зогсохгүй эх дэлхийн чакра буюу хүрдний системийн үйл ажиллагаатай адилхан зарчимтай системчилэгдсэн байдгийг шинжлэх ухаан олон зүйлээс судлан тогтоосон байна. Мөн манай бурханы шашны номонд ч гэсэн МЭӨVI зууны үед хүний биеийн хүрдний системийн онолыг ерөнхийд нь илрүүлэн түүгээр дамжуулан гадаад орчин болох уул усны эзэн, савдаг лус тэнгэр нугуудыг тахиж өргөл хүндлэл үйлдсээр ирсэн нь өнөөгийн үеийг хүртэл уламжлагдан дамжиж баяжиж ирсэн.

Шинжлэх ухаан хүнд 88000-н хүрдний систем байдаг гэж нээсэн. /бурханы шашинд номын цогцос 84000/ хүний үс ойролцоогоор 88000 ширхэг байдаг. Энэ нь дээрхи хүний хүрдний системээр дамжин гарсан илүүдэл зүйлсүүд үсээр дамжин хүний биеэр гадагшилдаг гэсэн дүгнэлттэй таарч байна. Жишээлбэл хүн хоол тэжээлийн зүйлийг гаднаас амаар дамжуулан улаан хоолойгоор боловсруулан 5 цул эрхтэн болон 5 сав эрхтэн мах, цус, судас зэргээр дамжуулан шимийг нь авч үлдэгдэл хэсгийг нь бүдүүн шулуун гэдсээр дамжуулан гадагшлуулдаг зарчимтай адил. Мөн хамраараа хүчилтөрөгчөөр өдөрт 21600 удаа амьсгалаад үлдэгдэл нүүрсхүчлийн хийг мөн гаргадаг. Энэ ч гэсэн бас нэгэн ижил зарчимтай механизм юмаа.

Дээр үед урт үстэй хүн ухаан богинотой гэж хэлдэг байсан нь үсээр дамжин 88000 чакра буюу хүрдний үлдэгдэл сэлт гарч байгаа тул өтгөнөө сайн арчдаггүй хүнтэй адил, хамраа сайн цэвэрлэдэггүй хүүхэдтэй адил үсний эд ширхэг бүрээр хүрдний илүүдэл гадагшилж байгаа нь нэг ёсондоо ялгадас маягтай гэдэг дүгнэлтэнд хүрч байна. /урт үстэй хүмүүс бодисийн соллоцоо бага байдаг/

ЦАГИЙН ХҮРДНИЙ НОМЛОЛЫН БУСАД ХЭМЭЭХ ДЭЛГЭРЭНГҮЙ АГУУЛГА

Цагийн хүрдний номлолын "гадаад" хэмээх агуулгад орчлон ертөнцийн тогтоц, "дотоод" хэмээх агуулгад хүний биеийн бүтэц, хэмнэл голлон багтдаг бол "бусад" хэмээх агуулгад орчлон ертөнцийг танин мэдэж төгс гэгээрэлд хүрэх зэрэг дараалал ба таньж мэдэх энэхүү зам мөрөөр суралцахын тулд хүртэх ёстой авшгийг багтаан оруулсан байдаг.

Төгс гэгээрэлд хүрэх хоёр зэрэг байх ба энэ нь жидрэм буюу үйлдэхийн зэрэг ба зогрэм буюу төгсөхийн зэрэг юм. Жидрэм буюу үйлдэхийн зэрэг гэдэг нь ариун бус үйл нисванисийн эрхээр төрөл авах хүчийг ариусган үүсгэхийн замд орж ном лугаа зохилдон үйлдэхийн бэлгэдэл юм.

Харин зогрим буюу төгсөхийн зэрэг нь бие махбодь тэргүүтэн түйтгэрээс хагацаж төгсөхийн зэргийн зам лугаа зохилдохыг бэлгэднэ. Ийнхүү ариун үрээр билиг билгийн номын лагшинг олж дээд үл хувирах их амгалангийн таалалд хүрнэ.

Цагийн хүрдний бусад гэдэгт жидрэм буюу үүлдэхийн зэрэг, зогрэм буюу төгсгөхийн зэрэг, авшиг буюу ван хамрагддаг.

Үйлдэхийн зэрэг ба төгсгөхийн зэрэг

Лхүндэв бандидийн ямандаг бурханы бясалгалын тайлбар Үйлдэхийн болон төгсөхийн зэрэг хэмээх номын Нанчод жанловын утга буюу дотоодын тахилын адислагаа хэмээхэд: хоосон чанарын агаар ЯМ үсгээс маш нарийн хийн хот мандал нум хэлбэртэй, хөх өнгөтэй дувааз тэмдэгтэй, түүний дээрхи РАМ үсгээс гал хот мандал гурвалжин хэлбэртэй, түүний Зн үзүүрт А үсгээс гарсан хохимой толгой, цагаан гавал усан мандал дотор, зүүн БҮРҮМ үсгээс зааны мах, өмнө АМ үсгээс

нохойн мах, баруун ЗАРАМ үсгээс үхрийн мах, хойд ХАМ үсгээс адууны мах, дундах ХУМ үсгээс хүний мах, зүүн өмнө ЛАМ үсгээс өтгөн, баруун урд МАМ үсгээс цус, баруун хойно ВАМ үсгээс цагаан дусал, зүүн хойно ДАМ үсгээс чөмөг, дунд нь ВАМ үсгээс шингэн гарч хохилдон УМ үсэг цагаан, А үсэг улаан, ХУМ үсэг хөх болон давхралж түүнийг хүчитгэн өмнийн огторгуйн/дүнжид/ бясалгалыг, өөрийн биеийн тэнгэр /дагжид буюу лха тэнгэрийг өөрийн биед байгуулах бясалгал/ сэтгэлийн ХУМ үсгээс гэрэл цацруулан, хийгээр хөдлөн, галаар бадарч, гавалын доторх зай хайлан, гэрэл цацарч, лагшин зарлиг таалалын очирын мөн чанараар ХУМ үсгээр гэм арилж, А үсгээр рашаан болон ариусаж, УМ үсгээр олон болон арвиждаг нь амьд организм буй болох процес хэмээсэн байдаг. Тэгвэл цагийн хүрдний номлолд

ཨོ།།ནམ་མཁའི་ཁམས་མཐའ་ཡས་པའི་ཚོས་འབྱུང་གི་ནང་ད།།ཡི་ལས་རྒྱུད་གི་
དགྲིལ་འཁོར་ནག་པོ་དབུས་སུ་གཞུང་རྣམ་བཤད་ཀར་དཔག་ཚད་འབུམ་ཕྱག་
བཞི་བསྟེང་འོག་རྗེ་ལས་སྐྱེས་པའི་སྣ་ཚོགས་དོ་རྗེ་གཉིས་དང་བཅས་བ་རྒྱལ་
མཚན་གྲིས་མཚན་བ། ཞེས་བ་ནས།།དཔལ་ལྷན་རྒྱ་སྐར་ཅན་གྱི་དགྲིལ་འཁོར་ལྷ་
དེ་རྣམས་ཐམས་ཅད་གཅིག་ཏུ་འདྲེས་པ་ལས་ཉི་ཤུ་སྟེ་ལྔ་ར་ཡ་གི་ཡི་གེར་གྱུར།

дээрх төвдөөр бичсэнчлэн Хайдүв шаллүн буюу Хайдүвжийн гэгээний өөрийн биед лха тэнгэр үүсгэхүй хэмээхээс: хязгааргүй огторгуйн таван эрдэм төгөлдөр махбодоос гурвалжин хэлбэрт чойнжүнгийн голд хар хөх хийн хот мандал нум хэлбэртэй 400000 багцад хэмжээтэй ба дээр доор нь ХУМ үсгээс гарсан элдэв очир бадангийн мөн чанартай түүн дээр гал хот мандал, усан хот мандал, шороо хот мандал, уул ургамал сав шимийн

ертөнцийг байгуулан тэдгээр нь од гарагийг төлөөлөн орчлон гадаад цагийн хүрдийг бүрдүүлжээ. Хайдавжийн гэгээн:

རྒྱ་མམས་ཅད་གྱི་ཐགས་ཀར་རང་རང་གི་ས་བོན་ལ་བསྐྱས་བྱའི་སྐྱལ་གྱིས་

བསྐྱར་བ་ལས་དགྱིལ་ལོར་གྱི་ལྷའི་ཚོགས་སྤྲོས་ཤིང་པའི་དོན་བྱས། སྐར་རྒྱུན་

ནང་ད་འཇུག་པ་དང་ལྷན་ཅིག་ཏུ་ཐགས་ཀའི་ས་བོན་ལ་སྐྱད་པའི་སྐྱོ་བ་དང་བསྐྱེ་

པའི་མཛན་པ་ཅན་ད་གྱུར། ཚི་ལྷུང་རྒྱ་རྩ་རྩ་ལྷ་སྐྱ་ལ་ལ་རྩ་ལྷ་ལྷ།

хэмээн төвдөөр бичсэнчлэн тэнгэр бүгд өөрийн хөрөнгө зүрхэн тарни болон биеийн хот мандалын голд Арван хий төгөлдөр язгуурын бурхадын мөн чанартай дотоод цагийн хүрдийг илэрхийлэн УМ-АА-ХУМ-ХАМ-ЧА-МА-ЛА-БА-РА -ЯМ хэмээх арван үсэгт тэмдэг НУМА ЖҮ болон хувирдаг.

Үүнийг жагсаавал Богд лам Зонхаваагийн үзлээр гаднаас орж ирэх 10 амин хий ажгуу.

1. Амь баригч хий огторгуйн Мижидва бурханы хөрөнгө хувь
2. Нэвтлэгч хий билгүүний Доржсимба бурханы хөрөнгө хувь
3. Тэгш оршоогч хий Дондүв бурханы хөрөнгө хувь
4. Яст мэлхийн мөн чанарт хий Дондүв бурханы хөрөнгө хувь
5. Дээш оргих гал хий Ренжүн бурханы хөрөнгө хувь
6. Ханан хүрээлэгч гал хий Ренжүн бурханы хөрөнгө хувь
7. Түгэн үйлдэх усан хий Нанваан Таяа бурханы хөрөнгө хувь
8. Тэнгэрийн өглөг усан хий Нанваан Таяа бурханы хөрөнгө хувь

9. Лусын хий газрын мөн чанарт Намнан бурханы хөрөнгө хувь
10. Үйл ялагч хий газрын мөн чанарт Намнан бурханы хөрөнгө хувь хэмээх 10 хий ээж аавын улаан цагаан дусалтай холилдон сүлэгдэж хүний бие буй болдог хэмээн өөрийн зохиолынхоо Дүйнхорын номлолын охь хэмээхдээ бичсэнчлэн цааш хураавал Ум - аа - хум гэсэн 3 үг болох ба Ум нь эр чанга, Аа нь бага, эм чанартай сул, Хум нь чанар тэнцүү манин бөгөөд ахин хураавал " Э" - "Вам" гэсэн 2 үсэг болдог. ба "Э" нь ухаан, "Вам" нь хийг илэрхийлдэг арга билгийн тогтолцоо юм гэж айлдсан байдаг. Иймээс хүний сүлд эхийн умайд дээрхи бүтцээр ордог байна. Харин хүн нас барахад бас л дээрх бүтцээр гадагш гардаг, Өнгөрсөн хүний хойд мөрийг сайн оронд төрүүлэхийн тулд Бурхан багшийн айлдсан Гүнрэг хэмээх судрын ЛХОГ дотор" шороон махьбод нь эм ч эр ч, үнэний үг бүтэж түүгээр хориг үгүй одож, шороон махьбодоор сав дүүрэх болтугай, шороон махьбодод шингэж Жанма бурханы язгуураар бурхан болж хоосон чанарыг олох болтугай гээд Усан махьбодь дээрхтэй адил Мамаги бурхан, Гал махьбод Гойгармуу бурхан, Хийн махьбод дарь эх бурханы язгуурыг олж хоосон чанарыг онох болтугай гэх мэт 5н махьбодийг язгуурын бурхадын мөн чанараар сайн замд нь үддэг байна энэ ёс нь 2500-аад жилийн тэртээгээс хэрэгжигдсээр иржээ.

Монгол ардын зүйр үгэнд "Урт үстэй хүн ухаан богинотой" гэдэг үгийг орчин үеийн хүмүүс олон утгаар ойлгодог. Мөн үс сайхан бол зүс сайхан ч гэж хэлдэг. Энэ үсний талаарх шинжлэх ухааны дүгнэлтийг /100 дугаар хуудаснаас/ үзээрэй. Цагийн хүрдний номлолд заахдаа хүний үс ойролцоогоор 88000 ширхэг байдаг гээд хот мандалын Дүмү буюу 8 хос 11 ланз үсгээр төлөөлөн гаргажээ. (хавтасны арын зургаас үзнэ үү) Энэ нь шинжлэх ухааны дүгнэлттэй таарч байна. Түүнчлэн номын

цогцос хүний биед 84000 орчим байдаг нь 1 номын цогцост 1 үс таарах ба. номын цогцос бүрт орших маш нарийн хийн байдалт хүрд нь үсээр дамжин дотогшилж, гадагшилдаг гэсэн дүгнэлтэнд хүргэнэ. Лам нар үсээ авахуулдаг нь үсний хөндийн голоор дамжигдан гарах, орох, номын цогцосыг чөлөөтэй нэвтрүүлэхийн тухайд үсийг тайрч байдаг гэж үздэг. Ерөөс монголчууд ном сайтай хүнийг халзан толгойтой байдаг гэдэг нь ч таарч байна. Энэ нь номын цогцос үсээр дамжин богино замыг туулан гадна орчинтой харьцаж бодисын солилцоо түргэн явуулахын тулд үсийг тайрах нь оюун ухааныг идэвхжүүлэхэд чухал үүрэгтэй хэмээн шинжлэх ухаан болон цагийн хүрдний номлол нэгэн дуугаар нотолж байна. /үсний талаарх "Шинжлэх ухааны тайлбар" (Үс- Арьсны нэгээхэн хэсэг болох нь: үсний бүтэц зохион байгуулалт хөгжлийн үе үсний хөгжил нь үр хөврөлийн хөгжлийн 2 дах сарын төгсгөл 3дах сарын эхэн үед хөмсөг, дээд уруул ооч, хамрын хэсэг эпидермисийн суурь булцууг үүсгэж үсний уутны эхлэл болдог. Үр хөврөлийн 4-5 сард үсний эх үүсвэр нь толгойны арьс нуруу, гэдэс хэвлийн хэсэгт үүсч цаашдаа зулайнаас ахар сүүл хүртэл аажмаар тархдаг. Үсний байрлал шинж чанараар нь шар үс, урт үс, /толгой суга умдагны үс/ ширүүн үс /хөмсөг сормуус сахал чих хамрын үс/ гэдэг.

Хэлбэрээр нь шулуун буржгар, эрчилсэн Бүтцээр нь ил хэсэг үсний уг үсний фолликул үсний булцуу үсний хөхлөг гэж ангилдаг. Үсний уг нь үсний фолликулд байдаг үс өргөгч булчинтай холбогдсон байдаг. Мөн олон тооны тосны булчирхай байдаг. /200000 орчим/ энэ нь үсийг сайхан байлгахад маш их үүрэг гүйцэтгэдэг. ҮС НЬ ҮНДСЭН 3-н давхаргаас тогтдог. 1.тархилаг давхарга 2.холтослог давхрага 3. кутикул давхрага. Мөн гадна, дотно гэсэн бүрхүүл уутнаас тогтох бөгөөд дотор бүрхүүл маань бас 3-н давхрагаас тогтоно. 1.гадна -генлийн давхрага 2.дунд-гекслийн давхрага 3. дотор кутикул давхрага хэмээдэг. Эдгээр давхаргууд өөрсдийн гэсэн маш нарийн бүтэцтэй, үүрэгтэй, үс болон үсний гадна бүрхүүлийн хоорон дах

хоолой хэлбэрийн эсийн бүрхүүлэн хэлбэр юм. ҮСИЙГ ЗААВАЛ ТАЙРУУЛЖ БАЙХ ёстой юу? Үсийг ямар ч хүн 14 хоногт заавал тайруулаж байх хэрэгтэй. Хүний үс сарын хугацаанд 1,5-2 см ургадаг. эрэгтэй хүн 14-21 хоногт 1,5 см ургадаг. Иймд үсээ эрүүл байлгахын тулд дор хаяж сард нэг удаа засуулж байх хэрэгтэй. Энгийн утгаар тайлбарлавал: үсний үзүүрийг авахгүй байснаас авах ёстой амьсгал агаарыг хааж боогдуулснаар шим тэжээлээ авахын тулд хугарч, салаалан ургадаг энэ нь үсний өвчлөл гэж Анаагаах ухааны магистр Г.Хулан диссертацийн ажилдаа дүгнэсэн нь зүйтэй санаа юм.

ҮЙЛДЭХИЙН ЗЭРЭГ

Цагийн хүрдний номлолын Зарлигийн хот мандалд байх 12, амьтан, 12 сарыг бэлгэдэх ба дотор нь тахилын 30 тэнгэр байрладаг. Энэ нь нэг сар дотор 30 хоног байдгийг бэлгэдэн өдөр болгон нэг тэнгэр харгалзаж цаг цагийг эрхшээн эргэж байдгийг илэрхийлнэ. Солигдон давтагдах сар хоногийн ээлж дарааг "бусад" хэмээх агуулга дахь "хурд"-ний тухай ойлголт илэрхийлнэ.

Одоо тэгвэл “цаг” хэмээхийг тайлбарлавал: Энэ нь өнгөрсөн, одоо, ирээдүй хэмээх 3-н цагт өөрчлөгдөхөө байсан үргэлж **цаг** хэмээх утгаа алдахгүй байх бөгөөд жишээ нь: Бурхан аль ч цагт байх яагаад гэвэл бурхан биш болох, уруудах ахих гэсэн асуудал байхгүй. Иймээс дүйнхорын 728 тэнгэр хувирахгүй эргэж буй учир үйлдэхийн зэргийн **цаг** нь 728 тэнгэр бөгөөд өөр өөрийн замаар эргэх ёсыг нь **хүрд** хэмээн тайлбарладаг. Үйлдэхийн зэрэгт хот мандалын тэнгэрийн байрлал байдлын талаар номлодог бөгөөд түүнийг танин мэдэх нь төгс гэгээрэлд хүрэх анхны үе шат юм.

ТӨГСӨХИЙН ЗЭРЭГ

Төгсөхийн зэрэгт дотоод “за” буюу “ума, ромо, жама” тэргүүтэй судсаар дамжин хийгдэх “лүн” буюу хийн урсгалын төвлөрөл бясалгалыг хийдэг. Дүйнхорын төгсөхийн зэрэг нь тэгли ши буюу 4-н дуслын талаар гардаг.

Оройд сэргээх дусал
Хүзүүн дээр зүүдлэхийн дусал
Зүрхэн дээр нам унтахын дусал
Нууцын оронд тэгш орохын дусал

Энэ 4-н дуслын орон нь **дүй** буюу **цаг** болох бөгөөд өдөр бүр гаднаас орж ирэх 21600 амьсгалах агаартай хамт ирэх үйлийн үр нис-ва-нисийг:

Оройноос - хүзүү хүртэл **མཚོག་དགའ་བ།** дээд баясал

Хүзүүнээс – зүрх тушаа **བྱེད་དགའ།** ялгамжаатай баясал

Зүрхнээс - нууцын орон **ལྗན་གཅིག་སྐྱིས་དགའ།** хамтын баясал гэх мэт дээрхи 3 замаар арилган цэвэрлэж төгсгөх нь төгсгөлийн зэрэг буюу **хүрд** хэмээх утгатай дүйж байна.

Баясалгалын үеийг төгсгөхийн зэрэг гэдэг бол брайв **བྱས་བྱ།**

буюу **үр дүн** хэмээх ойлголтоор төгсөхийн зэргийн эцэст хүрэх үр дүнг илэрхийлдэг. Хүний биеийг оройгоос магнай хүртэл хийн мандал “яа” үсэг, магнайнаас хүзүү хүртэл гал мандал “ра” үсэг, хүзүүнээс зүрхэн тушаа усан мандал “ба” үсгээр төлөөлүүлдэг. Тэгээд хүйс хүртэлх хэсгийг шороон мандал төлөөлж, хүйснээс нууцын орон хүртэлх хэсгийг их амгалангийн мандал “ма” үсгээр бэлгэддэг.

Мөн “ча” үсэг орой дээр орших бодьсадвааг төлөөлж, “хам” үсэг нар, сар, дөл гурвыг бэлгэдэж, “ума” судас, “ро” судас, “жаам” судас гурвыг илэрхийлдэг.

ДҮЙНХОРЫН ВАН

Зураг 49



Цагийн хүрдний номлолын лагшин, зарлиг, тааллын гурван давхар хот мандлын зураг оршвой

Дүйнхорын их авшгийг шавь нарын бэлтгэл ба газрын чого, дагон,-жинхэнэ авшиг гэж 3 хувааж авч үзэж болно.

1-р газрын тухайтад, Авшиг авах газрыг бусдаас илүү хэмээн, бумба буюу хумхаа сайн, онцгой гэж, хот мандалаа жинхэнэ гэж бодон 728 тэнгэртээ залбиран бид хувь төгөлдөр шавь нар хэмээн анхны санаа асар ариун байхаар сахил сахиж адист хүртдэг.

Бэлтгэл арав нь:

Залбирал талбиж ལྷོ་གླ་འཆི་བ་ན་གྲ་ཡ། жирга чава нидаеэ хэмээхийг даган дуйрааж уншина.

Зүншиг буюу барихуй дор оруулах བུ་བྱོད་ཚུར་ཤོག་ཐེག་ཆེན་པོ།
бүчод цүршог тэгчинбу хэмээх 4-н шүлгийг даган уншихад тариний тус эрдэнэ оршино.

Сахил авах. དགོན་མཆོག་གསུམ་ལ་བདག་སྐབས་མཆི། “гончог сумла дагжавчи” тэргүүтэнийг даган дуурайж уншиж сахил төрнө.

Адислагаа. Өөрийгөө энгийн бус хэмээн орой, хоолой, хүйсний 3-н оронд би хэл сэтгэлээр адислана.

Сошин дор буюу мод хаях. Хот мандалын өмнө 5 язгуурын аль болохын тухайд мод орхиж ойдов буюу шид бүтээлийг олно.

Ус ойчих. Хэлээр үүлдсэн гэмээ арилгахын тухайд ус ойчино.

Гүша. Цэвэрхэн дэглэмтэй байх ба зүүд тодорхой үзэгдэхийн тулд гүша өвсийг дэвсэж хононо.

Баясал. Удамбарын цэцэгтэй учрах хэцүүг ухаарч энэ адил дүйнхорын номлолд баясал үүсгэх

Цээр хорио тавих. Гадна дотны тотгороос сэргийлэх.

Зүүд манах. Шөнийг 3 хуваасны сүүлийн үе буюу үүрээр зүүдээ ажиглах ба хэрвээ муу байвал сүрэнхор бясалгаж буцаах чухал.

Ингээд бэлтгэл ажлууд дуусаж авшиг эхэлнэ. Бүгд ёгузорын сэтгэлийг үүсгэж хамаг амьтны тусын тулд бурхан бүтэх болтугай хэмээн ерөөлийн янагш сэтгэл зүрхэнд сарны хот мандалын

хэлбэртэй бясалгаж өөрийн сэтгэл чинагш бодийн сэтгэл болон саран дэвсгэр дээр 5-н үзүүрт очирын байдалтай байх чухал гэж аграм чимбууд номлосон мэт мэгдэр буюу нүдээ дарсан даавууг авах хэрэгтэй.

Ерөнхийдөө Авшиг нь 4-н хэсэг 16 авшгаас бүрддэг.

Үүнд:

Анхны хэсэгт: Нялхсын үйл адил долоон авшиг

Хоёрдугаар хэсэгт: Дээдийн чинагш орчлонгийн хумх, нууц билиг билгүүний, 4-р орны гэх 4-н авшиг ба эдгээрийг дээд дөрвөн ван буюу авшиг хэмээнэ.

Гуравдугаар хэсэгт: Дээдийн дээд ван буюу авшиг нь чинагш орчлонгоос ангижрсан хумх, нууц 4-н авшиг байх ба дээр нь Доржловон дагвуу чинбуван хэмээх 16 авшиг байна.

Зай, тарина, бясалгал гуравт шүтээд их амгалангийн билиг билгүүнийг эрхшээж үр дүнд нь бүрүлгү буюу хувилгааны лагшинтай болох нь **хумхын авшгийг мөн чанар** түүнчилэн дээрх гуравт шүтээд үр дүн нь лонгү буюу төгс төгөлдөр лагшинтай болох нь **нууцын авшгийн мөн чанар**.

Мөн дээрхчлэн үр дүнд нь чойгү буюу номын лагшинтай болох нь ширбан буюу **билиг билгүүний авшгийн мөн чанар** болой.

Дээрх гурван авшигийн гурван лагшинг эрхшээгээд калачакра яв юм буюу эр эмийн лагшин, тачаалал нь ариун дээд, үл хувирахын их амгалангийн хутагийг олох нь **4-р авшгийн мөн чанар** оршино.

Эдгээр 4-н авшиг оршихын гол үүд нь багшийгаа шүтэх ёс, энэрэнгүй сэтгэл хоёрт тулгуурлан бодь сэтгэлийг үүсгэдэг.

Нялхсын долоон авшигийг өчүүхэн төдий дэлгэрүүлбээс.

Анхны авшиг хүүхэд эхээс төрөөд угаалга үйлдэхтэй адил калачакра бурханы **хойд, тагаалалын** цагаан нигүүрт шавь нар лагшин очирын дүрээр шигма тэнгэр бээр хумхын авшиг айлтгаад хумхын рашаан хүртэж хам 5 буюу шороо, газар ус, хий, огторгуйн 5 орон машид ариусаж Дархи, Гойгарму, мамаги, жама, ванчигмаа хэмээх 5 бурхадын мөн чанартай болох болой.

Анхдугаар газар олно. Мөн **хойд талын тагаалалын** цагаан нигүүрт зодбон буюу толгой өмсгөл, малгай өмссөнөөр 5 цогцос язгуурын 5 бурхадын мөн **чанартай 2-р газар олно.**

Гуравдугаар ван. Нялхсын чихэнд ээмэг зүүхтэй адил калачакра бурханы хот мандалын урд талын зарлигийн улаан нигүүрт нума жү буюу арван хий болон даржан унжуураг чимгийн авшиг авах ба чимэг толгойд хүрмэгц арван хий 10 паражно, парамида болж ярих хэлний, явах хөлний, хөдлөх гарын булчингийн шөрмөс чангарна.

Дөрөвдүгээр ван. Нялхас хэлээрээ авиа гаргахтай адил калачакра бурханы хот мандалын урд талын зарлигийн улаан нигуураас хонх очирын авшиг хүртмэгц ромо, жама судас, ума судас адил төвлөрч хүчтэй болж нар саран хамт байгаа мэт **4-р газрыг олно.**

Тавдугаар ван. Нялхас тоглоом наадгай наадахтай адил калачакра бурханы хот мандалын зүүн хөх тагаалалын нигуураас очиртой бөгжний авшиг авмагц таван эрхтний хүч ихдэж төгс эдлэлийн **5-р газар олно.**

Зургаадугаар ван. Нялхас нэр авах үйлтэй адил зүүн талын нигүүрт тову 5 буюу тому 5 бээр бугуйвч өргөснөөр их амгалангийн билиг билгүүнийг эрхшээж **6-р газарт оршино.**

Долоодугаар ван. Нялхас төрөөд юм дуурайх, өнгө зүс орох, ном уншиж сурах зэрэг үйлийг үйлдэхтэй адил баруун талын шар

билиг билгүүний нигуураас бие хэл сэтгэлийн хирийг арилгаж **7-р газарт оршино.**

ДЭЭД ДӨРВӨН ВАН

- Орчилонгийн лай үйлийн үр, нисванис арилгах янагш үзлийн үүднээс оройн цэгээр сэргээгдэж арилгах нь **бумбын ван.**
- Дээрхийн адил хоолойн цэгээр зүүдээр засах нь **нууцын ван.**
- Дээрхийн адил зүрхэн тушаа цэг нам унтаж ариусах нь **билгүүний ван**
- Дээрхийн адил 4-р цэг нууцын оронд хамтын баясал төрүүлэх нь **цэгийн ван** буюу **4-р ван болой.**

Дээдийн дээд дөрвөн ван

Орчлонгоос хэтэрсэн чинагш үзлийн үүднээс:

- Оройн цэгээр бумбын **ван**
- Хоолойн цэгээр **нууцын ван**
- Зүрхний цэгээр **билгүүний ван**
- 4-р цэгээр **цэгийн ван**

хэмээдэг нь дээд 4-н вантай адил боловч зөвхөн өөрсдийн тухайд бус шавь нарын тулд учраас дээдийн дээд авшиг хэмээжээ.

Хамгийн сүүлийн Доржловон дагвуучинбуу ван нь нялхасын авшиг 7, дээдийн 4, дээдийн дээд 4 гэх вангуудыг нэтгээд Доржловон өөрөө ван тавих эрхтэй болдог.

**Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам Данзанжамцын айлдсан
дүйнхорын авшиг болон түүний ончлол, айлдсан газар,
оролцсон хүмүүний тоо**

<i>Он</i>	<i>Айлдсан газар</i>	<i>Хүн</i>
1.	1954 он Түвэд Норвуулинга	100.000
2.	1956 он Түвэд Норвуулинга	100.000
3.	1970 он Энэтхэг Дарамсала	30.000
4.	1974 он Өмнөд Энэтхэг	10.000
5.	1974 он Энэтхэг Доржданд	100.000
6.	1976 он Ладак	40.000
7.	1981 он Америк Вашингтон	1500
8.	1983 он Энэтхэг Бумдила	5000
9.	1983 он Бидада хийдэд	10.000
10.	1985 он Швецарт	6000
11.	1985 он Энэтхэг Дарждан	200.000
12.	1988 он Ладак Сангарт	1000
13.	1989 он Америк Лос-Анжелос	1500
14.	1990 он Энэтхэг Варнас	130.000
15.	1991 он Америк Нью-Йорк	2500
16.	1992 он Энэтхэг Хүннү	19.000
17.	1993 он Сиким Ганток	130.000
18.	1994 он Энэтхэг Гарша	20.000
19.	1994 он Испани Барселон	3000
20.	1995 он Энэтхэг Монгоод	120.000
21.	1996 он Монгол Улаанбаатар	30.000
22.	1996 он Энэтхэг Бэтүва хийд	20.000
23.	1996 он Австри Сэднэй	3000
24.	1996 он Энэтхэг Салугар	200.000
25.	1999 он Америк Индиана	4000
26.	2000 он Энэтхэг Салугар	200.000
27.	2002 он Австри	10.000

28.2003 он Энэтхэг Дорждан	300.000
29.2004 он Канада Торонта	2000
30.2006 он Энэтхэг Балдан Брайван	300.000

АРВАН ҮСЭГТ ТЭМДЭГТ БУЮУ НАМЖУБАНДАН ЦАГИЙН ХҮРДНИЙ НОМЛОЛЫН БЭЛГЭДЭЛ БОЛОХ НЬ

Намжүбандан буюу 10н Үсэгт тэмдэгийн тайлбар

Арван зүгийн гурван орчлонгийн сав ертөнц шимийн амьтан бүгдийг нууц тарнийн ёсоор хураасан яруу алдрын дувааз Намжү бандан цагийн хүрдний хутгийг олох, буяны тамгыг өөрийн оюуны халбагаар оочих төдий цухас дурдваас: жишээлбэл Монгол улсын бэлгэдэл туг сүлдэндээ оршдог үүнийг үндсэн хуулинд ч гэсэн хуульчилсан байдаг. НҮБ-ын өмнө 150 гаруй орны төрийн далбаа намирч байгаа нь цаанаа тэр улсыг төлөөлөн илэрхийлдэг. Ямар нэгэн муу зүйл тохиовоос тэр туг сүлдийг 45 хэмээс илүүгүй бөхийлгөдөг ба баяр ёслолын үед туг сүлдээ залж хийморь юугаа бадруулдаг. Мөн аль нэгэн улсын ерөнхийлөгч ч гэсэн бүх улсынхаа хүн ам газар нутгийг төлөөлөн гадаад гүрэнтэй харилцаа холбоо тогтоон, гэрээ контракт байгуулах эрхтэй төлөөлөл болдог. Тэрэнтэй адилхан цагийн хүрдний номлол нь хөлгүй далай шиг гүн,хөх тэнгэр шиг уужим хүний сэтгэлд


Зураг 11



Дээрхийн Гэгээнтэн XIV далай лам Данзанжамцийн Намжирaa дацанд бүтээсэн Намжванвангийн хамгийн анхны өнгөт зургуудын нэг болой.

багтахааргүй боловч Намжү бандан буюу 10н үсэгт тэмдэг нь / дээрхи 11-р зурагт үзүүлсэн/ дүрсжүүлсэн хэлбэрээр Дүйнхорын номлолыг хураан илэрхийлдэг.

Зураг 12



*Ялеусны дувааз
Намжүбандангийн бэлгэдлийг
компьютер графикийн аргаар
бүтээв*


Намжүбандангийн бэлгэдлийг дэлгэрүүлбэл


Намжү бандан буюу 10н үсэгт тэмдэг нь цагийн хүрдний номлолын гол шим бүгдийг хураангуйлсан дүрс болно. "Жамбал санжид" хэмээх номонд "ани игбру гүнжи чог" буюу А үсэг нь үсэг бүгдийн дээд гэдэгчлэн дива нагари буюу дива нь тэнгэр,нагари нь бурханы айлдвар гэж орчуулагдах самгард хэлний А үсэгтэй энэхүү 10н үсэгт тэмдэг нь адилхан хэлбэртэй. Самгард хэл нь дэлхийн соёл иргэншлийн анхны дурсгалыг бичиж тэмдэглэгдсэн дэлхийн анхны хэл гэж эрдэмтэд тогтоосон байна. Тиймээс ч Бурхан багш энэхүү хэлээр номоо

айлдсан. Эзэн Чингис хааны алтан гэрэгийг харсан амьтан хүмүүн бээр айн сөхөрч хүлээн авдаг шиг дээрхи 10н үсэгт тэмдэг Намжү банданг харсан Лха тэнгэр, лус, газрын эзэд бээр Чингис хааны алтан гэрэг шиг хүлээн авдаг. Тэр ч бүү хэл 3н орчлон ертөнцийг бүхэлд нь бэлгэдэж байдаг. Жишээ нь: хийг хар өнгөөр, галыг улаан өнгөөр, усыг цагаан өнгөөр, газрыг шар өнгөөр, огторгуйг хөх өнгөөр, ургамал амьтаныг ногоон өнгөөр үзүүлж байгаа бөгөөд 10 байдал гэдэг нь 10 зүгт буй Нумажү

хэмээх 10 хийг бэлгэдэж тэр нь махбодьтойгоо холбогдон орчлон ертөнцийг шүтэн барилдлагааны хуулиар тогтоон барьж байдаг ба хамгийн анх гал махбодьтой харьцаж хүчийг аван бадарч, усан махбодьтой нэгдэж улайссан төмөр хатаагддаг шиг нягт хатуурч, шороон махбодьтой холбогдон хатуу бүрхэвчтэй болон түүн дээр гадны арга билгийн, билиг талаас харьцан гадаад орчинг буй болдгийг үзүүлдэг. Энэ нь дэлхийн бүтэцтэй яг таарч байгаа процесс болно. Дэлхийн цөм нь Магма хэмээх маш халуун бодисыг хөдөлгөөнд оруулж буй маш нарийн хий байдаг гэж үздэг. Тэр хоёр нь усаар хүрээлэгдэн газар шороогоор бүрхэж түүн дээр ургамал амьтан буй болж шим ертөнц дэлгэрдэг. Үүнтэй адил хүмүүн төрөлхтөн мөн л ийм дараалалаар буй болж шүтэн барилдлагаагаар гадаад орчинтойгоо зохицон амьдардаг. Хүний таван цул эрхтэн элэг, зүрх, бөөр, уушиг, дэлүү нь таван махбодь болох гал, ус, хий, газар шороо, огторгуй таван сав эрхтэнтэйгээ хамт 10 хийг төлөөлөн мөн л 10 байдлыг үүсгэдэг. /Хайдавнорсонжамц:орчлонгийнтогтоц/

Самгард хэлний дармал 7 үсгийг давхардуулан бичсэн байдаг.





дээр нар сар дөл буюу ум - аа - хум гурвыг нэмээд намжү буюу арван байдлыг илэрхийлдэг умм аа хум хам ча ма

ла ба ра ям хэмээх нь Дүйнхорын зүрхэн тарни буюу 722 лха тэнгэрийн нэрийг хураангуйлсан бурхан багшийн аман гэгээнээрээ айлдсан адистид жанлав бүхий санскрид үг болой.

Өнгөний бэлгэдэл: Суурийн дөрвөн дэвсгэр нь "жуна ши" 4н махбодийн өнгөөр дэс дараалан шар дэвсгэр шороо, хөх дэвсгэр ус, улаан дэвсгэр гал, цагаан дэвсгэр хийн олбог бөгөөд түүн дээр давхарлан байрлуулсан босоо үсэг:

Ногоон дэвсгэрээр дүрсэлсэн самгард үсэг бол "яа"

Улаан дэвсгэрээр бүтсэн самгард үсэг бол "ра"

Цагаан дэвсгэрээр бүтсэн самгард үсэг бол "ва"

Шар дэвсгэрээр бүтсэн самгард үсэг бол "ла"

Ма үсэг нь хүсэлт орчлон билигдэж таван өнгөтэй байх ба

"ча" үсэг нь дүрст орчилонг бэлгэдэж цагаан өнгөтэй.

“Хам” үсэг нь дүрсгүй орчлонг бэлгэдэж хөх өнгөтэй. ༄ хам


Сар нь цагаан ༄ ум

Нар нь улаан ༄ аа

Дөл нь хөх өнгөтэй байдаг. ༄ хум

ТУС ЭРДЭМ

Гурван ертөнц сав шимийн амьтныг бэлгэдэхээр үл барам Цогт цагийн хүрдний гадаад дотоод бусад тэргүүтэй бүх



- шар олбог шороог
- Хөх олбог хийг
- улаан олбог галыг
- цагаан олбог усыг
- тус тус илэрхийлдэг

номлолыг багтаасан тул байшин орон хийдийн дотор залваас од гарагийн хорлол, гал ус салхи, газар хөдлөх аюулаас зайлуулж, өлзий хутгийг оршуулдаг бөгөөд биедээ сахиус мэт зүүж ачийг нь үргэлж бодож байваас төрийн хаан түшмэлийн аюул, төхмийн

хулгай дээрэм араатнаас гэтэлгэж, харшлах шалтгаан лугаа арилгаж, зохилдох үйл бүхнийг дэгдээж орон дэлхийг үр жимс хур бороогоор жигдэлж санасан хэрэг бүхнийг гүйцээж энэ хийгээд эцэс хойдын буяны үрээр Цогт цагийн хүрдний хутгийг олох буяны тэмдэг бэлгэдэл болой.


ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЦАГИЙН ХҮРДНИЙ НОМЛОЛ ДАХЬ ХОТ МАНДАЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Цагийн хүрдний номлолд орчлон ертөнцийг бүхэлд нь илэрхийлсэн бурханы хот мандлын тухай ойлголт чухал байр суурь эзэлдэг ба цагийн хүрдний зан үйлд хот мандал бүтээх нарийн ёс байдаг.

Бурханы хот мандал нь хүрээний хот мандлаас эхлэн лагшингийн, зарлигийн, тааллын ба их амгалангийн, билиг билгүүний хот мандал байх ба тус бүрд нь тодорхой үзэгдлийг илэрхийлсэн тэнгэрүүд оршдог.

Цагийн хүрдний хот мандлыг зурмал болон өнгөт элсээр бүтээдэг. Доорхи хот мандал нь өнгөт элсээр бүтээгдсэн. Дүйнхорын ёсонд хот мандалыг үндсэн 6-н хэсэгт хувааж үздэг. Үүнд: огторгуйн, бат бэх төмөр хүрээн, хийн, галан, усан, шороон хүрээний зэрэг хот мандал багтан ордог. Хий, гал хоёр хүрээн дээр 8-н хорол, дээр доор тус бүр нэг хорол нийлээд 10-н хорол эр эмээр тэгш оршин байрлаад 20-н тэнгэрийг илэрхийлдэг. Мөн хоролын завсар 11 ланз самгард үсэг 8 хэсэг хүрээлэн байрладаг нь 88 тэнгэрийг бэлгэддэг. Нийт 108 тэнгэр байдаг нь орчлонгийн тогтоцод хамгийн түрүүн химийн болон физикийн урвал үзэгдлээр хөдөлгөөнд ордог хамгийн гадна талын хүрээ хот мандал болой. (зураг 50)

ГАДНА ТАЛААСАА ХҮРЭЭНИЙ ХОТ МАНДАЛ



Намжира дацангийн 1990 онд Америкийн New York хотын үндэсний музейд зориулан бүтээсэн цагийн хүрдний номлолын өнгөт элсэн хот мандалын фото зургаас буулган авсан. Нийт гадна талын 6 хүрээнд 108 тэнгэр оршдог болой.

- А. Огторгуйн хүрээ Г. Галан хүрээ улаан өнгөтэй
Б. Бат бэх төмөр хүрээ Д. Усан хүрээ цагаан өнгөтэй
В. Хийн хүрээ хар хөх өнгөтэй Е. Шороон хүрээ шар өнгөтэй

ЛАГШИНГИЙН ХОТ МАНДАЛ

Лагшингийн хот мандал нийт 416 тэнгэрийг тойрсон 12 амьтан 12 сарыг цогнож түүн дээр байрлах 30 бурхан сарын 30 хоногийг бэлгэдэж нийт 360 тэнгэр болдог.

4 үүдэн дээр байрлах 7 гахай, 7 морь, 7 заан, 7 арслан дээрх 7 хангарьд, доорх 7 арслан тэгнүүдтэй эр эм тэнгэр хосоор 12 тэнгэр болдог.

Хаалганууд дээр байрлах 2 хий, 2 ус, 2 шороо, 2 гал, огторгуй билиг билгүүний тэнгэрүүд хосоороо 20 тэнгэр болдог.


4 талын 9 ланз үсэг нийлээд 36 тэнгэр болдог.

Иймээс лагшингийн хот мандал нь нийт 416 тэнгэртэй бөгөөд түүнийгээ Лүйдан, Равдүма, Чидодмой гэж нэрлэдэг.

Түүний дотор лагшингийн хот мандал дөрвөлжин 4-н хаалгатай ба зүүн хаалгийг 7-н гахай тэрэгтэй тэнгэр, урд улаан 7-н морин тэрэгтэй тэнгэр, хойно 7-н арслан цагаан тэрэгтэй тэнгэр, баруун 7-н шар заан тэрэгтэй тэнгэр, дээр 7-н хангарьд тэрэгтэй тэнгэр, доор 7-н арслан тэрэгтэй тэнгэр эр эмээр хослон нийт 12 тэнгэр үүд сахидаг. Ханан дотор тал талын ес есөн үсэг бүхий 36 тэнгэр хий, ус, шороо, галын хос, намхай билгүүний дангаараа 10-н тэнгэр эр эмээрээ хослоод 20-н тэнгэр болдог ба эдгээр нь лагшингийн гадна тэнгэр нийт 56 тэнгэр буй.

Лагшингийн хот мандал

Зураг 51



Лагшингийн дотор тэнгэрт 12 амьтан түүн дээр 30, 30-н тэнгэр байрлаж нийт 360 тэнгэр нэг жилийг бэлгэддэг.

**Лагшингийн хот мандал дотор орших 12 амьтны бэлгэдлийг
тайлбарлаваас**


1-р сар

Зураг 52-64



Лагшингийн хот мандалын зүүн талд байрлах ба догшин мангасын унаа бэрд нэг дүгээр сар буюу наг сарыг төлөөлж 30 хоногтой, хоног даасан 30 Бурхантай.

2-р сар




Лагшингийн хот мандалын зүүн өмнө талд байрлах ба салхины тэнгэрийн унаа болох гөрөөс нь хоёрдугаар сар буюу саг сарыг төлөөлж 30 хоногтой, хоног даасан 30 Бурхантай.

3-р сар



Лагшингийн хот мандалын урд талд талд байрлах ба гал тэнгэрийн унаа болох хонь нь гуравдугаар сар буюу нойн сарыг төлөөлж 30 хоногтой, хоног даасан 30 Бурхантай.

4-р сар



Лагшингийн хот мандалын баруун урд талд байрлах ба 6 толгойтой тэнгэрийн унаа болох тогос нь дөрөвдүгээр сар буюу чудо сарыг төлөөлж 30 хоногтой, хоног даасан 30 Бурхантай.

5-р сар



Лагшингийн хот мандалын хойд талд байрлах ба усан тэнгэрийн унаа болох матар нь тавдугаар сар буюу дошин сарыг төлөөлж 30 хоногтой, хоног даасан 30 Бурхантай.

6-р сар




Лагшингийн хот мандалын зүүн хойд зүгт байрлах ба Цогдог тэнгэрийн унаа болох хулгана нь зуравдугаар сар буюу түмдө сарыг төлөөлж 30 хоногтой, хоног даасан 30 Бурхантай.

7-р сар




Лагшингийн хот мандалын баруун талд байрлах ба Жажин тэнгэрийн унаа болох эр заан нь долдугаар сар буюу тагар сарыг төлөөлж 30 хоногтой, хоног даасан 30 Бурхантай.

8-р сар



Лагшингийн хот мандалын баруун хойд зүгт байрлах ба Цамба тэнгэрийн унаа болох галуу нь наймдугаар сар буюу мэндү сарыг төлөөлж 30 хоногтой, хоног даасан 30 Бурхантай.

9-р сар



Лагшингийн хот мандалын Жанхарын хойд талд байрлах ба Ванчиг тэнгэрийн унаа болох үхэр нь есдүгээр сар буюу гоо сарыг төлөөлж 30 хоногтой, хоног даасан 30 Бурхантай.

10-р сар




Лагшингийн хот мандалын зүүн талд байрлах ба Норжин тэнгэрийн унаа болох эм заан нь аравдугаар сар буюу жал сарыг төлөөлж 30 хоногтой, хоног даасан 30 Бурхантай.

11-р сар




Лагшингийн хот мандалын зүүн талд байрлах ба Бишнү тэнгэрийн унаа болох гарьд нь арваннэгдүгээр сар буюу чү сарыг төлөөлж 30 хоногтой, хоног даасан 30 Бурхантай.

12-р сар



Лагшингийн хот мандалын зүүн урд байрлах ба Ямаа тэнгэрийн унаа болох үнээ нь арванхоёрдугаар сар буюу о сарыг төлөөлж 30 хоногтой, хоног даасан 30 Бурхантай.

Бурхан багшийн лагшин найргийг 8 амьтан дээрх 116 тэнгэрээр илэрхийлсэн нь




Бурхан багшийн лагшин найраг буюу Цан самбуу дүгжү, Бижид жажү хэмээх 64 найраг 80 эрдэм төгөлдөр нийт 116 гишүүнийг бэлгэдэж 116 тэнгэр байдаг. Тэр нь дээрх 8-н амьтны дэлбээн

дээр нэг нэг бурхан дундах цоморлигт нь эр эм бурхад байрлаж нэг амьтан дээр 10 бурхан, 8 амьтан дээр нийт 80 бурхан буюу 80 эрдэм төгөлдөр, 80 эрдмийг үзүүлсэн.

ЗАРЛИГИЙН ХОТ МАНДАЛ

Лагшингийн хот мандлын дараа сүн буюу зарлигийн хот мандал 2-р давхарт дотор талд дөрвөн хаалгатай дөрвөлжин хэлбэртэй бөгөөд дөрвөн ханын дотор тал талын ес есөн ланз үсэг бүхий 36 тэнгэр, сүнгийн налжормаа нь 8 зүгт 8 дэлбээтэй цэцэг 8 байх ба дэлбээ бүрт нэг нэг тэнгэр цоморлиг бүрт эр эм тэнгэр нийлээд 80 тэнгэр зарлигийн хот мандал, гадна тэнгэр 36, дотор тэнгэр 80 байх ба нийт 116 тэнгэр зарлигийн хот мандалд багтдаг болой.


Зарлигийн хот мандал

Зарлигийн хот мандалд байрлах тал талын 9, 9 ланз үсэг нь нийт 36 тэнгэрийг харуулж буй болой. Энэхүү лагшингийн, зарлигийн, тагаалалын хот мандалын хэсэгчилсэн зургуудыг Ц.Отгонбаяр бээр компьютер графیکیн аргаар дүрслэн үзүүлсэн билээ.

ТААЛЛЫН ХОТ МАНДАЛ

Түүний дотор 3-р давхарт дөрвөлжин 4 үүд хана бүхий тагаалалын хот мандал 4 хаалган дээрээ 4 тэнгэр, тахилын 12 тэнгэр, дотор симба дан симма тэргүүт 24 тэнгэр, өнгө 6 тэнгэр цогцос 6 тэнгэр, орон 6 тэнгэр бөгөөд **нийт Таалалын хот мандалд 58 тэнгэр** байрладаг.


Зураг 75



ИХ АМГАЛАНГИЙН ХОТ МАНДАЛ

Тааллын хот мандалын дотор Их амгалангийн буюу дэчингийн хорлоо хэмээх хот мандал нь дэшиг пармаан орон дотор байрладаг.

Их амгалангийн хот мандал



1. Зүүн талд дондүвнагву
2. Зүүн өмнө дулма нагву
3. Урд талд ренжүн марбу
4. Баруун урд гойгарму
5. Хойд талд одвагмидгарбу
6. Баруун хойно жанма гарбу
7. Баруун тал намнан сирбу
8. Баруун тал одбагмид гарбу гэх мэт 8-н бурхан хосоороо 16 бурхан оршдог.


БИЛИГ БИЛГҮҮНИЙ ХОТ МАНДАЛ

Их амгалангийн хот мандалын дотор 8 дэлбээтэй лянхуа цэцгийн голд Дүйнхор яв юм тэргүүтэй 10 бурхад тойроод 8 дэлбээнд тус тус 8 бурхад байрлан билиг билгийн хот мандалыг үүсгэнэ. Нийт 18 бурхадтай.

Билиг билгүүний хот мандал



Зураг 77



Зураг 78

Хэсэгчилсэн дүгнэлт хийвэл:

- Хүрээний хот мандалд 108 тэнгэр
- Лагшингийн хот мандалд 416 тэнгэр
- Зарлигийн хот мандалд 116 тэнгэр
- Тагаалалын хот мандалд 58 тэнгэр бурхад
- Их амгалангийн хот мандалд 16 бурхадтай

Билиг билгүүний хот мандалд 18 бурхадтай нийт цагийн хүрдний хот мандалд 732 лха тэнгэр оршдог.

Гэвч 5-р далай багшийн дэглэсэн намжал дацангийн ёсоор билиг билгийн хот мандалын цэцгийн голд 10 бурхан биш 6 бурхан байна. Яагаад гэвэл элсээр хийх дүлцэнгийн хот мандал

учир 10 бурхадыг 6 бурханд хураагаад 6 өнгийн цомбо годолдог. Мөн Тагаалалын хот мандалд буй 12 сунмааг хосоор нь биш дангаар тоолдог. Иймээс 732 тэнгэрээс хасах нь 4 тэнгэр, дахиад хасах нь 6 тэнгэр учир 722 тэнгэр бурхантай гэж үзэж 722 цомбо годолдог учиртай.

Энэ нь Зава ламын Алтандэвтэрт Замбуулин 360 язгуурын, 722 хэлтэн амьдардаг гэж бичсэнтэй утга тохирч дүйж байна.



Зураг 79

Лагшин зарлиг Тагаалалын 3 давхар хот мандал

- Эхний зураг дээр цагийн хүрдний номлолын лагшин зарлиг тааллын хот мандал лойлон буюу оюуны байгуулалт оршвой.
- Хоёрдугаар зураг дээр тааллын хот мандал
- Гуравдугаар зураг дээр билиг билгүүн буюу ишээжийн хот мандал оршвой.

Цагийн хүрдний номлолын 12 сар болон Төвдийн 12 сарын дэс дараалал ялгаатай болохыг харьцуулсан харьцуулалт.

Төвдийн 12 сар

1. чи сар
2. о сар
3. навга сар

Дүйнхорын сар

1. навга сар
2. саг сар
3. нойн сар


- | | |
|---------------|---------------|
| 4. саг сар | 4. чүдо сар |
| 5. нойн сар | 5. түшин сар |
| 6. чүдо сар | 6. тагар сар |
| 7. түшүн сар | 7. тагар сар |
| 8. түмдой сар | 8. миндүг сар |
| 9. тагар сар | 9. го сар |
| 10. миндүгсар | 10. жал сар |
| 11. го сар | 11. чү сар |
| 12. жал сар | 12. о сар |

Дээрхи харьцуулалт зөрүүтэй байгаа нь Дүйнхор нагва сараас эхэлдэг ба хаврын адаг сарын шинийн 15-нд бурхан багш цагийн хүрдний номоо айлдсантай холбоотойгоор ийм зөрүүтэй байгаа гэдэг. Түүнчлэн 12 амьтныг унасан эзэд нь таван махбодийн шинжтэй учир хүмүүс өөрийнхөө биед харьцуулан энэ сар гал махбодьтой дараа усан махбодьтой гэх мэт жил, сар, өдөр цагийн махбодийн зурлага үүнээс үүдэн гардаг билээ.

ЦАГИЙН ХҮРДНИЙ НОМЛОЛ БА АВИДАРМАГИЙН НОМЛОЛ ДАХЬ ЕРТӨНЦИЙН ТОГТЦЫН ЯЛГАА


Бурханы хот мандлын ойлголтоор өмнөх хэсэгт илэрхийлсэн цагийн хүрдний номлол дахь ертөнцийн тогтоц нь Авидармын ёсон дахь ертөнцийн тогтоцоос ялгаатай байдаг.

Авидармагийн ёсонд ертөнцийн тогтоцыг үзүүлэх нь



Энэхүү ертөнцийн схемийг Авидармагийн их жаанд буй ертөнцийн тогтоц дагуу Энэтхэгийн Сира хийдийн лхаарамба аграмба Намжир дацангийн Кансүр Жадоренбүчигтэй хамтран зурсан болой.

Цагийн хүрдний ёсонд ертөнцийн тогтоцыг үзүүлэх нь



Энэхүү цагийн хүрдний ёсонд ертөнцийн зүй тогтлыг илэрхийлсэн схемийг Зава лам болон Хайдавнорсонжамц, Лондол лллам нарын ном дагуу ЭУЭнэтхэгийн Сира хийдийн лхаарамб аграма Намжира дацангийн Кансүр Жадорембүчитэй хамтран зурсан болой.

Авирдармагийн ёсноос ялгаатай тал нь

- Сүмбэр уулын хэлбэр бөөрөнхий
- Дүрст орчлонгийн 15 дахь орон Жанинба байхгүй.
- Багцын хувьд 2 дахин том

Үүнээс гадна цагийн хүрдний ёс ба Авидармын ёсон дахь орон зай, цаг хугацааны хэмжигдэхүүн ялгаатай байдаг.

Авидармын ёсон номлол дахь хэмжигдэхүүн

1. Маш нарийн дүрс /энгийн нүдээр харахгүй/
2. Маш нарийн дүрс 7 нийлээд маш нарийн ТООС
3. Машийн нарийн тоос 7 нийлээд ТӨМРИЙН ТООС
4. Маш нарийн төмрийн тоос 7 нийлээд УСНЫ ТООС
5. Маш нарийн усны тоос 7 нийлээд ТУУЛАЙН ҮСНИЙ ҮЗҮҮР
6. Туулайн үсний үзүүр 7-той ХОНИНЫ ҮС
7. Хонины үс 7 нийлсэнтэй ҮХРИЙН ҮС
8. Үхэрийн үс 7 нийлсэнтэй НАРНЫ ГЭРЛИЙН ТООС
9. Нарны гэрлийн тоос 7-той НЭГ ХУУРС
10. 7-н хуурстай нэг БӨӨС
11. 7-н бөөстэй нэг АРВАЙ
12. 7-н арвайтай нэг ХУРУУ
13. 24 хуруутай нэг ТОХОЙ
14. 4-н тохойтой нэг АЛД
15. 500 алд жанда буюу БЭЭР
16. 8-н жандаа нь нэг БАГЦАД

Нэг алдыг 1.5 метр гэж үзвэл:

500 алд х 1.5 метр = 750 метр нэг жанда буюу бээр
750 метр х 8-н жандаа = 6000 метр буюу 6 км нь нэг багцад болж байна.

Калачакра буюу цагийн хүрдний ёсон дахь хэмжигдэхүүн

1. Маш нарийн ДҮРС
2. Маш нарийн дүрс нь маш нарийн ТООС
3. Маш нарийн тоос 8 нь ҮСНИЙ ҮЗҮҮР
4. 8 үсний үзүүр нэг ХУУРС-тай
5. 1 хуурс нь нэг БӨӨС-тэй
6. 8-н бөөс нь нэг АРВАЙ-тай
7. 8-н арвай нь нэг ХУРУУ-тай
8. 24 хуруу нэг ТОХОЙ-той
9. 4-н тохой нь нэг АЛД-тай
10. 2000 алд нь нэг ЖАНДА буюу БЭЭР-тэй
11. 4-н жанда нэг БАГЦАД-тай тэнцэнэ.

Дүйнхорт алдыг 1.5 метр гэж үзвэл 2000 х 1.5 метр = 3000 метр нь нэг жанда болох ба 3000 метр х 4-н жанда = 12000 метр нэг багцад буюу 12 км болж байна.

Энэ нь Авидармагийн нэг багцад 6000 метр буюу 6 км байхад дүйнхорын багцын хэмжээ 2 дахин их 120000 метр буюу 12 км байна.

Калачакрагийн ёсон дахь цаг хугацааны хэмжигдэхүүн

Эрүүл насанд хүрсэн хүний нэг амьсгаа авах гаргахыг “үг” гэдэг хугацааны нэгжээр хэмждэг. Үүнд:

- | | |
|---------------|---|
| 6-н үг нь | - нэг чүсан болдог /хагархай тогоо/ |
| 60-н чүсан нь | - нэг чүцад буюу цаг |
| 60 чүцад нь | - нэг хоног болдог. |
| Нэг үг | - 5-н удаагийн судасны цохилттой тэнцдэг |
| Нэг үг | - 300 дунта гажигтай дүйдэг гэвэл |
| Нэг өдөрт | - 6480000 дунта гажиг |
| Нэг өдөрт | - 21600 удаа амьсгаа авдаг гэж дүйнхорын ёсонд үздэг билээ. |

Жүмэгийн ёсон дахь цаг хугацааны хэмжигдэхүүн

1. Гажиг буюу агшинг – 2 судасны цохилттой тэнцэнэ
2. Гажиг нь тантай адил бол
3. 4-н тан нь нэг чүсонтай
4. 4 чүсон нь нэг юүдзамтай
5. 2 юүдзам нь нэг чүцадтай буюу 1 цагтай тэнцэнэ гэж үздэг.

Дүнгарлуvsан пэрэнлайн ёсон дахь цаг хугацааны хэмжигдэхүүн

Хугацааны хамгийн богино үе бол дунта гажиг гэх ба энэ нь насанд хүрсэн хүн сигол давлах буюу дунд хуруу эрхий хуруу хоёроор товших хугацааг 60 хуваасныг хэлнэ гэжээ. Мөн дээрхийг:

- 20 хуваасныг гажиг
- 30 хуваасныг юүдзам гэж үзэж тайлбар хийсэн байдаг.

Эдгээрээс үзэхэд хэллэгийн хувьд өөр өөр боловч хугацааны хувьд адилхан.

- | | |
|----------|-------------------------------------|
| 1. Гажиг | 6. Сар |
| 2. Үг | 7. Жил |
| 3. Чүсан | 8. Галба хүртэл |
| 4. Чүцад | 9. Галав гэж ангилж болохоор байна. |
| 5. Өдөр | |

Цагийн хүрдний номлолын бусад жүдээс ялгарах онцлог

Ямантака 13 хортой буюу нөхөртэй, Гүеэ-самажо буюу Сандуй 32 нөхөртэй, Хэрүга буюу Дэмчог 64 нөхөртэй байдаг бол калачакра нь лагшин, зарлиг, тагаалалын 3-н давхар хот мандалтай ба ༄། ༄། буюу эр дамжлага учраас ༄ хум үсэгний

доор жижиг “а” үсэг байдаггүй шууд шавьж залгаж бичигддэг.

Түвдийн цагаан толгойд “Га” тэргүүтэй 30 гийгүүлэгч байдаг бол калачакрад “БО” хийгээд “ГО” үсэг байдаг болохоор 32 үсэг байна. Тову калачакра буюу Доржшүг бурханд 26 мутар буй (Калачакра 24 мутартай) 4-н жил болоод нэг илүү сар гардгийг илүү мутар байдгаар харуулсан гэж үздэг.

Ер нь са-жү буюу арван газар гэж тэгчин тонлом-оос жүнтаам хүртэл байдаг бол Калачакраагийн ёсонд 12 газар байдаг ба анхны “са” буюу газар нь - тэгшчин жорломчоймчигоос бурханы оронд тавигддаг. 12 дахь газар нь бурханд байдаг онцлог ялгаатай. 2-р газраас 11-р газар хүртэл паражно парамидатай адилхан байдаг. Нэгдүгээр газар ба арван хоёрдугаар газар нь өөр байдаг онцлогтой.

ས་དང་པོ་ཐེག་ཆེན་དོར་ལམ་ཡོད། ས་བཅུ་གཉིས་སངས་རྒྱས་ཀྱི་ལམ་ཡོད།

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Сэдвийг судалсны үр дүнд дараах дүгнэлтэнд хүрч байна.

Цагийн хүрдний номлолын номлооч нь Бурхан багш мөн бөгөөд номлосон газар нь Энэтхэгийн Амрапади хэмээх газар мөн болохыг эдийн дурсгал болох орон нутаг судлах музейн чулуун дээр сийлсэн хүрд, очир, чулуун, суврага, Шалабанзага хэмээх Дүйнхор бурханы үүд сахигч тэнгэрүүдийн чулуун сийлбэрүүдээр нотлогдож байна.

Мөн өлгийн дурсгал болох Бурханы гэгээний аман айлдварын хураангуй тэмдэглэл болох Ганжуурын 108 боть доторхи жүдийн “Га”, “Ха” ботид буй Дүйнхорын хураангуй дамжлага хэмээх ном, Лондон лам Агваанлуvsан тэргүүдтэй Төвд лам нарын бүтээл Заяа Гэгээн, Зава лам тэргүүтэй монгол нарын зохиол бүтээлүүд Бурхан багш цагийн хүрдний номлолыг Амрапади хэмээх газар номлосныг бичгийн дурсгалт зүйлээр нотлож буй.

Орчин үеийн шинжлэх ухааны эрдэмтэд, архилогичид болон палеонтологичид дээрх хоёр эдийн болон өлгийн дурсгалт зүйлүүдийг Бурханы гэгээний үеийн материал болохыг хөдлөшгүй нотлон, дүгнэлт гаргасан байгаа нь дээрх хоёр дурсгалт зүйлийг нотлоход маш дөхөмтэй болгож байна.

Гадаад гэдэг агуулгаар бясалгаачийн биеийн гадна оршиж буй орчлонгийн бүтэц, тогтцыг илэрхийлж байгаа нь шинжлэх ухааны ололт, дүгнэлтүүдтэй ижил төсөөтэй зүйлүүд олон гарч байна. Жишээлбэл: Цагийн хүрдний ёсонд үйлийн үрээс шалтгаалан орчлон ертөнцийг тогтдог гэж үздэг боловч Хайдавнорсонжамцын “Их тайлбарын хиргүй гэрлийн чимэг” хэмээх номонд орчлонгийн тогтцыг үзүүлэхдээ маш нарийн хий махбодь таван эрдэм төгөлдөр, маш нарийн гал махбодь дөрвөн эрдэм төгөлдөр, маш нарийн усан махбодь гурван эрдэм

төгөлдөр, маш нарийн шороон махбодь хоёр эрдэм төгөлдөр эдгээр махбодиуд өмнөхийн огторгуйд хоосон чанараар сүлэгдэн нэгдэгдэж, уул ус ургамлыг бий болгон, гадаад орчлонг бүрдүүлнэ хэмээсэн нь орчин үеийн шинжлэх ухаан дэлхийн бүтцийг тайлбарлахдаа: Маш нарийн хий магми хэмээх халуун галаар холилдон, усаар хүрээлэгдэн, шороогоор бүрхэгдэж, түүн дээр сав шимийн ертөнц уул, ус, ургамал тархдаг гэх дүгнэлттэй зөрөх юмгүй таарч байгаа. Дээрх судалгааны үед нотлогдож байна.

Дотоод хэмээх агуулгаар цагийн хүрдний номлолыг товч тайлбарлавал: Эрдэмтэн Л. Фейербах байгалийн бүх үзэгдлийн танин мэдэх түлхүүр нь хүн гэсэн байдаг. Түүнлүгээ адил хүмүүн төрөлхтөн эхийн хэвлийд бий болох процессоос эхлэн тодорхой гадны орчлонгийн нөлөөн дор хамааралтайгаар 12 шүтэн барилдлагаар дамжин буй болдог бодьгал ба хүн өөрийнхөө дотоод энерги хүчээ төвлөрүүлэн, өөрийгөө удирдан ялж чадваас гадаад орчинг танин мэдэж болно хэмээх дотоод цагийн хүрдний онол нь дээрх эрдэмтний дүгнэлтэй таарч байна.

Бусад хэмээх агуулгаар үйлдэхийн зэрэг, төгсөхийн зэрэг, авшиг тэргүүтнийг үзүүлдэг ба эдгээр нь цагийн хүрдний номлолыг төгс эзэмшихийн суурь Намжүвандан буюу арван үсэгт тэмдэг болох бөгөөд түүнд очихын замыг үйлдэхийн зэрэг болон төгсөхийн зэргээг илэрхийлдэг ба учрахын хувь ерөөлийг авшиг авч илэрхийлдэг болой. Энэ нь Бурханы шашны Ши Лам Брайв сүм буюу суурь зам үр дүнг харуулж байна.

Энэхүү судалгааны ажил болох цагийн хүрдний номлол нь 2500 гаруй жилийн түүхтэй далай мэт баялаг арвин агуулгатай тул нэг хүн насаараа судлаад ч барахгүй гүн номлол билээ. Тус диссертац нь цагийн хүрдний номлолыг нээх төдий, утгын хаалгыг онгойлгохын тулд бүдүүвч зургаар томъёолон нээлээ. Тус номлолыг автомашинтай зүйрлэвэл машины ганц дугуй бус, 1937 оноос хойш өнөөг хүртэл судалгааны аястай бүтээл ховор

буйг харгалзан үзэж, дараа дараагийн судлаачдад амар хялбар болгохын тухайд муу ч гэсэн бүтэн явдаг машин мэт гол утгын цуглуулгыг анислан дээжилсэн билээ.

Намжүвандан буюу арван үсэгт тэмдэг нь цагийн хүрдний номлолыг бүхэлд нь төлөөлж буйг дүгнэх нь

1. намхай буюу огторгуй нь хар хөх өнгөөр
2. лүн буюу хийн махбодь хар ногоон өнгөөр
3. мэ буюу гал махбодь улаан өнгөөр
4. чү буюу усан махбодь цагаан өнгөөр
5. са буюу шороон махбодь шар өнгөөр
6. Рэрав буюу уул ургамал нь өөрийн өнгөөр илэрхийлэгдэж байгаа нь хүсэлт орчлон, дүрст орчлон, дүрсгүй орчлонг төлөөлөн буй өнгүүд юм. Иймээс цагийн хүрдний номлолын **гадаад хэмээх** агуулгыг илэрхийлж буй билээ.

Намжү вандан буюу арван үсэгт тэмдэг нь цагийн хүрдний гадна, дотор, бусад хэмээх 3 агуулгыг илэрхийлнэ.

Арван байдал төгөлдөр авшиг нь санскрит үсгийн анхны А үсэг бөгөөд энэ нь цагийн хүрдний бурханы зүрхэн тарни болох

- | | | | |
|-------|-------------------------------------|--------|--------|
| 1. ум | 2. а | 3. хум | 4. хам |
| 5. ча | 6. ма | 7. ла | 8. ба |
| 9. ра | 10. я арван тарнийг агуулсан учраас | | |

бурханы шашинд бүх бурхадын хураангуй нь нууц увидасын бэлгэдэл болсон зүрхэн тарнидаа оршдог. Иймээс **дотоод бэлгэдлийг** төлөөлж байгаа нь илэрхий харагдаж байна.

Арван байдал төгөлдөр авшиг хэмээх бэлгэ тэмдэг нь хэлбэр дүрсээрээ дөрвөн махбодь болох цагаан усан дэвсгэр, улаан

галан дэвсгэр, хөх огторгуйн дэвсгэр, шар шороон дэвсгэр дээр босоо байрласан үсэгний хэлбэр нь хүний биеийн ерөнхий хэлбэрээр жишин үзвээс цагийн хүрдний бурханы 728 Лха тэнгэрийг Нумажү хэмээх арван маш нарийн салхиар төлөөлөн байгаа нь **бусад** хэмээх агуулгын **үйлдэхийн зэргийг** илэрхийлнэ.

Зургаан өнгийн үсэг хоорондоо систем болон холбогдсон байгаа нь за ум а, рома, жама судаснуудыг төлөөлөн нар нь оройн цэг, сар нь хүзүүний цэг, тэгээд доошоо зүрхэн тушаа, хүйсний харалдаа, нууцын орон гэх мэт таван орныг төлөөлж байгаа нь бусад хэмээх агуулгын **төгсөхийн зэргийг** үзүүлж буй билээ.

Энэхүү арван байдал төгөлдөр авшиг хэмээх бэлгэ тэмдгийн **авшиг** гэдэг үгээр нь нялхсын долоон авшиг, дээд дөрвөн авшиг, дээдийн дээд дөрвөн авшиг, очирт ловонгийн авшиг тэргүүтэй 16 авшигийг төлөөлөн бичигдсэн байдаг.

Дээрхи арван байдал төгөлдөр авшиг хэмээх бэлгэ тэмдгийг харсан хүн бүгдээрээ ирээдүй цагт залрах Рэгдан дагва хааны итгэмжит хувь төгөлдөр шавь болох хувь заяаг илэрхийлж буй учир бусад агуулга хэмээхэд хамаарагдах **үр дүнг** илэрхийлж байгаа буй за.

Ийм учраас бурхан багш бээр манай эриний өмнөх VI зуунд бодитой амьдарч байсан ба өмнөд Энэтхэгийн Балдан брэйвун хэмээх газар цагийн хүрдний номлолыг эхлэн номлосон гэдэг нь тогтоогдож байна.

Цагийн хүрдний номлолын гадаад, дотоод, бусад хэмээх гурван агуулгын хураангуйлсан тэмдэг нь Намжүвандан хэмээх тэмдэг болох нь цагийн хүрдний ном эшлэлийн дагуу тогтоох нь энэ болой.

ЭНЭХҮҮ ДИССЕРТАЦИЙН ҮР ДҮНД ДАРААХ ТААМАГЛАЛЫГ ДЭВШҮҮЛЖ БАЙНА

Очирбээр огтлогч хэмээх их хөлгөн сударт "Бурхан багшийн айлдсан" амьтны төрлийг: 1. Өндгөн ээцээс төрөгсөн ба 2. Умайн ээцээс төрөгсөн ба 3. хувилаж төрөгсөн ба 4. Зөөлөн дулаан ээцээс төрөгсөн ба гэж дөрөв ангилдаг. Зөөлөн дулаанаас төрсөн гэдэгт чийгэн улаан хорхой мэтийн эхгүй төрдөг амьтад хамрагддаг. Үүнийг шинжлэх ухаан маань тайлбарлаж хараахан чадаагүй. Энэ мэт сүнсэн бие эхийн хэвлийд улаан, цагаан бөөм буюу эр, эм хромсомтой нэгдэн хүүхэд амьлах процессыг орчин үеийн эхо оношлогооны аппаратаар бүрэн харж чаддаг. Бороо, салхи, газар хөдлөлт зэрэг байгалийн үзэгдлийг физик, химийн шинжээр тайлбар хийдэг боловч яагаад гэдэг асуултанд эдгээр нь төгс бус хариулт. Цагийн хүрдний номлолыг судалж итгэж, бясалгаж, номчлон, авшиг авч гаднаас ирэх арван хийн, язгуурын таван бурханы мөн чанарыг ухаарч өөрийн биед бурхад тэнгэрийг оршоох (Дагжид гомнох) ба өмнийн огторгуйд бурхад тэнгэрийг залж (Дүнжид гомнох) бясалган өөрийн биед оршоох, дотоод хүрдний бясалгалыг өмнийн огторгуйн гадаад хүрдний бясалгалтай арга билиг мэт нэгэн дор хоёр зул нэг болон дүрэлздэг шиг нэгдэж хүчийг эрхшээн үйлдэхийн зэрэг лугаа, дараа нь төгсөхийн зэрэг адил бясалгах дияанаар дээрх асуултыг хариулах нь төгс хувилбар гэсэн таамаглалыг дэвшүүлж байна. Иймээс цагийн хүрдний номлолыг судлах нь савын ертөнц, шимийн амьтантай харьцах түлхүүр гэж үзэж байна.

- 5. ཨ།དཔལ་དམ་གྱི་འཁོར་ལོའི་སྐྱབ་ཐབས་མདོར་བསྐྱུས་འཇམ་དཔལ་དགོངས་རྒྱན་
ཞེས་བྱ་བ་བཞུགས་སོ།། མཛད་པ་པོ།ཤི་གྱི་འཁོར་ལོའི་རྣལ་འབྱོར་བ་བཙུན་བ་སློ་
བཟང་ཚོས་གྱི་རྒྱལ་མཚན་གྱིས། ཚོས་གྲུ་ཚེན་བོ་བཀུ་ཤིས་ལྷན་པོའི་གཙུག་ལག་ཁང་ད་
ཐོགས་མེད་དར་བའི་ཡི་གེ་བ་ནི།ཤི་གྱི་འཁོར་ལོ་ཚོགས་སོག་པ་ལེགས་ཚོས་འབྱོར་རོ།

Цагийн хүрдэний номлолын бүтээлийн хураангуй Манзушрийн таалалын чимэг хэмээхуй судар анхдугаар Ванчин богд Лувсанчойжийжанцан бээр Дашлхүнбэ хэмээх ордонд зохиосоныг гавжү Лэгчой бээр бичэв Төвд үсгээр бичэгдсэн Архангайн гирган лам бүдүүн хэмээх Аюушийн хэлсэнээр Заяын барын судар болой.

- 6. ཨ།དང་པོའི་སངས་རྒྱས་དཔལ་དམ་གྱི་འཁོར་ལོའི་ལོ་རྒྱུས་དང་མིང་གི་རྣམ་གྲངས་
བཞུགས་སོ།། མཛད་པ་པོ།ཤི་ཡང་དགོ་སློང་ངག་དབང་སློ་བཟང་གིས་བཟུང་ཐོར་བྲིས།

Цагийн хүрдэний номлолын хураангуй түүх оршвой. Хэмээх номын зохиогч Лондол лам Агваанлуvsан билээ. Төвд хэл дээр зохиогдсон хүрээ барын судар.

- 7. ཨ།རྒྱལ་བ་ཙོང་ཁ་པའི་གཞུང་དང་མཐུན་པ་ཐམས་ཅད་ཕྱོགས་གཅིག་ཏུ་བརྒྱས་པའི་
དཔལ་དམ་གྱི་འཁོར་ལོའི་མིང་གི་རྣམ་གྲངས་བཞུགས་སོ།། མཛད་པ་པོ།ཤི་ཡང་སློང་
དོལ་སློ་མ་ངག་དབང་སློ་བཟང་གིས་བསྐྱོགས་པའི་ཡི་གེ་བ་ནི་སྐུ་མ་ཁར་དགུ་ཐོག་བ་
ཚོས་བཟང་གིས་བྲིས་པའོ།།

Богд ламын номлол лугаа тааруулан хийсэн цагийн хүрдэний номлолын хураангуй хэмээх судар. Лондол лам Агваанлуvsангийн эмхэтгэсэн Төвд барын судар. 20 хуудас

8. Агваандамдинсүрэн, Бизъяагийн их лам "Шамбалын орны байгуулалт" /хүрээ барын судар/ 0.4м х 0.12м хэмжээний цаасан дээр 0.35м х 0.10м, зургаан мөрөөр барлагдсан. 43 хуудас судар
9. Будан Ренчин дүв "Дүйнхор чойнжин", "Чайндэл", "Галбон" /Цагийн хүрдний гарал, түүний зүүлт, зөрөөтэй онолын нэгдсэн дүгнэлт төвд барын судар. 0.4м х 0.12м хэмжээний цаасан дээр 0.35м х 0.10м, зургаан мөрөөр барлагдсан. 56 хуудас судар
10. Бурхан багшийн аман гэгээнээр айлдсан ганжуурын жүдийн 22 ботийн эхний Гаа хаа 2 ботид нийт 5 бүлэг 1000 орчим цаас, цагийн хүрдний номлол, Гандан хийдийн номын сан. 1.2м х 0.40м хэмжээний цаасан дээр 0.9м х 0.35м хэмжээтэй, 8 мөрөөөр, тугалган хар цаасан дээр алтан үсгээр бичигдсэн.
11. Ванчин Лувсанчойжижанцан "Дүйнхор дэлчин янин" цагийн хүрдний их тайлбарын дахин тайлал, төвд барын судар, 0.4м х 0.12м хэмжээний цаасан дээр 0.35м х 0.10м, зургаан мөрөөр барлагдсан. 20 хуудас судар
12. Галсан жамц Далай лам "Намжира дацангийн чоги" /Намжираа дацангийн зан үйл, төвд барын судар, 0.4м х 0.12м хэмжээний цаасан дээр 0.35м х 0.10м, найман мөрөөр барлагдсан. 2010 хуудас судар
13. Лувсандагва Богд лам "Жорво янлагдуг" "Бэлтгэл 6 гишүүн" хэмээх төвд судар, 0.4м х 0.12м хэмжээний цаасан дээр 0.35м х 0.10м, зургаан мөрөөр барлагдсан. 12 хуудас судар
14. Лувсандаян "Салам" 17 ботийн хаа боть буюу 2-р ботид буй хүрээ барын судар, Тус ботийн эхэнд 24 хуудас бүхий гар бичмэл,
15. Рэгдан Жамбалдагва, Шамбалын хаан "Дүйжид" Шамбалын хаан Рэгдан Бадмагарав "Бадмалабарва" Төвд барын судар, Данжуурын, Жүдийн эхний 3 боть

16. Дамба аграмба "Шамбалд зорчихын замыг гийгүүлэгч болор шат" /хүрээ барын судар/, 0.4м х 0.12м хэмжээний цаасан дээр 0.35м х 0.10м, зургаан мөрөөр барлагдсан. 43 хуудас судар
17. Зая Лувсанпэрэнлэй "Нянба дүвцэл" /Аглагт суухын ёс, төвд барын судар/ 0.4м х 0.12м хэмжээний цаасан дээр 0.35м х 0.10м, зургаан мөрөөр барлагдсан. 65 хуудас судар

ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛ ХЭЛЭНД ОРЧУУЛАГДСАН БОЛОН ТӨВД ХЭЛ ДЭЭР ХЭВЛЭГДСЭН НОМ, ТОВХИМОЛ

1. Агваанбалдан намдоллингийн лам "Дандарын голыг тодруулагч хэмээгдэх оршвой "Төвд хэлнээс Монголруу орчуулсан С.Мөнхтайван орчин үеийн, 125 хуудас, Балданхажидлин хийдээс эрхлэн гаргав УБ хот, 2005 он.
2. Амгалан.Н "Агваанбалдан цоржийн намтар" 166 нүүр, УБ хот 2007 он.
3. Ангичагдар Гавж, гурван цагийн тийн ялгавар хэмээх шастир" лам гурван сайхны орчин үеийн ном хэлбэрт оруулан бичсэн, 98 хуудас, бүхий ном 2008 он, Улаанбаатар хот.
4. Баасанжав. До доктор профессор "Галав хэзээ юүлж байсан бэ, одоо хэзээ юүлэх бэ? 101 нүүр Улаанбаатар хот 2008 он.
5. Булган.Т доктор орчуулан эмхэтгэсэн ном Шантидэвэ "Бодисадын явдалд орохуй" Улаанбаатар 2009 он, 170 хуудас.
6. Бямбасүрэн. Д, Наро Хажодын үүсгэл, төгсгөлийн зэрэг Данзан орчуулсан. 2005 он, УБ хот (124 хуудас.)
7. Гантуяа. М "Буддын философи судлалын зарим асуудал. УБ 2004 он

8. Говь мэргэн вангийн хошууны зурхайч Өвгөнхүүгийн "Цагийн хүрдний замын зул" /төвд эх
9. Гэлэн лам Түвдэнжамц орчуулсан Г.Гүнжиймаа УБ 2004 он. Буддизм Доржийн Бямбасүрэн. 2005он,УБ хот (124 хуудас)
10. Диваасамбуу. Г "Гандантэгчилэн хийд дахин сэргэсэн түүх" 130 хуудас, Улаанбаатар 2009 он.
11. Диваасамбуу. Г лам эмхэтгэв "Монголын бурхан шашны түүхэн тойм" 85 нүүршашны сургуулийн 30 жилийн ойд зориулсан бүтээл, УБ 2000 он.
12. Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам Данзанжамц "Бурхан багшийг шүтэхийн учир"орчуулсан Д.Бүрнээ, Соёомбо хэвлэлийн газар 1991 оны 5 сар, цаасны хэмжээ 84x108x32,
13. Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам Данзанжамц "Миний эх орон, Миний ард түмэн дурсамж намтар" Англи хэлнээс орчуулсан доктор Т.Булган, 245 нүүр, Улаанбаатар хот 1995 он.
14. Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам Данзанжамц, "Өмнөд Энтхэгийн Дүйнхорын вангийн танилцуулга" 2006 он, Энэтхэг улс, норвуулингаас эрхлэн гаргав, 60 хуудас.
15. Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам Данзанжанцын айлдсан 1993 Сикимын Ганток хот, Дүйнхорын авшиг. Түүнд зориулагдан гарсан Шижа хэмээх сэтгүүл.
16. Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам Данзанжанцын айлдсан 1995 он Энэтхэг улсын Монгоодын цагийн хүрдний авшиг, түүнд зориулан гарсан ном.
17. Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам Данзанжанцын айлдсан 1996 он Улаанбаатар хотод айлдсан цагийн хүрдний авшиг, түүнд зориулсан ном, "Лавайн эгшиг.
18. Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам. Тайлбарласан. "Бодь мөрийн зул" bloomington. Indiana 2007 он (700 хуудас.)

19. Елена Рерих "Буддын сургаалын үндсүүд амьдралын гүн ухаан цуврал №3,64 нүүр, Улаанбаатар 2008 он, Орос хэлнээс орчуулсан Т.Мандал
20. Ёндон. Ш.Жанцан "Ламын Чодвын тэд" 2007он (380 хуудас).
21. Жавзан Дамба хутагтын намтар түүхийн хэлхээ "Итгэмжит үл дийлдэх саран авхайн нигуурын ишлэл" эмхэтгэсэн Бэри Агвандорж орчуулсан Д.Харалбат 2003 он (хуудас 193.)
22. Жалцавжи "Дүйнхор рэмний намшиг " /Цагийн хүрдний 2 зэргийн тийм байдал/
23. Жанжаа хутагтын зохиосон тогтсон таалалын тайлбар Гомон дацангаас эмхэтгэн орчин үеийн номны хэлбэрт оруулан хэвлэсэн, 508 хуудас, бүхий ном 2008 он Энэтхэг Улс гомон дацан.
24. Жүгдэр.Ч XIX - XX зууны заагт дахь монголын нийгэм улс төр философи сэтгэлгээний хөгжил" УБ 1972/
25. Зонхова Лувсандавга 1357-1419 он "Бодь мөрийн зэрэг " орчуулсан Аким, Г Алтангэрэл, П Бадрал, нарын орчуулга. Тайванд хэвлэгдсэн, 2006 он (314 хуудас)
26. Зопа Ренбүүчий лам "Зовлонг амгаланд урвуулахуй" 80 хуудас, 2003 он, Монгол хэлэнд орчуулсан Б.Батболд, Г.Гүнжиймаа.
27. Иш Жанцан Ёнзон Багшийг тахихын хөтөлбөр "Нууц аньсны яруу увидасын сан" богдийн зохиосон Төвд хэл дээр бичсэн судрыг орчин үеийн номны хэлбэрт оруулан, Төвд лам Лувсандандарын бичсэнээр 385 хуудас бүхий ном, 2007 он, Энэтхэг улс Сира дацан.
28. Ишбалжир, Сүмбэ хамба 1747 он "Төгс буянтын зурхайн гол номлол"
29. Куну Ренбүүчий "Бодь сэтгэлийн магтаал оршвой" Монгол хэлрүү орчуулсан, Б.Идэрбаяр, 133 хуудас, Улаанбаатар хот, 2003 он.

30. Лодой. Г "Философи ба шинжлэх ухааны арга зүй" УБ хот 2004 он Долгоржав. Я. "Шинжлэх ухаан танин мэдэхүй" УБ 2002
31. Лодой. Г "Шинжлэх ухааны судалгааны арга зүй" УБ хот 2002 он
32. Лодой. Г "Хоосон чанар" (шуньяата) хэмээх ойлголтын утгыг тайлах арга зүйн асуудал, УБ 1992 он
33. Лувсанжамц Угалзын лам "Дүйнхорын авшиг" /цагийн хүрдний номлолын авшиг 3 боть номын 3-рт төвд эх/
34. Лувсанцэрэн. Г "Буддын гүн ухааны онол түүхийн асуудлаас" УБ 2008 он
35. Лувсанцэрэн. Г, Э.Ариунаа, "Буддын уламжлалт мэдлэг ухааны үндэс 162 нүүр, БСШУЯ, Лондон дахь Төвдийн сангаас хамтран хэвлүүлэв ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад зориулсан гарын авлага, Улаанбаатар 2007 он.
36. Лувсанчүлтэмжамц "Лүүжингийн тайлбар" Монгол хэлэнд орчуулсан Бямбасүрэн. Д, 90 хуудас, 2005 он Улаанбаатар 2005 он.
37. Монгол тулгуур бичгийн цуврал (Анагаах ухааны 4-үндэс). Хуучин Монгол бичгээр Өвөрмонголын Хөх Хотод 1987 онд хэвлэсэн, 1174 хуудас бүхий ном.
38. Нагаржуна "Хаанд илгээсэн захидал" орчуулсан А.Батцэнгэл, 170 нүүр, Сэлэнгэ прэсс хэвлэлийн компанид хэвлэв улаанбаатар 2007 он.
39. Нацагдорж. Ц. (Хиад боржигон) "Хүмүний төөрөг" 460 хуудас, УБ 2004 он.
40. Отгонбаяр. Ц, эмхэтгэсэн "Цагаан сарын шинийн нэгний өглөө төрийн их шүтээн Арьяабал бурхан болон уул ус лус савдагтаа тахил өргөж дэмбэрэл дэглэх уншлага урилга оршивой" Улаанбаатар хот, 2009 он, гар бичмэл.

41. Отгонбаяр.Ц гавж "Арван цагаан буян дэлгэрч рашаан болон бургилах тэр газарт бүтээсэн суврага" Улаанбаатар 2007 он, 120 хуудас.
42. Отгонбаяр.Ц эмхэтгэсэн "Монголын бурхны шашинтны төв гандан хийдийн буян хураахын аргын дээд чогчингын анхны дэвтэр шулуун хөтлөгч хэмээх оршвой" судар 278 хуудас, бүхий ном Улаанбаатар 2008 он.
43. Пүрэв. О, Бямбажав Х., "Монголын уламжлалт ёс зүйн үндэс "БСШУЯ, Лондон дахь Төвдийн сангийн хамтарсан төслийн хүрээнд гүйцэтгэв, 55 нүүр, Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан гарын авлага Улаанбаатар 2007 он.
44. Саранцэцэг.Ц, эмхэтгэсэн бүтээл "Мунхагийн харанхуйг гийгүүлэгч билгийн зул оршвой" Чойжид дагины тууж, Улаанбаатар хот, 2007 он.
45. Сонинбаяр.Ш, "Буяны садан" шашны их сургуулийн 30 жилийн ойд зориулсан бүтээл,96 нүүр,Улаанбаатар хот 2000 он.
46. Сонинбаяр.Ш, гавж СГЗ "Дашчойнпэл дацангийн түүх" А5 форматаар, 87 нүүр, Улаанбаатар хот 2007 он, тус дацангийн 270 жилийн ойд зориулсан.
47. Сонинбаяр.Ш, эмхэтгэл "Чингис хаан ба Монголын бурхны шашин эрдэм шинжилгээний бага хурлын материал" 97 нүүр, Монгол улс байгуулагадсны 800 жилийн ойд зориулан гаргасан Улаанбаатар 2006 он.
48. Сонинбаяр.Ш, эрхлэн хэвлүүлсэн доктор профессор гавж "Номгоны сүмын дарь эх ламтан Агваанцүлтэмжамцын буман зарлигын гарчиг" Улаанбаатар хот 2005 он,145 хуудас.
49. Тидэ жамъянтүвдэнням "Шижэбандаг жинсрэг" /гал мандал өргөх ёслол төвд барын судар/

50. Түвдэн Зопа Ренбүүчий "Буян ба бодит байдал" УБ хот 2002, хөрвүүлсэн Ганбатын Гүнжиймаа хэвлэлийн эх бэлтгэсэн Самдангийн Батсүрлэг (87 хуудас.)
51. Түвдэн Ишээ лам "Төвдийн бурханы шашны мөн чанар" А5 форматаар 60 хуудас, Монгол хэл дээр Улаанбаатар 2003 он, Монгол хэлэнд орчуулсан Б.Батболд, Г.Гүнжиймаа.
52. Тэрбиш.Л эмхэтгэсэн. "Ламын Гэгээн Лувсанданзанжанцан, түүний зурхайн бүтээл туурвил "Ламын гэгээний түмэн өлзий гийсний 365 жилийн ойд зориулав. УБ хот, 2004 он. (хуудас 192.)
53. Тэрбиш. Л XVII жарны наран гэтэлгэгч хэмээх модон бичин жилийн Монгол зурхайн төөрөг, УБ 2003 он, 127 х
54. Тэрбиш. Л "Билгийн их хүн дуун хөврүүлэгч Д.Галсанжинбын намтар" УБ 1998 он
55. Тэрбиш. Л "Төвд хэл бичигт суралцах дэвтэр" УБ 2000 он, үрийн зурхайн болор толь
56. Төмөр-Очир.С "Диалектик матерлизм" УБ 1988 он.
57. Төмөр-Очир.С "Социологийн судалгааны арга техникийн дадлага" УБ 2003 он
58. Төмөр-Очир.С "Шинжлэх ухааны мэдлэгийг математикчлах нь" УБ 1981 он
59. Хавх. Н "Буддын гүн ухааны агуулгын харьцуулсан тайлбар" 2-р шүүн ариутгасан: гавж Д.Чойжамц УБ 2006 он, хуудас 620, профессор Дагвадорж. Д
60. Хажидмаа. Д орчуулсан шива лхагийн намтар "рашааны дусал" хэмээх 40 нүүр бүхий товхимол, Балданхажидлан хийдээс эрхлэн гаргасан, Улаанбаатар 2005 он.
61. Хайдав норсонжамц "Дүйнхор дэлчин дэмид од жан" /цагийн хүрдний номлолын эх тайлбарын чимэг, орчин үеийн ном хэлбэрээр
62. Хайдүвнорсонжамц "Цагийн хүрдний номлолын их тайлбар хиргүй гэрлийн чимэг" орчин үеийн дэвтэр болгон

- хэвлүүлсэн Намжираа дацан, 2005 он, Энэтхэг улс, Дармасала, А5 форматаар, 543 хуудас.
63. Хурцбилиг. Н "Монголчуудын оршуулгын соёл" хуучин Монгол бичгээр бичигдсэн 470 нүүр бүхий ном Өвөрмонголын соёлын хэвлэлын хорооноос 2002 онд, хэвлэн гаргав.
64. Хүрэлбаатар. Л "Эсэруагийн эгшиг дуун" Эрдэнэ бандид ханчин хамба Жамъянгаравын яруу үгийн онолд хийсэн шинэчлэл 527 нүүр бүхий ном, Улаанбаатар 1999 он, ШУА хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн гаргасан.
65. Чойжижанцан богдын Авидармын номлолын аньсыг сайтар болгоосон эрдэнийн сан хэмээх ном орчин үеийн хэлбэрт оруулан А5 форматаар, 369 хуудас, бүхий ном болгосон Сира дацан, 2008 он Энэтхэг улс.
66. Чоймаа. Ш, "Оюун түлхүүр нэрт шастирын крилл үсэгт хөрвүүлж тайлбар хийсэн ном, 61 хуудас, Улаанбаатар 2006 он.
67. Чоймаа.Ш, Янжинсүрэн. С, "Сэтгэлийг ариусгахуй" 92 нүүр бүхий хэвлэл, БСШУЯ, Лондон дахь Төвдийн сангийн хамтарсан төслийн хүрээнд гүйцэтгэв. Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сурагчдад зориулсан гарын авлага Улаанбаатар 2007 он.
68. Янжингаавийлодой "Суурийн гурван лагшин буюу төрөх, үхэх, зуурд гурвын тийн агуулга машид тодруулагч зул хэмээгч оршвой, Дашчоймбол дацангийн шунлайв С.Гантөмөрийн орчуулснаар 72 нүүр бүхий товхимол, Дашчоймбол дацангаас эрхлэн гаргасан, Улаанбаатар 2006 он.

АНГЛИ ХЭЛ ДЭЭР

1. **Taking the Kalachakra Initiation** Цагийн хүрдний номлолын гарал үүслийн тухай өгүүлэх нь. Зохиогч Александр Берзин "Швейцарийн цагаан арслан" хэмээх бүлгэмээс 1997 онд хэвлэн гаргасан. (The origin of the Kalachakra doctrine. Author: Alexander Berzin, from the chapter of "Switzerland's White Lion", published in 1997.)
2. **The Mandala, Sacred Circle in Tibetan Buddhism** Түвдийн Буддын шашин дах "Хот Мандалын ариун дагшин оршихуй" Зохиогч Мартин Браун. 1992 онд Димонт герман хэл дээр гаргасан. Дараа нь хэд хэдэн хэл дээр орчуулагдаж гаргасан. (From Tibetan Buddhist religion "Situating Hot Mandala's Holy Place", author: Martin Brown, published in German in Dumont in 1992. Later was translated into several other languages.)
3. **The Way to Shambala** Шамбалд хүрэх зам. Зохиогч Рерих. ОХУ. Эрик Верман Англи хэл дээр хэвлэсэн. (The Way to Shambala, author: Rerikh, Russia. Published in English by Eric Berman.)
4. **Kalachakra** Цагийн хүрдний номлол Дээрхийн гэгээнтэн XIV далай лам Данзанжамцын Намжил дацангаас 1999 эрхлэн хэвлүүлсэн. (Kalachakra doctrine His Holiness the 15th Dalai Lama, Danzanjamts's Namjil temple, published in 1999)
5. **The Wheel of Time, the Kalachakra in context.** Цагийн хүрдний номлолын агууллага. Гэвш Лхүндэв сопа. (The content of Kalachakra doctrine. *Gevsh* (a lamaist clerical degree below that of "gav") Lhundev sopa.)
6. **The Wheel of Time Sand Mandala** Цагийн хүрдний номлол дах Элсэн хот мандал. Барру Браунт хэвлэсэн. (Sand Hot

Mandala within the Kalachakra doctrine. Published bV BarrV Braunt.)

7. **Kalachakra, A visual celebration of the Wheel of Time**
Цагийн хүрдний ёслолын зорилго. Зохиогч Аллон Кинг (The purpose of Kalachakra doctrine's ceremonV. Author: Allen King.)
8. **MVriad Worlds**; Хэмжээлшгүй орчлон. Зохиогч Жамгун Контрул ренбучи (InfiniTV universe. Author: Jangun Kontrul Rinpochi.)
9. **Learning from the Dalai Lama**: Далай ламын сургаал. Цагийн хүрдний нууцын тухай. 1995 он. (The saVing of the Dalai Lama. The secret of the Kalachakra, published in 1995.)

ФРАНЦ ХЭЛ ДЭЭР

1. **L'initiation de Kalachakra**, Pour la paix dans le monde, par Sa Saintetй le Dalai-Lama, traduit et prйsentй par Sofia Stril-Rever (Paris, Desclee de Brouwer, 2001) (For peace in the world bV His Holiness the Dalai Lama, translated and presented bV Sofia Stril-Rever, published in Paris in 2001. "Desclee de Brouwer")
2. **Kalachakra, Guide de l'initiation et du Guru Voga**, Enseignements de Sa Saintetй le Dalai-Lama, et de Jhado Tulku Rinpoche, prйsentation de Sofia Stril-Rever (Paris, Desclee de Brouwer, 2002) (Lessons from His Holiness the Dalai Lama, and Jhado Tulku Rinpoche, presentation of Sofia Stril-Rever. Published in Paris in 2002. "Desclee de Brouwer")
3. **KALACHAKRA, enseignements prйliminaires et initiations**, Sa Saintetй le Dalai Lama, Traduit de l'anglais par Christian Charrier. (VajraVogini France) ; (His Holiness the Dalai Lama, translated from English bV Christian Charrier. Published in VajraVogini, France.)

4. **Tibet, la Roue du Temps - pratique du mandala**, par Jean-Pierre Barou et SVlvie Crossman (Actes Sud, 2000); (BV Jean-Pierre Barou and SVlvie Crossman, in 2000.)
5. **Kalachakra: le plus haut des tantras bouddhistes**, de Le Dalai-Lama **Kalachakra: the highest Buddhist Tantras** BV the Dalai Lama

ИТАЛИ ХЭЛ ДЭЭР

1. **Kalachakra - Iniziazione Tantrica del Dalai Lama**, J.M. Riviure - Edizioni Mediterranee. (BV J.M. Riviure, Mediterranean editions.)
2. **Kalachakra Guru Voga** di S.S. il XIV Dalai Lama e Ling Rinpoche, pubblicazione del testo Sacro a cura di SDK Shri DhanVa Kataka Associazione Culturale per la Preservazione e Studio del Tantra di Kalachakra. Disponibile su CD e in edizione estesa con note esplicative rilegato come gli autentici testi sacri tibetani. per prenotazioni (**Kalachakra Guru Voga** of His Holiness the 15th Dalai Lama and Ling Rinpoche, published Sacred Text bV Shri SDK DhanV Katak Cultural Association for the Preservation and StudV of Kalachakra Tantra. Available on CD and expanded edition with explanatorV notes bound as the authentic Tibetan sacred texts-for reservations.)
3. **Commentario della Guru Voga di Kalachakra** trasmesso da Jhado Tulku, pubblicazione del testo Sacro a cura di SDK Shri DhanVa Kataka Associazione Culturale per la Preservazione e Studio del Tantra di Kalachakra. Disponibile su CD per prenotazioni e-mail: info@sdk-kalachakra.com (Testi per praticanti) ; (transmitted bV Jhado Tulku, publication of the Sacred bV Shri SDK DhanV Katak cultural Association for the Preservation and StudV of Kalachakra tantra. available on CD

for bookings. Email: info@sdk-kalachakra.com (texts for students))

ГЕРМАН ХЭЛ ДЭЭР

1. **Kalachakra**, bV Michael Henss Broschert – (Fabri-Verlag Jurgen Aschoff, published in 1998) ISBN: 3980219968, bV Amazon.de **Kalachakra**, von Michael Henss Broschert - (Fabri-Verlag Jьrgen Aschoff, 1998), ISBN: 3980219968, bei Amazon.de
2. **Kalachakra and Other Six Session Vogas** – Alexander Berzin. Published in 1998, bV *Snowlion*. 11. The Kalachakra Tantra, Rite of Initiation. Tenzin GVatso the Dalai Lama and JeffreV Hopkins (Wisdom, 1985)
3. **Kalacakra Sadhana and Social Responsibility**, David Reigle (Spirit of the Sun Publications 1996, available via the Publisher).
4. **Kalachakra tantra** - The Chapter On The Individual Together With The Vimalaprabha, Vesna A. Wallace, Robert A.F. Thurman, Thomas F. Varnall (American Institute of Buddhist Studies, published in 2004). Available from *Snowlion*.
5. **The Inner Kalachakra tantra** – A Buddhist Tantric View of the Individual, Vesna Wallace. Published bV the Oxford UniversitV Press in 2001. Available from *Snowlion*.
6. **Kalacakra: Textual and Ritual Perspectives**, a dissertation bV Jensine Andresen (1997, UMI Number: 9733170, available from UMI Dissertation Services, 300 North Zeeb Road, P.O. Box 1346, Ann Arbor, Michigan 48106-1346, USA.)
7. **Naropa, the Kalachakra Initiation**- Raniero Gnoli and Giacomello Orofino - Adelphi Edizioni, 1994. (Texts in-depth)

- (translation of the Integral Sekodesa bV Naropa, and notes from the Vimalaprabha.)
8. **Tantra of Kalachakra** - The Book of the subtle bodV with its great reviews La Lumiere Immaculee Foreword bV His Holiness the Dalai Lama, translated and introduced bV Sofia Stril-Rever (Paris, Descl e de Brouwer, 2000). (Inner Chapters of the Kalachakra Laghutantra and the Vimalaprabha, translated from Sanskrit.)
 9. **Ornament of Stainless Light** – An Exposition of the Kalachakra Tantra bV Khedrup Norsang GVatso, translation Gavin Kilti and Thubten Junpa. Published in 2004, bV Snowlion.
 10. **The Practice of Kalachakra** bV Glen H. Mullin. Published in 1991, bV *Snowlion*
 11. **Tantra of Kalachakra** - The Book of the subtle bodV with its great reviews La Lumiere Immaculee Foreword bV His Holiness the Dalai Lama, translated and introduced bV Sofia Stril-Rever (Paris, Descl e de Brouwer, 2000). (Inner Chapters of the Kalachakra Laghutantra and the Vimalaprabha, translated from Sanskrit.)
 12. **Tantric Voga**: A StudV of the Vedic Precursors, Historical Evolution, Literatures, Cultures, doctrines, and Practices of the 11th CenturV Kasmiri Saivite and Buddhist Unexcelled Tantric Vogas, bV James Francis Hartzell (Part of Chapter 5 of the Vimalaprabha)(1997, UMI Number: 9723798, HopefullV soon available from UMI Dissertation Services, 300 North Zeeb Road, P.O. Box 1346, Ann Arbor, Michigan 48106-1346, USA.)
 13. **The Inner Kalachakra tantra** – A Buddhist Tantric View of the Individual, Vesna Wallace. Published bV the Oxford UniversitV Press in 2001. Available from *Snowlion*.
 14. **The Inner Kalachakra tantra** – A Buddhist Tantric View of the Individual, Vesna Wallace 1005. Dissertation – includes

translation of second chapter of Kalachakratantra and Vimalaprabha. UMI number 9602785. Available from UMI Dissertation Services, 300 North Zeeb Road, P.O. Box 1346, Ann Arbor, Michigan 48106-1346, USA.

15. **The Kalachakra Tantra, Rite of Initiation**. Tenzin GVatso the Dalai Lama and JeffreV Hopkins (Wisdom, 1985)
16. **The NispannaVogavali bV AbhaVakaragupta**: A New Critical Edition of the Sanskrit Text (Revised Edition - Sanskrit onIV), bV Vong-HVun Lee, Baegun Press, Seoul, in 2004 SVnthesizing a liturgical heritage: AbhaVakaragupta's 'Vajravali' and the Kalacakramandala (Mahapandita AbhaVakaragupta) a dissertation bV Vong-HVun Lee (2003, UMI number AAT 3089732 available from UMI Dissertation Services, 300 North Zeeb Road, P.O. Box 1346, Ann Arbor, Michigan 48106-1346, USA.)
17. **The Outer Wheel of Time: VajraVana Buddhist cosmologV in the Kalacakra tantra**, a dissertation bV John Ronald Newman (1987, dissertation. UMI number 8723348. Available from UMI Dissertation Services, 300 North Zeeb Road, P.O. Box 1346, Ann Arbor, Michigan 48106-1346, USA.)
The Practice of Kalachakra bV Glen H. Mullin. Published in 1991, bV *Snowlion* **Kalachakra: Textual and Ritual Perspectives**, a dissertation bV Jensine Andresen (1997, UMI Number: 9733170, available from UMI Dissertation Services, 300 North Zeeb Road, P.O. Box 1346, Ann Arbor, Michigan 48106-1346, USA.)
18. **The SadangaVoga bV Anupamaraksita** Translated and annotated bV Francesco Sferra, Rome, Istituto Italiano Per l'Africa E L'Oriente, 2000 **Kalachakra Tantra** bV Geshe Ngawang DhargVeV (Motilal) - Restricted to Initiates. Available from Snowlion
19. **Transcending Time, an Explanation of the Kalachakra Six-Session Guru Voga**, Gen Lamrimpa and B. Allan Wallace (Wisdom 1999)

The transformational power of the Kalachakra tantra bases, principles and issues, bV Jurgen Manschardt, “Dharmata Verlag”. Published in Berlin, 27 pages, paperback

БУСАД ОРОНД ХЭВЛЭГДСЭН НОМ

1. bV-DR.R.R.Ambedkar "The buddha and his dhamma"
"Бурхан багш ба түүний сургааль"(хуудас 599) 1997,
Тайван, buddha bhoomi publication NAGPUR
2. bV-ven. PiVadassi thera "Buddhist Meditation" "Буддын
бясалгал" Delivered at the UniversitV of Colombo, sri Lanka
(CeVlon) 1987он, 1979он (100 хуудас)
3. Dr.Frank G.French Vice President "the sutra of bodhisattva
ksitigarbha's fundamental vows" "Бодьсадваа
Кишгаварагийн судар түүний анхан шатны сахил. Young
Men's Buddhist Association of America, New York CitV
1985он.
4. Kinh Duae Su "Medicine Buddha Sutra" "Эмч бурхны судар"
International Buddhist monastic institute 2001 North hills CA
91343 USA (109 хуудас.)
5. lama Veshe Wisdom Archive. Boston "Make Your mind an
Ocean" Lama Thubten Zopa Rinpoche USA. "Таны
сэтгэлийн далай" 1998 он, 1999 он, 2003 он, (101 хуудас)
6. Lama Zopa Rinpoche "Making life Meaningful" "Бүх санаагаа
амьдралруугаа оруулах" 2001он, Weston MA 02493 USA
(133 хуудас.)
7. living Dharma "Амьд Сургааль" Venerable Ajahn Chah,
Тайван 2008.12 сар
8. Mahasi saVadaw "fundamentals of vipassana meditation"
"Анхан шатны бапапасана бясалгал" Rangoon, 1981, 1987,
1991 Translated bV u Maung tha Noe (96 хуудас.)
9. Miss P.C.lee of China "The Four Buddhist books in
MahaVana" " Их хөлгөний буддизмын 4 ном" 2008 он, 12
сар (хуудас 118.)
10. NHAT HANH "a Guide to Walking Meditation", "Бясалгалруу
алхах хөтөч" 1996 он. (35 хуудас.)

11. P.Lakshmi Narasu "The essence of Buddhism "Буддизмын мөн чанар" Энэтхэгийн шинэ Дели хот 1993 он.
12. Tan Teir Beng "Gems of Buddhist wisdom "Буддын сургаалын чимэг "Kuala lumpur MalaVsia 1995 он (519 хуудас.)
13. Ven.Dr.K SRI Dhammananda "Vou and Vour problems" "Та таны асуудал" мэт 2004 он, Kuala Lumpur MalaVsia (232 хуудас.)
14. Ven.k.Sri "Dhammananda "what Buddhists believe" "Буддизмын мөн чанар" 1993 он, Тайван (332 хуудас)

ЦАГИЙН ХҮРДНИЙ НОМЛОЛЫН ТОВЧ УТГА БОЛОХ ЕРӨӨЛИЙН ОРЧУУЛГА

Энэ адил хураасан буяны уулнаас
Өргөл бясалгалын хиргүй рашаан мэт
Өөрийн сүсгээр тогтоох булагийг.
Өчүүхэнд барилгүй далайд цутгаад.

Ямагт бусадтай учирах буян.
Ялангуяа оюуныг удирдах хүчээр.
Янагш чинагш төрөл бүхэндээ.
Яруухан итгэлт багштай золготугай.

Увидасын дээдийг хайрлах багшийн
Урьд номлосон авшигийн хураангуйг.
Уйсалгүй хүртэх тэсвэр боловсорч.
Ухаан минь тэлж зам нь тодортугай.

Асар ариун 7 авшигийг хүртэж.
Авирахуй бэрх 7 газарт хүрсний.
Агуу хүчээр алмид түүтгэр арилж.
Авьяас илтээр бүтэх болтугай.

Оршихуй гэтлэхүй орчлонгийн.
Охь болох авшиг хүртээд.
Очирт 4 лагшингийн хөрөнгө бүрэлдэж.
Онож сонсож бясалгахын ой ухаан тэлэг,

Очирт их хөлгөөр орны дээдийг зүглэж.
Онцгой сахил ариун бээр унаа юугаан тохируулж.
Огоот ариун 4 авшигийг эрхшээж.
Очирт суудалд залрах болтугай.

Бие хэл сэтгэл юугаа билэг билгээр ариулаж.
Зургаан язгуурын амьтан хүмүүнийг.
Бясалгал ёгүзарын биед хувилгаад.
Зэвэн үзүүрт очирийн гэрлээр зэвхий шулмыг шатаатугай.

Хязгааргүй огторгуй 4 мах бодийн
Хотол мандалыг очироор хүрээлж давхралсны төвд.
Хүчит Доржшуг бурхан хүрээлэх 60 тэнгэрийн хамт заларч.
Хаалга бүгдийг сахиж хавьтах адыг хөөсүгэй.

Адыг хөөсөн ариун огторгуйд.
Ачит буяныг номчлон хурааж.
Агуу чуулган илт төгсөж.
Агаарт замхарав хотол мандал.

Алгуур мандах алтан нар шиг.
Аржал бясалгаач номын лагшин.
Агшин төдий бодийг олж.
Ариун нирвааны 4 ёогзорыг.

Алдаал үгүй эцэст хүргэж.
Ашид амгаланг эдлэх болтугай.
Огторгуй салхи, газар ус, шороо.
Орчлонгийн сав шим уул ургамал.

Оноож бие дээр зүйрлэж үзвээс.
Орой дух, хоолой зүрх хүйс нууцын орон.
Очирын лагшин ахуйн ёсоор.
Онцгой бадам цэцэг наран саран дэвсгэр дээр.

Очирын хүрээ орон бясалгаснаар.
Оргих ромоо жама судсаар дамжиж.

Очирт Ёгузорын дээдийг олох болтугай.
Хир үгүй эрдэнийн гэрэлт орд харшид орж.

Хүрээт очир бясалгасны хүч.
Хаана ч бурхан болсон газар нь ариусхад.
Харин нь өөрийн бие минь түүтгараас хагцаг.
Арга билгийн тэмдэг агаар сэтгэлийн 2 үгсийг.

Агшаан нийлүүлж хум үсгийг бясалгаад.
Улаан эхийн цагаан эцгийн дусалыг.
Уураглан нийлүүлснээр төв амгалан төрөг.
Байдал бүгдийн дээд төгөлдөр.

Бат амгалан галазагдын лагшин.
Бүх талаас өөрийн язгуур сэлт.
Бат амгалан тэнгэр бясалгахын хүч.
Бадгар үйл байдал сэлт дараалан.

Бас илт барихийн хоосон дүрс үйл.
Хувирахгүй хамт төрөхийн амгаланг эдэлж.
Ханьцашгүй төгсөхийн зэрэгт хүрэх болтугай.
Эр,Эм тэгш оршихын хөрөнгөөс.

Эхийн умайд тэнгэр оршоод.
Өөр өөрийн оронд үүсгэхийн зэрэг бээр.
Өмнийн аглагт хот мандалыг байгуулж.
Таван байдлаар бодийг олж бясалгаад.

Таван цогцсоор нэгжээд эрхтэнг оноож.
Таван эрхтэнээр таарах ажилыг эрхэлж.
Тавтай замыг мэдэж төрөх болтугай.
Их амгалангийн хот мандалын цэцэрлэгт.

Эрхэм язгуурын Галазагда бурхан.
Эргэлдэн ноцох их галын төвд оршин хүчээр.
Их амгалангийн дусал дүрс дор оршоод замхархад.
Охин тэнгэр нугууд яруу дууны эгшгээр.

Одоо босож амьтны тус хийхийг айлтгахад.
Очирт 5 бурхад босож дуудах залах хүлэх баясах амтлахаар,
Омогт тавын тангараг лугаа онцгой таван үйлд шамдав.
Тэр мэт хорин байдлын бодийг бясалгаж.

Тэрчлэн авшиг айлдсан санамсарал ариунаар.
Төдөлгүй бүтээх гишүүн үйлийг.
Төвдөлгүй бясалгаж тус нь илт бүтэг.
Арга билгийн огторгуйд адис тэдээр тэгш оршоож.

Агаарын салхиар дүмүүн гал бадарч,
Аяндаа дээшилж дүдиен замаар.
Алхамаар ахиж баруун зүүн судасны замаа хорьж.
Ахин түрж магнайд бодь сэтгэлийг үүсгээд.

Аажмаар доошилж 4 баясал төрүүлэн.
Аг тарнийн төгсхийн зэрэг 4 дуслын Ёгузор бүтнэ.
Ахиж энэ мэт дээшлэн заларах нь.
Ачит эхийн бат баясал 4.

Аминчлан бүтээх нарийн Ёгузорыг.
Хувилгаан адил үзүүлэх шид бээр.
Хувьтай хүмүүн бодийг олтугай.
Товчилбоос энгийн нүдээр харах ус нь

Төгсөхийн зэрэг төрөн боловсрох зам.
Гадан дотно ариусах суурь үйлдэх зэрэг.
Гагцхүү зохилдох 4- ийг дадуулахыг хичээ.

Басхүү тарни тоолох гал мандал тахил өргөх дор.

Баттай хичээллийн орныг эзэлж.
Баараагүй үйлдэх шидэс бүтээл бээр.
Барагдашгүй амьтныг боловсруултугай.
Эхний буяны Ёгузор анхан Санаа Самаади хоёр.

Дундах буян амин самбаа барих хоёр.
Эцсийн буян дурьдах бясалгах зам.
Эдгээр бэлтгэл зургаан гишүүнийг эгнэгт дадуултугай.
Хорин мянга зургаан зуугаар тоолох мах бодь.

Хос улаан цагаан туслаар дээш доош гүйх зам.
Уртасган давхарлахын хүчээр.
Унаган биений муу цогцос.
Уустугай мөнгөн усаар идэгдэх төмөрчилөн.

Хоосон чанарыг оносон хувиршгүй их амгалан.
Хорин мянга зургаан зуу үйлийн салхиар.
Хорих түүтгэрийн багчиг ямагт.
Хоромхон судалж бурхны лагшинг олтугай.

Энэ адил ерөөлийн орон саадгүй.
Их амгаланг олох замын дээдийг.
Эгэл хүмүүсийн эрдэнийн тивд хөтлөх.
Эхний хөтөч нь би байх болтугай.

Асар цагаан буяны чугуулганыг.
Авч хураасан атаг энэ ямагтыг би бээр.
Алт эрдэнийн сан Шамбалд төрж.
Ахин доошлохгүй бурхны хутгыг олтугай.

**IV Богд Живзундамба Хутагт Лувсантүвдэнванчигийн
“Дүйнхор Дацангийн жаяг”
бүтээлийн шинжилгээ**

Жаяг бичгийн эхэнд: *“Аврал итгэлт Живзундамба IV Богд гэгээнтэн³ бээр шашин амьтаны тусын тулд баруун зүг Түвдийн газар⁴ залрахдаа олон түмэн лангийн хэрэгсэлийг, Далай лам⁵, Банчин эрдэнэ⁶ тэргүүтэн ихэс лам нартай уулзаж, Бурхан, ном ба хурал шашныг Халхын газар ихэд тогтоож, ордны цагаан хүрээний дотор⁷”*

Тайлбар: Уг хэсэгт гарч буй утга нь: Багшийг аврал итгэлт гэж үздэг нь багш орчлонгоос гэтэлгэж өгөх ач тустайд байгаа юм. Бурханы шашинд орохын үүд нь аврал одуулахуй, Их хөлгөнд орохын үүд нь сэтгэл үүсгэхүй, Очир хөлгөн буюу нууц тарнийн шашинд орохын үүд нь ван хүртэх юм. Тиймээс Цагийн хүрдний номлолд орохын үүд нь Цогт цагийн хүрдний ван авшиг хүртэхүй болой. Авшиг гэдэг *íü* үрх өгөх гэсэн утга бүхий санскрит үг бөгөөд төвдөөр: ван гүр, монголоор: “эрх авшиг” буюу “ван авшиг” хэмээнэ.

Тиймээс IV богд Жавзундамба хутагт бээр, бусадтай адилгүй, хоёр үгүй, ханьцашгүй дандар, тодорхой үндэс болох Цогт цагийн хүрдэний шашны дэлгэрүүлэхийн тухайд Түвдийн өмнөд

³Богд гэгээнтэн гэдгийн богд гэдэг үгийг монголчууд эртнээс нааш ихэс дээдэсдээ зориулж цоллож байжээ. Гэгээнтэн гэдэг нь гэгээрсэн хүн гэсэн утгатай үг юм. Жавзундамба хутагтын үе үеийн дүрийг ийнхүү нэрлэж ирсэн уламжлалтай.

⁴Баруун зүг Түвдийн газар гэдэг нь Түвд орныг хэлж байна. Хятадын нутгаас баруун зүг байх тул баруун зүг гэж нэрлэж байсныг монголчууд шууд авсан бололтой.

⁵VIII Далай лам Галсанжамц (1708-1757 он)

⁶III Банчэн эрдэнэ Балдан-Иш (1738-1780 он)

⁷Ордны цагаан хүрээ гэдэг нь Богдын харъяаны хүрээг хэлж байгаа ба энд гарч буйгаар цагаан хүрээгээр тусгаарлаж байсан бололтой.

нутаг болох Лхоха хэмээх газарт Жалсрай гэгээн Галсантүвданжигмэддамбижалцан ламын аман гэгээнээс Цагийн хүрдний лагшин зарлиг таалал огоот төгссөний өнгө будгийн хот мандалд түшиглэн ван, хөтөлбөр, увидасыг бүрэн гүйцэд хүртэн залж, нямба бүтээлийг төгсгөн үйлдсэн болой.

Монголд Бурханы шашин гурав дахь удаагаа дэлгэрэхдээ Түвдээс дэлгэрсэн тул, дамжлага, сүм хийдийн дэг ёс тэргүүтнээ ч тэндээс залж байсан байна. Энэ утгаар ном залахдаа багш нартаа өөрийн ба өглөгийн эзэдийн бэлэг сэлтийг хүргэж байжээ. Төвд багш нар өөрсдийн үндэсний дамжлагын номлолыг Халх нутагт үүсгэн бий болоход нь тусалж байжээ.

Жаяг бичигт: “Дэчингалвын дуганыг гурван давхар⁸ байгуулж, мөн өөрөө эхлэн санваар төгөлдөр хутагт ухааныг баригч гэлэн⁹, гэцэл¹⁰ тавин хувраг бээр Дүйнхор¹¹, Дэмчэг¹², Сандуй¹³, Жигжид¹⁴-ийн үндэсний аймаг¹⁵ олны дүлцэн¹⁶ хийх тэргүүнтэний журмыг тогтоож,”

⁸Дүйнхэр бурханы лагшин, зарлиг, таалал буюу бие, хэл, сэтгэл гурвыг төлөөлж гурван давхар байгуулжээ.

⁹Гэлэн: Винайн ёсны 253 санваарыг сахихаар ам авч, тэрхүү санваарыг ёсчлон дагагч тойн бөгөөд буяныг сахигч хэмээсэн утгатай үг юм.

¹⁰Гэцэл. Винайн ёсны 16 санваарыг сахихаар ам авч, тэрхүү санваарыг ёсчлон дагагч тойн бөгөөд хэмээсэн утгатай үг юм.

¹¹Дүйнхэр (санскр: Калачакра, монголоор: Цагийн хүрдэн) нь Их хөлгөний ёсны Ханьцашгүй дээд егүзэрийн үндэсний, ядам бурхан юм.

¹²Дэмчэг (санскр:монголоор:) нь Их хөлгөний ёсны Ханьцашгүй дээд егүзэрийн үндэсний, ядам бурхан юм.

¹³Сандуй (санскр:монголоор: Нууцын хураангуй) нь Их хөлгөний ёсны Ханьцашгүй дээд егүзэрийн үндэсний, ядам бурхан юм.

¹⁴Жигжид (санскр:Ямандака, монголоор: Аюулган үйлдэгч) нь Их хөлгөний ёсны Ханьцашгүй дээд егүзэрийн үндэсний, ядам бурхан юм.

¹⁵Үндэсний аймаг гэдэг нь Дандарын дөрвөн аймгийн Ханьцашгүй дээд егүзэрийн үндэст багтахыг хэлж байна.

¹⁶ Дүлцэн нь Дүйнхэрийн ёсны гол хурлын нэр юм. Дүлцэн жинхор гэдэг нь: өнгө өнгийн чулууны элсээр үрж бүтээсэн хот мандалыг хэлнэ.Тус хурлийн үйл ажиллагааны дараа мандал хийсэн элсийг (шороо) нь авч, Туул гол руу хийх ёс эртнээс бий болсон байна.

Тайлбар: Тийнхүү Монголын оронд Дүйнхорын ёсны эхийг тавин 1806 онд Их амгалант галава хотол буяны ордон буюу Дэчэнгалавгүндүгэвийнповрон хэмээх Цогт цагийн хүрдэн бурханы дацанг байгуулж, тус Дүйнхэр бурханы лагшин зарлиг, таалалын хот мандалыг билгэдсэн гурван давхар дугантайгаар байгуулж тус дацангийн жаяг бичгийг өөрөө зохиосон байна.

IV богд Жавзүндамба хутагт бээр өөрөө болон шилдэг сайн санваар сахигч гэлэн, гэцэл 49 лам, өөртэйгээ нийт тавин ламаар хурал номоо хурахаар тогтоосон байна. Тэрхүү хурал нь Нууц тарнийн ёсны Дүйнхор, Дэмчэг, Сандуй Жигжидийн хурал байжээ. Хэдийгээр тус хийдийн гол сахиус нь Дүйнхэр боловч Сандэжигсүм хэмээх гурвал бурхадын тахилгыг хамтад нь хийж ирсэн байна. Эдгээр 4 бурхад нь Дандарын буюу Нууц тарнийн дөрвөн аймгийн нэг нь болох Ханьцашгүй дээд егүзэрийн үндэсний бурхад болох юм.

Жаяг бичигт: *“мөн тэрхүү хуврагийн дотроос таван хуврагийг гаргаж сангийн бүрээний үед өдөр бүхий (á¿ð) Очирдар¹⁷-ын өмнө Банчин ринбүүчийн шавданд¹⁸ мандал¹⁹ дэлгэр өргөх ба туван шалжи, цэсүм тэргүүтнийг уншихийг тогтвой.*

Тайлбар: Дээрх нь Багшийг тахих ёсны зан үйл юм. Нууц тарнийн ёсонд багшийг тахихдаа Очирдара бурханы өмнө тус бурхантай Банчин эрдэнэ багш ялгалгүй нэгэн мөн чанартай хэмээн санаж тахилга хийдэг. IV богд Жавзүндамба хутагт сангийн бүрээний үед өдөр бүр таван хуврагар хийлгүүлэх жаяг тогтоожээ. Энэхүү тахилга хийх үед унших номыг нь мөн

¹⁷ Очирдара (санскр: Вадрадхара, монголоор: Очир баригч) Их хөлгөний ёсны Ханьцашгүй дээд егүзэрийн үндэсний, ядам бурхан юм.

¹⁸ Өөрийн багш III Банчэн эрдэнийн өлмийд (багшийн хөлийн дор) нас буян уртасгах үүднээс багшийг тахих ёсоор мандал өргөх зан үйлийг шавь нар нь хийдэг тахилын зан үйл.

¹⁹ Мандал нь нар, сар зэрэг ертөнцийн бүхий л зүйлийг мандал хэмээх тахилын тавганд билэгдлээр байрлуулж өргөх тахилын зан үйл.

тодорхойлсон байна. Туван шалжи, цэсүм тэргүүтэн нь Багшийг тахих үед бясалган унших судрууд болой.

Жаяг бичигт: ***“Мөн бас ногоон лавран Доржповронд Дэчингалвынд хурдаг Нагву Дэмчэгийн чогийн эрхэм шүтээн ба тахил балин тэргүүтэн байдаг тул мөн дэглэж хуруулахаар тогтвой”***

Тайлбар: Дорж поврон гэдэг нь очирт ордон гэсэн үг. Энэхүү повронд Хар дэмчигийн магтаал уншиж байгаа нь уг тахилын сүмийн онцлог бурхан болох нь тодорхой байна. Дэчэнгалава дацангийн Дорж поврон тахилын сүмд Энэтхэгийн шидтэн Нагбождвагийн дамжлагаар уламжлагдан ирсэн Дэмчэг буюу Загдсамбар бурханы бүтээлийг балин тахилтай хурж байжээ. Дүвчин Нагбо жодвагийн эхний үг нь Хар гэж байгаа тул түүний ёсны Дэмчиг ч мөн адил Хар Дэмчиг байх ажээ.

Жаяг бичигт: ***“Мөн Дэчингалавд жил бүр хурдаг Жигжидийн дүлцонгийн хэрэгсэл²⁰ ба шүтээний эрхэм тэргүүтэнийг Ригсүмгомб²¹-ынд байдаг тул мөн дэглэж, тэр хурлыг хуруулахаар тогтсон.***

Тайлбар: Дээрхээс үзэхэд Дэчингалав дацанд жилд нэг удаа Жигжидийн дүлцонгийн хурал болж байжээ. Энэ үед Жигжид бурханы дамжлага, зан үйлийг шинээр бий болгох шаардлага гарсан байна. Иймээс тус дацан өөртөө тус бурханы тахилгын дэг ёсыг шинээр бий болгох шаардлага гарчээ. Гэвч тэрхүү зан үйлийг IV богд Жавзүндамба хутагт өөрөө дэглэн бий болгосон гэж ойлгож болох юм.

²⁰ Жигжидийн дүлцонгийн хэрэгсэл гэдэгт Жигжид бурхан тахилганд хэрэглэх хэрэгсэлийг хэлж байна. Аливаа хурал өөр өөрийн ёсны хэрэглэлтэй байдаг. Энд мөн шороогоор Жигжидийн мандал бүтээх шаардлага гардаг

²¹ Гомбо нөхөр гурав гэсэн үг

Жаяг бичигт: “Мөн бас сар бүрийн шинийн найманд Дэчингалавд тэгчин сожин²²-той барилдуулсан Их манлын чого²³ хурахийн эрхэм шүтээн тахил балин тэргүүтэн Дара эхийн сүмд байдаг тул мөн дэглэж хуруулахаар тогтвой. Мөн бас 4 дүгээр Богд гэгээнтэн бээр энэ зүгийн лам хувилгаан сүжигтэн тэргүүтэн олонд Дүйнхорын их ванг гурван удаа хайрлавай”.

Тайлбар: Аливаа хийдэд жил бүрийн хурлаас гадна сар бүрийн хурал гэж байдаг. Сар бүрийн шинийн найманд Их манла бурханы тахилганы хуралтай байжээ. “Их Манла бурханы магтаал” хурахдаа Тэгчин сожинтой холбон явуулж байжээ. Ийнхүү тус тахилга хийж буй лам нар тэр өдөртөө нэг өдрийн Тэгчин сожон авдаг байжээ. Уг дацангийн ажиллагаа анх эхлэх үед Их Манлын тахилганы шүтээн, тахил, балин тэргүүтэн нь Их хүрээний Дарь эхийн хийдэд байсан байна. Өөрөөр хэлбэл, шүтээн гэдэг нь Манла бурхан, тахил нь бусад хэрэглэл, зан үйл тэргүүтэн, балин нь тахилд зориулсан гурилаар хийсэн бурханы идээ ба үүнийг хийх тусгай ёс горимтой байдаг. Иймээс тахилч, балинч нараа Дарь эхийн хийдийн лам нарын тусламжтайгаар шинээр бий болгожээ.

Бурхадын ван өгөх үйл ажиллагааг багш лам нь дэлгэрэнгүй, дунд, хураангуй гурван янзаар өгдөг гэж үздэг. Хураангуй нь богино хугацаанд явагдаж өнгөрөх ба ийм тохиолдлыг бэлтгэлтэй шавь нарт өгч байжээ. Дунд нь хоёр хоног хиртэй үргэлжилнэ. Харин дэлгэрэнгүйг 7 хоногоор ч өгч болох юм. Дэлгэрэнгүй өгөхийн давуу нь тэр хирээр шавь нарт адистэд оршино. IV богд Жавзүндамба хутагт Дүйнхэрийн их ванг гурван

²²Тэгчин сожин нь нэг өдрийн бацаг санваарын нэр юм.

²³Их Манлын чого нь Манла бурханы дэлгэрэнгүй магтаал судрыг хэлж байна. Тус судар нь бага Манлаасаа том хэмжээтэй учир бэлтгэл ажил их шаардагдана. Манла бурхан нь Их хөлгөний ёсны Ханьцашгүй дээд егүзэрийн үндэсний, ядам бурхан юм. Итгэн даатгаж хуралд айлтуулбал аливаа хүний эрүүл мэндийг сайжруулж, өвчин эмгэг илааршуулна.

удаа нийт лам хувраг шавь нарт хайрласан тухай энд гарч байна. Тэрээр мөн дүвчэн Нагву жодвын ёсны Дэмчэг, Сандуй, Жигжид тэргүүтэний ванг олонтоо хайрласан тухай намтарт нь гардаг.

Жаяг бичигт: **“Мөн Богд гэгээнтэн бээр Дэчингалвын Жалсрай гэгээн²⁴-д зоог тахил тэргүүтэнийг өөрийн хэрэглэдэгээс үлэмж илүү бэлддэгийн учир цогчид, чогор тэргүүтэний дээжийг мөн өөрийн зоогийн бэлддэг газар бэлдэж нягтлан болгоож соёогба бээр авчирч өргөөд мөн буулгаж өөрөөс эхлэн хүртэхийн журмыг тогтоосон”.**

Тайлбар: IV богд Жавзундамба хутагт Дэчэнгалба дацанд морилон ирж хурах үедээ Лхоха Жалсрай гэгээнд зориулан зоог тахилыг тэргүүтэнийг бэлтгэхдээ үлэмж их анхаарч байжээ. Тэрээр бурханд тахилга өргөж байгаагаа өөрт өргөж байгаа манз, цавнаас илүү байх ёстой гэж үзэж байжээ. Иймээс өөрийнхөө хэргэлдэгээс үлэмж илүү бэлтгэж, цогчэд цонхорын дээжийг зөвхөн өөрийн зоог идээг бэлддэг газар буюу гал зуухандаа тусгайлан бэлдэж нягтлан болгоож, өөрийнхөө соёгоор авчируулж өргөдөг ёстой байжээ. Энэ ёс заншилд онцгойлон анхаарч тахилга дуусаад тэрхүү тахилын идээ тэргүүтнээс өөрөөсөө эхлэн хүртэх журам тогтоосон байна.

Жаяг бичигт: **“Мөн Богд гэгээнтэн бээр Дүйнхорын хурлыг тогтоосноос хойш есөн жилийн эцэс²⁵ өөрөө лам дорж ловон²⁶-гийн үйлдвэрийг зохиосон. Дараагаар Жидорын**

²⁴ Жалсрай гэгээн

²⁵ Дэчингалав дацан 1806 онд байгуулагдсан гэдгээр 1815 он хүртэл IV богд Жавзундамба хутагт доржловонгийн алба гүйцэтгэжээ.

²⁶ Дорж ловон гэдэг нь Дандарын ёсны дацангийн тэргүүн лам буюу очирт багш гэсэн үг юм. Очирт багш нь тус дацангийн хурал номын үйл ажиллагааг удирдаж явуулна. Бусад дацанд жишээ авбал, Бадма ёога дацангийн тэргүүн ламыг мөн тийнхүү нэрлэнэ гэх мэт.

хамба²⁷ тэргүүлэн хамба, цорж бээр дорж ловонгийн албыг²⁸ хийсэн”.

Тайлбар: IV богд Жавзундамба хутагт бээр Дэчэнгалбын хурал номыг тогтоон байгуулсанаас хойш өөрөө дорж ловонгийн албыг есөн жил хашаад түүний дараагаар нь Жидорын хамба лам Агваанхайдав, хүрээ хамба лам, цорж лам зэрэг хүмүүс дорж ловонгийн албыг хийж байжээ.

Түүнээс хойш Дэчэнгалбын хурлын дорж ловонг олон лам нар залгамжлан хийж байсан юм.

Жаяг бичигт: **“Мөн бас Богд гэгээнтнээс: Би бээр бурхан олны нинбыг бясалгаагүй гагцхүү ламын нинбыг нэг сайныг үйлдсэний ёс нь эдүгээ унтах, хэвтэж нойрсох тэргүүтэнд үйлдвэр алин нэгийг яаравч миний өөрийн ачит лам нугууд ба ялгавартай Жалсрай Дорж чангийн үзэл луга хагацах, үл амсах мартахийг үл санах Жалсрай ринбүүчийн гэгээнийг бусад та нугуудын үзэлд жанч арилжсан мэт боловч чухамхүү миний өөрийн үзэлд таалал төгссөнгүй хэвээр байх тул мишээнгүйн дүрээр зарлиг буулгасан”.**

Тайлбар: IV богд Жавзундамба хутагт бээр энэхүү жаягийг бүтээсэн болох нь энэ хэсгээс харагдаж байна. Энэхүү, жаяганд өөрийнхөө очирт багшийг хэрхэн шүтэж буйг нь хэлсэн байна. Бурханы шашны зарим лам нар олон бурхан бясалгах нь бий. IV богдын хувьд олон бурхадыг бясалгаагүй, харин өөрийн багш

²⁷ Жидорын хамба гэж Их хүрээний хамба Агваанхайдав (1779-1838 он) ламыг хэлж байна. Тэрээр шашны равжамба цолтой, эрдэмтэн байлаа. Их хүрээний цорж, дад хамба, их хамба, Манжийн Төр гэрэлт хаанаас Хамба номун хан цол авч байв. Түүний сүмбум нь 200 гаруй бүтээлээс бүрдсэн 5 боть ном төвдөөр бичжээ.

²⁸ Жалсрай гэгээн (1743-18) нь IV богд Жавзундамба хутагтын Дүйнхэрийн дамжлагын багш юм. Тэрээр өмнөд Энэтхэгийн Лхоха гэдэг газарт мэндэлсэн бөгөөд

нар тэдгээрийн дотроос ялангуяа ялгавартай Жалсрай богд багшаа Доржчан бурхан адил хэмээн бясалгаж, унтах, хэвтэх, нойрсох алин бүхий цаг бүрд багшийг шүтэх бясалгалыг байнга бясалгаж байсан гэсэн байна. Өөрөөр хэлбэл, багшаасаа хэзээ ч үл хагацан, үл мартаж эдүгээ хүрч ирснээ энэ хэсэгт хүлээн зөвшөөрчээ. Тэрээр шавь нартаа хандаж: “Та нарын үзэлд жанч халсан мэт харин миний өөрийн үзэлд таалал төгссөнгүй хэвээр байх тул надад мишээнгүйн дүрээр зарлиг буулгасан” гэж айлджээ. “Надад мишээнгүй дүрээр зарлиг буулгасан” гэсэн нь багштайгаа нүүр тулан уулзаж түүний аман айлдварыг нь авч байсан тухайгаа дурдсан хэрэг.

Жаяг бичигт: ***Мөн бас Жалсрай гэгээний даншүгийг Дашчойнпэлд хаврын дүвчэдчимээс эхлэн намрын дунд сар хүртэл дүйсүмжалгүнийг дантай уншмой. Солдэв дүйсүмжалгүн тэргүүтэнийг хурал бүхүй²⁹ ба ялгавар (ᠶᠡᠭᠠᠭᠠᠢ ᠭᠡᠭᠡᠳᠡ ᠠᠡ) Дэчингалвын хурлын эх адаг бүхэнд уншдагийн учир орчлонг хоосрохыг хүртэл заларч байхын бэлэг болов уу хэмээн таалсан.***

Тайлбар: Дээрхээс үзэхэд Жалсрай гэгээний Даншүг буюу өлмий бататгахын соёрхолыг ганц Дэчингалбын хуралд ч биш, цаннид чойрын Дашчоймпил дацанд ч гэсэн адил хаврын дүвчэдчимээс эхлэн намрын дунд сар хүртэл дүйсүмжалгүн хурлын үед дантай уншиж байжээ. Ингэхээр хурлын ая данг нь бас тогтоож өгсөн байсан нь тодорхой. Харин Дэчингалавын сүмийн хувьд онцлог Жалсрай гэгээнтэй барилдлага ихтэй тул хурлын эх, адаг бүхэнд уншдаг байжээ.

Жаяг бичигт: ***“Мөн Дэчингалвын хурдаг Сандуй, Жигжидийн дүлцон хурахад мөн Галба, Жүд³⁰ хоёроос хуврагийг данс адил хуруулдаг. Мөн шүтээний эрхэм тахил балин***

²⁹бүрд гэсэн үг.

³⁰ Жүд (санскритаар: Тантра, Дандар, монголоор: Үндэс) нь Нууц тарнийн гүн ухааны сургалт явуулдаг дацан юм.

тэргүүтэн Жүдэд байдаг тул мөн дацангийн чомбо хуруулахаар тогтсон. Мөн Дүйнхор, Загдсамбарын дүлцон хурахад Жүдээс арван лам хурмой. Шаддүвлингийн найдан лам, унзад, тэргүүтэн ирж жүг³¹ өргүүлж хурмой. Мөн гэцэл манж³² цав³³-ыг баримой. Мөн бас Дүйнхорын дашгадан ба Аюуш³⁴-ийн даншүг тэргүүтэний цоглаамийг босгоход хоёр цанидын гэсгүй ба, аграмба гавж нар босож байхаар тогтвой”.

Тайлбар: Энэ хэсэгт Дэчингалав дацанд Сандуй, Жигжидийн дүлцон хурахад Галба, Жүд хоёр дацангаас хувраг ирүүлж хурдаг байжээ. Дээрх хоёр хийд нь Сандуй, Жигжид сахиустай байсан нь тодорхой. Судалгаанаас үзэхэд Их хүрээний Жүд буюу Жүдпунцагшаддүблин дацан нь II Богд Живзүндамба хутагтын үед буюу Манжийн Тэнгэрийг тэтгэсэн хааны 2-р онд байгуулагдсан байна. Тэрхүү Сандуй, Дэмчиг, Жигжид гурван бурхантай, эдгээр бурхадын тахилгын хурлыг хийхдээ онцгой яламжтай байсан тул Сандуй, Жигжид хурахдаа эрхэм тахил балин тэргүүтэнээ Жүдээс байх авах болж тогтоод Жүд дацангийн чомбо-ыг залж, бэлтгэл ба хуралдаа туслалцаа авдаг байжээ. Үүний зэрэгцээ Дүйнхор, Загдсамбарын (Дэмчиг) дүлцон хурахад Жүдээс арван лам авч хамт хурдаг байжээ. Энэ үед гэцэл лам хүн манж, цавыг нь барихаар хуульчилан тогтоожээ. Энд гарч буй Шадивлингийн тухай дурдахад Шадивлинд бясалгалын хийд байсныг анх дөрөвдүгээр богдын үед байгуулсан гэдэг.

³¹ Жүг нь Дүйнхорын уншалгийг бүрэн цээжлээд шүүлэг өргөхийг жүг өргөх гэдэг

³² Манз буюу манж нь цайг хэлж байна.

³³ Цав нь хоолыг хэлнэ.

³⁴ Аюуш нь (санскритаар: Амитаюш, төвдөөр: Цэнд, монголоор: Насан цаглашгүй) Их хөлгөний ёсны бурхан юм. Хүний нас буяныг уртасгаж, өлзий хутаг хураах бурхан.

Жаяг бичигт: **“Аврал итгэл Очирдара богд Живзундамба дөрөвдүгээр гэгээнтэн бээр Дүйнхорын дуганд хуваргуудад Зуугийн Далай³⁵ ламын дэргэдийн Намжал дацан³⁶-гийн дэглэм мэтээр дэглэмд айлдан соёрхсон нугууд алин хэн оюундаа агуулах буюу үсэг дор бичиж авбаас жаяг дор болно хэмээн зарлиг соёрхсон ямарчилан хойноос дагаснаас Дүйнхорын шавь нугууд бээр анхан даруй хурал хурахын уриа хэнгэрэг буюу харанга дэлдсэн даруй нэгэн зэрэг цугларч, гурав гурав мөргөөд дээрээс суудал баримой. Суудал барьж төгсөглөө Ойдовгунжүн³⁷ уншсаар хожигдолгүй ирэх хэрэгтэй. Хэрэв хожигдвоос зул өргөж, мөргөх хэрэгтэй. Бас ном хэдий хожигдвоос түүний тоолон гурав гурав мөргөх хэрэгтэй. Дүйнхор, Сандуй, Дэмчэг, Жигжид тэргүүтэн буюу хангалд дорсомгомдай өнгөрвөөс хэн ч хуралд суухгүй”.**

Тайлбар: Тус дацан байгуулагдсны дараа шавь нар нь IV богд Жавзундамба хутагтад хандаж жаяг хийж өгөхийг хүссэн байна. Энэ үед Дүйнхэрийн дацанд буй хуврагуудад хандаж: Төвдийн Далай ламын Намжил дацангийн жаягийн маягаар хийх нь чухал гэсэн зөвлөмж өгсөн тухай дээр гарч байна. Тэгээд жаягийн талаар санаа өгч бичүүлээд тэрхүү жаягийг засч боловсруулсан байж болох юм. Тэрээр урд нь Далай ламын Намжил дацангийн жаягийг үзэж судалж байсан тул түүнээс нэмж, хасаад өөрийнхөө саналыг тодорхой хэлж бичүүлсэн тул энэхүү жаягийг үүсгэсэн зохиогч хэмээн алдаршжээ. Хожим тэрхүү анхны жаяганд Далай ламын хэлсэн үгүүдийг нэмж оруулсан нь хожим уг жаяг хуулагдахдаа дахин шинэчлэгдэн боловсруулагдан хувилбараар

³⁵ Зуугийн Далай лам гэж нэрлэсний учир нь Төвдийг монголчууд алдарт шүтээн Зууг залсан баруун зүгийн мөргөл орон гэж нэрлэж байсан тул Зуугийн Далай лам гэдэг нь Төвдийн Далай лам гэсэнтэй утга нэг.

³⁶ Үе үеийн Далай лам нарын Намжил дацан нь Түвдийн нэгэн алдартай дацангуудын нэг. Энэтхэг дэхь Намжил буюу Намжара дацан нь Химачал Парадеш мужийн Дарамсала хотод байна.

³⁷ Есөн шадны мэгзэмийг хэлж байна.

бидэнд иржээ. Энд гарч байгаагаас IV богд Жавзүндамба хутагт жаяг гэж юу болох талаар хэн оюундаа агуулах буюу үсгээр бичиж буулгаваас жаяг болно гэж өөрийнхөө санааг хэлсэн байна.

Дүйнхэр дацангийн шавь нар жаягийн ёсоор хэнгэрэг буюу харанганы аль нэгийг дэлдэх даруй хуралдаа цугларах ёстой ажгуу. Ингээд хийддээ ороод гурван эрдэнэд гурав мөргөөд дээрээсээ эхэлж суудал барих ёстой. Суудал барьж төгстөл нь Ойдүвгүнжин уншиж байх ба энэхүү уншлага дуусахаас өмнө бүгд ирэх ёстой ажээ. Хэрэв хожигдох бол зул өргөж, мөргөх хэрэгтэй. Ингээд дацаны дөрвөн бурхан тэргүүтэн буюу хангалд дорсомгоддай өнгөрөх үед уг хийдийн хэн ч хуралд суух эрхгүй болдог байна. Энэ бол хурлын гол хэсэг өнгөрсөн тул шаардлагагүй болжээ гэсэн үг юм.

Жаяг бичигт: *“Энэ үед гэсгүй хүж эргүүлэн, анхны манзыг шүүл, гэсгүй галын байдалтай, умзад усны байдалтай номыг эхлээд сүүлд төгсөнө. Энэ хуралд олон хүний дотроос шилж хуруулсан тул гэсгүй олонд сургаал айлдахаас, бусдыг бэрээгээр жанчихгүй. Шинэ орох хуврагийг нагва давгийн шинийн хоёрт оруулах буюу бусад үгүй билээ. Гэсгүй бэрээ барих үес нь Их хурал буюу Майдар эргэх, сэмбэр тэргүүтэнд барина.*

Тайлбар: Дээрх хэсэгт хурлын гэсгүй унзад тэргүүтний үйл ажиллагааг тодруулж өгсөн байна. Үүнд: унзад, гэсгүй хоёрын үйл ажиллагааг тодруулан хэлжээ.

Жаягт гарч буй гэсгүйн үүрэг:

1. Хүж эргүүлж, уугиулна.
2. Хуралын анхны манзыг шүүлэх.
3. Гэсгүй бэрээ барихгүй.
4. Бэрээ барих үе нь их хурал буюу Майдар эргэх, сэмбэрэм тэргүүтэнд барина.

5. Гэсгүй олон лам нарт сургаал айлдахаас бус бэрээгээр жанчихгүй. Учир нь тус хуралд шилдэг лам нар байх юм.
6. Хийдийн дэг журмыг сахиулна.
7. Суудалд байхдаа галын байдалтай цомцойж сууна.

Жаягт гарч буй унзадын үүрэг:

Хийдийн унзад ламын үүрэг бол хурлын уншлагыг эхлүүлэх, дуусах хоёрт гол үүрэг гүйцэтгэдэг. Тус хийдийн умзад лам хурлын уншлагыг эхлүүлэхдээ усны долгио байдалтай аялгуулж эхлээд сүүлд мөн тийм байдлаар төгсгөх ёстой ажээ. Энэ нь хурлын ая дантай холбоотой зүйл юм. Хурлын ая данг дээрх мэт олон тооны уран зүйрлэлээр нэрлэсэн байдаг нь дорно дахины сэтгэлгээний нэгэн өвөрмөц онцлог гэлтэй.

Жаяг бичгийн эхэнд: ***Хурал гадаалахад цав баримагц доороос дээш базарсад уншсаар гадаална. Манж барихад өндөр дуугаар хэлцэх буюу, аягаа хэлээрээ долоох, мөр хооронд нулимах ба багана түшиж үйлдэх хийгээд залхуурах тэргүүтэн маш хориотой тул болохгүй. Бас эвшээхдээ чимээгүй амаа бөглөх хэрэгтэй. Гэлэн, гэцэл лавайн дивээр суух³⁸ мөн боловч хурлын эрхээр мөр тасалж засаж дээрд суух байна”.***

Тайлбар: Өмнөх хэсэгт хурлын үе ба манз барих үеэр болон бусад үед хийх үйлдэл бүрээ хянах болон ямар байх талаар журамлан тогтоосон байна.

Жаяг бичигт: ***“Хувраг нугууд шувууны өд мэт хөгшин, залуу зэргээр³⁹ хүндэлж үйлд. Олноор чагж хийх, наманчилах хонх дэлдэх тэргүүтэн дээр доор бүгд адил дэлдэх. Хажуугийн хувраг, хуваргийн өмнө тавьсан хонх, дамарыг газар***

³⁸Лавайн дивээр суух гэдэг нь

³⁹Шувууны өд дээрээсээ доош нарийнаас уртассан дараалалтай байдаг. Түүн шиг хөгшинөөсөө эхлээд залуу нь дараалж суухыг хэлж байна.

унагаваас хүмүүн түүнийг гурав мөргүүл ларжүдэд дүнрэв мэт наманчилах гүйцэд хэрэгтэй. Орхимжоор хурал дотор толгой бүрхэхгүй. Ер хурал буюу өөрийн тухайд гэсгүйд айлтгаад гарч яваад буцаж ирсэн нугууд гурав мөргөөд хуралдаа сууна. Хурлын хуварга хийгээд хаалгач нар гэсгүйд айлтгал айлтгаваас орхимжоор амаа таглаж айлдах хэрэгтэй. Бас чогор, цогчид, идээ ундаа тэргүүтэнд ловон тэргүүтнийг харж амсах хэрэгтэй. Бас ч цогчидын эрхэм дорж ловонд бас хуваргаас идээ ундаа хоёр хувь барих бөгөөд түгээх нь хоёуланд чагж үйлд. Хоёр гараар авах хэрэгтэй. Чогор дотор өгүүлэл хийгээд мэтгэлзэх⁴⁰, хоч сөхөх⁴¹ тэргүүтэн болохгүй. Хүртэхдээ сорох тэргүүтэн дуу гаргаж болохгүй. Идээг газар боодолгүй тавьж болохгүй бөгөөд дээгүүр алхахгүй, идээны сав хоосон тавихгүй. Лхагдор гаргалгүй гадагш гаргахгүй”.

Тайлбар: Энэ хэсэгт хонх цохих болон бусад журмыг тодорхойлсон байна. Тухайлбал, бүгдээрээ чагж хийх, наманчлах ба хонх цохих зэрэгт бүгд нэгэн зэрэг үйлдэх, Хажуудаа байгаа ламын хонх, дамарыг санамсаргүй унагаавал авч өгөхдөө гурав мөргөх ёстой ажээ. Хурлын хэрэглэлийг бурханы адистэд оршсон гэж ингэж хүндэлдэг байжээ. Хувраг нар орхимжоороо толгойгоо бүрхэх үе энгийн үед байх бол хурлын үед үүнийг хориглодог. Хурлын үед хувийн ба ажлын шаардлагаар гарч явах хэрэг гарах шаардлага гарахыг зөвшөөрдөг. Хуралд эргэж орж ирээд суудал барихдаа гурав мөргөөд хуралдаа хурах ёстой. Хурлын хувраг хийгээд хаалгач нарын хувьд гэсгүйд айлтгал айлтгах үед орхимжоороо амаа таглаж айлтгадаг нь гэсгүйг ариун санваартан гэж хүндэлсэн хэрэг юм.

⁴⁰Маргахыг хэлж байна.

⁴¹Хочоор дуудахыг цээрлэсэн байна.

Жаяг бичигт: *“Яарч яавах хэрэг боловоос ламд айлтгаад гадагш гарч явах дотор орох бүгдэд мөргөж үйлдэх хэрэгтэй. “Архинд мадан, маханд бал” хэмээмэй. Бас хуралд шинэ орох нугуудын хурлын уншлагыг лам багшаар уншуулж үйлдээд, хуваргуудад манж өргүүлж оруулмой. Шинэ орсныг цагийн хуралд олны дотор жүг өргүүлж гүйцэтгэхгүй, голын суудалд суулгаж болохгүй. Мөн шинэ нугуудыг мигзэм хийгээд Жигжид тэргүүнтний нинба үйлдүүлэх хэрэгтэй”.*

Тайлбар: Энд хурлаас гарах үедээ мөргөл үйлдэх тухай журамлажээ. Энд гарахдаа лам айлтгаад гэсэн нь гэсгүйг хэлж байна гэж үзэж байна. Ингээд гарах ба хуралдаа эргэж орохдоо бүгдэд мөргөх ёстой ажээ. Энэ бол онцгой шаардлагаар гарсан тул энэ бүхнийг та бүхэн болгоон хайрлана уу гэж өршөөл эрсэн утгатай гэж ойлгож болно. Шинээр хуралд орох явдал нь Дүйнхэр дацаны хувьд томоохон нэр хүндийн хэрэг байх нь тодорхой. Энэ дацанд шинэ хүн орохдоо урьд өмнө нь хуралд хурж байсан шигшмэл лам нарыг авдаг байсан тул хийдийн багшаар уншлага уншуулж шалгалт авах нь анхан шатны шаардлага болох нь тодорхой. Ингээд шалгалт өгч тэнцсэн лам хуралд суухын өмнө хийдийн нэг өдрийн манз, цавыг дааж, хуврагуудад өргөл өргөх шаардлагатай байжээ. Шинэ орсон хуврагыг олны дотор жүг өргүүлж гүйцэтгэхгүй, хэдийгээр тэрхүү лам нэр хүндтэй нэгэн байсан ч голын хүндэт суулгаж дээдэлж болохгүй ёстой. Учир нь Дүйнхэр дацангийн лам нар Дүйнхэрийн тахилгын хувьд өндөр мэргэжилтэн нар байсан тул шинэ ламын нэр хүндээс илүү эрдэм энэ дацангийн лам нарт байх ёстой юм. Дүйнхэр дацан нь Шарын шашны хийд учир юуны өмнө Богд Зонховын мигзэмийн нимбанд суулгах шаардлагатай байжээ. Нөгөө талаар Нууц тарнийн ёсны дацан учир Жигжид тэргүүтэн бурханы нимбанд суусан байх нь анхан шатны шаардлага байсан байна. Энэ нь энэ дацанд орсон лам нар өмнө нь хангалттай боловсрол эзэмшсэн байх ёстойтой уялдаж холбогдож байна.

Жаяг бичигт: *“Миндагтай хүн орвоос дагжид уншуулж жүг өргөхгүй. Шаддүвлүнгийн найдан лам⁴² жүдийн дорж ловонгоос бусад гадна хүмүүнд олбог хэрэглүүлэхгүй. Дамбрам⁴³, даш⁴⁴ уншихын үесд овоодой⁴⁵ өмсөж цацаж үйлд. Эс өмсөөс арвай цацаж бүү үйлд. Хурал тарахад дүйсүмчилгүн хийгээд мигзэмийн үесд мөрний адгаас түгээж мөн адгаас босоод ойдовгүнжүн уншиж хурал гадаалж үйлдэх хэрэгтэй. Нэгэн зүйл магтаал унших дор анхны шүлэг төгсөтлөө наманчилгаа, хангал хурахад унзад гүйцэтгэж эс чадваас шавь нэг бээр уншиж гүйцэтгэнэ. Хурал олон давхарлах тус ян⁴⁶ хураамжилан татна”.*

Тайлбар: Өмнө нь шашны цол мяндагтай хүн хуралд орвол хэрхэн үйлдэх шаардлагыг дээр өгүүлсэн байна. Өмнө Шаддүвлин хийдээс лам ирж хурдаг байсан гэсэн бол энд тэр хийдийн найдан лам ба дорж ловон хоёрт л олбог хэрэглүүлж байсан тухай өгүүлсэн байна. Тус хийдийн дорж ловон нь IV богд Жавзүндамба хутагтын хэмжээнд ганцхан Шадүвлин хийдээс ирж хурдаг найдан ламыг ингэж хүндэлж байгаагийн учир нь нэг бол Шаддүвлин хийдийн үйл бүтээлийг ихэд үнэлсэнийх, нөгөө талаар тэрхүү найдан лам IV богд Жавзүндамба хутагтын багш байснаас хожим ийм ёс тогтсон байх боломжтой юм.

Жаяг бичигт: *“Цанг хураахгүй суудалд, цанг хэнгэргийн доор цохихгүй. Бишгүүрийг баруун талд, ганданг зүүн талд үлээх, зэс бүрээ баруун талд, цагаан бүрээ зүүн талд*

⁴²Найдан буюу архад лам гэдэг нь монголоор батад оршигч гэсэн утгатай тул дияны их бясалгагч лам болох нь тодорхой.

⁴³Дамбарам нь: Богд Зонхава бээр шарын шашин дэлгэрэх ерөөл хэмээх номын нэр юм

⁴⁴Даш гэдэг нь: Өлзий хутаг гэсэн төвд үг бөгөөд энэ нь хурал номын сүүлд уншиж өлзий хутгыг дэлгэрүүлэх ном юм.

⁴⁵Овоодой нь: Малгайны нэр юм

⁴⁶Ян гэдэг нь:Хурлын уншлагийн ая эгшиг

үлээх хэрэгтэй. Хааяа цагт солиж болохгүй. Сэлнэнгээс урьд хэнгэрэг үл цохихуй. Гүл довог⁴⁷-т хэнгэрэгний голын хуваарьт цохих, бусдад болвоос доодхи хуваарьт цохино. Гүлийн эхийг тасалснаас хойш хэнгэрэгийг эргүүлэн цохино”.

Тайлбар: Энэ хэсэгт хурлын хөгжмийн зэмсэгийн талаархи зааварчилгаа гарч байна. Суудалд сууж буй лам өмнөө буй цанг далд хийхгүй байх ёстой, мөн цанг хэнгэрэг буй газрын доор цохихгүй байх ажээ. Энэ нь хэнгэрэгийн дэргэд буй цан нь хэнгэрэгний дуутай зэрэгцэхээс болгоомжилсон явдал гэж үзэж болох юм. Харин зайтай байвал, хэнгэрэг цан хоёрын дуу салж дуугарах ёстой гэж үзсэн хөгжмийн онолын үндэстэй зүйл байх боломжтой юм. Хөгжмийн зэмсэгийн дуугаралтыг маш сайн бодож төлөвлөсөн явдал бол хөгжим тус бүрийг нэг дор дуугаргахгүй баруун, зүүнд нь хуваарлисан явдал бололтой. Дээр өгүүлснээр: Бишгүүрийг баруун талд, ганданг зүүн талд үлээх, зэс бүрэг баруун талд, цагаан бүрээг зүүн талд үлээх ёстой ажээ. Дээрх дарааллыг аль цагт солиж болохгүй талаар журамласан байна. Ингээд хурлын хэнгэрэгний тухай журамлажээ. Сэлнэнгээс урьд хэнгэрэг цохихгүй юм байна. Гүл довогт хэнгэрэгний голын хуваарьт цохих, бусдад болвоос доодхи хуваарьт цохино. Гүлийн эхийг тасалснаас хойш хэнгэрэгийг эргүүлэн цохих ажээ.

Жаяг бичигт: “Гүл уншихаас эхлэн төгсөх хүртэл үүдийг хаана. Шавь нар орж гарч болохгүй. Шинэ жилийн их ерөөлд шавь нар бүгд шар жанч нөмрөх хэрэгтэй. Хурал бусдад хүрэн цэмбэн тэрэм жанч нөмөрсөн боловч Аюушийн даншүг хийгээд хаврын сарын наймны тахилга мэт

⁴⁷Гүл, довог нь: Зөвхөн хангал сахиусын тахилгын зан үйл дотор байдаг уншлагийн нэгээхэн хэсэг бөгөөд гүл нь сахиусанд шашны харшлах шалтгаан болсон зүйлээс хамгаалж зохилдох шалтгаан бүгдийг ирүүлэхийн сануулга юм. Довог нь: төвдөр буцаах гэсэн үг бөгөөд 80-зэтгэр хийгээд 60-ад тэргүүтэн муу зүгийн зүйлийг буцааж уншдаг ном юм.

жанчгүй цэвэр хувцас хэрэгтэй. Жанчны дотор орхимжоо буулгаж суух хэрэгтэй. Гэлэн, гэцэл Жүдмадва мэт дэвсгэрний дээр дэнва⁴⁸ луга адил дэнвааг цэмбэ тэрмээр үйлдэж хадгалах хэрэгтэй. Ер шавь нар нугуудын хувцас цөм хилэн хиаз захтай байх хэрэгтэй. Шавь нар нугууд нимгэн ултай гутал өмсөх хэрэгтэй.

Тайлбар: Энэ хэсэгт хурлын бусад дэг журмыг нарийн тодорхой гаргасан байна. Энэ хэсэгт ямар үед хийдийн хаалга хаах ба шавь нар гарч орж болохгүй тухай гарч буйгаас гадна хуралд өмсөх хувцасны талаар тодорхойлжээ. Лам нарын хувцас олон төрөл байдаг. Жишээлбэл, цагаан сарын их ерөөлд тус хийдийн лам нар бүгд шар жанч нөмрөх ёстой юм байна. Бусад хуралд хүрэн тэрмэн жанч өмсөх ба Аюушийн даншүг ба хаврын сарын наймны тахилганд жанчгүй цэвэр хувцас өмссөн байх ажээ. Жанчны дотор орхимжоо буулгаж суух ёстой. Энд бусад олон зүйлийг зааварчилснаас гадна сонирхол татахаар нэг зүйл бол шавь нарын хувцас цөм хилэн хиазтай байгаа нь анхаарал татаж байна. Энэ бол жирийн сүм хийдэд төдийлөн хэрэглэдгүй хүндэт томчуулын өмсдөг хувцас гэж ойлгогддог бол Дүйнхэрийн лам нар бүгд хилэн хиазтай шар дээл өмссөн байх ажээ. Түүнчилэн тус дацангийн лам нар нимгэн ултай гутал өмсөхийг зааварчилсан нь өвөрмөц зүйл болох нь тодорхой.

Жаяг бичигт: “Эндэхийн шавь нар жил бүр ном цээжилсэн ба нинбаны тоог ловон нугуудад сонсгоод дээрх дор айлтгах хэрэгтэй. Хурлаас саарваас нинба нугууд сонсгоод дээрх дор⁴⁹ айлтгаад банзай өргөж мөргөх хэрэгтэй. Бас гэсгүй солилцоход хуучин гэсгүй лавир өргөж мөргөх, шинэ

⁴⁸Дэнва нь: Гэлэн, гэцэл хүмүүс олбогон дээр дэвсэж суудаг дэвсгэрийн нэр юм.

⁴⁹Энд IV богд Жавзүндамба хутагт буюу дорж ловонгийн үүрэг барьж буй ламыг хэлж байна гэж ойлгох ёстой.

гэсгүй гэсгүйн үйлдвэр⁵⁰ чадваас гүйцэтгэх хэрэгтэй. Эс чадваас жилийг гүйцэтгэлгүй гарч болно. Шар тасалгаанаас хойш орхимжоор толгой бүрхэж эрих барьж үл явна”.

Тайлбар: Аливаа хийдийн шавь нар жил бүр ном цээжилж багш нартаа шалгуулах шаардлагатай байдаг. Энэ үүргийг хийдийн ловон хариуцдаг. Ингээд эцэст нь IV богд Жавзундамба хутагтад айлтгаж байжээ. Сүүлд дорж ловон хэн байсан түүнд айлтгаж байсан нь тодорхой. Дээрх хэсэгт, бусад журмыг гаргажээ. Ялангуяа хуучин гэсгүй ажлаа өгөх, шинэ гэсгүй ажил авах, хэрвээ шаардлага хангахгүй бол шинэ гэсгүй хугацаа харгалзахгүй ажлаас чөлөөлөгдөх зэргийг тодорхой өгүүлсэн байна. Шар тасалгаанаас хойш орхимжоор толгой бүрхэж, эрих барьж явахыг хориглож байна. Дээрх хэсэгт Дүйнхэрийн дацанд шар тасалгаа нэртэй нэгэн өргөө байсныг мэдэж болох ажээ.

Жаяг бичигт: **“Дорж ловон унзад, гэсгүй энэ гурав гурван хувь соном хадагтай, гош-ын ловон дөрөв, загдсамбарын унзад нар хоёр хоёр хувь даш хадагтай. Гарван чогвон⁵¹ нар хувь хагас дундын даш хадагтай эд нараас бусад хэнч хувь хадаг⁵²-гүй. Дэд хамба угаас энэ дацангийн шавь бус бөгөөс гол мөрөнд хуралд суудаггүй. Доржловонгийн алаг нацагдоржтой дэвсгэр хоёр, Хамба номун хан мөн дэвсгэр түшлэгтэй, давхрагтай”.**

Тайлбар: Энд хадаг нь албан тушаалыг харуулж байна. Цол бүрд тусгай хүндэтгэлийн хадаг хадгалуулж байжээ. Хэрвээ дээд албан тушаалын лам биш бол хадаггүй байсан байна. Хадганд нэрийг нь албан тушаалтай нь бичиж хадгалуулдаг байсан юм.

⁵⁰Үйлийг үйлдвэр хэлж байгаа нь хуучирсан үг хэллэг юм.

⁵¹Гарвон гэдэг нь: Бүжгийн дарга гэсэн төд үг бөгөөд сагар, чогорын бүжгийн үед голлж удирдаг хүний мяндагийн нэр юм.

⁵²Энд дөрөв, гурав, хоёр, хувь хагас дунд хадагтай гэж гарч байна. Хувь гадаг гэж хэмжээг заасан үг бололтой.

Энэ нь нөгөө талаар түүний албан тушаалынх нь батламж болдог байжээ. Энд бусад зарим зүйлийг хуульчилж өгсөн байна. Тухайлбал, “дэд хамба угаасаа энэ дацангийнх биш” гэсэн нь өөр хийдээс дэд хамбыг залж, онцлог хурлын үед хуруулж байсантай холбоотой байж болох юм. Дэд хамба энэ хийдэд шууд хамааралгүй тул гол мөрөнд суулгадгүй нь Дүйнхэрийн ёсны лам нарыг илүү өргөмжилж байсны гэрч юм. Дорж ловон л гагцхүү алаг нацагдорж голд нь залсан хоёр дэвсгэрт сууж байсан байна. Харин Номун хан мөн ижил дэвсгэр, түшлэгтэй, давхрагатай суудалд сууж байжээ.

Жаяг бичигт: ***Дорж ловонгийн дэргэд чог-д бусад лам ламын хэрэглэл хэрэглүүлэхгүй, хангал-д нэг ламд хэрэглүүлэх. Дүйнхорын чог-д дорж ловонгоос бусад хэнч дамар үл хэрэглэх***”.

Тайлбар: Энэ хэсэгт дамар тэргүүтэн хэрэглэлийн талаар танилцуулжээ. Дээрхээс үзэхэд хийдийн зүгээс лам бүр өөрийн хэрэглэлтэй байхыг заасан гэж ойлгож байна. Тус хийдийн нэг онцлог нь Жүд, Шаддүблин зэрэг хийдээс зарим онцлог хурлын үед шилдэг лам нар ирж хуралд хурах, балин бэлтгэх зэрэгт оролцож байсан тул тус хурлын онцлогтой хэрэглэл бүгдэд ижил байгаагүй бололтой.

Жаяг бичигт: ***“Хурлын газар дорж ловонгийн манжийг соёогва⁵³ барих, манж бүрээс Жалсрай гэгээнд соёогва дээж өргөх мөн чогор бүхийн дээж өргөх, хангалын уриа, хэнгэрэг бусад хурал бүхүйн уриа, харанга дэлдэх, шинэ шавь ороход Дүйнхор цээжилж шүүлгэсний сүүлд шагналд овоодойны оройны цэмбэ бүчний ногоон торгийг дотоод сангаас хүртэймой***”.

⁵³Соёгва буюу соёг нарыг эндээс үзээд манзич буюу манз, цав барьж үйлчилдэг лам гэж ойлгож болох ажээ. Богдуудын орд, өргөөнд соёг нар үйлчилж байсан баримт бий.

Тайлбар: Хурлын үед дорж ловонгийн манжийг соёгва барих гэснээс соёг нарын ажлын онцлог харагдаж байна. Хуучин цагт соёг нар зарим сүм хийдэд байсан бол орчин үед ийм цолтой хүн байхгүйгээс энэ талаар мэдээлэл хомс байсан юм. Энэ мэтчилэн жаягийг судлах нь хийдийн зарим тушаалтан юу хийж байсныг тодруулах боломж гаргаж байна. Тус хийдийн лам бүр овоодой малгайтай байжээ. Тиймээс шинэ шавь ороход Дүйнхор цээжилж шүүлгэсний сүүлд шагналд овоодойны оройны цэмбэ, бүчний ногоон торгийг дотоод сангаас хүртээж байсан байна. Шинэ хувраг тэрхүү овоодойн оройн цэмбэ, бүчний ногоон торгийг авч овоодой хийлгэж өмсөж байжээ.

Жаяг бичгийн эхэнд: ***“Бас өвөл зуны хангал хуучин ном түмт хангал, түмтийн магтаал тэргүүтэнд ордны сойвон, оточ⁵⁴, бойнзомчин бараа болооч донир, тахилч, соёогоос дээш бүгд хамт хурмой. Өвөл зуны ба дунд хуучин ном мөн хангал хураhad зургаан өлгүүрчнийг Дашчойнпэл, Гунгаачойлин, Жүд дацангаас нэг нэгэн өдөр бүр ирэхээс тогтоосон шинэ хуучин чойрын чуйнлайв, унзад, гэсгүй нар хурж байсан. Мөн Их хангалд Жүдийн лам гэсгүй нар ирж хурдаг билээ. Хамба номун хан угаас Дүйнхорын шавь бус боловоос манж чанаж, хурж, ногоон угтай бүч зүүдэг. Энэ дуган сүм хурал номыг хэн ч өөрчлөхгүйгээр тогтоосон учир болбоос шашин үргэлшид батдан оршихыг таалан зохиожээ”***.

⁵⁴Оточ гэдэг нь эмч юм.

ЛҮЙЦХӨР ПАЛАНЫ ЖАРГ БОСОО МОНГОЛ БИЦГЭЭР

1-р хуудас

1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14

2-р хуудас

15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28

3-р хуудас

29 30 31 32 33 34 35 36 37 38 39 40 41

30-р хуудас
 31-р хуудас
 32-р хуудас
 33-р хуудас
 34-р хуудас
 35-р хуудас
 36-р хуудас
 37-р хуудас
 38-р хуудас
 39-р хуудас
 40-р хуудас
 41-р хуудас

4-р хуудас

42 43 44 45 46 47 48 49 50 51 52 53 54 55 56

42-р хуудас
 43-р хуудас
 44-р хуудас
 45-р хуудас
 46-р хуудас
 47-р хуудас
 48-р хуудас
 49-р хуудас
 50-р хуудас
 51-р хуудас
 52-р хуудас
 53-р хуудас
 54-р хуудас
 55-р хуудас
 56-р хуудас

5-р хуудас

57
 58
 59
 60
 61
 62
 63

64
 65
 66
 67
 68
 69
 70

6-р хуудас

71
 72
 73
 74
 75
 76
 77

78
 79
 80
 81
 82
 83
 84

9-р хуудас

112 113 114 115 116 117 118
 119 120 121 122 123 124 125

10-р хуудас

126 127 128 129 130 131

132 133 134 135 136 137 138

11-р хуудас

139 140 141 142 143 144 145
 146 147 148 149 150 151 152

12-р хуудас

153 154 155 156 157

158 159 160 161 162 163

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ БУРХАНЫ ШАШИНЫ УЛБАА

Доктор Ц.Отгонбаярын илтгэл

Одоогоос 2550 жилийн өмнө Бурхан багш лагшин мэндэлж номын хүрд өргүүлсэнийг та бүхэн бүгд мэддэг билээ. Тэгвэл бурхан багш цагийн хүрдний номлолыг өмнөд энэтхэгийн балдан брайван суварган дээр номлосон байдаг. тэрхүү одоогийн энэтхэгийн карнатака муж амравати хэмээх газарт 14-р Далай лам данзан жамц бээр цагийн хүрдний авшиг айлдахдаа Лондол ламын зохиосон дүйнхорын түүх хэмээх номыг ишлэл болгон энэхүү газар бурхан багшаас өмнө заларсан Сэртүв бурханы үед нэгэн гэлэн бээр өлсөж буй түмэнд туслахаар лусаас хурын оронд амуу тариа хүсэж хурчилан буулгасан бөгөөд түүнийг бэлэгдэн арвайгаа бөөрөнхийлэн хумиж суварга мэт овоолон тэнгэр бурханаас хайрласан хишгийн газар үүнээс хойш бурхан тэнгэртэйгээ эндээс тахиж харьцана гэж тэмдэг тавин чодён буюу тахилын суурийг анхлан бүтээсэн гэж цохон тэмдэглэсэн байдаг.энэхүү он тоололоос 12000жилийн тэртээ ВЕД иин шаштир дэлгэрч кастийн системтэй байжээ. Вархман буюу барамсай язгуур кшастра буюу хаан язгуур вайвшика буюу худалдаачин гар урчуудын язгуур,шутра буюу боолын язгуур гэх 4 ангид харъяалагддаг ба боолын хүүхэд боол байх хувь зохиолтой дээд ангитайгаа харцахгүй байдаг байжээ. гэтэл энэхүү систем монголд тэгэх тусмаа хуучин сайн ноён хаан аймаг далай вангийн нутагт ордог байсан завханы алдархааны богдын голд хадан дээр дээрх барамсай,хаан, худалдаачин цэрэгийн хүн, боолыг дүрсэлэн зурсан 4хүний хадны зурагыг монгол телевизийн сурвалжлагч Бадамсамвуу тайлбар хийсэн байдаг энэ тэр кастийн систем байсаныг батлан харуулах эд өлгийн дурсгал болно. Манай хүннү дээдэс хааныгаа шаню гэж

тийм системтэй байсан ба тэр уламжлал нь урагшаа энэтхэг оронд дамжсан тэр бол бөгсөндөө хөх тольботой аричууд байсан гэж оросын холбооны улсын академич Вангорд Левин гэдэг эрдэмтэн, мөн энэтхэгийн эрдэмтэн Радхакришна нар олон зохиол бүтээлээрээ баталсан байдаг. Бурханы шашины өмнө ведийн шашин буюу мани шашинтай байжээ гэсэн дүгнэлтэнд хүрч болох юм. бурханы шашин бас эрт манай нутагт дэлгэрчээ. Монгол улсад төрт улс байгуулагдсаны 2220 жил гэж бид энэ жил тэмдэглэсэн энэ нь миний төрсөн нутаг болох эзэгийнтийн хужиртаас баруун 25км т хүннүгийн хаад түмэн шанюгийн хөвгүүн модун шаню луут хотыг байгуулсан түүний туурь болон бичгийн дурсгалаар эрдэмтэн Гүнжийн Сүхбаатар хүннү нар монголчуудын эртний өвөг болох нь гэх цуврал бүтээлээрээ нотолсон билээ. Тэр үед хан улс Зчи өндөр бурхан багш манай хүннү чүүдээс дээрэмдэн авч тахиж байсан тухай баримт бий энэ нь бас л манай нутагтай холбоотой мөн ц доржсүрэн.1956он Архангай аймагт археологийн шинжилгээ хийсэн тухай тайлан, Г мэнэсийн 1982онд хийсэн археологийн тайлан, С Г Кляшторный. В А Лившиц нарын Согдийская надпись из бугата хэмээх эрдэм шинжилгээний бүтээл, японы эрдэмтэн эрдэмтэн Ятака юүшида, Такяа муруша нарын sogdian part of inscription хэмээх бүтээлүүдэд бугатын баян цагаанаас авчирсан яст мэлхий дээрхи хүүхэд хөхүүлэж буй чонын дүрстэй бичигт хөшөөг тайлан уншиж 528онд босгосон бурханы шашинтай холбогдох эд өлгийн дурсгал хэмээн нотолсон нь тэр үед бурханы шашин дэлгэрч байсаныг таамагаар бус бодитоор нотолсон хошгүй ховор дурсгал юм.

Батмөнх Даян хаан 11 хөвгүүнтэй байсан бөгөөд тэдгээрийн отгон нь Гэрсэнз Жалайр хунтайж бөлгөө. Гэрсэнзийн 7 хөвгүүний гутгаарыг Онохуй Үйзэн гэдэг ажгуу. Монголд бурхны шашныг дэлгэрүүлэхэд ихээхэн хүчин зүтгэсний учир Онохуй Үйзэн ноён буюу хүндүлэн цохурыг Ванчин богдоос Гаслан үгүй номын хааны залгамж хойд дүр хэмээн тодруулсан энэ нь Заяын

гэгээнтэний урьд дүр билээ. Күндүлэн цокур ноен 13 хүүхэдтэй ба 2-р хөвгүүн нь ламын гэгээнтэний аав Лоёг цокур ноен, 3-р хөвгүүн нь Данзан лам буюу гэгээнтэний номын эзэн, шива ширээтийн анхдугаар дүр бээр Чонотын хөндий хэмээх булган уулын өвөрт дуганы суурь тавьж эхэлэн. 1725 онд манжийн Найралт Төв хаан халхын гурван аймгийг 75 хошуу бүхий 4 аймаг болгож, Данзан ламын жич хүү Хошой чин ван Дашдэндэвт “хан” цол олгож, Түшээт хан аймгаас 19 хошуу тасдаж эзэмшил болгон өгч, Сайн ноён хан аймгийг байгуулаж улмаар 20 гаруй хаадууд дамжин Төгс-Очирын Намнансүрэн 19 настайдаа 1897 онд эцгийн хэргэм зэргийг залган хошой чин ван цол шагнагдаж, сайн ноёны хошууны засаг ноён, Сайн ноён хан аймгийн хан болжээ. Гэгээдүүд хийд ороноо дээш хөгжүүлсээр сири живзүнбийн эхжа буюу сургалттай, дашлунбэ дэгтэй, Сэрхүгийн манба буюу лхантүв зүчин сүм цээжээр шүүлгэж маарамва болдог, 5 н зава цээжилж гавжийн дамжаа барьдаг, зээрэмбийн дамжаатай, жалбаан авын жаягтай их хүрээний дараа орохоор шашины хоер дахь том байжээ. доод, дээд гэсэн хоёр хүрээнээс бүрддэг ба дээд хүрээндээ Жи дацан буюу шашин төрийн хэргийг эрхэлэн явуулах газар Гүшүг дацан буюу гэгээнтэний албан дацан, Жара буюу нүгнээ сахидаг жанрайсиг дацан, гүнрэг дацан, сандуйн дацан энэ дацантай тохомтой шавь нар нь одоогийн эрдэнэ мандалын урьд хэсэг хамрагдах ба толгойлж буй өглөгийн эзэнээ сандуйдарга хэмээгдэг, Дэмчиг дацан шавь нар нь одоогийн цэцэрлэг сумын урьд бигээр байдаг ба гол эзэнээ дэмч дарга гэдэг, Дүйнхор дацан шавь нар нь бугат баян уул сумын хан байдаг ба гол өглөгийн эзэнээ дүйнхор тэргүүн гэдэг байжээ. Жи дацангийн ли нарын хуваарийн дагуу улиралын хуралыг хувиарлан цогчинд нийлж хуран цогсаг босдог байжээ. доод хүрээндээ аюуш цэвээлэн хоёр дацантай байв Эргэн тойрондоо буи хийд ороноо боловсон хүчнээр хангаж хамтын ажилгаан дор шашинаа хөгжүүлэж байв Тэдгээр хийдүүдийг дурьдвал Баян уул сум Лхамын хурлын дэнж.агьтийн хурал, бугатын хурал,

бурхангийн дуган зэрэг газаруудад улиралын хурал болдог байжээ. Батцэнгэл суманд Тарваачинбуулин хийд, улаан чулууын хүрээ, халчиний хийд зэрэгт байнгийн хуралтай 300 гаруй лам нартай байв. Баянбулаг суманд баруун хийд, бугатын хийд, Сангийн далай хийд, Хадатын хийд зэрэг хийдүүд байжээ, Баянхонгор суманд Гавжийн чойнхорлин хийд, Ганданцэцээлэн хийд, Бөмбөгөр суманд Галдан дуган, хишгэн жас, Бугат суманд тайжид сүм, дарь эхийн хурал, Чойжоо хурал Майдарын хурал, Урт булагийн дарь эх, зэрэг Буянт цагаан гол суманд Буянтын хийд, Данхорын жас, Зүүн жас зэрэг. Заг гол суманд Хөгнө хийд үйзэн хурал, Шивэртийн сүм, Идэр суманд Мандахын хүрээ, Нарийний хүрээ, Дэрстийн дуган, зэрэг. Их жаргалант суманд Арын хүрээ, Агьтийн сүм Гүнжилийн сүм, Их уул суманд Зартийн хийд, Зартын бага дуган, Дарь эхийн дуган, Юмын байшин. Мандал суманд Мандалын хүрээ гэх олон лам нар салвар дугантай том хүррээ байв. Их тамир суманд Чойдэлэг хийд Майдар хурал, Шивэртийн дуган Бумбатын дуган, Их хужиртын дуган, Урт булагийн дуган Арцатийн дуган хан өндөрийн хүрээ, Лүн суманд Эрдэнэ зуу хийд, Чойнхорын хурал, хурахуйн хурал, Хорчиний хурал Могод суманд Урт мэргэний хийд, баргын хийд, Эрдэнийн хийд Жаргалантийн хийд, Баян өндөрийн хийд, Рашааны хийд, Баясгалантын хийд, Наран суманд Хожуулын хийд, Өлзийт суманд Будантын хийд, Лавран хийд, Өндөрсант сант суманд Цагаан сүмийн хийд, Өндөр улаан суманд Хануйн дуган, одорхын дуган, Тахилын дээд дуган Маанийн дуган, Тариат суманд Тариатийн хүрээ, Суурийн хийд, чоичирлэн хийд, Улаанчулууын хийд, Хайрхан суманд Хануйн хүрээ, Журамтайн хүрээ, Хашаат суманд Ар өвөр номгоны хийд, Хотонт суманд Хотонтын хүрээ зэрэг хийд сүм дуганыг Заяын хүрээний Жи дацангаас удирдан дэлгэрүүлж иржээ.

Сайн ноён хан аймаг 1725-1911 оны хооронд 24 засаг хошуу, 8 тамгатай хутагтын шавь бүгд 32 засаг захиргааны нэгжтэй, халх

дөрөв, дөрвөд хоёр нийт зургаан аймгаас хамгийн томд нь тооцогдож байжээ.

Хутагт хувилгаад нар нь: Богдоос гадна тамгатай 13 хутагт байснаас Сайн ноён хан аймагт Зая бандид хутагт, Эрдэнэ бандид хутагт, Чин сүжигч Номун хан, Нарбанчин хутагт, Эрдэнэ мэргэн ноён хутагт, Шиваа ширээт хутагт, Наран хутагт, Хамба хутагт, Засагт хан аймагт Жалханз хутагт, Ялгуулсан хутагт, Бигэр Номун хан гэсэн гурван хутагт Цэцэн хан аймагт Егүүзэр хутагт, Ялгуулсан хутагт гэсэн хоёр хутагт тус тус харьяалагдаж байжээ.

ЗАЯЫН ГЭГЭЭНИЙ ХҮРЭЭ БОЛОН САЙН НОЁН ХАН АЙМГААС ГАРСАН ЭРДЭМ НОМТОЙ ЛАМ НАР

Агваандамба. Сайн ноён хан аймгийн Илдэн бэйлийн хошууны гавж, XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть. Судар тарнийн тайлбар ба зан үйл, Илдэн бэйлийн хошуунд бартай.

Агваанпэрэнлэй. Сайн ноён хан аймгийн Хошууч бэйсийн хошууны Лашин хувилгаан. XX зууны үеийн хүн. Зохиол нь таван боть, зан үйл, намтрууд. Бичмэл.

Артасэдбазар. Сайн ноён хан аймгийн Далай чойнхор вангийн хошууны Ялгуугсан тойн. XIX зууны үеийн хүн, зохиол нь таван боть, судар тарнийн тайлбар, яруу найраг, зан үйл боть үйл зэрэг. Ялгуугсаны хүрээнд бартай.

Өлзийбат. Сайн ноён хан аймгийн Заяын хүрээний маарамба. XX зууны үеийн хүн, зохиол нь дөрвөн боть, эмийн дохионы тайлбар зэрэг бичмэл.

Бадрах. Сайн ноён хан аймгийн Сайд вангийн хошууны Заяын хүрээний гавж, XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, судрын тайлбар, зан үйл зэрэг, бичмэл.

Балдандэчинодсэл. Сайн ноён хан аймгийн Пүрэв гүний хошууны Наран хутагтын III дүр. XX зууны үеийн хүн, зохиол нь долоон боть, судар тарнийн тайлбар, зан үйл зэрэг, зарим нь бар, зарим нь бичмэл.

Галсан. Сайн ноён хан аймгийн мөн хошууны Ловон. XIX зууны үеийн хүн, нэг боть зохиолтой. Тарнийн тайлбар номууд зэрэг, бичмэл.

Галсан. Сайн ноён хан аймгийн Заяын хүрээний хамба. XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть тарнийн тайлбар, хөтөлбөр зэрэг, бичмэл.

Галсан. Сайн ноён хан аймгийн Заяын хүрээний Шүнлайв, XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, судар тарнийн тайлбар зэрэг, бичмэл.

Галсангэмпэл. Сайн ноён хан аймгийн мөн хошууны хамба. XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, зан үйл, залбирал, мөргөл зэрэг бичмэл.

Жамбацэвээн. Сайн ноён хан аймгийн Ламын гэгээний хүрээний ловон. XVIII зууны үеийн хүн, зохиол нь хоёр боть, судар тарниын тайлбар, зан үйлийн зэрэг, бичмэл.

Жамъянгарав. Сайн ноён хан аймгийн Даян жалбуу засгийн хошууны хамба, гэгээн. XX зууны үеийн хүн, зохиол нь арван гурван боть, уран зохиолын онол зэрэг мөн хошуундаа бартай.

Жамсран. Сайн ноён хан аймгийн мөн хошууны цорж, XIX зууны үеийн хүн, зохиол нь таван боть, элдэв зан үйл зэрэг мөн хошуунд бартай.

Ёндон. Сайн ноён хан аймгийнсайд вангийн хошууны маарамба. XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть. Эмийн дарван үндэсний түүвэр зэрэг, мөн хошуундаа бартай.

Дашравдан. Заяын хүрээний цорж. XIX зууны үеийн хүн, зохиол нь дөрвөн боть, дотоод ухааны тайлбар, зан үйл, магтаал зэрэг бичмэл.

Далай. Сайн ноён хан аймгийн Сайд вангийн хошууны маарамба. XX зууны үеийн хүн, нэг боть зохиолтой, эмнэлгийн тухай бичмэл.

Даваа. Сайн ноён хан аймгийн Сайд вангийн хошууны цорж. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, Билиг барамидийн тайлбар зэрэг, Арвай хээрийн хүрээнд бартай.

Дондов – Ринчин. Сайн ноён хан аймгийн Заяын хүрээний гавж, XIX зууны үеийн хүн, зохиол нь хоёр боть, судар тарнийн тайлбар, зан үйл бичмэл.

Дүвжүү. Ламын гэгээний хамба. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, элдэв зан үйл зэрэг, бичмэл.

Ринчиндагва. Сайн ноён хан аймгийн Заяын цагаан равжамба. XVIII зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, чойрын ном, бичмэл.

Рэгзэнсэвжиддорж. Сайн ноён хан аймгийн Далайчойнхор вангийн хошууны шавь. XVIII зууны үеийн хүн, зохиол нь таван боть, судар тарнийн тайлбар яруу найраг, элдэв зан үйл, мөн хошуунд бартай.

Самданлхүндэв. Сайн ноён хан аймгийн Дайчин вангийн хошууны даянч лам. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, элдэв зан үйл, бичмэл.

Сампил. Сайн ноён хан аймгийн Сайд вангийн хошууны гавж, жорвон. XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, чойрын номууд, бичмэл.

Сономжамц. Сайн ноён хан аймгийн мөн хошууны ловон, долоон боть зохиолтой, судар тарнийн бан дуун ухааны тайлбар зэрэг, мөн хошуунд бартай.

Содов. Сайн ноён хан аймгийн Сайд вангийн хошууны гэцэл. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, судар тарнийн олон зүлийн тайлбар, бичмэл.

Шаравжамц. Сайн ноён хан аймгийн Арвайхээрийн хошууны зурхайч. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, зурхайн гол зэрэг, бичмэл.

Лувсан. Сайн ноён хан аймгийн Сайд вангийн хошууны Шива ширээт. XVIII зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, тарнийн зан үйл зэрэг бичмэл.

Лувсаннамжил. Сайн ноён хан аймгийн Зая бандидагийн хоёрдугаар дүр. XVIII зууны үеийн хүн, зохиол нь хоёр боть, зан үйл зэрэг, бичмэл.

Лувсанняндаг. Сайн ноён хан айгийн мөн хошууны хамба. XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, тарнийн тайлбар, бичмэл.

Лувсанжамба. Сайн ноён хан аймгийн Заяын хүрээний хамба. XX зууны үеийн хүн зохиол нь нэг боть. Ванайн тайлбар, зан үйл зэрэг, бичмэл.

Лувсанданзан. Сайн ноён хан аймгийн Арвайхээрийн хошууны XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, Номун сахиулсан билгийн зан үйлийн тайлбар, бичмэл.

Лувсанданзанжалцан. Сайн ноён хан аймгийн Ламын гэгээний анхдугаар дүр. XVII зууны хүн, зохиол нь дөрвөн боть, судар тарни, эмнэлэг, зурхайн тайлбар мөн шууны бартай.

Лувсандорж. Сайн ноён хан аймгийн мөн хошууны хамба. XIX зууны үеийн хүн, зохиол нь дөрвөн боть, судар тарнийн тайлбар, бодь мөрийн шалгалт зэрэг. Мөн хошуунд бартай.

Лувсандамба. Сайн ноён хан аймгийн XVIII зууны үеийн хүн зохиол нь нэг боть, судрын тайлбар тэмдэглэл, бичмэл.

Лувсан-Агваанчүлтэм. Номгоны Дарь-эх лам XX зууны үеийн хүн, зохиол нь хоёр боть. Судар тарнийн тайлбар, зан үйл, намтар зэрэг, бичмэл.

Лувсанчимэддорж. Сайн ноён хан аймгийн Түшээт вангийн хошууны Цорж. XX зууны үеийн хүн, зохиол нь хоёр боть, Авидарамгийн тайлбар зэрэг, бичмэл.

Лувсансодовжамц. Лхарамба. XVII зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, судар тарнийн тайлбарг зэрэг, бичмэл.

Лувсанпэрэнлэй. Сайн ноён хан аймгийн Зая бандидагийн анхдугаар дүр. XVII зууны үеийн хүн, зохиол нь зургаан боть, судар тарнийн тайлбар, зан үйл зэрэг, Бээжинд бартай.

Лувсанцэрэн. Сайн ноён хан аймгийн Далай вангийн хошууны гавж. XIX зууны үеийн хүн, нэг боть зохиолтой судрын тайлбар зэрэг, бичмэл.

Лувсанчүлтэм. Сайн ноён хан аймгийн Заяын таягт лам хэмээн алдаршсан. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, судар тарнийн тайлбар, зан үйл зэрэг, бичмэл.

Лодойдамба. Сайн ноён хан аймгийн мөн хошууны ловон. XIX зууны үеийн хүн, зохиол нэг боть, судар тарнийн тайлбар, зан үйл зэрэг, мөн хошууны хүрээнд бартай.

Доржбал. Сайн ноён хан аймгийн Далай вангийн хошууны цорж. XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, Дохионы бичиг зэрэг, мөн хошууны хүрээнд бартай.

Ванганжав. Сайн ноён хан аймгийн Заяын хүрээний гавж. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, судар тарнийн тайлбар, зан үйл зэрэг, бичмэл.

Зундуйсодов. Сайн ноён хан аймгийн Дайчин вангийн хошууны даяан ламын ёнзон. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть,

хамба гэгээн Жамкянгарав, Нарангэгээн, Дэчин-Одсэл зэргийн намтар, бичмэл.

Цэвэлванчогдорж. Сайн ноён хан аймгийн Арвайхээрийн хошууны бандида лам. XIX зууны үеийн хүн, зохиол нь арван таван боть, судар тарни, эмнэлэг зэрэг, Арвайхээрийн хошуунд бартай.

Цэвээнлхасүрэн. Сайн ноён хан аймгийн Түшээт вангийн хошууны тойн. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, Билэг барамидын тайлбар зэрэг, бичмэл.

Цэрэндорж. Сайн ноён хан аймгийн Гадан засгийн хошууны гавж. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, элдэв чухал үгс зэрэг, бичмэл.

Цэрэнжав. Сайн ноён хан аймгийн Далай гүнгийн хошууны аграмба. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, чойрын ба эмнэлэг зэргийн, бичмэл.

Цэрэндорж. Сайн ноён хан аймгийн Илдэв бэйлийн хошууны гавж. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, Бодь мөрийн зэрэг, Шалгадаг ухааны тайлбар зэрэг, бичмэл.

Цэвээнчавцог. Сайн ноён хан аймгийн Ламын гэгээний гуравдугаар дүр. XVIII зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, тарнийн ёсны утгыг тодруулсан зэрэг, мөн хүрээнд бартай.

Чүлтэм. Сайн ноён хан аймгийн мөн хошууны ловон. /Дондоо/ XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, тарнийн ёсны ном зэрэг, бичмэл.

Гол нандин шүтээнүүд:

Көндүлэн цоохор ноёныг жинсрэг зутган чандарлахад магнайнаас нь Одбагмид бурханы дүр гарч хөлийн улнаас түвд а үсэг гарсныг би үзсэн хэмээн Зая гэгээнтэн өөрийн бичсэн

намтартаа бичсэн байдаг ба түүнийг жаарийн дуганы гол шүтээн жанрайсигт жанрайсиг бурханы сүншүгт гэгээнтэн өөрийн мутраар хиисэн хосгүй шүтээн байв. Цогцон дуганы гол шүтээн майдар бурхан бээр 1905 онд 13-р Далай ламын дагуул лам нар ирж номгүй газарт хэмээн дорд үзэхэд заяын Балжиржанцан гавж ном хаяж номхруулан госо өндөр гэдгийг мэдрүүлсэн байдаг тэгтэл тэд мөчөөгөө өгөлгүй жаяг дүлбаа гүй хэмээхэд жалваан авын жаягтай гэхэд түүнийгээ үзүүл гэж шаардахад майдар бурханы шүншүгт бий гэж гэсгүй хэлсэнд үзнэ хэмээн тэд Майдарт ойртоход бурхан дуу гарган хөлөрсөнд тэд айж буцсан гэдэг, Баян уул багын эзэгийнтийн хужирт хэмээх газар байх Лхамын дуганы гол шүтээн Балдан лхам бурхан урдуураа морьтой хүн гарагдаггүй догшин шүтээнтэй байв, тэр шүтээний гарал үүслийг яривал Түүгээр увс аймагийн харьяат илжгэн ноён тэмээн хөсөгтэй үдлээд явах гэтэл лхам бурхан ачиж явсан тэмээ хэвтээд босоогүй тул аргаа бараад нутгийн эзэн Зая гэгээнээс асуулгахад лхам сахиус энэ нутгийг таалжээ хэмээсэнд ноён дуган барьж залаад орхисон түүхтэй билээ, Галдан бошигт хүрээнд ирж дамдин чойжоо бурхан д сэлмээрээ адис өргөөд гарах гэтэл хамраас нь цус гараад тогтоогүй гэдэг нандин шүтээн олон байжээ

Орон нутгийн шүтээн уул усны талаар:

Зая гэгээнтэн үе уламшлан тахиж ирсэн тахилгатай уул ус дурьдваас Отгон тэнгэр хайрхан, Бөхөн шарын нуруу, Суварга хайрхан, Булган хайрхан зэрэг уулас, Орхоны эх, Тамирын эх Шаргалжуут зэрэг уул усыг тахидаг байжээ Эндээс би булган хайрханыг онцлон дурдаж байна Яагаад гэвэл 1-р богдийн хүрээ 4 н уулын дунд байдаг уншлага сэлтэд жаврэ чингэл хэмээн хойморийн хайрхан гэж хүндэлдэг бөгөөд угаас монгол хүн хоймор талаа хүндэлэн эрдмийн зүйлээр бөөлжөөд байдаг эрүү цагаан хулгана зүг гэж тооцон шүтээнээ залж гэрийн эзэн зүүн

хоиноо бар зүгийг эзэлэн сууж болохгүй нөхдүүдийг баруун хатавчанд нохой зүгт эзэндээ үнэнч байхийг сануулан суулгадаг байжээ. 2-рт Булган хайрхан нь эөнө эртний тахилагтай бурхан уул байжээ Арван буяны шинж бүрдэхээр аранжин маань гардаг гэдэг бол энд маань түвд үсгээр ургаад байгааг та нар бэлхнээ харж байгаа Их хүрээ 10 хангал хурахдаа өөр өөрийн аймагийн ниитийн бус сахуисыг тахидаг түүнтэй адил заяын хүрээнд нисэр хангай хэмээх сахуис хурдаг байсаныг Би аав заяын доод хүрээний лам Г цэрэнбатаас асууж тахилгын сударыг нь хадгалссар ирсэн юм..Тэр бол булган хайрханы тахилгын судар болно Уг судар гар бичмэл 18 хуудастай ба түвдийн дашилхүнбү жүд дацангий н ловон лам нарын нэрсийг Доси цэрэндоржийн дашлүнбийн түүх номын дагуу дугаарлавал 1-р Зонон лувсан дамбижанцангаас 6-р Гэндэн дүв гэгээн 8-рт Синчин гэлэг равжаа, Зүүнгарын лам 31-р Агчин дарав бандид монгол хүн, 2 монго л хүн байсаны 8-р Синчин гэлэг равжаа бээр 1861оны 11 сарын 15 нд Буян дэлгэрүүлэх хийдийн хамба хувилгаан лагшинт Галсан Гүжи Да лам, Зая гэгээний Засаг лам гэх албаны хоёр хүнээс гадна дагуул Гэлэн лувсан чойнжүр донир, Ча лам Иш ширав нарын хүсэлтээр зохиосон болой гэжээ. Сударт ондог буюу илт бүтээлт жандэн заллага ганс шавга сан сэржим балан тахил магтаал бүхий өвөрмөгц судар болно. бүгдийг орчуулаж ондогийн дагуу уг сахиусийг хоёр нөхөр сэлттэй нь бүтээсэн, Булганы өвөр хэмээх 12 бадаг дуунд хайрханы байдалыг тодорхой харуулсан байдаг. Зээ Булганы өвөрт Зуу галдан хийдтэй, Зургаан мааний үсэг зүг бүхэндээ дэлгэсэн, Долоо найман дацантай ямар сонин ламаа бээ гэж магтсан байдаг энэ үнэхээр биелэлээ олсон нутагаа Миний номын ах Аюуш агсан бээр энэ уулын талаар 31 жилийн өмнө тайлбарлахдаа БАр арлан сарлаг хайнаг гэх 4 хүчтэнтэй, арслан зохио бол нэг нь хойшид бурхан ном дэлгэрвэл энэ дөрөвийг сэргээн дүрд оруулаарай мөн гэгээний рашааныг сэргээж гаргаарай, нүүрэнд байдаг зонхов бурханыг сэргээгээрэй засаг эхлээд эвлэлийн

тэмдэг дараа нь улаан таван хошуу зурж арилгахаар үзээд бараагүйг хэлж тойроод долоон одны байрлалтай Намсиг бурхан, Зүгдэр бурхан, Тамжид жав бурхан,Хорвоон жиг бурхан,Сиртүв бурхан, Одсүрэн бурхан, Шагж түв бурхан зэрэг 7 н бурхан байгаа ранжин маанийг олон хүнд битгий хэлээрэй бузартвал алга болно шүү гэж нэг өдөр бүтэн явган дагуулж яваад булган хайрханы дагуул уул усыг нэрлэхдээ Сангийн толгой,Сайрын овоо Цөөн цод Бүрдэнэ хоолой,бүхэг цэнхэр цөөн цод, Алтан овоо Арцат хайрхан цөөн цод, Майдар чулуу, Мааньтийн овоо,цөөн цод хэмээн үрс гаргаж тахил өргөөд Жи дацангаас зохион баигуулж найр үүтгэн 6 насны морьд мордуулахад мэгзэм уншиж асарын өндөр, армаг түмэн эх холч хурдан,өндөр хангай зэрэг дуу эхэлдэг хайлан гадаалаж найр зохиож лам нар Лам гурван эрдэнэ Булганы өвөр, Төгс цогт их янжимаа хилигнэсэн дүртэй боловч амирлангүй байдалтай гэж Лам едам чойжин сахиусаа магтан дуулдаг дүйцэн өдрүүдээр булган хайрхандаа зул өргөж дацангууд ээлжээр тахидаг байсныг хэлж байсан нь өнөөдөр юм шиг санагдаж уул ус лус аргадаж булган ууландаа бүтээн босголт хийхийг та бүхнээс хүсэж байна.

13-Р ДАЛАЙ ЛАМЫН МОНГОЛД ИРСЭН ТУХАЙ НЭГЭН ТЭМДЭГЛЭЛ:

Ум сайн амгалан болтугай Бадаргуулт төрийн 30-р онд

Далай ламын гэгээнтэний 13-р дүрийн хувилгаан Түвдэнжамц Халхын газраа залран ирж Их хүрээ ба Түшээт хан аймаг, Жанжин чин ван, Сайн ноён хан аймаг, Зая бандида хутагт, мөн Хэбай сайн ноён чин ван нарын хийдэд заларсан хойно нь 32-р онд Гүмбүмд заларсан хүртэл тус шавь харъяат хутагтын гонзогт буян үйлдсэн, шинэ дүрийн гэгээнийг тодруулах зэрэг аврал мандал айлтгасан мөн тус хүрээний газар заларч байх цагтаа өршөөлтэй сайшаасан лүндэн айлдсан таалал гарсан гайхамшиг зүйлийг дараалан сийрүүлж бичсэн нь:

Далай ламтан 30-р он 10 сард энгийн учир энэ халхын газраа залран ирсэн хир тохиолдож ийм гайхамшигтыг сонсож идэвхийлэн эдүгээ тушаалын бэйл Дондовчингын хошуу хүрээний ойр газар ирсэн замд шанзудва Цэвэгдорж, сойвон гавж Гэлэгдорж, донир маарамба Литов, зайсан бичээч Баточир, дэмч хэлмэрч Дашдондог нарын зэрэг хүмүүс угтаж халхад заларч ирсэн баярын мандалд хадаг, зах бүхэл торго нижгээд дурдам хоёр,..... газрын хурган дотор тав, мөнгө зуун лан, зоог мандалд.....хадаг хоёр, мөнгө найман лан өргөвөө. Тавдугаар дүрийн гэгээний гонзогын мандалд хадаг торго дурдам, өргөө сэлтсийг өргөж басхүү зургаадугаар шинэ дүрийн хувилгааныг аль зүг хаана хувилсаныг залгаахын тухай мандалд шавиас хадаг, мөнгө торго дурдам өргөдөл бичихдээ өргөсөнд уг бичиг дээр харъяат хийдийн зүүн зүгт ойрхон хаврын сард мэндлэх мөнчүү эхийн жилийг заажээ. Басхүү гонзогт өргөсөн зүйл сэлтсийг харъяат хутагтын урд дүрийн гонзог үйлдсэн ба шинэ дүрийн хувилгаан тодруулсан дансанд бүрнээ сийрүүлсэн тул

үүнд үл сийрүүлснээс гадна мөн энэ ялдраа шавь тив олны сайжралын тухай аврал айлтгаж шавиас Баранзад хадаг, мөнгө, лан, сайн зах торго, бүхэл дурдам хийтэй өргөж аврал мөн өргөсөн бичиг дээр бичиж хайрлав. Эл бүхий явдлыг хийлцсэн..... хамба, хэлмэрч нарт 22, мөнгө 847 бун дай өгөв, 32-р он.... сард хүрээний газар шинэ залан баярын мандал ба, цэдэв өргөхөөр,.....,.... ламын хувилгаан Батсуурь нар одож зааг мандал өргөв, Далай ламтаны хүрээний газар заларч бүхийд шинэ дүрийн хувилгааны эцэг эхийн нэр овгыг зарлан нарийвчлан доторхойлон заалгахаар заасан бичгийн эхэн..... учир лавлахаар мандал өргөн өргөж удаа дараа бараалхасан явдлыг мөнхүү өөр дансанд бичсэн тул,.....үл сийрүүлбэй. Далай ламтан түшээт хан аймгийн жанжин чин ван Ханддоржын хүрээнд заларч ирэхийн хэрд жанжин чин вангын хүрээ ба, сайн ноён аймаг зая бандида хутагтын хүрээ, мөн сайн ноёны хүрээ, засагт хан аймаг бэйс Ёндондоржын хүрээг дайран буцмой хэмээснийг хүрээний сайдаас уламжлан харъяат аймгийн чуулганы даргын газраас тушаасанд 32-р он...сард хэзээ заларч ирэх ба, хувилгаан нь хэзээ хэдүйд заалган тодруулах зэрэг лавлах одсон сойвон Гэлэгдорж дамба донир Литов нар мөргөх мандалд,...лан мөнгө, вандан хадаг.....,.... зоогын харамжинд 3 лан мөнгө, вандан хадаг....., бас харъяат хүрээнд залах эл..... айлтгаж мандалд 10 лан, баранзад хадаг... өргөжээ. төвд ханчид сойвон, ложин нарт талархаж мөнгө...лан, вандан хадаг..... 32-р онд 11 сард жанжин чин вангын хүрээний газар шанзудва Цэвээндорж, хийд хамба Дарав бандида Агваанчойнжүрдондүв, сойвон Гэлэгдорж, донир Сономдорж, аймгаас зарагдсан засаг бөлгөө Өлзийбадаргуулах нарын хамт, Далай ламын гэгээнтнээс шинэ дүрийн хувилгаан тодруулахаар очиход амгаланг олж мөргөхийн мандалд мөнгө 8 лан сунтагийн мандалд мөнгө..... бун бүхэл сайн шар торго..., амгалан олох сунтуг, шавдансолдэв баярын мандал, цэдэв өргөсөн сэлтэсд зан хадаг..... өргөжээ. Төвд хамба сойвон нарт талархаж мөнгө 100 лан....., аюуш

хадаг....., төвд хэлмэрчид мөнгө 10 лан вандан хадаг Далай ламын сойвоноос цай..... шагнаж хүргэн ирсэн.... хүнд мөнгө.....бун, вандан хадаг....., төвд ханчид сойвоноос цай..... ирсэн.... хүнд мөнгө..... бун, сунтуг буух нь..... аврал эрж, дэргэдэл сэтгэлийн.... тахиулж.... мандалд мөнгө....., цэдэв төвлүүлсэн тэр хүрээний аграмба хамба ламын зууд вандан хадаг....., мөнгө....., шавдансолдэв номлосон нь мандалд мөнгө..... бун, өргөлцөв, мөн солдэв бичсэн бичээчид вандан хадаг 1, мөнгө 48 жин өгөв. Хувилгаан дүрийн гэгээний тодруулсан сунтугын бичиг Далай лам өөрөөн мутарлан бичиж ахуйн цагт жанжин чин вангын хүрээний... хамба ламд урд захин айлтгаж бараалхасан хойч харуй бүдий ном түүж өргөхөөр авчиж айлтгасан цаг тохиолдсон ба, бас энэ өдөр миний өөрийн хий морь дэлгэрүүлсэн өдөр тохиолдсон тул, энэ хувилгаан нь ном ихтэй хийморь дэлгэрэн сайн хувилгаан болох амуй хэмээн сайшаасан лүндэн айлтгаж сунтугын бичиг нь энэ өдөр өгсүгэй хэмээн шар хадгаар ороож таван цон саран бурхан багш..... хамтад 11 сарын шинийн 3-ны лхагва гараг, цаг бич, өдрийн тахиа цагт буулган өршөөж хайрлахуйд шар цагаан баранзад хадаг 11ийг давхарласан дээрэн тусч шанзудва хүлээн авч, мөн өдөр савдангын тухай төвлөсөн цэдэв өргөхөд билэгтэй сайн болов хэмээн айлтгасан дараа шавдансолдэв хувилгаанд нэр айлтгасан мөнхүү судар ба, Лувсантүдэвчойжиням хэмээх алдар хайрласан бичгийг шар хадгаар ороож захлагны хамт хайрлаваа Далай ламтанаа хувилгаан тодорсон тухай баярын мандалд зан хадаг мөнгө....., жанжин чин ван танаа баярлаж зан хадаг... бөгөөд олонд баярлаж вандан аюуш хадаг.... барив, шавдан бат байх ба, ширээнд хэзээ залах зэрэг хэдэн зүйлийн аврал айлтгаж мөнгө 10 лан зан хадаг... өргөв, төвд лхаарамба Ёндоноос дүр..... шавдан бат ахуйн аврал эрж мөнгө... лан вадан хадаг....., жанжин чин вангын хүрээний Дайчилэн аймагт аймаглаж мөнгө 10 лан, аюуш хадаг нэгтэй барив, өдөр сонгож харъяат.... анхан сунтуг залж ирэхэд жанбай дээрэн бүрээ

бишгүүр татаж захис хуваргууд угтаж буйн гэж өргөөний давцан түшилгэн дээр залж мандалд зан хадаг, зах торготой өргөв, хойдхонд зан хадаг 1, шанзудва, Даравбандида, дархан засаг Ү нар эхлэн тодорхойлохоор явсан бүгдэд вандан хадаг 11 идээ сэлтэсийг барьж ерөөл бэлэглэжээ. Даруйд сонгож хувилгаан хувилсан газар очиж гэгээнээ цэрэн цэцэн мандал өргөхөд бүхэл мөнгө....., сайн торго 1 зах зан хадаг 1 өргөв, мөн төрсөн эхэд вандан хадаг, зах торго 11, эмгэн эхэд вандан хадаг, зузаан нимгэн цай нижгээд жимс сэлтэсийг өгчээ, мөн ах дүү нарт тушаалын зэргээр тус бүр хадаг өгчээ, мөн өдрөөс өөр өргөө барьж цорж гавжын зэрэг хүмүүсээр сан түй цэдэв судруудыг уншуулж хамгаалах бараа болов. хувилгааныг тодруулахад шавиас явсан шанзудва дагалдсанд вандан хадаг 11, Даравбандидад их хадаг 1, шавиас зах торго 1, дагалдсан хувилгаан лам Буйжинжамба нарт вадан хадаг зах торго 11, дарга засаг Ү-д зан хадаг зах торго 1, дагалдсан 8 тайжид бурган торго вандан хадаг 11 гүдүн хүнд вадан хадаг цай дэлэгбүү нижгээдийг өргөв. Живзундамба хутагтын гэгээнтнээ шинэ дүрийн хувилгаан тодорсон ба, шавдан бататгахыг даатгаж зан хадаг 1, мөнгө 80 лан, 1 жин, жамцогын мандал мөнгө 80 1 жин, зан хадаг нэгтэй, сойвон Шараваар өргүүлбай 31-р он 12 сард Далай ламтанаа баринтаг ган сау газрын хурган дотор 1, мөн дотрын олон хамба нэг зах, гадарын шар хамба нэг бүхэл, гүбүн товчтой мандал 8 лан өргөжээ. эмч хамба ханчин сойвон нарт ач тус хүргэсэн учир талархаж зах сайн торго ган саурын дотрын гүбүн товчтой донир Чүлтүм нараар өргүүлж 32-р он хоёр сарын шинийн нэгэнд Төвдийн цагаан сарын шинэ болох тул донир Ванчогдорж нар жанжин чин вангын хүрээний газар бараалхаж зоог мандалд зан хадаг 2, мөнгө 8 ланг өргүүлжээ. Далай ламтан манай харъяат хүрээнд заларч ирэхийн тэргүүн угтахад жанжин чин вангын хүрээнд очсон самбүн дорж, нараар мандал өргөж 81 2 бун бүхэл мөнгө зан хадаг нэгтэй өргөв, думдад угтахад өгүйн нахурын газар бараалхасан шанзудва нэг бүхэл....., зан хадгыг..

бан хадаг 2, зоогын харамжинд мөнгө 3 лан, өргөжээ, мөн шанзудва хувилгаан дүрийн хаана мөргүүлэхээр айлтгасанд тахилгын өртөөлгэн дээр шинийн долооны өрлөг мөргүүлсүгэй хэмээн айлтгасныг дахин би хувилгаанд санваар өгч... авмой, шинийн 7-оос шинийн 8ны сайн өдөр тул мөн өртөлгөний газар зургаанд ирүүлсүгэй хэмээн, лүндэн буулгасанд шанзудва нар хувилгааныг залж анх мөргөхийн мандалд мөнгө хүрэл зан хадаг мөнгө 100 лантай өргөв, дараа..... мутараар хайчилж санваар хайрласанд баярын мандалд зан хадаг нэг мөнгө 80 лан, өргөсөнд, хувилгаанд санваарын алдарын урьд тодруулан заахдаа хайрласан нэрийг нэгэн хувь бичиж.....5 цун, бурхан багшийг зангиа хадагтай хайрлав. манай газраас манай газраас дамнуурганд хиа лам хаалгач нарын 8 хүнийг дайрбор өртөөний газар сүсгээр хас морьтой бараалхуулсанд таалж ёсоор болгожээ. Сүүлийн угтлагат Тээлийн мөнгөт хошууны өртөөний газар хийдийн хамба Даравбандида ихэс лам нар барсын сүүл, шүхэр, дадартай бараалхаж мандалд нэг бүхэл тавин лан зоог мандалд таван лан, баранзад.....хадаг нижгээд дээд хүрээний газар 3 сарын шинийн долооны өдөр залрахын замд цагаан усны газар дагшаан дээр хоёр хийдээс амгалангийн мандал өргөхөөр цорж Дашдэлэг, дацангын гэсгүй Гэнпил, цэвэлин хийдийн гэсгүй Гэлэгдорж нар мандалд.....шар цагаан хадаг нижгээд мөнгө таван лан өргөжээ. Мөн өдөр заларч ирэхэд хүрээний өмнө дэдэн барьж мандалд...хадаг нэг бүхэл таван лан өргөжээ. Хамба Даравбандида цорж Сономтүдэв нарын цөөхөн ихэсийг мөргүүлж ширээн дээрээн....хадаг тальбиж залрахад Майдарын сүм бүхий есөн... тэргэнд залруулж хийдийн хуварга бүгдээр угтаж бишгүүр чимэг тахилын хөгжим бүрнээ өргөж бүрээ ямбай? дээр татаж лавранаа дунд ордныд залж цагаан лавай солбимол очир хадсан шар торго олбог түшлэг шар цагаан... хадаг 11, зуун амт бүрдсэн идээ жимс, мөнгө зуун лангаар мандал өргөжээ. Хувилгаан лам Сономтүдэв, Гүж лам Батсуурь, тамгын зайсан Хөлөг, да лам Раднаа нарын цөөхөн ихэс мөргөж зангиа зоогын

цай барьсан сэлтсийг хүртэвээ. Дараа манай газраас сойвон Далхжав, донир Чүлтэм, хиа лам, хаалгач нарын зэрэг хорин хүнийг бараалхуулсан. Дараа шинийн найманд тус шавь лавран, хурал яамны хэргэмтэн олон хуварга мөргөхөд зоог мандалд наян хоёр цэн мөнгө өргөжээ. Шавь нарт мөнгө хайрлаад цогчингоос эхлэн булганы сүм хүртэл бүгдэд тааллаар заларч шүтээнд хадаг барьж тус тусын сахиусны сэржимийг гонируудаар уншуулан гонируудад мөнгөн зоос хайрлаваа. Бас шүтээнүүдийн тус тус учрыг нарийн асууж айлдсан бас сүм тус бүрт будаа авчируулж аравнай айлдсан бас удаа дараа дацан бүрд олонтоо сэржим өргүүлсэн. Бас заларч ирсэн даруй удаа дараа дацан сүм бүрд хоёр дахин тавин таван лан мөнгө хайрлаж даатгал хийсэн. Галдан зууд..... хуруулж таван лан мөнгө их хадаг барьсан мөн зууд хамба нар ээлжлэн..... олон хураваа. Зуу эхлэн дацан бүрд заларч Даш өргөж айлдаваа. Заларч ирсэний даруй Лувсанпрэнлэйгийн гүдэнд эхлэн дэргэдийн гурван шүтээнд хадаг өргөвөө. Заларч ирсэн тухай чойрын баярын дамжаа, шавь олноор Сэмжид чог номын рашаан хүртэх, шавь даншиг өргөх эдгээр гурван зүйлийн соёрхолын мандалд мөнгө 15 лан вандан хадаг 6-г өргөжээ. Заларч ирсэн учир баярын дамжаа өргөхөөр айлтгасанд чойрт 4 сарын хориноос хорин гурваны өдөр залрахад чойр лам цорж Дондог, гэсгүй гавж Өлзийт нар..... хийж чойрын дуганд чимэг дэлгэж..... асарт дэвцэгт залруулж..... хадаг найман лан мөнгөөр зоог мандал өргөж басхүү мяндагтай арван хуврагас баранзад хадаг нэг мөнгө найман лангаар зоог мандал ба бэрээс идээ жимс сэлтсийг өргөж тэндээсээ зүүн этгээдэд зассан дэвцэгт заларч миндагва нараас шавь цогчин гэсгүй маарамба Цэрэндорж, гэлэн Цэдэндорж, Дондогдаш, Шаравжамц засаг Мөнх-очирын хошууны хамба Даравбандидын шавь гэлэн Жамсран нарын таван хувраг дамжаа барихад хийдийн хамба Даравбандида Агваанчойнжүрдондов, шунлайв лам Махбал, Намчин нар эхлэн дараалж ном хаясаны дараагаар Төвд хамба нар дараалан

хаясаны дараа нь Далай ламын гэгээнтэн босож эргэлэм эрчимтэй талибаж төгсгөөд ном хаясан Монгол хуварга ба, миндагва нарын таван хүмүүн мөргөхөд тус бүрийн баранзад хадаг зангиатай хайрлаж лавран түгдамдаа залрахад мөн бойноо хийж залармагц лам гэсгүй нарт хадаг хайрлаад дараа нь залруулж миндагва нар мандал зэргийг урьд ёсоор өргөж миндагва нарын шавь гэлэн Шарав, Пунцагбал, Далхаа, Ширнэн, Пүрэвжав нарын таван хуварга дамжаа барьж ном талбьсан нь мөн урьд ёсоор иймийн хоёр өдөр хайрласан. Бас заларч ирснээс залрахыг хүртэл чойроос өдөр бүр хориод хуварга бараалхаж ном заалгасан бас гавжын мяндагыг гэлэн Цэрэндорж, Дамдиндэлэг, Лувсандаш, Цэнджав, Даравбандидаын шавь бөгөөд гэлэн Жамба, бас..... хошууны гэлэн гэцэл нарын долоон хүмүүс мандал өргөж мөргөхөд тус тус бүр зангиа хүртээж олон игчааны номыг сайтар үзсүгэй хэмээн лүндэн буужээ. Гурван сарын арванзургаанд даншиг өргөхөд гардан, бойноо бишгүүр, бүрээтэй цогчинд залж дэвцэгт баруун зуугын их ёслолоор залармагц шанзудва зоог мандал өргөж маргөвөө. Дараа их мандлын Даравбандида, шунлайв Могундорж, хэбай сайн ноён чин ван На, да жүн ван Чү нар өргөвөө. Мөн шунлайв шадав уншжээ. Үүний өргөлт шавиас Алтаночир, мөнгө 2001 лан 3 цэн 5 пун их хадаг хоёртой өргөж даншиг ба сэмжидчог олноор хүртэхийн гурван зоогт есөн лан өргөжээ. мөн бараа бологсод бүгдэд баяр мэдүүлж долоон зуун лан бариваа. Энэхүү даншиг өргөхөд гайхамшигтай билэг болсон нь:

Орос цагаан хааны түшмэл консуль сайд мөн хаанаас зарагдаж ирж Далай ламтанаа бичиг бэлэг өргөсөнд түүнийг Буриадын ноён..... бээр дуудуулж айлдсанд тэрхүү бичгийн дотор Цагаан хаан миний захиргааны буриад нар Далай ламтанаас ном сонсож шажин дор сүслэл бүхүй буй билээ. Тэрхүү буриадаас цэрэгт мордож дайтахад олон орос нэгэн буриад байхад олон орос үхэх байтал гагц буриад амьд гармуй.

Олон буриад нэгэн орос дайтахад гагц орос үхэх байтал олон буриад амьд гарсан хэргийг үзбэл Далай ламтаны адистид бурхан номын аврал иймийн гайхамшигтай мэдэж бүхүйд би баярлан сүслэж захиргаанд буй шажинаа өргөө. Мөнчүү бурхан шажин иймийн аврал ачтай байхыг мэдэж сүсэлсүгэй хэмээн арван хоёр муж оросын ноёдод зарласанаас гадна консул сайдыг бараалхуулж бичиг бариулвай хэмээсэн..... хойно энэ ялдраа Далай ламтан лүндэн буулгасан нь:

Би энд ирсэн нь сайн боловоо, басчуу энэ шавьд сайн амуй сайн боловоос бус этгээд мужын оросын хаан энэ өдөр надад шажинаа өргөсөн, мөн энэ өдөр есдүгээр Чүлтэмжамц Далай ламын жанч халсан их дүйцэн өдөр тохиолдсон нь ийнхүү давхар давхар учиртай өдөр болой хэмээн жанжин чин вангын аграмба хамба, Хачин сойвон нарт айлдсан мөн хамба Даравбандидад айлдсан Даравбандида сойвон Гэлэгдоржид айлдаж ийнхүү уламжлан гаргаж ирсэн лүндэн амуй. Бас Даравбандида гэгээнтэнд энэ мэт дүйцэн бүрт шавь нар олноор өөр өөрийн байшин дээр шөнө зулыг өргөвөөс билэг маш сайн хэмээн айлдсан. Далай ламтан Норовлин хүрээнд анх тааллаар заларч лаврангын сэмчинд сүү жимс дээж өргөж мандалд... хадаг нэг, тавин лан мөнгө өргөвөө, бараа болсон арваад төвд нарт хадаг, вандан хадаг тус бүр арван нэгийг бариваа. мөн хүрээний сүмүүдэд дээд хүрээний сүмүүдэд заларсан нь нэгэн адил заларжээ. Голын ордонд залрахдаа гэгээнтний цагаан чулуун үртэй хашааны ясан шийсэн сийлбэртэй чухам сайн зандан ширээ эдгээрийг тааллааран би хэрэглэе хэмээн айлдсан бас өөрийн тааллаар дээд дүрийн гэгээний бээжинд хийсэн цайтай ширэн олбог жинтүү шинэ хилэн овойдой сэлтсийг хэрэглэн таалжээ. 3 сарын аравдаас эхлэн жанжин чин вангын хошууны аграмба хамба Дандараас Далай ламтан ямандагын түнхарын зүйлийг хэдэн өдөрт зооглосоноос мөн даруй 3 зүйл хотлолыг жамган өврөөсөө мөн аграмба хамба чодбумба Сономлай нарыг бараа болгон бүтээсэн даруй мөн сарын хорин долооноос хоёр

гурван хоногт цас ихэд орж арилсаны сүүлд Далай ламтаны гэгээн Даравбандида гэгээнтний ордонд заларч ирээд энэ орсон цасыг олноор юун хэлэлцэж байна хэмээн айлдсанд Даравбандида бээр:

Ногоон юм дэлгэрэх сайн буй за хэмээн хэлэлцэж байна хэмээн айлтгасанд, энэ сайн энэ нь миний хот мандлыг бүтээсний ёсчилон болсоны тэмдэг мөн хэмээн айлдсан тэр хот мандлын нэг нь манай энд хайрласан Ханддүвийн хот мандал энэ мөн болой бас мөн аграмба хамбаас энд ном зооглохын урд 31-р оны хавар цагт хүрээний гандан дээр заларч байх үеэсэд энэ аграмба хамбад хадаг нэгийг хайрласнаас үүний хэрэг нь зая хүрээнд дээр очсоноос харах болно хэмээн лүндэн болсон үүнийг нь мөн аграмба бээр Даравбандида сойвон Гэлэгдорж нарт өөрөө айлдсан сүүлд гадуурах бараа бологч их, бага төвд нар нийгмээрээ хэлэлцсэн нь:

Жамган хүрээ ба, чин вангын хүрээний газар заларч чөлөө бүхий цагтаа энэ хамбаас энэ номыг зооглолгүй энд ирж зооглосоныг санахуул энэ заяын хүрээ сайн юманд саадгүй нь лавтайяа мөн буйза хэмээн хэлэлцжээ. Бас илүү 4 сарын хуучдаар нэг өдөр:

Жамган булганд Зонховагыг хүртэл заларснаас бууж Даравбандида гэгээнд заларснаас энэ оронд бүтээл бүтэх бэрх нэгийг бүтээвээс амар бүтэх хэн хүнд амар бүтдэгийг бүтээвээс өчүүхэн бэрх мэт буй буй заа. Үүний учир нь:

мод ургаж болохгүй газар мод ургасан, ус гарахгүй газраас ус гарсан буй атал энэ бэлээр модгүй энэ мөн болой. Үүний тул энэ миний тарисан бургасын намайг явсаны сүүлд энхрийлж ургуулваас сайн. бас ч гадуур мод тарисан өвс юун сайн цай хэмээн Даравбандида айлдсан Далай ламтанаас ханчүн сойвоныг зарж Даравбандида, шанзудва нарт бэлэг өг хэмээн 8 цун бурхан багш нижгээд шар улаан цам хошуунд хүж.... багц

хайрлаваа, бас 8 шунлайвд 33 цун бурхан нижгээд цам нижгээд хүж... багц хадаг зангиатай, шанзудвын газар тушааж өг хэмээн хайрласныг тус бүр хүргүүлбэй, үүнд бид нар хайрласан хишигт баярлаж дор бүрээс хандав гаргаж 8 лан мөнгөөр мяндаг өргөв, ханчүн сойвонын 3 хүнд Даравбандида, шанзудва нар...лан барив. Далай ламтан...сарын шинийн...нд баридаг навс солихын баярын хурим дээрэн хамба шанзудва шунлайв нар зоог мандалд... лан, мөнгө хадагтай өргөж мөргөв, хурим дээр бараа болгов, мөн 15 ны өдөр доод хүрээнээ дахин цам дээр тааллаар заларсанд зоог мандалд...лан өргөжээ..... тус бүр хадаг.... лан мөнгөтэй хайрлаж үүнд хэбай амбан ван Чи бараа болон орбай, мөн тэр цамыг гүйцээсний сүүлд лавранд заларч гүнцэг өргөхөд амбан ван, хамба Даравбандида нар бараа болж байхад Далай ламтанаар манай анхдугаар дүр Лувсанпрэнлэй гэгээнээ элдэв гайхамшигийг олонтой айлтгасаны дараа тэрхүү зая Лувсанпрэнлэй түүний сайныг наад захан дээд хүрээг барисан газар үүгээр мэдмой,энэ нь доор оронд хаанач үгүй ганцхан тэрхүү зая Лувсанпрэнлэй олж хүрээ барисан бөлгөө, тийм учраар энэ орон ч сайхан байх бөлгөө хэмээх зэрэг олонтой лүндэн болсон нь хамба Даравбандидаас сойвон Гэлэгдорж сонссон бас илүү дөрвөн сарын арван таванд цогчинд залж сэмжидчог олноор хүртэхэд мянган лан мөнгийг анхны зоог мандлыг Даравбандида, сүүлийн мандлыг шанзудва өргөжээ. Овоо айлдаж гэгээнтнийх урд тавдугаар дүрийн алдар Сандуй хамба хувилгаан дүрийн алдартай цагаан хадаг нэгийн хамтад өргөжээ. эдүүгээ хувилгаан дүр Даравбандида нарын алдар шанзудвын нэрийг шар хадагтай өргөжээ. Мөн 30-ны өдөр сожинд заларч түй айлдсанд мандалд 5 лан мөнгө.... хадагтай өргөжээ. Илүү 4 сарын 25-нд зарлигаар зарагдсан шадар сайд нар ирж 26-нд зарлиг ба шагнал Далай ламтанаа өргөхөд лаврангын үүдэн дээр бага чимгүүд гаргаж мөн хамба шанзудва шунлайв нарыг Далай ламтны хамба ихэсийн хамтаар угтуулан залж ирэхэд төвд нар зүүн сэмчин дээр хөгжим өргөөд залж

ормогц Далай ламтан баруун сэмчингийн гадна угтан гарж торгон олбог дээр сэнтийний өмнө заларч байхад зарлигыг манжаар сайд гүн.... уншиваа. мөн дэд да сайд хятадаар, Далай ламын бичээч хамба төвдөөр уншсаны сүүлд мөн дэд да сайд хятадаар шагналыг дараагаар уншиж зул тахил бүхүй ширээ тавиж барисны сүүлд Далай ламтанаа мөн олбог дээрэн гурвантанаа сөгдөж есөнтөнөө мөргөөд уг дэвцэг дээр, залармагц сайд нар амгалан эрэн хадаг сольж тус тусаа дэвсгэр дээр суусанд зоог идээ хүртэж олон зүйлийн жимс тавьж бүгдэд цэгэм тэрэм шагнаваа эзэний хишиг хүртэхүйд ийнхүү ёсолдог ёс үүний хожим мэдсүгэй хэмээн айлтгасан маргааш нь дацанд заларч эзний хишиг хүртсэн их баярын хурим үйлдэхэд өөрсдийн 9 хүнээр гар цам дэглүүлж хамба лам Даравбандида, шанзудва, шунлайв сойвон Гэлэгдорж нар байсугай хэмээн айлдсаныг дагаж баярын мандалд 5 лан, зоогын харамжинд 3 лан өргөжээ. энэхүү хурим дээр улиастайн хамаарсан жанжин журган нар цөм бараа боловоо. басхүү харъяат газраас ба, давхар мөн ламын газраас дотоод гадаад сайд нар ирэх буцах тус бүр угтаж үдэж хүрээний асараар цай идээ барин ёсоловоо мөн орос улсын сайд консулыг ирэхэд мөн нэгэн адил ёсолжээ. Сайд гүн нарыг морилж ирснийг баяр мэдүүлж сан шавиас цай идээ, буцахад гүн.... бурхан хадаг торго идээтэй сайд нарт идээ хадаг дагалдсанд хүн бүрийн гурван лан мөнгө нижгээд нижгээд хадагтай бариваа. Консул сайдад торго нэг зах хадаг идээ ёсолж бариваа. мөн сайд тамгын газар ирж шанзудвад цэм хадаг идээ зүйлийг хайрласанд шанзудва хувиас хадаг торго бариваа. улиастай хамаарсан жанжин журган нарт морилж ирсэнд баяр мэдүүлж мөнгө 165 лан хадаг сэлтэстэй бариваа. илүү 4 сарын хориноор манай харъяат хүрээний баруун сэмчинд гандангүнсэнлэн хэмээн нэр шагнаж дараа 28 өдөр энэхүү заларч бүхий ордон нэгэнд Пунцагдодгүү гүнчил хэмээн нэр өг гадуур байгуулсан цагаан хүрээг шар өнгөөр болгосугай хэмээн энэ хоёр нэрийг ланз, тарни, төвд, монгол ийм дөрвөн хэлээр сийлж

гадуур хөвөөнд зургаан луу тойруулсныг үйлдэж даруй дотоод сайд ирэхийн урд зүүсүгэй хэмээн лүндэнм өршөөснийг өчүүхэн тухай бүр хичээнгүйлэн дагаж нэрсийг ёсоор гүйцээж цагаан хүрээг шар өнгө болгожээ. Иймийн тул лүндэн дагаж гүйцэтгэсэн явдлыг бүрнээ тодорхойлж чуулганы тэргүүн танаа байцаах тэмдэг болгон мэдүүлжээ. 5 сарын шинэ дээр харъяат хутагтын сүргийн үрс гаргаж Даравбандида шанзудва нар баруун түгдамд үрсний дээжийг өргөсөнд зоогын цай хүртээж мутараар зоогын тамхыг хайрлаж хадаг зангиа хүртээвээ. Мөн шинэ дээр Далай ламын гэгээнтний тааллаар энэ гэгээний анх гэгээн Далай лам Банчинэрдэнэ бид нарын багш болсон ба басчуу энэ тухай миний ирсэн тохиолдсон тул энэхүү 5-р дүрийн гүдэнг би засамжлан үйлдмүй хэмээн айлдаж дараагаар гүдэнг олноос нууцлаж сэмээр толилон үзсэнээс хойно тийн атал илүү 4 сарын 28-ны үдэш цагаан гэгээтэй байхад Далай ламтаны лаврангын баруун сэмчингийн дээд давхар хойт этгээдэд зассан зарлага? дээрээ ном тавьж хойш хандаж болгоомжлон үзэж байхын цагт цагаан Цамба бурханы дүрээр бараалхаж би эндэх хүрээний шажиныг сахиж буй энэ 5-р дүрийн гүдэнг даруйхан засаж аравнайлж хайрла удаваас шинэ дүрийн хувилгааны шавданд цөв бололтой байна хэмээн айлтгаж басхүү олон зүйлийн айлтгал айлтгасан мэтэд тэр үдэш сойвон Ханчиныг ирүүлж цамбын тийнхүү айлдсаныг айлдаж даруй дор цамбын цогчид сэндор бэлтгүүлэн жамган өөрөө уншиж өргөсөн гэхийг сойвонгоос сэмээр нууцлан сонссон агаад дараа 29 би гүдэнг даруйд засмуй хэмээн шавдсаар ажуу 5 сарын шинийн нэгнээс эхлэн таван хүртэл, дээд ламын шиш тохиолдохгүй өдөр сонгуулсугай хэмээн айлдмагц өдрийг сонгуулбаас мөн шинийн 3-ны өдөр даваа гараг цагаан хулгана өдөр сайн гэхийг айлдсанд мөн өдөр Далай ламтанаа дагалдсан сойвон ба, эмч хамба эл зэрэг 4 хуваргын хамт гүдэнг нээж дэлгэр түй өргөж эхэлж шаваас нь жимчидийн тарни шүншиг нарийг нягталж төгсгөөд ихэд баясаж, лүндэн болсон урд дээд ламын ямарчилангаар

нирваан болсон ёс нирваан болмогц ямар ном уншсан гүдэн ямар янзтай залсан нямба тайлснаас бүрцаа шаваас өргөсөн ёс гүдэнгийн дотор өргөсөн эмийн зүйл, лавтайяа занданшиж гүйцсэн хэмжээ хэдүйд болсон тэргүүтнийг сойвон Гэлэгдоржоос нягтлан асууж айлтгасанд мөн сойвон тус бүрийн хийсэн ёсоон айлтгасанд энэ мэт ёсчилон болдог нь төвд оронд ч чухам номын ёсоор болжээ тийн боловч дээд дээд Далай лам нарын гүдэнгүүдийн мутрыг зүрхний тусад солбиж хонх очир бариулсан байдаг, энэ 2 ламын гүдэнгүүдийг тэр мэт болгож занданшуулах хэрэгтэй, нямбанд заларч ахуйн тэмдэг гүдэнгийн зүрхний хараалдаа хэсэгт бүлээн байдаг, бас дээр доороос буусан тэмдэг түүний тус тус үрэл хийж хадгалбаас чухам жансүмгармарын үрэл тэр мөн амой, та нарын дагаж хийсэн тэр ном лаврангын зүүн гомон гэгээний зохиол мөн буй энэ мэт дэлгэр гарсан үүгээр өөр байдаггүй. Энэ нирваан болсноос эхлэн миний энэ үйлдэх ёсыг ном болгон бичиж хадгалбаас ихэд тустай бөлгөө. Би урьд өөрийн багшийн гүдэнг засаж үйлдсэн Лин бүрэлгүүгийн гүдэнг засахад жимчидийн тарни дахин дахин наавч унах мэтийн их зөвчөө болж би ч мардан хийж гүйцсэнээс миний бие өвдсөн лам Жамбаринбүчи гүдэнг засахад ер зөвчөө үгүйн энэ гүдэн мэт сайхан болсон. Лин бүрэлгүүгийн гүдэн тэр мэт болсон нь ламын зарлиг түгдамд харшсан тангараг буурсан шавь бараа болж байсан ажгуу. Лам Жамба ринбүчийг гүдэн сайхан болсон учир чухам ламын зарлиг таалалд нийлсэн шавь бараа болсны учраар тэр мэт болсон. Одоо энэ гүдэн ч та нар ламын зарлиг түгдамд ёсчилон нийлсэн учраар ийм сайн болжээ. Хойшид ламын дэргэд ба гүдэнгийн дэргэд тангараг ариутан шавь бараа болох хэрэгтэй энэ үе би ямар болноо хэмээн баахан зовнисон. Энэ жимчид сүншигийн тарнийг наалдуулахад амархан мэт боловч хэцүү цөвчөөтэй байдаг. Одоо сайхан болж санаа амар боллоо. Ер буян үйлдэхэд ламын гүдэнийг өргөмжлөн тахисаны буян их тиймийн тулд би ч их буян хураамуй хэмээн олонтой лүндэн болж баясахын дүр үзүүлж

байхад эмч хамба лам хэмээсэн хар үрэл авчирч сойвон Гэлэгдоржид өгч үүнийг гүдэнгийн баруун талын доор хавдар байх газар түрхсүгэй хэмээж түрхүүлсэн. Энэ учир болвоос уржигдар шөнө эмч хамба би зүүдлэсэн ану гүдэнгийн дэргэд ирсэн нь миний өвчин энэ чи надад эм өгсүгэй хэмээн бөхийж баруун талаа надад үзүүлбэй. Басхүү олон зарлиг айлдсан энэ гэгээний аль явдал зүйл бүхийг би мэдэж гүйцсэн хэмээн хэлснийг сойвон Ханчун мөн Гэлэгдоржид хэлснийг сонссоноос гадна Жамган өөрөө заларч өөрийн шар хэв хадгаар гүдэнгийн бүх лагшиныг ороож самбой дамбой хэмээх сайн хүжийг талхалж бас адист эмийг хольж зуураад Жамган өөрөө эхлэн сойвон Ханчун эмч хамба төвд зурхайч Цэрэндондог монгол сойвон Гэлэгдорж донир тойн Жанчивринчин хиа лам Диштайбазар, соёгва Содов, галч Дорж нар шаваасыг өргөн мөн өдөр төгсгөж басхүү нигуурыг сэрүүн бүхүй дүрийн адил болсугай хэмээн Жанчивринчин, Диштайбазар нарт лүндэн айлдаж орой болмогц түйн үйлдвэрийг уншиж навсаа банзай өргөж самудагт залж хоноод маргаашын шинийн 6 ний өглөө мөн урьд мэт түй айлдаж навсыг авч толилон урьд өдөр энэ гүдэн баруун тийш бага хазгай байсан нь тэгширч хоножээ хэмээн ихэд сайшаан ийм гайхамшигтай болсон. Мөн өдөр нигуурыг алт болгон шаваад шаваасыг хатаахаар гадна нар салхинд өчүүхэн талбиж залсан лагшингын дээр доороос тос нэвтэрсэнд алт өргөхөд болохгүй дургүй юмуу хэмээн өчүүхэн ундууцахын ёсыг зохиосон даруйханаа тос нь дотогшоо шингэсэн тэр үесэд үзсэн төвд монголчууд ийм гайхамшигыг үзэж хэлэлцээд алтадхын дэвсгэрийг түрхэж орой болмогц урьд мэт залсан шинийн тавны өглөө урьд ном айлдаад харъяат шавиас 600 хуудас алт төвд Ханчун сойвон сүсгээрээ 300 хуудас алт өргөснийг нухаж дэвсгэрийн ёсоор түрхсэний дээр Жамган өөрөөсөө зуугын нигуурт өргөдөг дигү хэмээх алт нэг бүр нэг лан мөнгөний үнэтэй энэ алтыг хичнээн хэд болохыг үл мэдэх атгаар хийсэн алтыг нухаж бүх лагшинд 3 дахин өргөж хатмагц энэ өдөр Далай лам

миний төрсөн өдрийн баяр тохиолдсон тул мэлмий нээхийг ихэд хичээвч бороо хур нойтон чийгийн эрхэнд хатаж гүйцсэнгүй. Алтыг өргөсөн үүгээр болмой хэмээн лүндэн болж бас тэр үе тэнгэр их дуу гарч хур их буусанд гэгээний тунилхаа юу буй хэмээн сойвон Гэлэгдоржоос асуун айлдсанд таван хаан хэмээн айлдсанд миний тунилхаа Чойжижалбуу хэмээмой түүнийг сонссон буй хэмээн зарлигласанд манай энд шүтдэг билээ хэмээн айлтгасанд түүнийг энд яагаад шүтдэг билээ хэмээн айлдмагц гараг чойжидын нөхөрт буй билээ хэмээсэнд ай тэр их сайн хэмээн таалан бас миний төрсөн газарт ширзан хэмээх маш догшин алибан нэг буй тэр энэ өдөр заавал ирж байдаг занг ин монгол газар орхисонгүй тэр ирэх бүрт тэнгэр ихэд дуугарч бороо орж тэнд боловоос тэнгэрийн сум буулгадаг тэр нь муу бус эдүүгээч тэнгэр ихэд дуу гарна буй хэмээн айлдсан дараа тэнгэр ихэд дуугарч бороо орсон. маргаашнаас чухам ёстой сайхан бороо орно буй хэмээн айлдсан дараагаар дацанд заларч мэндлэсэн баярын хурим хийвээ. Тэр орой гүдэнг урьд мэт залж хоноод шинийн 6,7-ны өдрүүдэд урьд мэт ном айлдаад үргэлж залран олонтой зарлиг өршөөж орой бүрт өөрөө заларч урьд мэт залсан шинийн 5 наас эхлэн шинийн 8 хүртэл шөнө тасралтгүй зөөлөн бүлээн хур орж ус мөрөн бүр ихэд үерлэж үр жимс бүхий дэлгэрч онц гайхамшигт бэлэг болсон. Мөн шинийн 8-ны өдрийн өглөө урьд мэт заларч ном айлдаад үдшийн хэрд сайн цагийг тохиолдуулан төвд зурхайч Цэрэндондог бээр мэлмий нээлгүүлэхэд алтаар нээдэг ёс нь урьдын Гаадамбын дээдэс лам нарын ёс тэр мэт, Богд Зонховын гүдэн, Далай ламын дээд дүрүүдийн гүдэнгүүдийн мэлмийг тэр мэт нээдэг ёстой.....Энэ мэт хэрвээ бурханы мэлмий боловоос хөх буюу хараар нээх хэрэгтэй тэр мэт ялгал буй хэмээн лүндэн болж мэлмийг нээхийн сацуу тэнгэрийн хур арилж гийсэн хатсан булгуудын ус гарсан мөн гаыхамшигтай болсон үүнд шавь бүхнээр баярлаж Жамганд.... шар цагаан хадаг нижгээд бүхэл шар торго нэг, үзэх бие байвч ургуулан үзэж чаддаг гайхамшигт дуран нэг

бэлэглэсэн бэлэгтээ бичгийн хамт өргөвөө. Зурагч Цэрэндондогт....хадаг мөнгө 10 лантай барив, эмч хамба сойвон Ханчун Чодбумба Сономлай нарт бид хадаг тойног мөнгө тус бүр нижгээдийг бариваа, хамт урласан манай хүмүүст мөнгө хадаг сэлтэстэй бариснаас гадна үүнд Далай ламаас төвд зурагч Цэрэндондогт энэ гүдэнг засах өдрөөс эхлэн төгсөх хүртэл мах бүү идсүгэй хэмээн лүндэн болсныг төгсөх өдөр мөн Цэрэндондогоос сойвон Гэлэгдорж сонссон агаад иймд энэ мэт ариутган залж авбаас сайн гэхийг өчүүхэн ухамсарлан мэдэвээ. Бас лүндэн болсон нь:

Би лаахар хэмээх өмнө зүгт явахын далимд Таавраг хийдэд очсонд урьдын..... гүдэн энэ мэт лагшинг шавж алт өргөж сайхан..... үзсэн тэр зүгт өвчин зовлон үгээгүй ядуу ган зуд хэзээч тохиолддогүй ном ертөнц алины талаас ч төвдийн нутаг бусад бүгдээс дэлгэр байдагыг гүдэн түүний ач мөн. Тийн атал Тим номун хан төвдийн хаан суугаад гүдэн түүний зүүн мутрын махнаас огтлож авсаны учраар жил дараалан өвчин тахал зуд турхан болж тариалан алдах тэргүүтэн үргэлжид болсонд би тэр гүдэнг хуучин ёсоор сайхан засамжилсугай хэмээн тушаагаад нааш ирсэн. Гүдэн түүнийг засамжилснаас урьд мэт сайхан боллоо хэмээсэн бичиг энэ жил ирлээ. Энд ч энэ гүдэнг энэ мэт сайхан засамжилсан учраар энэ доор зүгт шажин төрд улам сайн болохын дээр хувилгаан гэгээний шавдан бат хийгээд үйлс зохиол бүгд дэлгэрэх магадтай хэмээн айлдсан бас гэгээний шүтсэн бурхан юу хэмээн айлдсанд жигжид, янсан хоёр билээ хэмээсэнд амирлангуйн бурхан юу шүтдэг буй вэ хэмээсэнд Цагаан дарь эх билээ хэмээн айлдсанд хувилсан уг нь ямар бурхан хэмээдэг буй хэмээн айлдсанд Жанрайсиг хэмээдэг билээ хэмээн айлтгасанд тиймүү мөн буй за суварганы бумбаны бурханыг нь мянган мэлмий мутарт Жанрайсигыг бүтээвээс сайн түүний учир боловоос бусад Далай лам нарын гүдэнд Жанрайсиг алин болох магадгүй боловч 5-р Далай ламын гүдэнгийн суварганы бурхан мянган мэлмий мутарт Жанрайсиг тэр байдаг

тул үүнийг ч тэр мэтээр бүтээх хэрэгтэй хэмээн айлдсанд сойвон Гэлэгдорж бээр гүдэнг ил залсан, суварганд битүү залсан энэ хоёрын аль нь ламын шавдан болоод шавь олонд өлзий билэг ану их байдаг боловуу хэмээн айлтгасанд эл залсаны сайныг би тэргүүн үзүүлсний гүдэнгээр үлгэрлэж хэлсэн тэр мэт боловч энэ үе яах хэрэгтэйг хягт шинжилснээс хариуг хожим хэлсүгэй хэмээн айлдсаны хойно 4 хоносоны сүүлд гүдэнийг эл залваас сайныг урьд чамд хэлсэн мэт боловч энэ доор газар орос буруу номтон хамаагүй хэрж явдаг тул алсдаа суварганд залаваас бат мэт байх тул руьдын хэлсэн бумбаны бурханыг нэг төө хэмжээтэй бүтээж гүдэнгийн зүрхний харалдаа билэгийн бодьсадвын ёсоор залаад бумбаны үүдээр гүдэнгийн тэргүүнийг ил үзэгдэхээр залтугай хэмээн айлдсан дараа маргаашын шинийн 9-өөс эхлэн 11-ний хүртэл 3 өдөр Далай ламтан унзад лам жүд хамба ламдаж төвд 10 хуварга, монгол Даравбандида, сойвон Гэлэгдорж, соёгва Содов, галч Дорж нарын 4 хуваргатай өдөр төгстөл ямандагын үүднээс гүдэнг бүтээж аравнай хурж аравнайлсаны зэдэнд Далай ламтанаа...хадаг зах торго ембүү нижгээдийг өргөв бусад хуваргуудын зэдэнз тус бүр хадагтай мөнгө хориод лан барив. Зул тахил ба зоогын харамжин тус бүр 99 лан өргөжээ. Мөн өдөр Далай ламтанаас хамба Даравбандида, шанзудва нарт зангиа их хадаг хүртээснээс гадна бас сойвон Гэлэгдоржид зангиа их хадаг мөнгө 20 лан, Содов, Дорж нарт вандан хадаг 11 мөнгө 10,10 лантай хүртээсэн. Гүдэн сайхан асарсанд шагнасугай хэмээн лүндэн болсон маргаашын 12-ны өдрөөс эхлэн буцаж залах хүртэл лаврангын шүтээн сүмийн дээд давхарт өдөр бүр хэд дахин заларч сойвон Гэлэгдорж нарт олон лүндэн айлдсаны дотор нэг үе сүм түүний дээд давхарт залсан Банчин эрдэнийн тунравын 14 хөргийг болгоомжилсноос энэ хөргийн 1 зураач хүн нь хэдэн өдөр зурж төгсгөмүү хэмээн айлтгасанд сайн шамдан зурваас 20 хоногт төгсгөх боловуу хэмээн айлтгасанд тэр нь мөн энэ боловоос 5-р Далай ламын үесэд Манзуширын хувилгаан.... хэмээгдэгч тэр

рид хувилгаанаар нэгэн өдөрт ийм хөргийн 1 зах шалхив сэлтэстэй гүйцэтгэж байсан түүний зураг мөн энэ төвдийн оронд ч ховор тул энхрийлэн залж байваас сайн үүнийг нь тавдугаар Далай ламаар зая Лувсанпрэнлэйд хайрласан нь магад буй за хэмээн айлтгасанд энэ адилаг нэг Дэмчигдацангын ничийн сүмд буй билээ түүнийг 7 Далай ламын үед хайрласан хэмээн айлтгасан бас ничийн сүмд хэлбэр маягыг нарийвчлан авч зуугын газар энэ мэт намжрай дацанд үйлдмүү хэмээн айлтгасан бас сойвон Ханчунаар Живзундамбын 5-р дүрд 7-р Далай лам Жамбалжамцын гэгээн хайрласан нэг буй хэмээн айлтгасанд аяа монголд ийм олон буйн маш сайн төвд оронд цөөхөн болсныг би хаана буй байсныг цуглуулаад өнөө маргааш тив шүнд цөөн цугларч буй энэ хөргийг үргэлжид шалхивыг буулгаж ар өвөрт нь хөшиг татаж байсугай жилд нандин нээх нэг өдөр нээж байсугай. Одоо энэ үе энэ гүдэнгийн тахилга, бие энд байх их дүйцэн мөн тул энэ хэвээр нь агуулаад намайг явсаны сүүлд битүүмжилсүгэй хэмээн айлдсан. Басчуу ер аль ч газрын хөрөг бурханы шалхивыг битүүмжилж тогтоолтой нэг өдөр нээж аваас сайн хэмээн өнөгө хэвээр залагдаж залах цагт суварганы тэнд шавь нар олноороо түйний жандиныг татсаар хөгжим сэмбэрэм бойноо өргөн угтаж салашүн? хэмээхүй лугаа сацуу суварганы сэнтий дээр залснаас миний уншдаг мэт түйг дэлгэр өргөн банзай титэмийг уншлага лугаа зохилдуулан өргөөд хойш сүншиг болоод суваргыг гүйцэтгэсүгэй. Суварганы доторч ламын лагшингын хэрэгллийг юу таалж хэрэглэж байсан бүрийг залах хэрэгтэй. Түүнээс дэлгэр аравнай 3 хоног хийж мөн энэ өдөр хэв нарыг шинэ талбиж тэрийг ч эхэлж тогтоодог ёстой. Энэ мэт их нягт зарлигыг дахин давтан..... өршөөсөн. Бас чуу буцаж залрахын урьдахнаа хийдийн сүм шүтээнд хадаг барихаар цогчинд заларч зуугын өмнө хадаг өргөж энэ хурж буй хурал юу мөн хэмээн айлдсанд маани бүтээж байх билээ хэмээн айлтгасанд намайг явахад энд маанийн бүтээл бүтээж буй тохиолдсон энэ билэг маш сайн хэмээн айлдаж бас сүм шүтээнд

өргөсүгэй хэмээн хадгыг хайрласанд цөмийг өргөж гүйцэтгэсэн. Мөн тэр даруй гүдэнгийн дэргэд заларч хадгыг талбиж заларч хараад шүтээн сүмийн үүдэнд 3 эргэж залбиран заларсан. Залрахын урьд 5 сарын 26-ны өдөр гүдэнгийн дэргэд сойвон Ханчунгын хамт заларч хамба Даравбандида, сойвон Гэлэгдорж хоёрт би танай хоёр хүнд амь захиа захисугай хэмээн миний дээд дээдэх лам нар шажины эзэн болсон учир бурхан нирваан дүрийг үзүүлэх цагт Жанрайсигт шажингүй газрыг чи гийгүүлсүгэй хэмээн айлдсан мэт төвдийн оронд шажиныг эхэлж дэлгэрүүлснээс эхлэн эдүгээ намайг хүртэл шажины эзэн хэмээн сайшаасан бөлгөө. Энэ халхын оронд боловоос эртнээс шажин дэлгэрсэн боловч гүйцэт дэлгэрэхдээ мэт байх тул би биеэрээ яахавч нэгэн ирэх хэмээн санаж аталаа энэ үед яавалч ирэх хэрэг болсон учир дээд ламын нирваан үзүүлэхийн учир ухаж атал өчүүхэн цагийн үймээн болж шалтаг тохиолдон гарч ирсэн энд ирсэн тухай учир хэрэг тэр мөн. Энэ ламын дээд дүр нар боловоос миний дээд лам нартай үе дараалан барилдлага маш их буй учраар би ч дээд ламын гүдэнг гардан зассанаас аль таалал бүхийг гүйцэтгэсэн одоо ч энэ хувилгааны аль явдал зүйлийг гүйцэтгэе хэмээн саначухуй. Санасан мэт байх хэмээн горилмуй хэмээхээс эхлэн хувилгаан дүрийг бойжуулах ёс ба эрдэм ном зооглуулахын зүйл, бараа болоочин ямар мэтийг бараа болгох ба бас энэ хийдийн дэг дэглэм ариутган нарийн нягт болгох учир алс хэт ямар мэт болохын сайн болохын зүйл бүхнийг маш дэлгэр айлдсан лүндэн зүйл тусгай төвд бичигт тодорхой буй тул энд үл сийрүүлвээ. Мөн энэ дараа олонд тушаал тушаасан зүйл ч үүнд товчын төдий бичсэн нь: Далай ламын гэгээнээс бидний хамба шанзудва, шанлуйв нарыг дуудаж тушаасан нь: эдүгээ би ирж урьд гэгээний гүдэнг үйлдээд төгсвөө энэ хувилгааныг найм, есөн нас хүрэхэд баруун зуугын газар явуулсугай би сурсанаа зааж өгмүй явуулахыг та нар мэдсүгэй очсон хойно би мэдсүгэй энэ хувилгааныг Лувсанпрэнлэй мэт лам болгох буй за хэмээн горилмуй. Энэ хувилгаанд ном зааж

багш нь болсугай хэмээн тааллаар айлдаж Даравбандида гэгээнд хадаг зангиа хайрлаж басхүү хааяа багш нь эзгүйд зааж байсугай хэмээн сойвон гавж Гэлэгдоржид хадаг зангиа хайрласан бас та нар энэ хүрээ хийдийн аливаа явдлыг хичээ Богдын хүрээ энэ хоёр шажины хоёр нүд мэт тул ийм хийдүүд залихай боловоос бус бага хийдүүд сайн бус болмой хэмээн айлдсан харъяат хоёр хийдийн шүн сан жас нярцангуудын хишгийн сав ба сахиус дүвлүүлж аравнайлсаны зэдэд мөнгө тавин лан,..хадаг нэгтэй өргөжээ. бас мутрын гэгээний 30 гаруй хадагт залж хийдийн сүмүүдэд тус бүр дайлгаваа. Банчин богдын гэгээнээс сойвон Гачин нарыг зарж манай хүрээний газар Далай ламтанаа шинийн 7-ны өдөр даншиг өргөхийн хуралд манай хамба шанзудва, шунлайв хоёр гэвхий нарын 6 хүмүүнийг хуралцуулж мөн хурим дээр бараа боловоо үүнд бараа болсон төвд нар олноор Банчин богдоос Жамганд даншигыг өргүүлсэн эндэх оронд тохиолдсоныг онц гайхамшиг их билэгтэй боловоо хэлэлцсэнийг сонсоовоо. бас 5-р сарын 14-нд Норивлин хүрээний майдарын цамын тэгд залараад тэндээсээ голын ордон дээр залрахад сойвон Гэлэгдорж бараа бололцож очсонд орон өргөө бүхийд хэсэж залараад ямар хэрэг бүхийг гүйцэд....айлтгасанд хэрэв мэдэх зүйлээ айлтгаж үл мэдэх зүйлийг мэдэхгүй хэмээн айлтгасанд долоон их сэмчинд заларсанд тахилын жасаас мандалд тавин лан их хадаг нэгтэй өргөж бас айрагны дээж өргөж сойвон Гэлэгдоржоор тэрхүү хурал жас тогтсон учрыг нарийвлан айлтгасанд дээд ламаар миний энд ирэхийн учир юун айлдсан буй хэмээн айлдсанд тэр үесэд мэдсэнгүй хожим ухамсарлаваас хулгана жилийн цагаан сарын шинийн нэгэнд энэ хурлыг эхэлж тогтсоны маргаашын шинийн хоёрны өдөр Ламуучойжин буугаад дээд ламын дэргэд бараалхасанд тэр үед сойвон би додом байсан билээ тэр цагт гэгээнтэнээр миний энэ барисан орон тогтсон хурал сэлтсийг лам Доржчаныг энэ заларч ирэхийг хүртэл шамшайхгүй байхыг цамба та мэдсүгэй би ину тэр цагт дайралдаж байх эсэх магадгүй тул тэр цагт би тохилдож

болох боловуу хэмээн айлтгасанд ламуучожин бээр айлтгасан нь: таны урьдын барилдлагаа ерөөл нэн зузаан буй тул заларч тохиолдож болноо тэрхүү таалал бүхийг гүцэтгэхийг цамба би мэдэе хэмээн айлтгасан. түүнд өчүүхэн миний бие ухамсарласан нь манай дээд ламын багш Лавжамгандоржчан буюу Шинсаадоржчан алин болох нэгэн хувилгааны дүр нараас заларч ирэх мөн буй за хэмээн ухамсарласан билээ. басчуу Ламдоржчаныг заларч ирэхэд хийх буюу энэ хуралд би өөрөө суух биш бус хэмээн олонтой айлдаж байсан нь одоо ухамсарлаваас Жамган энд заларч ирэхийг ил айлдсан омтоггүй боловч тэр цагт таны энд заларч ирж маньг өршөөж болдогыг огт санаанд багтсангүй хэмээн айлтгасанд ихэд баясахын дүрийг зохион дээд лам миний ирэх учрыг магадтай ил болгоомжилсон мөн байнаа. энэ лаврангын олон өргөөн миний дагалдагсадыг доор бүр нь буулгаваас илүү дутуугүй таацаж байхын дээр миний өөрийн суух яамлах мөргөл хайрлах асар хүртэл цөм бүр таацаж байх тул үүнийг нь надад бэлтгэсэн нь магадтай буй үүнийг үйлдэхэд хичнээн түмэн лан мөнгө орсоньг мэдмүй айлдсанд, удаа дараа о олон жил хийсэн тул жил бүр хэд хэдэн мянган лан зарж байсан багцаалж санаваас нэлээд олон түмэн лан зарсан боловуу хэмээн айлтгасанд энэ айлдсан учир бүхийг Жамган өөрөө эмч хамбад айлдаж бараа болсон төвд нар бүхий аяа жавсуучи дээд лам нэн гайхамшигтай хэмээн хэлэлцсэний дараа, Жамган бээр лүндэн болсон нь, эдүгээ энэ үе би энд суусангүй дээд хүрээнд суусаар болноо, үүнээс урагш энэ хүйсний думдах орчимыг чухам сайн гүйцэлдүүлээд гадуурах илүү олон өргөө савыг хураан авч уг гадуурах энийг хэвээр агуулж олон зүйл мод цэцгийг тарисугай, энэ нь зун цаг миний сэрүүний орд Норовлингаа хэмээдэг буй түүн лугаа адил сайн болноо, хувилгаан гэгээнээ чухам зуны буюу халууны цагт цөөхөн хоногт томоотой сайн цөөхөн бараа бологчидтой залруулсугай, энэ хурлыг ч үргэлжийн заларсан тэр сэмчинд хувилгаан гэгээний залрахыг хүртэл хурж байсугай, энэ ордонд

муу хүн суулгалгүй ариун цэвэр байлгатугай хэмээн лүндэнлэсэн. Мөн 15-нд Норовлин хүрээний майдар дээр залраад Цамчин бүгд ба үйлдвэр хийсэн лам нар бүгдэд хадаг мөнгө, бас хамба шанзудва, шунлайв нарт хадаг зангиа хайрлав, мөн 18-нд цогчинд залж аймаг даншиг өргөхөд мөн ноёд ард хамт хам шонзудва шунлайв нар мөргөлцөвөө, энэхүү даншигын наадам дээр манай шавиас Далай ламын алдар дээр барилдсан Аюушжав, Галсан тэргүүлдсэн бөхийн отгыг орсонд шар цагаан хадаг зангиа цэгэм мөнгө хайрлажээ. Бөх тарсан даруй сайн ноён чин ван На дэд да ван Гү жанжин түшээ гүн Га шанзудва Цэвэгдорж нар түвдэнд бараалхуулан тус бүр дэвсгэр тавьж цай идээ хүртээж хадаг зангиа хайрлаваа, хурдан морин дээр тус шавийн Балжинжавын 2-р дээр гүйсэн нэг морийг шар ногтоор ноглож шар хадаг уяж өргөсөнд Далай ламтан ихэд таалсан байдал үзүүлэн шанзудваад хадаг зангиа ембүү нэгийг наадам төгссөний даруй дэргэд хайрласныг мөн Балжинжав нарт өгөвөө, энэ наадам төгссөний дараа хувилгаан Батсуурид таван давхар дэвсгэр мөнгөн завъяа гүртэм Даржаад цол,гавж Дашдондог Буянцогт нарт дэвсгэр, зайсан Баточирт нягтбилэг цол дэвсгэртэй ийнхүү тус тус олгожээ. Далай ламтаны буцаж залж ирэхийн урд өдөр хамба шанзудва шунлайв нарын арваад хүмүүс Шавдансолдэвийн лүн хүртэж залрахын мандалд 500 лан мөнгө өргөвөө, 27-нд хөмба шанзудва шунлайв нарт Сэрэг бурхан 11, зангиа хадаг хүж цэгэм хайрлав. бас орон олныг дайлсугай хэмээн өөрийн навс битүүмж шар торгон вадантай нэг хуваргын чуулган хурах сахиус нэгийг Цогчин дуганд, мөн үүднийдотор залсугай хэмээн хайрлаваа, бас Норовлин хүрээнд битүүмж шар торгон вадантай навс нэгийг тахисугай хэмээн хутагт лам хувилгаан Дамбийжанцанд хайрлав, дараа баруун сэмчингийн дээр шанзудвыг бараалхуулан лүндэнгээр айлдсан энэ сэмчинд миний орхисон 21 сэргэ Дарь эх, Данжуур гүйцэд нэг, дотоод навсай нэг бүтэн иймийг орхивой. Мэлмийний саравч нэгийг зарлиг захиагүй орхисоноос гадна Дарь эхийг эндээс бүү

шилжүүлсүгэй худвилгаан суувч энэ хэвээр байгуулсугай хэмээн мишээн зоогын тамхийг мутраар хайрлах зэрэг өршөөл хайрлаад залрахад залж ирсэн мэт залруулан хүрээний өмнө барисан асарын амныг хийдийн зүг хандуулан барьж залаад зоог мандал өргөж шунлайв Намчин, сойвон Дамба, цогчин Аграмба хоёр гэсгүй мөргөвөө, ширээн дээрээ баранзад хадаг тавьж залраад ман өдөр цэцэрлэгийг голд дагшаан дээр хувилгаан дүрийг мөргүүлэхэд мандал кзоогын харамжинд мөнгө 103 лан... хадаг нэгтэй өргөв мөнчүү хувилгаан дүрд ном сонсуулахын айлтгасанд энэ удаа байяа хойтын билэгийг бодъё хэмээн сэргэ бурханыг хадаг зангиа цэгэм тэрэм хайрлаваа, нутгийн захад зоог мандал өргөжээ. Далай ламтанаа бараа болсон Найчүнгийн гүртэмбэ гүжир хамба Ханчин, жүд хамба, дүнег хамба, эмч хамба, ханчин сойвон, донирчин хэлмэрч Банчин богдын сойвон Гачин нарт дээлийн гаасуу газрын хурганы арьсан дотор 4 мөн арьсан урт хүрэмний дотор 2 мөн 40 лан тус бүр хадагтай бариваа, залрахад сайн ноёнтоны хийд хүртэл үдэж бараа болсон шанзудва хутагт лам донир нэг хаалгач 2, хөтөл 3 явуулваа. манай хүрээнээс сайн ноёнтоны нутаг булган хошууны 3-р өртөөн дээр Далай ламтан айлдав хэмээн Ханчин сойвон шанзудва Ц-д хэлсэн нь: Дээрээс миний зүүдэнд сайн боловоо манай хүрээ шавь сайн байнаа би дагалдсан донир хма лам хаалгач нараас баруун зуугын газар авч явна байхаа чи шанзудватай хэлц хэлэлц хэмээн айлдсаныг шанзудва таалал юугаан боловоос даган баярламуй хэмээн айлтгуулаваа, мөн өдөр сайн ноёны хүрээнд залраад хэд хоносны хойно дотоод санд бараалхаж байтал мөн соавон урд айлдсаныг юун санаж амуй урд бидний газраас аливаа хэргийн учир зоригдож ирэгсдийг халхын хүрээний газраас гүйцэтгэж явсан удаа буй боловч энэ удаа үгүй тул би эд нарыг авч явмуй тэр явах хүмүүс тийн ийн санах ба газрын сүр хорноос айх хэрэггүй харин та нар тэнд очоод сууриших аваас би баярламуй буцах гэхүүл хэрэгллийг сүн сан хамаагүй би өөрөөсөө бэлтгэж хүргүүлмой.

Хутагт лам тэд нарыг цөм дараа буцаа шанзудва чи ачнаа хэмээн айлдсаны дараа хутагт тэд нар бүгдийг бараалхуулан мутраар зоогын тамхи идээ сэлтсийг хүртээж урдын шанзудвад 14 хнийг бараалхуулж лүндэн айлтгасанаа бүрнээ айлдан буцаасан. 5-р дүрийн гонзогт Банчин эрдэнийн гэгээнээ өргөх зүйлийг даруй гүйцэтгэж чадахгүй учир, Далай ламтанаа айлтгасанд бичиг дагуулан шүнд тушаасугай хэмээн айлтгасан тул, урьд дүрийн гонзог, эдүгээ дүрийн шавдан бататгахын хамтран дагаж бие мөнгө 100 лан, 500 лан үнэ таацах торго дурдам, пансын зэрэг эдийн өргөдөл бичиг нэг бүтэн хадагтай шүнд барив, дараа 6 сарын аравдаар шанзудва нар буцахыг айлдсанд сэмчинд бараалхуулан зангиа хадаг мутраар зоогын тамхи, жимс идээ, боов бэлэг, тэрэм зэргийг шагналыг хайрлаад би та нарт голын ордныг захихыг умартжээ, түүндээ хувилгааны халуун цагт цөөхөн хоног томоотой хэдхэн хүнтэй байлгасугай, тэр ордон бас ч эдэнд ихдэх тул түүнээс хасаж дээд хүрээний цогчин дуган зэргийг сүмүүдийг сэлбээс болноо хэмээн айлдаад чи аваачиж харэглэсүгэй хэмээн янз янзын төвд цаас нэг вадан хайрласан би хойд хшрээнд 4 сар шахам суухад нэг сар суусан мэт санагдам энд ирээр араваад хоноход их удсан мэт санагдаж уйдмуй, даруй зуу тийш буцна байх хэмээн айлдаж мөнчүү ордны тухай шанзудвад айлдсаны нэгэн адил хамт явсан донир майдард ханчин сойвонгоор уламжлан айлдсаны мөн донир сонсож эргэж ирэвээ, дараа нь Далай ламтаны газраас гүмбүмийн зүг залрахын мэдээ ирмэгц бараа болгон явах тус шавь донир Чүлтэм нарын 14 хүнээр гонзогын тухай баруун зуугын сүм шүтээнд тахил зулын зэргийг өргүүлэхээр мөнгө 700 лан энэ ялдраа дээд дүрийн гэгээн ба ман бүгдийн багш болсон Шинсаринбүчи, Лавжомгон нарын хувилгаан нарт урд эдүгээ дүрийн гонзог ба шавдан бататгахын тухай тус тус 50 лан өргүүлжээ. эдний хамт цорж Дашдоржыг заржээ, дээш залрахын мандалд зан хадаг нэг мөнгө 53 лан өргөжээ. эмч хамба ханчин сойвон нарт талрхаж мөнгө 50 лан хадагтай барьжээ, 4 сарын

29-нд 80 гаруй хүнд, илүү 4 сарын шинийн 8-нд 108 хүнд, 5 сарын шинийн 3-нд 50 гаруй хүнд ийнхүү гэлэн сахил хайрлахад цөмд барын Шагжтүв бурхан нэг нэгийг хайрлажээ, Далай лам заларч бүхийд ийм цогчин чойрт хурал хурж хуварга бүрт таван цэн мөнгө зэд манз хайрласан, мутраараа шавар бурхан олныг барлаж хуваргуудад хайрлаж өөрөө хэрэглэсэн. булган уул ба өөр уул усуудад зугаацах мэтээр майхан барьж олонтой заларч ном айлдсаны дотор донойд 3 дахин заларч савдаг нь нүд гар хөл нь гэмтсэнийг би эм өгсөн одоо эдмүй хэмээн айлдсан гэхийн дээр булаг усны эхийг малтаж чулуугаар хашиж залран ирэхэд тэр булаг нуур мэт их боловоос баяжмуу хэмээн айлджээ. бас хавтгай модонд 3 удаа заларсны сүүлийн залрахад Намсрайн даллага 7 хоног хурж төгсгөсөн өдөр ? ихэд жаргаж байх цагт зүүн өмнө зүгээс солонго татаж өнгө нь дээд хүрээний дээр тогтож туссан нь дэмбэрэлтэй болвой хэмээн айлтгажээ, шүтээн ядамын гэрүүдийг сэтэлвээс тааллаар бүрүүлж будуулан алтадваа, өглөгийн эзэд лам ноёдын хар олонд жэй дацанд аюушын цэвээн 13 өдөр, Жанрайсигын жанан 12 өдөр хайрлажээ, лаврангын баруун сэмчинд лүн жанан ихэд олон хайрласан дүйнхор хурж 3 сарын 15 нд цам дэлгэхэд, Далай лам тааллаар залархад зоог мандал өргөсөн мөн хурлын хуварга бүрт хадаг нэг ембүүтэй хайрлажээ. Агваа дацанд жүд хурал тогтоохыг айлтгаж мандал өргөснөөс лүнгийн ёсоор болгоо 5 сарын 10,11 залрахад шунлайв, цогчин гэсгүй Цэрэдорж нар бойноо хийж сүмийн дуганы дотор чимэг дэлгэж сүм дээр бүрээ татаж харанга дэлдэж дэвцэгт залруулж мообын жасаас зоог мандал өргөж аграмбын мяндаг буулгасан агваа гэвш Дашдондог, гэсгүй Буянцогт нараас хадаг мандал барьсан, жич: манз, идээ, жимс өргөж мяндаг буусан хоёр хуварга дамжаа барьж ном талбисан хадаг зангиа хүртээсэн нь чойрын нэгэн адил болой. Дараагаар жүд хамба ламаас шунлайв Махбалд жүд хамба Агваа лам Гончигжавт ламаунзад хэмээх цол хайрлажээ. Далай ламтанаас соёрхол олж Найчинчожингын сахиусны


чойжинд..... адислах шавдан бататгах шавь нийтэд харшлахын муу зүйл үгүй авралыг айлтгаж залахад навс сэржимийн харамжинд мөнгө 25 лан, тахилын харамжинд мөнгө 5 лан, мандлын харамжинд зах торго мөнгө 5 лан, хурлын 12 хуваргын зэдэд мөнгө 5 лан, соёрхол ба мандалд...хадаг нэг, вандан хадаг 2 гуртамбад....хадаг зах торго нижгээд, мөнгө 15 лантай өргөл барьсан, бас Найчин чойжингын сахиуснаас Прэнлэйжалавын цогчидод гашиг олгохын тухай 20 лан, ламуу зураг Прэнлэйжалав чойжидыг адистадлахын тухайд 100 лан, сэлтсийг өргөж сахиусны гонзогт залж мөн энэ 3 сахиусыг залж учруулаваа. 5 сарын 10-дын үед нэг өдөр Жамган гүдэнгийн дэргэд заларч байх цагт Ламуучойжингын сахиуслан залахаар нянсан өргөхөд энэ ямар юу буй хэмээн айлдсанд Ламуучойжин буухаар нянсан өргөж байх билээ хэмээн айлтгасан би Ламуучойжин үзье хэмээн Ядамын сүмийн зүүн... дээр сойвон Гэлэгдорж бараа болгон заларч гэтэл Чойжин буусан даруй сүмийн гадаа гарч олонтой мөргөл оршисоны даруй сэлэм нэгийг зангидаж бурханы навснаас хуучин баранзад хадаг сэлтсийг шанзуваар дамжуулан Жамганд өргүүлсэнд ихэд таалан зохиож лүндэн болсон нь: Энэ нь цам ондгой үгүй мөн манай зуугын газар ч янз энэ адил байдаг энэ хувилгаан гэгээний түнилхаа мөний дээр хэзээ ч ондгой үгүй мөний тул цамбыг маш эрхэмлэж аваас сайн болмой би зууд очсоноос хувцас чухам сайн нэгийг гүйцэд хийлгэн өгье хэмээн айлдаж тааллаараа маргаашын өдөр залж баранзад хадаг нэг мөнгө 50 лан, энэ гэгээн 2 хийд хийгээд шажин төр бүхийг даатган захирсаныг лүндэнгийн бичиг сэлтсийг хайрласан, басчуу олонтой сайшаасан лүндэн буусан ер чойжингуудын гуртам нарыг ариун цэвэр нямбайг ёсчилон үргэлжид хянаж аваас улам улам тодорхой сайн болмуй номд ч мэргэн хэрэгтэй хэмээн зарлиг өршөөсөн Далай ламтаны өөрсдийн ах гүн Цэвэгдорж баруун газраас зарагдаж ирэхийн замд хөх нуурын газар бие барсаныг хамтын хүмүүн нар энд ирж айлтгасанд Далай ламтанаас манай хувилгаан гэгээнтэн хадаг

нэг.....бичиг сэлтэс хайрласанд бичгийн захих зүйлийг..... бүгд ухуулж айлтган барисугай гэм үгүй хэмээн айлтгасан, Банчин эрдэнийн садангын ханчин Жамбалдачин манай хийдийн шунлайв, цогчин гэсгүй нарт энэ булган уулны орой дээр нясар бурханыг бүтээж жасаа хурал булганы сүмд хуруулж авбаас энэ хийд нь,..... мэт болохын тэмдэг мэдэгджээ, энэ мэт болгох эсэхүү та нар зөвлөлдөн хэрвээ ёсоор болговоос би, Жамганд айлтгаж ишийг олсоноос бид нар өглөгийн эзнийг үйлдэе хэмээн айлтгасныг ёсоор болгохоор хэлэлцэн хариу айлтгасны мөн гачин бээр, Жамганд айлтгаад Банчин богдын хайрласан нясар бурханы гуу гэртэй бус олон шүтээдийн хамт булганы сүмд залж нэг өдрийн хурал хуруулсны харамжинд 10 лан мөнгө хайрлаж бас үүнээс хойш энэ жишээ хурлыг үүний хүүгээр хуруулж асуугай хэмээн 50 лан илүү... хайрласан ёсоор дараа өвлийн тэргүүн сарын 23-ны өдөр булганы оройд нясар бурханыг залж тэр өдрөөс жасаа ёсоор булганы сүмд....., бас Банчин богдоос зарагдаж ирсэн гачин Жамбалдачин сойвон нар, Банчин богдын шавданы тухай, Жамган эхлэн найчин чойжин нарт айлтгасны хариу авралыг цогчинд 3 өдөр хуруулж хичнээн хэрэглэл орсоны харамж мөнгө мөн чойжин жасад хайрласан. Далай ламтанаас шинэ дүрийн хувилгааны шавдан үүрд бат ахуй ба,.. хийдийн хуваргууд олон болж номын сургуульд..... хичээлтэй сайн байх... тив шавь нийтэд үүрд харшлахын муу зүйлгүй улам сайжран дэлгэрэх зэрэг, зүйлд жил бүр тогтмол болгон уншуулах аврал айлдсанд ганжуур данжуур хуруулж асугай хэмээн буусан нь, бас хур бурхан гуйж хувилгаан дүрийн гэгээн гэгээнд шавь нийтэд..... зэргийн тухай аврал айлтгаж.... аврал хүртсэн олон болой,.... дацангын хуварга.... тушаав, Гэлэгдорж, Цэрэнпэл нарын 3 хүнд мангармба мяндаг бууж зоог мандал өргөж мөргөсөнд хадаг.... хүртээсэн дэмцог дацангын.....тохойн дээрхи цогчин шалшын....(хур бороо гуйж чулуун... нэг өдөр Далай ламтанаа галдан зуу хэрхэн заларсаны даруй бага буруу урагш хүр хур оруулахад даатгаваас

сайн байна хэмээн айлтгасныг сойвон ханчунаас сойвон Гэлэгдорж сонссон) доторхи бурхан зай тэргүүтнийг аравнайлахын Далай ламтанаа сойвон Гэлэгдорж айлтгасанд сайн сайн хэмээн айлтгаж аравнайлж айлдан шалшыг маш хэцүү... дүр буй хэмээн айлдаж тус бүр атга дүүрэн будаа хадаг нижгээдийг шагнаж үүнээс нэг ширхэгийг шамшиггүй тус тусын дотор хийсүгэй, энэнь маш сайн хэмээн баясгалантай. зарлигыг өршөөж ихэд сайшаабай. 33-р он 2 сард гүмбүмээс, Далай ламын газраас.....нарыг зарж илгээн лаврангын шүтээнд 7-р Далай ламын дотоодын... боть ном гэгээнтэнээ... хадаг.....,хамба Даравбандидад хадаг...., шанзудва, сойвон Гэлэгдорж нарт..... адис..... бурхан нижгээд захидал хайрлаваа, тэрхүү.... лам сойвон Гэлэгдоржид хэлсэн нь: манай зуу балдан ноёны очсоноос энэ хийд ба, Жамган ямар мэт заларч байсан учрыг олноор сонсож тэрхүү заяын хүрээ бага атал, юун гайхамшигтай аж...

**ХИИ ДАЛАЙ ЛАМ ТҮВДЭНЖАМЦЫН ЗАЯЫН ХҮРЭЭН
МОРИЛСОН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛИЙН БОСОО МОНГОЛ ЭХ**





150. A detailed account of the remarkable prayers, teachings, and rituals given by the 13th Dalai Lama Thubten Gyatso between his visit to Hah and his visit to Kumbum (*Guangxu* 30-32 [1904-1906], 150-17-55; in Mongolian).

Handwritten Mongolian script on a rectangular piece of aged paper. The text is arranged in approximately 12 vertical columns, written from right to left. The characters are in a traditional cursive style. The paper shows signs of age, including some staining and uneven edges.

2

Handwritten Mongolian script on a rectangular piece of aged paper, similar to the one above. It features about 12 vertical columns of text, written from right to left. The script is consistent with the one on the previous page. The paper is aged and has some visible texture and minor discoloration.

3

Handwritten Mongolian script on a rectangular piece of aged paper. The text is arranged in approximately 12 vertical columns, written from right to left. The script is a cursive style, and the paper shows signs of age with some staining and uneven edges.

4

Handwritten Mongolian script on a rectangular piece of aged paper, similar to the one above. It features about 12 vertical columns of text, written from right to left. The paper is yellowed and has some foxing, indicating its age.

150_X1-55


Handwritten Mongolian script on a page, likely a manuscript or letter. The text is written in vertical columns from right to left. The script is a cursive style, characteristic of traditional Mongolian writing.

6


Handwritten Mongolian script on a page, continuing the text from the previous page. The layout and style are consistent with the first page, showing vertical columns of cursive script.

7

ARCHIVAL DOCUMENTS



Handwritten Mongolian script on page 8, arranged in vertical columns. The text is dense and appears to be a historical or administrative document.



Handwritten Mongolian script on page 9, arranged in vertical columns. The text continues from the previous page.

ARCHIVAL DOCUMENTS

Handwritten Mongolian script on a rectangular piece of paper. The text is arranged in approximately 15 vertical columns, written from right to left. The script is a cursive style, likely a form of the traditional Mongolian alphabet. The paper shows signs of age, with some discoloration and slight wear at the edges.

12

Handwritten Mongolian script on a rectangular piece of paper, similar to the one above. It also consists of about 15 vertical columns of text, written from right to left. The script is consistent with the one on page 12. The paper is aged and has some staining, particularly towards the bottom.

13

150_X1-55

Handwritten text in Mongolian script, arranged in vertical columns. The text is dense and appears to be a historical or literary document. The columns are written from right to left.

14

Handwritten text in Mongolian script, arranged in vertical columns. The text is dense and appears to be a historical or literary document. The columns are written from right to left.

15

ARCHIVAL DOCUMENTS

Handwritten Mongolian script on a rectangular piece of aged paper. The text is arranged in several vertical columns, written from right to left. The ink is dark, and the paper shows signs of age and wear.

16

Handwritten Mongolian script on a rectangular piece of aged paper, similar to the one above. The text is arranged in several vertical columns, written from right to left. The ink is dark, and the paper shows signs of age and wear.

17

18
 19
 20
 21
 22
 23
 24
 25
 26
 27
 28
 29
 30
 31
 32
 33
 34
 35
 36
 37
 38
 39
 40
 41
 42
 43
 44
 45
 46
 47
 48
 49
 50
 51
 52
 53
 54
 55
 56
 57
 58
 59
 60
 61
 62
 63
 64
 65
 66
 67
 68
 69
 70
 71
 72
 73
 74
 75
 76
 77
 78
 79
 80
 81
 82
 83
 84
 85
 86
 87
 88
 89
 90
 91
 92
 93
 94
 95
 96
 97
 98
 99
 100


101
 102
 103
 104
 105
 106
 107
 108
 109
 110
 111
 112
 113
 114
 115
 116
 117
 118
 119
 120
 121
 122
 123
 124
 125
 126
 127
 128
 129
 130
 131
 132
 133
 134
 135
 136
 137
 138
 139
 140
 141
 142
 143
 144
 145
 146
 147
 148
 149
 150

ARCHIVAL DOCUMENTS


Handwritten Mongolian script on a rectangular piece of aged paper. The text is arranged in approximately 12 vertical columns, written from right to left. The ink is dark, and the paper shows signs of age and wear.

Handwritten Mongolian script on a rectangular piece of aged paper, similar to the one above. The text is arranged in approximately 12 vertical columns, written from right to left. The ink is dark, and the paper shows signs of age and wear.

ARCHIVAL DOCUMENTS



Handwritten Mongolian script on page 24. The text is arranged in vertical columns, reading from right to left. The script is a traditional cursive style. The page number '24' is centered below the text.



Handwritten Mongolian script on page 25. The text is arranged in vertical columns, reading from right to left. The script is a traditional cursive style. The page number '25' is centered below the text.

150_X1-55

579

Handwritten Mongolian script on page 26. The text is arranged in vertical columns, starting from the right side and moving towards the left. The characters are densely packed and written in a traditional cursive style.

26

Handwritten Mongolian script on page 27. The text is arranged in vertical columns, starting from the right side and moving towards the left. The characters are densely packed and written in a traditional cursive style.

27

ARCHIVAL DOCUMENTS

Handwritten Mongolian script on a rectangular piece of paper. The text is arranged in approximately 15 vertical columns, written from right to left. The script is a traditional cursive style. There are some larger characters at the beginning of the columns, possibly serving as section markers or titles.

Handwritten Mongolian script on a rectangular piece of paper, similar to the previous page. The text is arranged in approximately 15 vertical columns, written from right to left. The script is consistent with the one on page 28. There are some larger characters at the beginning of the columns.

ARCHIVAL DOCUMENTS

Handwritten Mongolian script on page 32, consisting of several vertical columns of text.

Handwritten Mongolian script on page 33, consisting of several vertical columns of text.

ARCHIVAL DOCUMENTS

Handwritten Mongolian script on page 36, consisting of approximately 18 vertical columns of text.

Handwritten Mongolian script on page 37, consisting of approximately 18 vertical columns of text.

ARCHIVAL DOCUMENTS

Handwritten Mongolian script on a rectangular piece of aged paper. The text is arranged in approximately 15 vertical columns, written from right to left. The characters are in a traditional cursive style. There is a small, distinct mark or symbol at the top left of the page, possibly a date or a specific identifier.

Handwritten Mongolian script on a rectangular piece of aged paper. The text is arranged in approximately 15 vertical columns, written from right to left. The characters are in a traditional cursive style. There is a small, distinct mark or symbol at the top left of the page, possibly a date or a specific identifier.

ARCHIVAL DOCUMENTS

Handwritten Mongolian script on a rectangular piece of aged paper. The text is arranged in approximately 12 vertical columns, reading from right to left. The ink is dark, and the paper shows signs of age and wear.

44

Handwritten Mongolian script on a rectangular piece of aged paper. The text is arranged in approximately 12 vertical columns, reading from right to left. The ink is dark, and the paper shows signs of age and wear.

45

Handwritten text in Mongolian script, arranged in vertical columns from right to left. The script is dense and appears to be a historical or religious document.

Handwritten text in Mongolian script, arranged in vertical columns from right to left. The script is dense and appears to be a historical or religious document.

ARCHIVAL DOCUMENTS

Handwritten Mongolian script on a rectangular piece of aged paper. The text is arranged in approximately 15 vertical columns, written from right to left. The characters are in a traditional cursive style. There are some faint markings and bleed-through from the reverse side of the page.

Handwritten Mongolian script on a rectangular piece of aged paper. The text is arranged in approximately 15 vertical columns, written from right to left. The characters are in a traditional cursive style. There are some faint markings and bleed-through from the reverse side of the page.

150_X1-55

39A

Handwritten text in Mongolian script, arranged in vertical columns. The text is dense and appears to be a historical or administrative document. The columns are written from right to left, with the rightmost column being the most prominent.

50

Handwritten text in Mongolian script, arranged in vertical columns. This page continues the text from the previous page, with columns written from right to left. The script is consistent with the previous page, showing a formal or official style.

51

ARCHIVAL DOCUMENTS


Handwritten Mongolian script on aged paper, arranged in vertical columns. The text is dense and appears to be a formal document or record.

52

Handwritten Mongolian script on aged paper, arranged in vertical columns. The text is dense and appears to be a formal document or record.


53

150_XI-55



Handwritten Mongolian script fragment, likely a portion of a larger document. The text is written in a cursive style on aged, yellowed paper.

54



A full page of handwritten Mongolian script on aged paper. The text is organized into several columns, written in a cursive style. The paper shows signs of age and wear.

55

ДӨРВӨН УУЛЫН ТАХИЛГА

ЧИНГЭЛТЭЙ ХАЙРХАНД ТАХИЛ ӨРГӨХҮЙ

Ялж төгс нөгчигсэн, тэгүүнчлэн ирэгсэн, дайсан бүгдээ амирлуулагсан үнэхээр тугуулсан их нигүүлсэхүйн бурхан багшдаа нийт нийслэл хотын иргэдийн өмнөөс бие хэл, сэтгэл бээрээ мөргөн тахин номончилмой. /Здахин/

Хойморийн богд чингэлтэй хайрхан минь болгоон соёрхоо.

1.Сүү өргөхүй

Асрал энэрэлийн дээд
Ачит эх бурхан багшдаа
Алив муу үйл хийсэн бол
Ард түмнийхээ өмнө наминчилж
Ариун цагаан сүү өргөсний
Агуу буян хүчин еээр монгол түмэн
Ашиддаа аюулгүй амгалан байх болтугай

2.Тараг өргөхүй

Энэрэл нийгүүлсэхүйн дээд ачит дээд бурхандаа
Элгэн цагаан тараг өргөсний
Энгүй буянаар эх болсон монгол түмэн
Эмгэг хууч өвчингүй эрүүл мэнд байх болтугай

3.Хоормог өргөхүй

Хүч бүхэн төгөлдөр бурхан багшдаа
Хоормог хэмээх ундаа малын буяныг
Харам үгүй сэтгэлээр өргөсөн монгол түмэн
Хил,хэл, мал, гурваасаа үл хагацах болтугай

4.Ундаа өргөхүй

Ач бүхэн төгөлдөр бурхан багшдаа
Айраг хэмээх ундаа өргөсний
Алив буян еээр монгол түмэн
Ам цангах, өлсөх зовлон амирлах болтугай

5.Цэцэг өргөхүй

Үнэхээр тугуулсан бурхан багшдаа
Үр тарианы охь цэцэг өргөсний хүчин еээр монгол түмэн
Үржилт түмэн бодис ургаж
Үйлс сайн бүгд дэлгэртүгэй.

6.Үнэртэн хүж өргөхүй:

Шагшаа бодийн явдалт бурхан багшдаа
Сайхан үнэрт хүжэс өргөсний хүчин еээр монгол түмэн
Саар муухай бузар дэвээс өнөд хагацаж
Сайн мөрийн зам лугаа учрах болтугай

7.Зул өргөхүй:

Мөнхийн гэрэлт бурхан багшдаа
Мунхаг харанхуйг гийгүүлэх зул өргөсний ачаар
Монгол түмний оюун ухаан
Машид бадрахын өлзий орших болтугай

8.Нанчид өргөхүй:

Нигүүлсэхүйн туйл бурхан багшдаа
Нанчод хэмээх унааны дээдийг өргөсний хүчин еээр
Нийт монгол түмэн олон
Нийгэм даяараа шидэс бүтээл олох болтугай

9.Тахилын идээ өргөхүй:

Энэрэлт бурхан багшдаа
Идэж уухынхаа дээдийг өргөсний хүчин еээр

Эх болсон хамаг амьтан
Идээ ундаагаар тасрахгүй байх болтугай

10.Дүү өргөхүй:

Жаран эгшиг төгөлдөр бурхан багшдаа
Яруу зохист хөгжим өргөсний агуу хүчин еээр
Цээл хоолой нь тэнгэрийн эгшиг шиг
Цэнгэл жаргалаар өнөд мандтугай

ИТГЭЛ

Бурхан ном хийгээд чугуулганы дэгээд дор бодийн хутагийг олохуй хүртэл би бээр итгэмой (3 удаа уншина).

Миний өглөг тэргүүтэн эдгээр еээр хамаг амьтаны тусын тулд бурхан бүтэх болтугай.(3 удаа уншина).

Хамаг амьтан амгалан хийгээд амгалангийн шалтгаан лугаа төгөлдөр болтугай.Хамаг амьтан зовлон хийгээд зовлонгийнг шалтгаан лугаа хагацах болтугай.Хамаг амьтан зовлон үгүй амгалан лугаа үл хагацах болтугай.Хамаг амьтан ойр хол уурлах дурлахаас хагацаж тэгш дор орших болтугай.

ГАНДАНЛХАВЖАА

Төгсбаясгалантын зуун тэнгэрийн итгэлийн зүрхнээс
Маш цагаан шинэ тараг овоолсон мэт үүлийн үзүүрт
Номын хаан Бүхнийг айлдагч Сумадигирди
Хөвгүүд лугаа сэлт энэ орноо залран соёрх

Өмнийн огторгуйд арслант ширээ,лянхуа,сарны дээр
Гэтэлгэгч лам баясгалангийн цагаан мишээлтэй
Миний оюун сүсгийн буяны дээд орноо
Шашныг дэлгэрүүлэхийн тулд зуун галавт оршин соёрх

Мэдэгдэхүүний эн бүхнийг мэдэгч оюун таалалтай
Сайн хувьтын чихний чимэг болсон сайн номлол зарлигтай
Алдаршлын цогоор үлэмж үзэсгэлэнт лагшинтай
Үзэн,сонсох,дурдахуйн хэргийг төгсгөсөнд мөргөмүй

Сэтгэлд зохистой элдэв тахилын усан, цэцэг хийгээд
Анхилуун үнэрт хүж, зул, үнэрт усан тэргүүтэн

Бодтой бэлтгэсэн, сэтгэлээр хувилгасан тахилын үүлэн далай
үүнийг

Буяны орны дээд тан дор тахил болгон өргөө.

Алин бээр тэргүүлэш үгүй цагаас хураасан
Бие,хэл,сэтгэл нүгэл юун үйлдсэн хийгээд
Ялангуяа гурван санваарын үл зохилдохуйн зүгүүдийг
Зүрхнээс хатуу гэмшлээр тус тус наманчилъя

Цөвүүн цаг үүнээ олонтаа сонсоод бүтээл дор хичээн
Найман номыг тэвчихээр чөлөө учралын хэргийг хийсэн
Итгэл таны ахуй их зохионгуй дор
Ба бүрэн саналын угаас даган баясмуй.

Гэтэлгэгч лам дээдэс та нугуудын
Номын биеийн огторгуйд айлдал энэрлийн үүлний үзүүрт
Ямар мэт зохистой номхотгогдохууны газар дэлхийд
Аяндаа бүтсэн номын хурыг буулган соёрх.

Би бээр хэдий чинээ хураасан буян үүгээр
Шашин амьтан бүхнээ алин туслах хийгээд
Ялангуяа Гэтэлгэгч Сумадгирдийн
Шашны зүрхэн өнөд гийгүүлэх болтугай

ТҮЙ БУЮУ УГААЛ ӨРГӨХҮЙ.

Тэгүүнчилэн ирэгсэн бурхан бүгд бээр надад илт авшиг
хайрлан соёрх хэмээбээс бурхадын таалалаас гойгарму буюу
цагаан баринтагт тэнгэр тэргүүт охин тэнгэр нугууд бээр рашаан
дүүрсэн Бумба бариад-

Тэр мэт бурхан мэндэлмэгц
Тэнгэр нугууд угаал өргөсөн адил

Тэнгэрийн ариун рашаан дор
Тэгүүнчилэн би бээр угаал соёрхоё

УМА-САРВА-ДАТА-ГАДА-АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-А-ХУМ
Ò É áóρ ó óãàæ ° ðã° ð¿é

Бурханы лагшин зарлиг таалал хир үгүй ч
Бусдын бие хэл сэтгэлийг ариулахын тухайд
Бурханы лагшинд угаал өргөснөөр
Бүхий л хүмүүний сэтгэл ариустугай

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГУЛА-ЦУНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Огоот төгс лагшинт тан дор
Орчлонгийн хүлээс үгүй ч гэсэн
Адаг биднийг ариулахын тухайд
Ариун усаар соёрхол өргөө

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГУЛА-ЦУНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Эрхэм бурхан шавь нугуудад
Эрдэнийн бумбандах ариун усаар
Сэтгэл зохисоор дүүргэх лус нь
Силнэнгийн дуутай хамт угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ

ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Өглөгийн чанарт энэ усаар
Өөдгүй харамын хирийг угааж
Өгөгдэхүүн болсон цэвэр усаар
Өөр бусдад угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Шагшаабодийн чанарт усаар
Шантрах муу гэмээ ариулаад
Сахилын цэвэр энэ усаар
Сахиагүй бүгдэд угаал өргөмү

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Тэсвэрийн чанарт энэ усаар
Тэсэшгүй уурын гэмээ ариулааад
Асралын чанарт энэ усаар
Амьтан бүхэнд угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Хичээлийн чанарт энэ усаар
Хойшлуулахын залхууг арилгаад
Хичээнгүйн цэвэр рашаанаар
Хотлыг шамдуулах угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Самадийн чанарт энэ усаар
Саад алгасрал гэмийг арилгаад
Бясалгалын үнэрт энэ усаар
Бясалгаагүй түмэнд угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Ухааны чанарт энэ усаар
Ухаараагүйн гэмийг арилгаж
Увидаст энэ рашаанаар
Ухааны хур буулган өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

Угаалын дээд цог төгөлдөр
Таалал ханьцасгүй энэ усыг

Билгээр адислан рашаалсанаар
Бүгд хүсэл биелүүлж хайрла

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ –ГО –ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ –ШОДО-НА-ЕЭ-СУХА

МАНДАЛ ӨРГӨХ ЁСОН ОРШВОЙ

Орон дэлхийг өргөн айлтгомой. **Ум базар бүмэ-а-хум**
Их эрхэт алтан дэлхий. **Ум базар рэ-хэ а-хум**
Гадуур төмөр уулаар эргэн тойрон хүрээлсний төвд,

Уулсын хаан Сүмбэр уул, Дорноо үлэмжийн биет, Өмнөө
Замбуу тив, Өрнөө Үхэр эдлэгч тив, Умараа Муу Дуут тив болон
Биет хийгээд Үлэмж биет завсрын тив, Дохиурт хийгээд Бус дохих
завсрын тив, Хэлбэрэлт хийгээд Дээд мөрт зорчигч завсрын тив,
Муу дуут хийгээд муу дуутын нөхөр завсрын тив, Эрдэнийн
уул, Галбарагча мод, Гаминдини үнээ. Эс тарьсан тутарга, Хүрд
эргэнэ, Чандмань эрдэнэ, Хатан эрдэнэ, Түшмэл эрдэнэ, Заан
эрдэнэ, Морь эрдэнэ, Баатар эрдэнэ, Их сангийн хумх,
Үзэсгэлэнт эх, Эрхич эх, Дууч эх, Бүжигч эх, Цэцгэн эх, Хүжирч
эх, Үнэртэн эх, Наран, Саран, Эрдэнийн шүхэр, Хамаг зүгээс
сайтар ялгагч ялгуусны тэмдэг, Төв дунд тэнгэр хүмүүний хотол
төгс цог учрал бүрдсэн эдгээрийг ачит ёзоорын ба дамжлага
сэлтийн цог төгс лам дээдэс хийгээд, Итгэлт нигүүлсэнгүй
Аръяабал нөхөр лүгээ сэлтэд өргөмүй. Их нигүүлсэнгүйгээр
амьтаны тусад таалан соёрхоо. Таалан соёрхоод би тэргүүтэн
хамаг амьтаныг адистэдлэн соёрхоо.

Газар дэлхийг анхилам хүжсээр сүрчин цэцэг дэлгээд
Сүмбэр уул, дөрвөн тив, нар сараар чимэглэсэн үүнийг

Гэтэлгэгч бурханы гайхамшигт орноо зоригдон өргөснөөр
Сац амьтан бүхэн арилсан орноо эдлэхүй болтугай

Тус амгалан гарахын орон шашин өргөжин дэлгэрснээр
Шашиныг баригч төрөлхтөн бүгдийн бие батжин сайжирч
Түйтгэрт амьтан бүхэнд амгалан жаргалан гарахын орон
Шагжамүнийн шашин өнө мөнхөд орших болтугай

Богд тойн ламын нас сүүдэр машид батжаад
Буянт цагаан үйлс арван зүгт дэлгэрэх ба
Зонхабын шашины зул гурван газрын амьтдыг
Зүүдрээгч мунхагийг ашид гийгүүлэх болтугай

Буяныг ихэд дэлгэрүүлэгч төгс баясгалант Их хөлөгний хийд
Сансрын эцсийг хүртэл оршин өргөжин үйлс нь дэлгэрээд
Саруул оюунт олон мэргэд үргэлжид хурдан чуулаад
Бахдам номлол бүтээлийг шинийн саран мэт арвижуулсугай

Багш шавь нугуудын ном лугаа зохилдох шалтгаан
Ямар мэт санасанаар сэтгэлчлэн бүтэх хийгээд
Барчид саад өвчин, ад, тотгорлогчийн чуулган
Ямар мэт буйг амирлуулан адистлэн соёрхоо.

Дээд их эрдэнэ бодийн сэтгэл
Эс төрсөн нь төрөх болтугай
Эрт төрсөн нь доройтолгүй
Дээш дээш арвижих болтугай

Орон үүнд өвчин, мэсний аюул, зуд турхан зэрэг
Үл зохилдон доройтуулагчийн нэр ч гаралгүй
Оройн дээд Зонхабын шашин зүг бүхнээ дэлгэрээд
Үймрэгч амьтан бүхнээ амгалан жаргалан төгс болтугай

Өмөг болсон их нигүүлсэхүй, энэрлийн мөн чанарт бээр
Би тэргүүтэй хамаг амьтаны харшлах шалтгааныг арилгаж
Өвчин,ад,хилэнцийн түйтгэрийг сайтар амирлуулаад
Балартуулагч гэм хирээс нүдийг илааршуулан адистэдлэ

Эцэг,Эх хамаг амьтан амгалан лугаа төгс болтугай
Энэлгээт муу заяаны орон бүгд үргэлжид хоосроод
Энэрэлт Бодьсадбын аль ч газарт оршсоноор
Эндүүрэлгүйгээр тэдний ерөөл бүтэх болтугай

Өглөгийн эзэн нөхөр сэлт нүгүүдийн
Нас үүнээ санасан хэрэг бүтэх бөгөөд
Өмөг бус зэтгэр амирлан, өлзий хутаг
Номчилон санаснаар бүтэх болтугай

Гайхамшигт Бодьсадба сэлт Бурхадын адистэд ба
Аяа шүтэн барилдлага хуурмаг үгүй үнэн хийгээд
Гагц бас миний ариун санааны хүч чадлаар
Асар ариун ерөөлийн орон энэ нь бүтэх болтугай

Бишрэнгүйгээр мөргөж, тахиж, наминчилсан хийгээд
Бишрэнгүйгээр даган баясаж, дуртган залбирсанаар
Бишрэнгүйгээр өчүүхэн буян юу хураасан бүгдээ
Бишрэнгүйгээр би бээр бодийн уг доор зориулмой

Хотол хүслийн баялаг нь зуны далай мэт аврижиж
Хориг гэм үгүй язгуурын явдал үргэлжид тасралтгүй
Хоног өдөр бүхэнд Зонхабын шашны номын дуу дуурсаж
Хотол чуулганы цогоор цэнгэхийн өлзий хутаг орштугай

Умаа сарваан дата гада раднаа мандала хам ниряа даряами

Чингэлтэйн сан тахил тус бүхэн оршив.

Ом сва сти.

Өмнө зүгийн огторгуйд элдэв өнгийн эрдэнсээр
Өөрөө бялхтал дүүрсэн зарлигийн сүүн далайгаас үүдсэн
Хүслийг хангагч ороонгон модны найлзуур сэлгүүрэхийн дээр
Хүчит арслант тавцанд лянхуа, нар сараар чимэглэсний

Элдэв дэвсгэр дээр аврагч гурвын зарлиг лугуу
Эрхин чухаг Чингэлтэйн шивдагийг амирлуулан
Амирлангуй хилэнт элдэв дүр байдалд нөхөд сэлт
Аргачлан тус тусын суурин дээр машинд баясаад
Ашид мөшилзөхүй нүүрээр сүсэглэн батад оршин соёрх.

Эрхэм та нарыг баясгах дээд эд зайг өргөснөөр
Эгэл миний зарлигийн болон зарлигийн бус сайн бүхэн нь
Эндэхийн тахилын үүлэн цогц болон газар орныг дүүргээд
Эндэлгүй дээд зай, жансигийн сэржмийг дэлгэрүүлэх зэргийг
Ил бодитой бэлтгэн, сэтгэлээр хувилгаж та бүхэндээ өргөө.

Сац бас ялангуяа гурван оронд эгүүдэгсэн
Сайн сангийн зай хаа буй бүхнийг
Сааршгүй билгийн галаар шатаасны утаан үүлс
Сааталгүй бүх л орчныг дүүргэснийг Тандаа өргөө

Ийн баясгаснаар сайтар дөрөв, ба бүрний багш шавийн
Эд баялаг, нас буян, сав шимийн юм доройтсны шалтгаан арилж
Илрэх зүүдний болоод хонзонгийн бих будангуйн хийгээд
уруудахын бузар
Илтэд ариун бус дэв бүхэн эдүгээ цэвэршин ариусах болоод

Эрхин цаглашгүй дөрөв хутагжин, нөхөд харлиг иргэд эд
эдлэлээр дэлгэрч
Элчилгүй аянд аюул, хулгай дээрэм зэргийн

Онц ноцтой хөнөөл бүхнээс авран соёрхож
Ончтой ном, цог учрал бүхэн сайтан дэлгэрээд
Огтоос үл зохилдох болгон амирлаж, зохиолдох шалтгаан ээсэн
Өөрийн санасан хэрэг шамдлагагүйгээр өөсөөн бүтэхийн өлзий
оршиг

Хэмээсэн Чингэлтэйн сан тахил тус бүхэн энэ мэт нэгэн
хэрэгтэй хэмээн Чадагчийн шашны огоот төгссөн агуу эзэн, умар
зүгийн их хөлгөний зан үйлт Халх Жавзандамбын ринбүүчийн
зарлигаар дурдсанаар /эс/ зохиосончлон зөөлөн цогт эрлэгийн
шидийн егзөрваа Шагжийн гэлэн
Лувсанбалдандамбийннямчоглайнамжилбалсанбо-бээр алба
бүтээх төдийд үйлдсэн болой.

ЧИНГЭЛТЭЙ ХАЙРХАНД ӨРГӨХ АЯЛГУУ**Лам Ц.Отгонбаярын дууны үг**

Хоймороо залрах их шүтээн
Хотолд цэнгэл жаргалтай
Улсын нийслэлээ тэвэрсэн
Увидас төгөлдөр хайрхан

Буян хишиг дэлгэрсэн
Багш гэлэнгийн шинжтэй
Бурхны дүр их суврагтай
Бодон их бодон их савдагтай

Саяаар тоолох ард олноо
Салаа мөчиртөө өлгийдсөн
Хотол түмнээ бүүвэйлсэн
Хоймор хойморын их шүтээн

БАЯНЗҮРХ ХАЙРХАНД ТАХИЛ ӨРГӨХҮЙ

Их хүрээний эрхт зүгийн уул Баянзүрх хэмээн алдаршсан орны тэнгэр сан тахил өргөх ёсон амгалан жаргалангийн хур буулгагч хэмээх

Хум

Өвөрчлөнгийн тийн ариун номын агуу уудам төвөөс
Өсөн асар олноор гэтэлгэх тус амгалангийн хур буулгах
Өнөө бидний Багш, Ядам, Чухаг дээд гурав, зарлигийн хамсаа
сэлт
Өөдлөж эдүгээ энэ орноо ариусгалын зочноор зочлогтун.

Онцолбоос умар зүгийн халхын эд баригчийн төвд
Олноос сүртэй үзэсгэлэн төгс Баянзүрх хэмээн
Онгон нэрээ алдаршсан уулнаа дээд орны тэнгэр
Орны эзэн, дэлхийн эзэн нөхөд сэлт энэ орноо залрагтун.

Өмнөдийн үзэсгэлэнт дүр байдалт орны төвд
Өнгө улаан, цагаан үзэсгэлэнт эрдэнийн уналга баригч
Өв тэгш хивэрлэг торго, эрдэнийн чимгээр чимсэн бар
хөлөглөсөөр
Өөрийгөө баясгасан дүр батад залрагтун.

Самди тарни хийгээд ариун мутраар адистидласан
Сайн тахил, балин тангарагийн зай элдэв жансиг зэргийг
Сац бас маш хэтэрхий газар хийгээд завсрыг гэгээн гэрлээр
дүүргэснээр
Сайтар хоцроолгүй нөхцөлдүүлэн бүхнийг баясган жаргуулахын
тулд өргөө.

Өгөөмөр эрдэнийн санд долоон морьт хэмээгдэх нарны
Өгснийг идэгч хэмээх галд билгийн гал бадарсны төвд
Угаас сайхан үнэрт сангийн элдэв зайг шатааснаар

Утаан үүлэн үхэлгүйн мөр бүхнээ түгсэн үүгээр

Багш. Ядам, Чухаг дээд гурав, зарлигийн хамсааг ариусгая.
Бас ертөнцийн амарлангуй зочдуудыг хоцроолгүй ариусгая.
Онцгойлбоос сайн жавхлант Баянзүрх хайрханы
Онгои навдаг, шивдаг, эзэд нөхөд сэлтийг ариусгая.

Улмаар та бүхэн дээдийн сан тахилгыг таалсан бөгөөтөл бидэн
Улаал, цагааны хиншүү хярвас тавих, амласанаа эвдсэн аваас
Урхаггүй тэнгэр шүтээнд андаймаа буруу юм хийсэн ахиул
Ууч таалалтай харшилсан бүхнийг хүлцэн зохиож хайрла.

Гутаггүй ба бүрний багш, шавь өглөгийн эзэд, нөхөд сэлт-бээр
Гурван үүднээс тийн үйлийг юутай ч атугай үйлдэвч
Гутаах атаа хилэн бо.Лж найдангуйн дээдийг зохиохуй-дор чу
Гудиггүй санасан хэрэг бүхнийг бүтээхийг нөхцөлдүүлэн хайрла

Бус бас хэл ам, хэрүүл тэмцэл, эвдрэл самуурал болон
Бусцар хяруу, мөндөр, ган зуд, догшин хуй салхин үймэх
Буруу дайсан, хулгай дээрмийн хир хэмжээ ихсэх, гуйранч
мухардах
Бусад үл зохилдох барцадыг үлдээлгүй арилган зохио.

Ус хур цагтаа бууж өвс мод, навч цэцэг дэлгэрээд
Ухаант хүмүүний язгуур үндэс эд баялаг арвидахын ам дэлгэрч
Улс амьтны амгалан жаргалан нь зуны далай мэт тэгшрэн
Угаас зуун баясгалангаар мөшөөлгөх эрхин үйлсийг зохио.

Хамгаас онцолбол Их хүрээний энэ зүгийн газар оршоод
Хамтаар хуран чуулсан хамаг төрөлхтөний
Харшлах нөхцөл арилаад зохилдох нөхцлүүдийг бүтээхийг
Хань хамсаа болсон Далх-та бээр ивээтүгэй.

Багш Ядам, Чухаг дээд гурвын адистид хийгээд
Басхүү тангарагтан далайн орны догшин тэнгэрийн хүчээр
Ба бүрнийн нөхөд сэлтийн барилдлагын шүтээн гарснаар
Баясангуй сэтгэлийн ерөөл ямарчилан бүтэхийн өлзий хутаг
оршиг.

МОНГОЛ ОРНЫ САН

*Би ямагт нэгэн эгшин дор нэг нигуурт хоёр мутарт
Аръяабал бурхны дүрийг эрхшээмэй.*

Ариусгалын тахил балан гадаад дотоод нууцын
Агуу сүсэгтнүүдийн мөнхийн мэлмийг дүүрч
Цувралтгүй бэлэг билгийн рашааны усан далай
Цалиглан давлах тахил мэт болтугай.

Умаа хум Умаа хум Умаа хум

Аяа агуу хүчит бүрэг хангай хийгээд
Алдарт бүрэн Орхон Сэлэнгэ мөрөн
Асарлах уул урсах ус бүхнээ оршсон
Ачит их навдаг шавдаг бүгдийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Онон Алтай хавийн их уулс ус
Олноо алдартай Увс их арал тэргүүт
Ихэнх уул усан бүхнээ оршсон
Илч этгээдийн хамаг шадвагийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Хэнтий улаан сүрэг болон
Хэрлэн Туул Хөлөн тэргүүт
Догшин уул усан бүхнээ оршсон
Дорно зүгийн шавдаг бүхнийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Аяа

Умар зүгийн монгол орны их сүлдэн тэнгэр

Уул хангай ханы дөрвөн их тэнгэр

Эх хөвгүүн гадаад дотоод түшмэл

Элчис үйлчний нөхдийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Бас бус дөрвөн зүг найман зовхисын

Бараантан шовхрох их хайрхан

Ус гол их мөрөнд оршсон

Улс орны тэнгэр шавдаг хамгийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Ялангуй ба бүрний нөхөр сэлт

Ямарваа шүтээн мөр үйл хамаггуравнаа

Алинд ч оршсон энэ зүгийнхээ

Алдарт орны тэнгэр хамаг шавдагийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Хангай ханы аймагт харъяалагдсан

Хань болох Идэр Тэрх хоёр

Хас өлзийт Цагаан нуур Чулуутын

Хамаг шавдаг орны тэнгэрийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

ДАЛЛАГА АВАХ

Хоёр түүтгэрээс ариуссан номын шим

Хэлбэрэлт үгүй бат бүхний суурь

Өндөр үгүй бат бүхний суурь

Өнөөдрийн идээр даллан авъяа

1.Хурай Хурай Хурай

Ариун огторгуйн төв хүчнээс
Алаглах солонго зуран хээлсэн мэт
Өмнүүрхэн ургах хишиг бүгдийг
Өнөөдрийн идээр даллан авмуй

2.Хурай Хурай Хурай

Асар арвин төгс долоон эрдэнээр
Аварга их тивүүдийг эрхшээгч
Өнхрөх хүрдийг эрхшээгч хишгийг
Өнөөдрийн идээр даллан авмуй

3.Хурай Хурай Хурай

Олноо өргөгдсөн хаанаас эхлээд
Оргил эхт Гангын урсгал мэт
Өнөд үргэлжлэх хишиг буяныг
Өнөөдрийн идээр даллан авмуй

4.Хурай Хурай Хурай

Гурван сургаалийн ёзоорыг баригч хөвүүн
Гунхашгүй мөчрийн үзэсгэлэнт нахиа
Хоёр зэргийн эцэст хүрсэн үрээр
Хосгүй үзэсгэлэнт төгс номын хишиг ба
Үхлийн эзний аймгийг ч ялсан
Үхэлгүй бүтээх насны хишиг
Өнөд оршоох буян заяаг ч
Өнөөдрийн идээр даллан авмуй

5. Хурай Хурай Хурай

БАЯНЗҮРХ ХАЙРХАНЫГ МАГТАН ЗОХИОСОН

Лам Ц.Отгонбаярын дууны үг

Наран ургах зүүн зүгээс
Нийслэл хотоо сахин залрах
Намсрай бурхны даллага хишигтэй
Нандин баянзүрх хайрхан минь

Арвидах дэлгэрэхийн билигдэл болсон
Адистэдийн түгээмэл үндэс
Асар басараа савдаглан залсан
Ард зоны шүтээн хайрхан минь

Эрдэнэ баялагийг үүтгэх хөрөнгө
Эдийн тэнгэр бурханы орон
Эдүүгээ хүмүүсийн шүтээн болсон
Энгүй тансаг их хайрхан минь.

БОГДХАН УУЛАНД ТАХИЛ ӨРГӨХҮЙ

Полха /Богд/ Дүнжонгаравын залбирал тахил оршвой.

Их амгалан өөсөн бүтэхүй номын бие Гүндсамбуу
Илт төгс жаргалангийн бие, сэтгэлээр хувилгасан бие Шагжтүв
Идэт тарнисыг баригч Бадамжунайн ялгуусан эрхт Зонхов
Ийм гурван язгуурт тэнгэрийн чуулганууд бээр хутгийг соёрх

Өвөрлөгчийн их амгалан орд өргөөнөөс
Өндөр огторгуй газрын эрх баялаг их Чингисийн
Өөр язгуур үндсийг тэтгэсэн дээд тэнгэр Дүнжингарав
Орны тэнгэр, шивдаг нөхөд сэлт ажран соёрхог

Өмнөдийн огторгуйд рид хувилгааны хүчин чадлыг барьсан
Өөсөн сэлгүүрэх цагаан үүлэн мэт ажнай хөлөглөсөн
Цаст уул мэт цагаан сүлдэн тэнгэрийн их хаантан
Баруун мутартаа дайсны амийг таслагч урд жад

Зүүн мутартаа хорлогчийг хүлэх цалам барьж
Улбалзан намилзсан торго, чимгээр үзэсгэлэнжээд
Хань хамсаа болсон тэнгэр, лус, шивдгууд
Хамаг нөхдийн хамт баясгахуйн ёсоор залрах болтугай

Үнэнхүү уужим саван дахь ариутгагч хоёр усан тахилын уйлганд
Үзэсгэлэнт сайхан цэцэг, элдэв навч гишүүнийг дэлгэрүүлэн
Үнэр шимт хүжсийн утааг үүлэн мэт бүрхүүлээд
Үсэд гэрэлтэгч зул бадарснаар зүг бүхнийг гийгүүлэн

Хүж,усны үнэрийн анхилгаар бие сэтгэлийг хангаад
Хүмүүн дээдийн биеийг дэгжээгч идээ зоогийг уул мэт цогцлоон
Үнэхээр яруу аялгуу элдэв цэнгэлийг дуурсгаад
Үнэр өнгө, анхилын хотол чуулган зуун амттаных

Үлэмж цуврилгүй амгаланг өгөгч рашаанаар адистидласны
Үнэн гурван цагаан, гурван амтат үр жимс, элдэв самар тэргүүтэн
Идээ зоогийн балинг уул овоо мэт цогцлуулан
Сарны сүрчилгийн уйлгатай ижилдсэн тараг сүү

Сайн гүргэмийн өнгө төгөлдөр билгийн цайг дээжлэе.
Элдэв үр жимсийн шимийн охь сүлд тэргүүтэн
Идэт ундааны рашаан далай мэт хүрээлээд
Арц зандан, агарваа тэргүүтний болон

Аятай сайхан үнэр төгс элдэв мод, эм тан
Олон зүйлийн жимс, элдэв торго, сайн бүхнийг
Олж шатаасан сангийн утаагаар завсрын үзэгдлийг дүүргэсү
Асар дулаан баринтаг хувцад, шасар малгай, хөмөн гутал

Агуу үзэсгэлэнт чимэг, сайн тавцант суудал
Бат бэх хуяг дуулга, хатан болд мэсийн зүйл
Бадралт төрийн долоон эрдэнэ, өлзийт найман тахил
Барьж унах дээд морь, ачлагын атан тэмээ

Байнга үргэлж сүүн урсгалыг барин мөшөөхүй
Бас бус шалтгааныг арвитгасан сүргийн манлай үхэр
Үнэт ноос, ноолуурыг үүтгэн баригч хонь ямаа
Үзээрийн дайсан хулгай, араатны хөнөөл аврагч нохой

Үргэлж газраар гүйгч гөрөөс араатан болон
Үүлт огторгуйгаар бядагч шувууд болоод бялзуухай тэргүүтнээ
Үнэхээр хэрэгтэй бүхий л хав заслыг дутаалгүй өргөө
Гурван мянганыг хормын зуурт эргэх хүчин чадалт

Гуталгүй цагаан ажнайн хазаар ногт, үзэсгэлэнт чимгийн дээр
Лагшингийн өнгө нь цайвар цагаан баясгалангаар мөшөөсөн

Лавтайяа улбалзан намилзсан элдэв торгон баринтаг хувцастай
Таарсан дайсны тотгодын амин сүнсийг таслах хурц илдтэй

Тангараг доройтсон бүхнийг хоцроолгүй хүлэгч цалам барьсан
Даамай урьдаас язгуур үндсийг сайтар тэтгэн зохиосон
Далха-Сүлдэн тэнгэрийн хаан, нөхөд сэлтийг магтая
Алимад шалтгааны барилдлагат ба бүрний нөхөд сэлтийн

Аху нас цаг, хүчний учралын амны хишгийн язгуур үндэс
Адуу мал, эд баялаг, хонь ямаа, тэмээ, нөхөд, зардсан
Алт, мөнгө, хив торго, чухаг хэрэгтэй эд эдлэлийг арвитга.
Цаг бусын үлэмжийн их хур цас, хяруу мөндөр, ган халуун

Цалгай хямрал, хэрүүл тэмцэл, хүн малын өвчин
Хүмүүн ба хүмүүн бусын санасан муу шалтгаан цөвүүн учрал
Хүчир хөнөөлийн хорлолын үндэс бүхнийг хариулан буцаа.
Ус хур цагтаа бууж, өвс ургамал, үр жимс дэлгэрээд

Ухаант хүн зоны амар баясгалангийн гэгээ машид арвижаад
Урьдын ихэс дээдсийн сайн явдал өргөжөөд
Улмаар асар цагаан буяны хичээлийн үйлсийг зохио.
Сансар огторгуйд сайн гариг одыг сайтар учруулж,

Сац бас газрын өлзийт хишиг буяныг сайтар арвижуулж
Сайн буяны хотол чуулганы цогт цэнгэлийн
Сайн амгалангийн өлзийт буяны билэгийн хурыг буулга.

ДҮНЖИНГАРАВ ХАЙРХАНД ӨРГӨСӨН ДУУ***Лам Ц.Отгонбаярын дууны үг***

Далх бурхны тахилгийн орон
Дэвэн халих хангард савдагтай
Дүнжингарав хайрхан уул минь
Дүнхийн алсаас холын бараатай

Эрдэнэ зэндмэн номин оргилтой
Энгүй түмэндээ богд суурьтай
Өмнийг сахих их хангай
Өтгөс дээдсийн дархалсан хайрхан

Үүдэн тэнгэр хан уул минь
Үр удам дамжсан их шүтээн
Үй олон араатан гөрөөстэй
Үзэсгэлэн төгөлдөр их хайрхан

ӨНДӨР ХАЙРХАН БУЮУ СОНГИНОХАЙРХАНД ТАХИЛ ӨРГӨХҮЙ

***Сонгино буюу Өндөрхайрханы шивдагуудад сан тахил
өргөх ёс есөн хүслийн хур буулгагч хэмээх оршвой.***

Намо гүрү ра наа тха еэ. Эндэх хүрээний баруунаа орших Сонгино /Зон жаа/ уул буюу Өндөр хайрхан хэмээх алдаршсан ууланд оршсон шивдэгуудад ариутгал тахил өргөхийг хүсвээс агар, хүж тэргүүтэн сайхан анхилагт элдэв ариун эд галд шатаагаад:

Ум хэмээн. Ариутгалын зай, тахил балин гадаад дотоод нууцын Аль буй тэргүүтнээр гол болгон адислаад:

Хум, Агуу уужим газрын эд баригч хамгийг эрхэндээ хураасан
Асар жавхлант, үзэсгэлэнт Өндөрхайрханаар алдаршсан
Энэхүү уулнаа оршсон орны их тэнгэр
Эрхт нөхөд сэлт өөдлөн өөдлөн эл орноо ирэн соёрх.

Өмнөдийн огторгуй дахь шуурган хий адил
Өрвөлзөх догшин хар үүлсийн дунд
Өөрийн лагшин нь харанхуйн өнгө адил
Өгүүлэшгүй маш хилэнгийн дүртэй

Торгон молцогтой зэр зэвсэг
Тод эрээн мод мутартаа барьсан
Том хөх үхрийн дээрээс
Тонж баясгалангаар залрагчийг урьмуу.

Үнэмлэхүйн агаарт өвөрчлөн зорьшгүй ч

Янагуухуйн гадаад дотоод тахилгын үүлэн
Үлэмж дээд эд зай, жансаг үл бүрэлдсэн үүнийг
Дайны тэнгэр, хэвцэг нөхдийг баясгах үүднээс өргөө

Гайхам бхүрмийн эрдэнээр зуунтаа чимэн хээлсэн
Гагцхүү илтэд үзэсгэлэнт савын доторх билгийн
Галын цогцод сайхан анхилга үнэдийг шатааснаар
Гарсан утаан үүл нь огторгуйд түгсэн үүгээр

Багш дэгэд гурав, номыг тэтгээчин сахиулсан
Бас онцолбоос Өвөрхангайн хэмээгдэхийн
Навдаг шивдаг, охин тэнгэр, найман аймаг тэргүүтэн
Насад хоцролгүй ариусан баясаж ханах болтугай

Таалснаар орны эзэн ба бүрний багш шавийн эрдэм тахилгаар
Таагүй улаан, цагаан эдээр тулга тогоо бузар болох
Чулуу ховхлох, газар сэндлэх тэргүүтнийг юун боловч
Чухаг хүлцэн тэвчиж, залбирч хөвгүүнчлэн тэтгэн зохио.

Энэ л орон газрын хүн, малд тусах
Элдэв өвчин жижиг, хяруу мөндөр, ган зудаас
Этгээд муу гай гамшиг
Эрчит догшин аянга цахилгаан буухаас

Энэрэлгүй араатан амьтны хор хөнөөлөөс
Эрх биш тэжээхүй бүхнийг амирлуулан
Жилийн сайн үр шимийг
Жигд арвижуулан дэлгэрүүлж хайрла.

Эрдэнэ сүрэг, адгуус амьтан арвидахын ам дэлгэрч
Эсэг цагаа, тараг айраг зуны далайтай тэнцэн
Хамаг төрөлхтөний энх эсэн, орь залууг дэлгэрүүлэх
Харгүй сайн буяны хотол гурван чуулганы үйлсийг зохио

Хамгаас ангид Жавзандамбын энэ хүрээнд
Халамжт бурхны шашны зул машид мандаад
Хотол олны доройтлын харанхуйг сайтар арилгаад
Хосгүй тус амгалангийн гэгээг түгээн хайрла.

Аанай бас энэ зүгийн орноо хуран чуулсан
Алив хүмүүн хаа нэгтээ одож, хаа нэгтээ суух болсон ч
Орон нутаг, зам харгуй, хээр тал бүхэнд ялгалгүй
Онц цагаан үйл бүтээхийг нөхцөлдүүлэн зохио

Эмхэтгэвээс хэвцэг догшин орны тэнгэр та бүхэн
Энэ газрын хүч төрөлхтөнийг алгасалгүй сахин аварч
Элдэв дайсны тотгодыг дарж, өнид зүрхний нарыг гийгүүлж
Эеэр заяагч тэнгэрийн сахиусыг үл алгасран сахиж

Энгүй хэвцэг Гүл тэнгэрийн их хүчний хувилгаанаар
Эл гурван сансрын хамаг буян хишгийг энд хураагаад
Сав шимийн дуртмал өнгө, сүр жавхлан
Сайн хутгийн далайгаар газар бүхнээ түгэх болтугай.

Хэмээсэн Их хүрээний өрнийн сайн жавхлан уул Сонгинот
буюу Өндөрхайрханы шивдагууд ариутгал тахил өргөх ёс есөн
хүслэнгийн хур буулгагч хэмээн үүнийг ариун явдалт дээдийн
даяанч Лувсаннамжилын дурдсанд Радэн хийд Доржчангийн
хувилгааны нэр баригч ханчин Агваанпрэнлэйжамц найруулсны
бичээч нь Дамдин болой. Сайн буян орох болтугай.

**СОНГИНХАЙРХАН БУЮУ "ӨНДӨР ХАЙРХАН"-нд
ӨРГӨСӨН ДУУ**

Лам Ц.Отгонбаярын дууны үг

Бүхий нийслэлийн баруун шүтээн
Баатар дагинас шинж нь тодорсон
Бухаан хөлөглэх өвөг савдагтай
Бараантан шовхрох өндөр хайрхан

Сэржим голдуу ундаа зооглох
Сэвжид төгөлдөр их шүтээн
Олны итгэлийг батлан даасан
Оргил цавчим халил хайрхан

Аян замын саадыг засах
Ар өвөртөө олон суврагтай
Айлчин гийчин ирж одох
Амар мэндийг даасан хайрхан

АДИСТЫН ДЭЭДИЙГ ХАЙРЛАГЧ ЭХ

Адистын дээдийг хайрлагч ихэс багш нар болон
Авралын хурыг буулгагч амирлангуй ба догшин тэнгирс
Барцад бүхнийг арилгагч дагнис чойжин нугууд
Бишрэнгүй бээр бие сэтгэлээрээ мөргөн залбирья

Ариун сэтгэлээр бэлдсэн тахилын чуулганыг
Агуу огторгуйд дүүрэн түгээн дэлгэрүүлж
Алс хэтээс хурсан нүгэл хилэнцийг тэвчин
Аливаад дуурсагдах буяныг даган баясмуу

Асар дэлгэр номын хүрдийг эргүүлэн соёрхооч
Ачит тэр хүрд орчлонгийн эцэс хүртэл оршиг
Аяа үүгээр гийсэн буяны алив цогцос
Анхлан бүхний ухааныг гийгүлэн тэтгэж

Ашид билгийн гэгээг гэрэлтүүлэхээр зорь тугай
Мунхаг цагийн их харанхуйгаар бүрхэгдсэн энэлсэн
Муу заяаны туйлыг нигүүлсэнгүй сэтгэлээр авар

Үйлийн үрийн гасланг сэтгэлээр боловсорсон
Үнэхүү зовлонгийн их түймрийг намжааж
Өш хонзонгийн зовлонт сэтгэлийг арилган
Өрөвч ухааны гайхамшигт цогцос дэлгэрэх болтугай

Аврагтун аврагтун үнэн итгэлт дээдэс минь
Болгоогтун болгоогтун их нинжийн сан минь
Эндүүрэл алгасралгүй эртний зарлиг сонс
Эхлэн таалан соёрхож авралаар түргэн тэтгэ

Ариун шашны гэрэл арван зүгт дэлгэрч
Амьтан бүхэн амгалангийн цогийг дуурсган

Алмад түүтгэрийг зогсоох билгийн хутгийг
Асар түргэн дэлгэрүүлж хайрла

Дээд гурван эрдэнийн адистэд хийгээд
Дээдийн номын урвалтгүй барилдлагааны хүч
Хүндэтгэн сүслэн сахих бидний үйлсээр
Хүсэл бүхэн сэтгэлчлэн бүтэх болтугай

Аврал бүхнийг хураасан багшийн адистэдээр
Ахуй үесийн доройтол бүхэн амирлаж
Хорвоод сайн үйлс сүндэрлэн бүтэж
Хотлоороо цэнгэхийн өлзий орштугай

БУРХАНЫ ШАШИН ДЭЛГЭРЭХИЙН ЕРӨӨЛ

Баатар долоон бурханд мөргөмү

Амьтны тусд урьд би
Аль бэрх хатуужлыг эдлээд
Амар жаргалаа зориулсны хүчинд
Ариун шашин өнөд бадартугай

Өвчтөний тусд урьд би
Өөрийн амь амьдралын зольж
Үгээгүү амьтныг эмнэсний тулд
Үнэн шашин өнөд бадартугай

Эхнэр хийгээд хөвгүүд охид
Эд эрдэнэ, хөлөг хэрэгслээ ч
Эгнэгт гэгээрлийн төлөө зольсноор
Эрхэм шашин өнөд бадартугай

Эцэг, эх, ширвага, брадига
Энэрэлт бурхан, арш дээдэст
Эндэлгүй би вээр тахил өргөснөөр
Эрдэнэ шашин өнөд бадартугай

Олон сая галавт би
Онц элдэв зовлонг амсч
Оюун гэгээрүүлэх номыг эрснээр
Онол шашин өнөд бадартугай

Асар нарийн ёс журам
Аливаа хатуужлыг үргэлж сахин

Арван зүгийн бурхадыг тахиснаар
Аврал шашин өнөд бадартугай

Эргэж буцахгүй хичээл зүтгэлээр
Эсрэг хүчин бүхнийг ялж
Эндүүрч төөрөгсдийг аварсан тул
Эрдэмт шашин өнөд бадартугай

Хүлцэл тэвчээрийг үргэлж эрхэмлэн
Хөнөөлт сэтгэлийн өвчинд баригдсан
Хөөрхий дордсыг уучлан хайрласнаар
Хүндэт шашин өнөд бадартугай

Ганга мөрний хумхийн тоо шиг
Дээд түвшний дияан бясалгалыг
Гаргууд сайн эзэмшсэн тул
Гайхамшигт шашин өнөд бадартугай

Билиг ухаан нээхийн тулд
Бэрх хатуужлаар аглагт сууж
Бичиг шаштир судалсны хүчинд
Бишрэлт шашин өнөд бадартугай

Өршөөлт энэрлээр мах цус
Өнө амьдрлаа ч огоот зориулж
Үе мөчөө харамгүй өгснөөр
Үнэн ном машид дэлгэртүгэй

Алдас нүгэлтнийг урьд би
Агуу хайраар асран сэнхрүүлж
Аль зохих замд нь оруулснаар
Алдаршгүй номын өглөг арвижтүгэй

Арга билгийн хүчээр би
Атхаг үзлээс бусдыг чөлөөлж
Ариун үнэнд залуурдсаны тулд
Авралт ном үлэмж дэлгэртүгэй

Хураах дөрвөн үйлсээр би
Хорсол тачаалын галаас аварч
Хор хилэнцийн хүчийг ялснаар
Хувьт шавь нар минь өнөд орштугай

Буруу зөрүү номтныг би
Буртагт үзлийн уснаас гэтэлгэж
Буцалтгүй үнэн үзэлд оруулснаар
Буянт нөхөд минь өнөд бишэртүгэй

Бурхан шашин үүрд бадартугай

БОГД ЗОНХОВЫН ШАШИН ДЭЛГЭРЭХ ЕРӨӨЛ

Хамаг гэгээрэгсдийн оюун санааны эцэг боловч бурханы хүүгийн дүрээр тоо томшгүй ертөнцөд гэгээрлийг номыг түгээх ерөөл зориг үнэний хүчээр Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Эрт урьд Эрхэт-охь бурханы өмнө тангараг өргөхөд Чин зоригтон хэмээн бурхад бодисатва нар алдар сууг нь дуурьсгасан үнэний хүчээр Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Ариун үзэл онол зам мөрийн уламжлалыг дэлгэрүүлэх ерөөлөөр Бурхан багшид цагаан болор эрх өргөхөд нь номын лавай соёрхон зөн бошгыг үзүүлсэн үнэний хүчээр Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Ариун үзэл нь буй, үгүй хоёрын туйлаас ангижирсан, ариун бясалгал нь саатал нойрмоглолын харанхуйг ярсан, ариун замнал нь Бурхан багшийн сургаалыг дагасан Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Номын дууг үлэмж сонссон мэргэн, сонссон утгаа сэтгэлдэ төлөвшүүлсэн ариун, тэр бүхнээ шашин амьтны тусын тулд зориулсан сайн чанарт Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Бурхан шашины жинхэнэ утгат ба татвар утга бүх сургаалыг харицан харшилдалгүйгээр хувь нэгэн бодгалийн судлаж бясалгах гарын авлаг болгох ухаарлаар гэм алдаа бүхнийг хаасан Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Гурван ай сав эш сургаалийг судлах, номлох буюу гурван ариун онол суртахууныг бясалган эзэмших эрдэм билиг, ид

чадал хосолсон гайхамшигт замнал Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Гаднаа сахил журамтны явдал ёсоор номхон дөлгөөн, дотроо бурханлаг дүрийн хоёр зэрэгт йога бясалгал төгөлдөр, судар тарнийн зам мөр харшилдалгүй эвлэсэн Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Угийн хөлгөнд номлосон хоосон чанар, үрийн аргаар нээх их амгаланд төгс төгөлдөр цогцлон найрсах найман түмэн номын чуулганы зүрхэн шим Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Гурван төрөлхтөний гэгээрлийн замыг ивээн сахигчийн манлай Махагал, Бисарван, Эрлэг номын хаан тэргүүтэн түг түмэн тангарагт сахиусны ивээлээр Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

Цог жавхлант багшийн лагшин тунгалаг, өлмии батжиж, гэгээн эрдэмт, ариун сэтгэлт шашны залуурчид эх дэлхийд дүүрч, өглөгийн эзэн сүсэгтэн олны өмөг хүчин бадарснаар Суу билигт ялгуусны шашин дэлгэрэх болтугай.

ШҮТЭН БАРИЛДЛАГЫН МАГТААЛ

*Намо гүрү Манзугохаяя
/Багш Зөөлөн цогт дор мөргөмү/*

Нэвтэрхий болгоох нь ижилгүй мэргэн,
Нигүүлслээр номлох нь хосгүй заагч,
Нягт шүтэн барилдахуйн ёсыг
Нээн, сургасан Ялгуусанд биширмү.

Ахуй ертөнцийн доройтод бүгд
Андуу мунхгаас үндэслэх бөгөөд
Алимад шүтэн барилдлагыг мэдсэнээр л
Аюул түүнийг няцаахыг зарлиглажээ.

Үүнээс үүдэн ухаантан бүгдээр
Үлэмж шүтэн барилдлагын мөрийг
Таны шашны оньс хэмээн
Таалахгүй байж яахин чадах.

Магад иймээс итгэлт таныг
Магтахыг хүссэн хэн нэгэнд
Эл шүтэн барилдлагыг номлосноостань
Илүү гайхамшиг олдоно гэж үү.

“Аль аль шалтгаанд харгалзсан
Тэр бүгд нь хоосон чанартай”
Энэ айлдвараас үнэ цэнэтэй
Эрхэм номлол юу байх вэ.

Эгэл нялхасын хувьд энэ нь
Эцэст баригч хүлээсийг бататгана.

Эрдэмт мэргэдийн хувьд тэр нь
Эндүүрлийн тор бүгдийг таслана.

Зүйтэй номлол бусдад үгүй,
Зөвхөн таныг л “Багш” хэмээлтэй,
Зүдэг үнэгийг “арслан” гэсэн шиг
Зөрүү тэрсүүдэд зусар үг.

Гайхамшигт багш, гайхамшигт аврал
Гайхамшигт өгүүлэгч, гайхамшигтитгэл
Эндүүрэлгүй шүтэн барилдлагыг номлосон
Ижилгүй багш тандаа мөргөмүү

Ачлан ивээгч таны айлдсан
Амьтныг эмнэх сургаалын шим
Агуу хоосон чанарыг танихад
Адилтгашгүй дээд нотолгоо болсон

Харилцан шүтэлцэхүйн жам ёсыг
Харш бөгөөд бүтэхгүйгээр үзвэл
Хамгийг айлдагч таны зарлигийг
Хаанаас зөв ойлгох билээ.

Таны болгоосноор хоосон чанарыг
Шүтэн барилдлагын утганд ухаарвал
“Өвөр чанар хоосон” лугаа
“Үйлдэгч, үйлдэгдэхүүний зохицол” харшлахгүй.

Үүнээс эсрэгээр үзэх аваас
Хоосон тул үйлдэгдэхүүн бус,
Үйлдэгдэхүүн бол хоосон бус,
Үгүйсгэл, туйлшралын ангалд унаюу.

Учир тиймээс таны шашинд
Шүтэн барилдахуйн үзлийг дээдэлсэн.
Угтаа огт байхгүй ч бус
Уул чанараараа байгаа ч бус,

Тулгуургүй огторгуйн цэцэг мэт
Тусгаар орших нь байж болшгүй
Угаасаа бүтсэн бол тэр нь ч
Учир шалтгаанд харгалзахтай харшилна.

Иймийн тул шүтэн барилдлагаас
Ангид зүйл нэгээхэн ч үгүй,
Тиймийн тул хоосон чанараас
Ангид зүйл ч бас үгүй.

Мөн чанарыг буцаашгүй тул
Мөн чанартай зүйл байхуул
Эгнэгт гаслангаас нөгчих аргагүй,
Элдэв цацралаас ч ангижирч чадахгүй.

Аяа, тиймээс, арслангын дуугаар
“Ахуй чанар хоосон” хэмээн
Ахин, дахин мэргэдийн чуулганд
Алгасалгүй номлосныг тань хэн эсэргүүцнэ

“Ямарваа мөн чанаргүй” хийгээд
“Янагуухь энэ, тэр шүтэлцсэн
Хамаг ялгаврын зохицол” хоёр нь
Харшлахгүй хурахыг өгүүлэх юун.

“Шүтэн барилдахуйн учиршалтгаанаар
Туйлшрагч үзлээс гэтэлнэ” хэмээсэн
Эрхэм айлдвар тань итгэлт таныг

Эгнэшгүй өгүүлэгч болохыг нотолюу.

“Эл бүгдийн чанар хоосон”
“Энэ үр нь энэ шалтгааных”
Ийм хоёр ондоо магадлал
Эсрэг тэсрэггүй нөхөрлөж болох

Үүнээс илүү сонин юун
Түүнээс илүү гайхамшиг юун,
Үүгээр нь л таныг магтах аваас
Үнэнхүү магтаал, өөрөөр бус.

Адаг мунхгийн зарц болж
Аюумшиггүй таньтай мөчөөрхөгчид
Ахуй чанар хоосны дуунд
Амаргүй болоход гайхах юун.

Харин таны эрхэм сан
Шүтэн барилдлыгыг зөвшөөрөх атлаа
Хоосон чанарын дуурьсгалд уурсах
Хоёрдмол санаанд л гайхнам, би.

Мөн чанаргүйн мөрт хөтлөх
Мөхрөлтгүй үүд шүтэн барилдлагыг
Мөчид ухаарч, нэр төдийгөөр нь
Мөн чанартайд баримтлагч тэднийг
Агуу хутагтнуудын сайтар зорчсон
Адилтгашгүй дээд орц олом,

Аврал таныг баясуулах замд
Арга юугаар хөтлөнө билээ.
Засвар, тулгуургүй мөн чанар
Засвар, тулгуурт шүтэн барилдлага

Харшилдаж эсрэгцэлгүй нэг сууринд
Хаанаас цуг оршиж чадах вэ.

Үүний учир шүтэлцсэн бүгд
Өвөр чанар угаас хоосон ч
Өнгөц тэр мэт үзэгдэх нь
Үнэндээ илбэ шиг болохыг зарлигласан.
Эрхэм таны аливаа номлолоос
Эсэргүүцэгч нэгээхэн бээр зөв зүйтэй

Эргэлзээт асуудал олшгүй гэсэн нь ч
Энэхүү учраар тайлагдах буйза
Яагаад гэвэл, энэ л номлолоор
Ямарваа ил, далд юмст
Хийсвэрлэл хийгээд үгүйсгэлээр хандах
Хийдэм ташааг арилгах болно.

Ижилгүй өгүүлэгч болохыг тань нотлох
Эл шүтэн барилдлагын мөрөөр
Эрхэм зарлиг бусдыг ч жишээд
Эндүүгүй үнэнд нь итгэмж төр юу.

Утгачлан болгоож, учирлан номлосон
Ачит таныг даган суралцахад
Уршигт гэмийн үндэс таслагдсанаар
Уруу, дорой бүхнээс ангижирна.

Билгүүн сургаалаас тань гадагш зүглэвээс
Бэрхшээл зүдрэлийг өчнөөн эдлэвч
Бишид гэмийг улмаар даллаж,
Би г баримтлагч үзлийг бататгана.

Аяа, энэ хоёрын ялгааг
Аливаа ухаантан таних буйза,
Ясны угаас тэр цагт
Яхин таныг үл биширнэм.

Энгүй олон зарлигыг тань хэлэлтгүй,
Эгэл нэгэн зүйл утганд ч
Энгүүн ерөнхий ухаарлыг олоход
Энх амгалангийн дээжийг хүртдэг.

Ээ халаг, оюун минь мунхарчээ,
Энэ мэт эрдмийн цогцод
Эрт өнөөс залбирсан боловч
Эрдмийнх нь хувь төдийг ч эрсэнгүй.

Хэдий тэгэвч эрлэгийн ам уруу
Хэзээд зүглэсэн амиа алдаагүй дээр
Өршөөлт танд өчүүхэн итгэснээ
Өлзий буян хэмээн омогшном.

Заахаас шүтэн барилдлагыг заах,
Ухаарахаас шүтэн барилдлагыг ухаарах нь
Орчлон ертөнцөд ялгуусны эрхэтшиг
Охь түүнийг та л айлдана.

Гайхамшигт таны зарлиг бүгд
Шүтэн барилдлагыг ухуулах бөгөөд
Гаслангаас гэтэлгэхийг зорьсон танд
Амирлуулагч бус зохиол үгүй.

Аяа таны ариун сургаал
Аливаа бодгалийн сонорт хүрвээс
Алгасалгүй тэдний зовлонгарилгахуй

Аялдан бишрэхгүй хэн байх вэ.

Эсэргүүцэгч бүхнийг сөхөөн гартаах,
Эх, адаг харшилж хутгалдаагүй,
Энгүй хоёр тусыг соёрхогч
Энэхүү сургалт урамшив, би

Ачит та үүний тулд л
Амь бие, амраг садан
Алив баялгаа тоолшгүй галавт
Ахин дахин олонтаа зольсон

Гоц чухал эрдмийг нь үзсэнээр
Гохонд баригдсан загас мэт
Таалал тань татагдсан энэ номыг
Танаас сонсох хувь минь дутжээ.

Энэ гомдол энэлгээний хүчээр
Энхрий үрээ санан мөрөөсөх
Эхийн сэтгэл шиг эгээрэл хүслээ
Эгшин ч үл орхиж чадъяу.

Бас ч үүнд, зарлигийг тань санаваас,
Бадрангуй жавхлант лагшин найраг
Бахдам гэрлийн тороор хүрээлэгдсэн
Багш та, эсэруагийн эгшгээр

“Утга энэ нь ийм” хэмээн
Учирлан айлдахуйн дүр хөрөг
Санаанд минь ургамагц халуун энэлгээ
Сарны гэрэлд эмнэгдэх мэт.

Зүйрлэшгүй эрхэм уг номлолыг

Зүдэг мөхөс зарим хүмүүс
Зүлэг ширгийн хүлэс өвч шиг
Зүйл бүрээр орооцолдуулсан аж.

Үүнийг үзээд миний бие
Үй олон мэргэдийг даган
Өчнөөн шамдлаар ахин дахин
Үнэн голч тааллыг тань эрлээ.

Ийнхүү өөрийн болоод бусдын
Элдэв зүйл аймаг үзэлтний
Эрхэм гол шаструудыг судалсаар
Эргэлзлийн торонд сэтгэл минь энэлсэн

Бурханы шашны дээд хөлгөны
Буй, үгүйн хязгаарыг огоорч
Нарийвчлан тайлбарлах бошгыг олсон
Нагаржунайн үзлийн гүндаацэцэрлэгч

Тунгалаг оюуны дэгжмэл мандал
Туж зарлигийн огторгуйд торолгүй
Туйлшрагч сэтгэлийн харанхуй арилгаж,
Тусгүй өгүүлэгчдийн оддыг бөхөөсөн

Цогт сарны (Чандрагирди) сайн номлолын
Цолгин цагаан гэгээ туссаныг
Авралт багшийнхаа ачаар үзмэгц
Агсагадсан сэтгэлийн миньалжаал тайлагдлаа.

Үйлс зохиол бүгдийн дундаас
Үнэн зарлигийн зохиол дээд.
Үлэмж тэр нь энэ л учраас
Үүнээс л мэргэд Бурханыг дурдью.

Түүнийг даган хувраг болж,
Төгс зарлигийг нь багагүй судалсан,
Йогт хичээгч нэгэн гэлэн
Их аршдаа ийнхүү биширнэм.

Эгнэшгүй Бурханы шашинтай учирсан минь
Эргэлзээгүй багшийн л ач тул
Энэ буянаар ч амьтан бүгд
Эрдэмт багшаар удирдуулахыг ерөөнөм.

Авралт шашин орчлон эцэслэтэл
Атхаг муугийн салхинд ганхалгүй,
Ариун чанарыг нь ухаарч мэдээд
Бурханд итгэгчдээр дүүрэх болтугай.

Шүтэн барилдахуйн чанарыг тодруулсан
Бурханы сургаалыг төрөл тутамд
Амь биеэ зориулан дээдлэхдээ
Агшин зуурч алгасрахгүй болтугай.

“Аврагч тэрээр цаглашгүй зүдэрч,
Асар хичээлээр бүтээсэн хүнийг
Арга юугаар арвижуулах вэ” хэмээн
Өдөр шөнөгүй шинжлэх болтугай.

Үлэмжийн сэтгэлээр үүнд шамдаваас
Эсрүн, Хурмаст, ертөнцийгтэтгэгчид,
Эрхин Махгал, номыг сахигчид
Эндэлгүй мөнхөд нөхөрлөх болтугай.

**ДЭЭРХИЙН ГЭГЭЭНТЭН ДАЛАЙ БАГШИЙН АЙЛДСАН
МОНГОЛЫН ИХ БОГДЫН ХОЙД ДҮР ЭХ НУТАГТАА
ТҮРГЭН ЗАЛРАХУЙН ЗАЛБИРАЛ**

Лам Ц.Отгонбаярын орчуулга

Яруу эгшиглэнт бурхан багш
Ялгуусан ванчин далай лам
Гүнчиндолбуу гэндэндүв тэргүүт
Гүйцэт дамжлагын багш нар

Мэдэхүйн нарны хурц гэрлээр
Мэдэхгүйн харанхуйг эцэслэн хөөгч
Манзушир мэт хэтийтсэн замналд
Манлай богдын өлмийд залбирнам

Уужим орчлонг бүхэлд н ялган
Ухааруулах тааллыг үүрэглэн авсан
Удамт монголын их богд минь
Удалгүй түргэн заларч соёр биднээ

Гэм бие хэлний нүглийг галагшлуулж
Гэнээн бодь бусдын тусыгдотогшлуулж
Нууцыг уламжлан егүзэрт хүрсэн
Нигүүлсэнгүй шашныг тэтгэгч та залрагтун

Номлол нь ухаантны сонорын мялаалга
Номхотгол нь бул хадыг ч тээрэмлэгч
Аялгуун асар тэнгэрийг чалмайруулам та
Ажралгүй заларч шашинаа дэлгэн зохио

Носын ёс сонортохуйн далайгаас хэтийдсэн

Наминчлал нь эндүүрэн үзэхийг огоорсон
Нотлохуй дор тус бясалгалыг эрхшээсэн
Ном дээд хувилгаан та түргэн залраг тун

Шашны алдар гала загдын ёс
Шамдан боловсрох авшиг үндэс
Гэтэлгэн найруулга хөтөлбөр сэлтийг
Гэгээрүүлэн бадраагч та түргэн залрагтун

Барилдлагат шавь нарын чинь сүсэг
Бат хуурмаггүй гурван эрдэнийн адистэд
Бадрангуй цогт охин тэнгэрийн хүчээр

Буян ерөөл саадгүй түргэн биелтүгэй

*“Wherever the Buddha’s teachings have flourished,
either in cities or countrysides,
people would gain inconceivable benefits.
The land and people would be enveloped in peace.
The sun and moon will shine clear and bright.
Wind and rain would appear accordingly,
and there will be no disasters.
Nations would be prosperous
and there would be no use for soldiers or weapons.
People would abide by morality and accord with laws.
They would be courteous and humble,
and everyone would be content without injustices.
There would be no thefts or violence.
The strong would not dominate the weak
and everyone would get their fair share.”*

*** THE BUDDHA SPEAKS OF
THE INFINITE LIFE SUTRA OF
ADORNMENT, PURITY, EQUALITY
AND ENLIGHTENMENT OF
THE MAHAYANA SCHOOL***

Taking Refuge with a mind of Bodhichitta

**In the Buddha, the Dharma and the Sangha,
I shall always take refuge
Until the attainment of full awakening.**

**Through the merit of practicing generosity
and other perfections,
May I swiftly accomplish Buddhahood,
And benefit of all sentient beings.**

The Prayers of the Bodhisattvas

**With a wish to awaken all beings,
I shall always go for refuge
To the Buddha, Dharma, and Sangha,
Until I attain full enlightenment.**

**Possessing compassion and wisdom,
Today, in the Buddha's presence,
I sincerely generate
the supreme mind of Bodhichitta
For the benefit of all sentient beings.**

**"As long as space endures,
As long as sentient beings dwell,
Until then, may I too remain
To dispel the miseries of all sentient beings."**

GREAT VOW
BODHISATTVA EARTH-TREASURY
(BODHISATTVA KSITIGARBHA)

**“ Unless Hells become empty,
I vow not to attain Buddhahood;
Till all have achieved the Ultimate Liberation,
I shall then consider my Enlightenment full !”**

**Bodhisattva Earth-Treasury is
entrusted as the Caretaker of the World until
Buddha Maitreya reincarnates on Earth
in 5.7 billion years.**

**Reciting the Holy Name:
NAMO BODHISATTVA KSITIGARBHA**

**Karma-erasing Mantra:
OM BA LA MO LING TO NING SVAHA**

With bad advisors forever left behind,
From paths of evil he departs for eternity,
Soon to see the Buddha of Limitless Light
And perfect Samantabhadra's Supreme Vows.

The supreme and endless blessings
of Samantabhadra's deeds,
I now universally transfer.
May every living being, drowning and adrift,
Soon return to the Pure Land of Limitless Light!

*** The Vows of Samantabhadra ***

I vow that when my life approaches its end,
All obstructions will be swept away;
I will see Amitabha Buddha,
And be born in His Western Pure Land of
Ultimate Bliss and Peace.

When reborn in the Western Pure Land,
I will perfect and completely fulfill
Without exception these Great Vows,
To delight and benefit all beings.

*** The Vows of Samantabhadra Avatamsaka Sutra ***

DEDICATION OF MERIT

May the merit and virtue
accrued from this work
adorn Amitabha Buddha's Pure Land,
repay the four great kindnesses above,
and relieve the suffering of
those on the three paths below.
May those who see or hear of these efforts
generate Bodhi-mind,
spend their lives devoted to the Buddha Dharma,
and finally be reborn together in
the Land of Ultimate Bliss.
Homage to Amita Buddha!

NAMO AMITABHA

南無阿彌陀佛

《外蒙文：時輪金剛之意義及傳佈至蒙古之過程》

財團法人佛陀教育基金會 印贈

台北市杭州南路一段五十五號十一樓

Printed and donated for free distribution by

The Corporate Body of the Buddha Educational Foundation

11F, No. 55, Sec. 1, Hang Chow South Road, Taipei, Taiwan, R.O.C.

Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415

Email: overseas@budaedu.org

Website: <http://www.budaedu.org>

Mobile Web: m.budaedu.org

This book is strictly for free distribution, it is not to be sold.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО

Printed in Taiwan

3,500 copies; September 2018

MO039 - 16017

